

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1 – 2
Хуралдааны товч тэмдэглэл:	3 – 21
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	22 – 193
1. <i>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлт /Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/</i>	24 – 31
2. <i>“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	31 – 32
3. <i>“Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/</i>	32 – 40
4. <i>“Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/</i>	40 – 46
5. <i>“Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/</i>	46 – 57
6. <i>“Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/</i>	57 – 65
7. <i>Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай асуудал</i>	66 – 71
8. <i>“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	71 – 91
9. <i>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөх тухай асуудал</i>	91 – 104
10. <i>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	104 – 114
11. <i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай</i>	114 – 147

	<i>хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/</i>	
12.	<i>Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамиуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	148 – 153
13.	<i>Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	153 – 178
14.	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	178 – 180
	<i>Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн санал хураалт</i>	180 – 191
15.	<i>Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно</i>	191 – 193

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
07 дугаар сарын 04-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 75 гишүүн хүрэлцэн ирж, 59.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Амгаланбаатар, Х.Баттулга, Ж.Ганбаатар, Ц.Идэрбат, П.Наранбаяр, Д.Цогтбаатар, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Бум-Очир, А.Ганбаатар, Л.Гантөмөр;

Тасалсан: Б.Батбаатар;

Хоцорсон: О.Алтангэрэл – 02 минут, Н.Алтаншагай – 45 минут, Т.Аубакир – 32 минут, Ц.Баатархүү – 1 цаг 27 минут, М.Бадамсүрэн – 34 минут, Р.Батболд – 06 минут, Д.Батлут – 49 минут, Ж.Бат-Эрдэнэ – 1 цаг 19 минут, Х.Болормаа – 1 цаг 34 минут, Ш.Бямбасүрэн – 01 минут, Г.Ганбаатар – 03 минут, С.Ганбаатар – 39 минут, Д.Ганбат – 05 минут, П.Ганзориг – 06 минут, Х.Ганхуяг – 33 минут, Ц.Даваасүрэн – 52 минут, Г.Дамдинням – 48 минут, Т.Доржханд – 11 минут, Б.Дэлгэрсайхан – 5 цаг 42 минут, Б.Жавхлан – 3 цаг 26 минут, Б.Жаргалан – 06 минут, Д.Жаргалсайхан – 37 минут, Ц.Мөнхтуяа – 17 минут, Н.Номтойбаяр – 1 цаг 36 минут, Э.Одбаяр – 24 минут, Б.Пунсалмаа – 14 минут, О.Саранчулуун – 17 минут, Ц.Туваан – 4 цаг 24 минут, Б.Тулга – 20 минут, А.Ундраа – 32 минут, Н.Учрал – 49 минут, Г.Уянгахишиг – 1 цаг 20 минут, Да.Цогтбаатар – 16 минут, Ж.Чинбүрэн – 4 цаг 05 минут, Б.Энхбаяр – 43 минут, Ж.Энхбаяр – 3 цаг 03 минут, Р.Эрдэнэбүрэн – 1 цаг 38 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд тус тус хуваарилсаныг танилцуулав.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлт
/Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ц.Цолмон оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ц.Цолмон, цэцийн дүгнэлтийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нар танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, П.Сайнзориг нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 10 цаг 33 минутад хэлэлцэв.

***Хоёр.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 10 цаг 36 минутад хэлэлцэв.

***Гурав.“Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын
Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн
мэдүүлсэн/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал

Г.Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

“Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар илтгэлийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, тогтоолын төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуудан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын тавьсан асуултад Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, П.Сайнзориг нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 10 цаг 54 минутад хэлэлцэв.

Дөрөв. “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

“Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар илтгэлийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, тогтоолын төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 11 цаг 10 минутад хэлэлцэв.

Тав. “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

“Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар илтгэлийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, тогтоолын төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Г.Лувсанжамц, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 11 цаг 36 минутад хэлэлцэв.

Зургаа. “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

“Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар илтгэлийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, тогтоолын төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, А.Ундраа нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 11 цаг 56 минутад хэлэлцэв.

Долоо.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Ө.Гэрэлт-Од оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Нэр дэвшигчийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Б.Уянга нарын тавьсан асуултад нэр дэвшигч О.Гэрэл-Од хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, А.Ариунзаяа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 12 цаг 03 минутад хэлэлцэв.

Найм.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Мөнхнасан, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Батбаатар, Д.Гантулга, Мал эмнэлгийн ерөнхий газрын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газрын дарга Т.Балжинням, Татварын ерөнхий газрын Бүртгэлийн хэлтсийн дарга Т.Баярмаа, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Мал эмнэлгийн хяналт хариуцсан Гаалийн улсын байцаагч Д.Анхтуяа, Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуйн технологи дамжуулах төвийн захирал О.Баатарцогт, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Мал аж ахуйн салбарын эрхлэгч П.Мягмарсүрэн, Монголын үндэсний морин уралдаан, уяачдын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга М.Ариунболд, Монголын морин спорт, уяачдын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Ганбаяр, эрдэмтэн, судлаач А.Баярмагнай, Морьтны соёл судлаач, сэтгүүлч Л.Цагаандалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, П.Мөнхтулга, Х.Баасанжаргал, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, У.Отгонбаяр, Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуйн технологи дамжуулах төвийн захирал О.Баатарцогт, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Мал аж ахуйн салбарын эрхлэгч П.Мягмарсүрэн, эрдэмтэн, судлаач А.Баярмагнай, Морьтны соёл судлаач, сэтгүүлч Л.Цагаандалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Б.Бейсен нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 12 цаг 59 минутад хэлэлцэв.

Ес.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Г.Адъяа оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн тавьсан асуултад нэр дэвшигч Г.Адъяа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, А.Ариунзаяа, Ж.Батсуурь, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 13 цаг 29 минутад хэлэлцэв.

Арав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн бодлогын төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 13 цаг 31 минутаас 15 цаг 03 минутад хуралдааныг даргалав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Б.Заяабал, С.Эрдэнэбат, Б.Түвшин нарын тавьсан асуултад

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Түвшин, П.Сайнзориг, С.Эрдэнэбат, Б.Пунсалмаа, Да.Цогтбаатар, Б.Пүрэвдорж нарын асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 15 цаг 03 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Л.Мөнхбаясгалан, Ц.Мөнхбат, О.Номинчимэг, М.Мандхай, Ө.Шижир нар үг хэлэв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нар танилцуулав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэв.

Арван гурав.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх И.Баттөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Г.Лувсанжамц, А.Ариунзаяа, Г.Хосбаяр, Р.Батболд, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 16 цаг 35 минутад хэлэлцэв.

Арван дөрөв.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 45 минутад хэлэлцэв.

■ Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн санал хураалт

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг нэгтгэн явуулав.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлт.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Х.Булгантуяа: 1.Байнгын хорооны саналаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн хүнээс бууруулж бүртгэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 49

Бүгд: 110

55.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн

хүнээс бууруулж бүртгэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 47
Бүгд: 110
57.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн хүнээс бууруулж бүртгэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх эрхтэй” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 45
Бүгд: 110
59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

Байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Х.Булгантуяа: 1.Байнгын хорооны саналаар “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 45
Бүгд: 110
59.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Гурав. “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Х.Булгантуяа: 1.Байнгын хорооны саналаар “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 41
Бүгд: 110
62.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Дөрөв. “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Х.Булгантуяа: 1.Байнгын хорооны саналаар “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 51
Бүгд: 110
53.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Тав. “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Х.Булгантуяа: 1.Байнгын хорооны саналаар “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 46
Бүгд: 110
58.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Зургаа. “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Х.Булгантуяа: 1.Байнгын хорооны саналаар “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 42
Бүгд: 110
61.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Долоо. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.7-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох нууц санал хураалтыг явуулав.

Х.Булгантуяа: Байнгын хорооны саналаар Өвгөнхүүгийн Гэрэлт-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 44
Бүгд: 110
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Найм. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Х.Булгантуяа: Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 46
Бүгд: 110
58.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Ес. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.7-д заасны Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх нууц санал хураалтыг явуулав.

Х.Булгантуяа: Байнгын хорооны саналаар Цэндийн Сүхбаатарыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 42
Бүгд: 110
61.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Х.Булгантуяа: Байнгын хорооны саналаар Горчинсүрэнгийн Адьяаг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 39
Бүгд: 110
64.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Арав. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Х.Булгантуяа: Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 39
Бүгд: 110
64.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Арван нэг. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

**НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН
ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ, ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН
СУУЦЖУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Х.Булгантуяа: 1. Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.7¹ дүгээр зүйлийн 7¹.2.1 дэх заалтыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 39
Бүгд: 110
64.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн “3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 37
Бүгд: 110
66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН
ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ, ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН
СУУЦЖУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан
гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Х.Булгантуяа: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, М.Ганхүлэг, Ж.Батжаргал нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “бүсэд” гэсний дараа “нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, барилга байгууламжаас бусад” гэснийг “бүсэд” гэсний дараа “инженерийн дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламжаас бусад” гэж өөрчлөх.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга санал гаргав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

**Хоёр.ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Х.Булгантуяа: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “албан тушаалтан” гэсний дараа “зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/

газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн” гэж,” гэснийг “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “харьяалах шүүхэд хүсэлт гаргана.” гэснийг “харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана.” гэж,” гэж өөрчилж 4 дүгээр зүйлд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 35
Бүгд: 110
68.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 6.8 дахь заалтын “7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг,” гэснийг “7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 7.6 дугаар зүйл, 7.7 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.15, 7.17 дугаар зүйл,” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 38
Бүгд: 110
65.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Х.Булгантуяа: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.7.Энэ хуулийн 16.6-д заасан тохиолдолд даатгагч энэ хуулийн 15.2-т заасан үүргээс чөлөөлөгдөх ба хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа үнэлгээний тайлан шаардахгүйгээр эд хөрөнгийг засуулахаар тохиролцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 39
Бүгд: 110
64.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 16.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.6.Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй, холбогдогч талуудын тээврийн хэрэгслээс бусад эд хөрөнгийн хохиролгүй, холбогдогч талууд өөр хоорондоо маргаангүй тохиолдолд даатгагч, жолоочийн даатгалын сан нь даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл, баримтыг цахимаар даатгуулагч болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.6-д заасан автоматжуулсан системээс хүлээн авч, нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	39
Бүгд:	110

64.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Арван тав.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-т Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

-Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай”, “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай”, “Бүгд Найрамдах Тринадад ба Тобага Улстай дипломат харилцаа тогтоох тухай”, “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”, “Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай”, “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай”, “Хуулийн төсөл буцаах тухай”, “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолуудын эцсийн найруулгатай танилцлаа. /17.08/

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.3-т тус тус заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо. /17:09/

Уг асуудлыг 17 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 15 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 00 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 113 гишүүн ирж, 89.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр, Баасан гараг

Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим

10 цаг 10 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Булгантуяа: Гишүүдийн ирц 126-аас 72, 57.1 хувьтай байна.

Хоёр Байнгын хороо бас яг одоо хуралдаж байгаа. Тэндээс манай Байнгын хороо хуралдаад гишүүд ороод ирэхээр гишүүдийн ирц бүр нэмэгдэх байх.

Өнөөдөр 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 16 асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Хоёр.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Гурав.“Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Дөрөв.“Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тав.“Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Зургаа.“Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Долоо.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай асуудал.

Найм. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Ес. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал.

Арав. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Арван нэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Арван хоёр. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг хийнэ.

Арван гурав. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Арван дөрөв. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Арван тав. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Арван зургаа. Баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Дээрх 16 асуудлыг өнөөдөр хэлэлцэж, хамгийн сүүлд баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчдаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

▸ Нэгд, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг нарын 9 гишүүн 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд.

▸ Хоёрт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл нарын 3 гишүүн 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлснийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Эхний хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлт
/Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн
9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг
зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Цэдэвийн Цолмон танилцуулна.

Индэрт урьж байна.

Ц.Цолмон: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан, Э.Энхтуяа, Ц.Цолмон, Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн дарга Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Э.Болор-Эрдэнэ, О.Батхүү, Э.Тамир, С.Номынбаясгалан, түүний өмгөөлөгч З.Тамир болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, мөн шинжээчээр Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D) Б.Буянхишиг нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 3 хэсэг, 16 дугаар зүйлийн 3 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Та бүхэнд дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсгоё.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Үндсэн хууль (цаашид “Үндсэн хууль” гэх)-ийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурал (цаашид “Улсын Их Хурал” гэх)-аас 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг баталсан байх бөгөөд энэ хуультай холбогдуулан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж өөрчлөн найруулсан байна.

2.Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэж заажээ.

Өмчлөх эрх нь Үндсэн хуульд тухайлан заасан иргэний үндсэн эрхийн нэг бөгөөд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...” гэж баталгаажуулсан. Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт заасны дагуу өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй байна. Өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ өөрийн мэдэлд байлгаж, түүний ашиг, үр шимийг хүртэх, өмчлөлийн эд хөрөнгөө чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй боловч энэ эрх нь туйлын эрх биш юм. Уг

эрх нь нийтийн ашиг сонирхлоор хязгаарлагдах бөгөөд хязгаарлалт нь хуулиар тусгайлан зохицуулсан тодорхой хэм хэмжээнд үндэслэгдсэн байх ёстой.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийн хэрэгжих гол хэлбэр нь хэлцэл буюу гэрээ юм. Гэрээний эрх чөлөөний агуулга нь хүн бүр гэрээ байгуулах эсэхээ чөлөөтэй шийдэх ба гэрээ байгуулах тал, гэрээний агуулгыг өөрөө тодорхойлох эрхтэй бөгөөд иргэний эрх зүйн харилцааны үндсэн зарчим юм. Уг зарчим нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад заасан хөрөнгө чөлөөтэй олж авах үндсэн эрхийг хэрэгжүүлэх суурь болдог. Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, ...хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх ... зарчимд үндэслэнэ.”, мөн хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэгт “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.” гэж гэрээний эрх чөлөөг бататган хуульчилсан байна.

Иймд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг (цаашид “маргаан бүхий зохицуулалт” гэх) нь Монгол Улсын иргэн үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх эрхээс гадна иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрийн хүсэл зоригийн дагуу чөлөөтэй гэрээ байгуулах, эд хөрөнгийн харилцаанд оролцох эрхийг хязгаарласан зохицуулалт болжээ.

3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг хууль ёсны зарчимд нийцэхгүй байдлаар хязгаарласан, иргэдээс цаг хугацаа, илүү зардал шаардсан, нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, тодорхойгүй зохицуулалт болох нь тогтоогдож байна.

Иймд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-д заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх эрхтэй” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, ... өмчлөх ... эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд О.Мөнхсайхан, Г.Энхтуяа, Ц.Цолмон, Б.Болдбаатар.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Цэцийн дүгнэлтийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна.

Индэрт урьж байна.

Х.Баасанжаргал: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 сарын 06-ны өдрийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 06 дугаар дүгнэлтийг 2025 оны 07 сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 07 сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг цэцийн шийдвэрийг хүлээж авсан тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг зориудаар бууруулан татвараас зайлсхийх хоёр гэрээ байгуулах явдал үргэлжлэх бөгөөд бөгөөд ингэснээр дээр талуудын хооронд маргаан үүсэж, шүүх, цагдаад хандаж, даатгал болон хохирол нөхөн олгох асуудал хүндрэх тул үнэлгээ болон бүртгэлийн бодит үнэ, гэрээний ил тод, нэгдмэл бүртгэлийг нэвтрүүлэх, хуурамч баримтыг таслан зохих зохицуулалтыг чангатгах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлт нь үндэслэлтэй учир хүлээн авах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат чөлөөт эдийн засгийн нийгэмд үнэ, зах зээлийн зарчмаараа тогтох бөгөөд иргэд үл хөдлөх хөрөнгөө хүссэн үнээрээ худалдах ёстой тул Цэцийн дүгнэлтийг хүлээн авах нь үндэслэлтэй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй ч тус хуулийн холбогдох зүйл нь үл хөдлөх хөрөнгийг бага үнээр бүртгүүлж татвараас зайлсхийх үзэгдлийг багасгах зорилготой байсныг анхаарч цаашид сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалд үл хөдлөх хөрөнгийг чөлөөтэй өмчлөх, захиран зарцуулах эрх Үндсэн хуулиар баталгаажсан ч энэ эрх нь туйлын биш хууль тогтоомжоор тодорхой нөхцөлд хязгаарлагдаж болно гэдгийг ойлгох ёстой бөгөөд цэцийн дүгнэлтийг энэ удаа хүлээж аваад холбогдох зохицуулалтыг илүү оновчтой болгох шаардлагатай байгаа талаар тус тус үг хэллээ.

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-д заасан үнийг хамгийн сүүлд бүртгэсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг Монгол Улсын үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “...өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэж заасныг Монгол Улсын үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “...үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх эрхтэй.” гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн Наян дөрөвдүгээр зүйлийн 84.2.2 дахь заалтын дагуу Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

А.Ариунзаяа гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын П.Сайнзориг. Ирцээрээ ахиад өөрчлөгдсөн байна шүү.

Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: Энэ шийдвэрийг хүлээж аваасай гэж хүсэж байна.

Анхны хуулийн зорилго нь татвараас зугтаж байгаа иргэдийн татварыг бүрэн авахын тулд үнийн манипуляц хийдгийг зогсоох байсан гэдгийг итгэмжлэгдсэн төлөөлөгч болон Сангийн сайд, Татварын ерөнхий газраас ирүүлсэн тайлбарт тухайн үедээ өгсөн байдаг.

Яах вэ, татвараас зугтаах агуулгаар борлуулж байгаа үнээ хоорондоо тохиролцож бууруулдаг явдлууд байдаг аа байдаг. Үүнийг нуугаад яах вэ. Гэхдээ энэ маань өөрөө эргээд бусад шударга иргэдийн эрхэд халдаж болохгүй гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгэхээр татвараа зөв гүйцэд авах нь өөрөө нэг хэрэг. Нөгөө талдаа иргэд өөрсдийнхөө хөрөнгийг борлуулахдаа заавал өмнө нь өөрөө худалдаж авсан үнээсээ дээшлүүлж гэдэг юм уу, үнэ нэмж, эсвэл яг тэр хэмжээгээр нь борлуулах нь тухайн хөрөнгийн үнэ цэн нь ямар ч асуудлаар буурсан бай түүнийг үгүйсгэж эрхэд нь халдаж байгаа нь зөрчил юм гэдгийг тогтоосонд баярлалаа.

Тэгэхээр миний хувьд үүнийг дэмжиж байна. Хүний эрхийг бүрнээ хангах ёстой.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд хариуцлагатай байж энэ дүгнэлтийг хүлээж аваасай гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Цэцийн дүгнэлтийг манай Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд ер нь хүлээж аваад ажлын хэсэг гараад холбогдох өөрчлөлтийг нь

аль аль талынх нь эрх ашгаа бодоод зөв зохистой хийе ээ гэдэг дээр тохирсон байгаа.

Тийм учраас гишүүд цэцийн дүгнэлтийг дэмжээд хүлээж авах асуудлыг Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг дэмжээд өгөөрэй гэж хүсэж байгаа юм.

Гол зорилго маань ийм байдаг. А.Ариунзаяа сайд маань тодорхой хэмжээний тэр шударгаар үл хөдлөх хөрөнгөө ч гэдэг юм уу, борлуулж байгаа асуудал байгаа. Гэтэл иргэд маань зарим нь хожмын гэрээ байгуулах үеэсээ яг энэ аргыг ч гэдэг юм уу, хэт үнээ бууруулж байгаад явсны үр дагавруудыг зарим кэйсүүд дээр гарч ирээд байдаг. Жишээ нь, хоёр гэрээ байгуулдаг. Хоёр гэрээ байгуулна гэдэг ерөнхийдөө татвараас зайлсхийх гэмт хэрэг зөрчлийг шууд автоматаар үлдэж байгаа юм.

Тэгээд хамгийн бага үнэтэйгээ бүртгэлд бүртгүүлнэ. Нөгөө талдаа худалдагч, худалдан авагч талуудын хооронд маргаан гараад ч юм уу, бага үнийн дүнгээр хоёр гэрээ байгуулаад үл хөдлөх хөрөнгөө өгсөн хүмүүс яг үүнийг ашиглаад гэрээгээ цуцлах гэдэг юм уу, гэрээнээсээ буцах тохиолдлууд гардаг. Яг ийм залилангийн кэйсүүд практик дээр мэр сэр гардаг. Энэ дээр нь дараа нь худалдан авагч тал маань хохирдог ийм талууд гардаг юм.

Тэгээд ер нь үүнээс зайлсхийх. Энэ нь өөрөө эргээд шүүх, цагдаагаар маш олон жилийн процесс болдог. Үүнээсээ үл хөдлөх хөрөнгөө бүр эргэлтэд оруулж чадахаа больдог ч гэдэг юм уу ийм тохиолдлууд гардаг.

Хоёрдугаарт, хэт зориудаараа бага үнэлгээтэй зүйлүүд явахаар янз бүрийн байдлаар үл хөдлөх хөрөнгүүд нь байгалийн гамшиг, осолд яахаар үнэлгээ нь өөрөө буураад ороод ирдэг. Даатгалын нөхөн төлбөрөөр ч гэдэг юм уу, яг ийм юман дээр эрсдэлүүд гарах магадлалтай байгаа юм. Тэгээд үүнийгээ хаана хаанаа бодох ёстой.

Хоёрдугаарт, яг энэ үл хөдлөх хөрөнгийн бүртгэл дээр 1990-ээд оны дундуураар ч гэдэг юм уу ийм байдлаараа бүртгэлд яг энэ үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг шинэчлээгүй тохиолдлууд гарсан байдаг юм. Хотын төвийн том том оффисууд жишээ нь 2 сая төгрөгийн үнэлгээтэй байх жишээний ч байдаг юм уу, ийм юмнууд практик дээр байдаг. Татварыг шударгаар төлүүлэх ёстой байдаг. Энэ дээр зөрүүнүүд гардаг юм. Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт энэ тэр дээр.

Тэгэхээр үүнийгээ хаана хаанаасаа бодоод мэдээж энэ үл хөдлөх хөрөнгүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг бид хэд маш оновчтойтойгоор аль аль талынх нь эрх ашгийг хохирохоос тэр эрсдэлүүдийг бодолцож энэ зөв зохицуулалтыг хийх нь чухал гэдэг зүйл байгаа.

Хоёрдугаарт, энэ асуудлуудыг цэгцлэх хуулийн гаргалгаа нь Үл хөдлөх эд хөрөнгийн тухай хууль дээр байсан юм. Бид хэд ерөөсөө Хөрөнгийн үнэлгээний

тухай хуульд заасны дагуу мэргэжлийн шинжээч үнэлгээчнээр үнэлүүлээд манай үл хөдлөх хөрөнгө ийм үнэ буурсан байгаа, ингэсэн байгаа гээд үнэлгээгээ гаргаад энэ "transaction"-ыг хийх бүрэн бололцоо нь байгаа юм. Тэгээд манайхан тэрийг ашиглахгүй.

Мэдээж үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхэд нэмэлт 300-аас... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулахаар байгаа.

Хоёр Байнгын хороо яг зэрэг хуралдаад байгаа учраас санал хураалтыг түр хойшлуулаад хоёр Байнгын хорооны дараагаар ирц сайтай үед санал хураалтыг явуулъя.

Дараагийн асуудлаа хэлэлцэж эхэлье.

**Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна.

Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлцэлд бэлдүүлэхээр Хууль зүйн байнгын хороо шилжүүлсэн билээ.

Байнгын хороо нь 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан нь уг асуудлыг хэлэлцсэн бөгөөд чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг явуулах үед хавтаст хэргийг цахимжуулах болон цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаан шинжлэн судлах, цахим суурьтай

нотлох баримтыг үнэлэхтэй холбоотой зохицуулалтыг төслөөс хасах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу ажлын хэсгээс “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

“Хуулийн төсөл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

“Хуулийн төсөл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Х.Булгантуяа: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Асуулт асуух, үг хэлэх гишүүн байхгүй байна.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулахад хоёр Байнгын хороог дуусахаар больё. Тийм ээ.

Саяын тогтоолтой холбогдуулан санал хураалтыг Төрийн байгуулалтын байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны хуралдаан дуусаад гишүүд ч танхимдаа орж ирэхээр санал хураалтыг явуулъя.

Дараагийн асуудалдаа оръё.

Гурав. “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

“Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг танилцуулна.

Б.Батцэцэг: Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2011 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан гадаад бодлогын үзэл баримтлалыг тус тус үндэслэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох шийдвэрийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2013 онд гаргаж байсан.

Энэхүү шийдвэрийн мөрөөр Монгол Улстай дипломат харилцаагүй байсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орнуудтай дипломат харилцаа тогтоохоор ажилласны дүнд 2018 он хүртэл 25 улстай дипломат харилцаа тогтоож, Монгол Улсын үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 15 дугаар хэсэгт заасны дагуу улс тус бүртэй дипломат харилцаа тогтоох асуудлыг тухай бүр нь Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэн Улсын Их Хурлын тогтоол батлуулж ирсэн.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2019 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар дипломат харилцаа тогтоох асуудлыг нэг нэг улсаар нь биш, харин Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоож дууссаны дараа нэгдсэн байдлаар Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхийг үүрэг болгосон.

Энэ дагуу 2018 онд Эсватинийн Хаант Улстай, 2019 онд Барбадос Улстай, 2021 онд Тринидад ба Тобаго Улстай, хамгийн сүүлд 2023 оны 12 дугаар сард Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох хамтарсан албан мэдээнд тус тус гарын үсэг зурснаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох зорилт бүрэн хэрэгжих нөхцөл бүрдсэн.

Иймд хамгийн сүүлд дипломат харилцаа тогтоох болсон дээрх 4 улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг улс тус бүрээр хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Манай улс Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох сонирхолтой байгаагаа илэрхийлж хоёр тал дипломат харилцаа тогтоох тухай хамтарсан албан мэдээнд 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр гарын үсэг зурсан.

Барбадос Улс нь 1966 онд Британийн колоничлолоос тусгаар тогтнож Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн болсон.

2021 онд Британийн хаант засгаас бүрэн салж, бүгд найрамдах засаглалтай болсон түүхэн өөрчлөлт байсан.

Тус улс нь 77-гийн бүлэг, Карибын хамтын нийгэмлэг, Америкийн улсуудын байгууллага зэрэг бүс нутаг, олон усыг байгууллага, олон талт

механизмуудын гишүүн бөгөөд уур амьсгалын өөрчлөлт, хөгжиж буй орнуудын эрх ашгийг хамгаалах чиглэлд идэвхтэй байр суурьтай.

Тус улстай дипломат харилцаа тогтоосноор Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд нийтлэг ашиг сонирхлын төлөө харилцан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах боломж нэмэгдэх ач холбогдолтой.

Иймд “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталж өгөхийг хүсье.

Х.Булгантуяа: Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл танилцуулна.

Индэрт урьж байна.

Н.Батсүмбэрэл: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Барбадос Улстай дипломат харилцаа тогтоосноор хоёр талын харилцааг хөгжүүлж, хоёр талын болон олон талт тогтолцооны хүрээнд нийтлэг эрх ашгийн төлөө харилцан дэмжлэг үзүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Гадаад харилцааны яам дипломат бодлогоор дамжуулж үйл ажиллагаагаа өргөн далайцтай хэрэгжүүлж байгааг сайшаан, дотоодын нийт бүтээгдэхүүний үзүүлэлт өндөр, парламентын тогтолцоотой улстай дипломат харилцаа тогтоож байгааг онцлоод Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн хэдэн улстай дипломат харилцаа тогтоосон болоод, цаашид хэдэн улстай тогтоох төлөвлөгөөтэй байгааг, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн 2013 онд Байнгын хорооны хуралдаанаар эдгээр улстай дипломат харилцаа тогтоох тухай шийдвэр гарснаас хойш 2019 онд талууд хамтарсан албан мэдэгдэлд гарын үсэг зурж, одоо тогтоолын төсөл хэлэлцүүлэхээр оруулж ирж байгаа нь цаг хугацааны талаар тодруулан асууж, хариулт авсан болно.

Тогтоолтын төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны гишүүд үг хэлээгүй болно.

“Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа.

Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцаар 3 гишүүн нэр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Карибын тэнгисийн жижигхэн арлын улстай дипломат харилцаа тогтоож байгаа нь их сайн хэрэг гэж бодож байна.

Гэхдээ зүгээр нэг хоорондоо визгүйгээр зорчих ч байдаг юм уу, дипломат харилцаа тогтоолоо гээд дуусаж болохгүй. Энэ улсаас сурах юм их байгаа. Миний хувьд Барбадост олон улсын зөвлөхийн төслөөр ажиллаж байсан туршлагатай.

- Хүн ам нь ерөөсөө 300 мянга хүрэхгүй жижигхэн улс.
- Гэхдээ жилд 1.3 сая жуулчин хүлээж авч байгаа.

➤ Өөрсдийн байршил, мөн Америк болон Англи Улстай цагийн зөрүүгүй байдлаа ашиглаад жуулчдыг маш ихээр татаж чаддаг.

➤ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээ маш их дэмжиж байгаа. LOCAL BRANDING гэж ярьдаг. RUM буюу согтууруулах ундаан дээр өөрсдийн брэндийг олон улсад үүсгээд, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх хэмжээний бүтээгдэхүүнтэй болсон.

➤ Дээрээс нь нэмээд ямааны махны экспорт, ямааны махаа төрөлжүүлэх гэсэн тийм зүйлүүд дээр маш их анхаарч, хөрөнгө оруулалт хийж, олон улсад танигдаж байгаа ийм улс байгаа.

➤ Үүнийхээ үр дүнд **дотоодын нийт бүтээгдэхүүн нь 11.5 тэрбум доллар** буюу нэг хүнд хуваахаар манай улсаас 4-өөс 5 дахин их байгаа.

Ийм цөөхөн хүн амтай улс ингэж сайхан амьдарч болж байна. Олон улсад танигдсан алдартай хүн гэх юм бол **Рианна** /Rihanna/ гээд дуучин байна. Энэ дуучинтайгаа маш их хамтарч аялж ажилладаг. Ялангуяа аялал жуулчлалын тал дээр. Америкаас маш их жуулчин авахад энэ Рианна дуучин сургалт болон сурталчилгаа, тийм зүйлүүдийг аялал жуулчлалын байгууллагуудтайгаа, хувийн хэвшилтэйгээ хамтраад хийгээд явдаг.

Зочид буудлын үйлчилгээг маш их сайжруулж байгаа. Манай улс “GO MONGOLIA” хөтөлбөрийг хэрэгжүүлээд олон улсаас жуулчин аваад 1 сая, 2 сая жуулчинтай болно гэж бодож байгаа бол цаашдаа бид аялал жуулчлалын үйлчилгээгээ сайжруулах ёстой буюу эхлээд дотооддоо аялал жуулчлал хөгжих ёстой.

Монголчууд маань өөрсдөө тав тухтай аялдаг тийм соёлтой тав тухтай амьдрах боломжтой, хонох боломжтой. Дээрээс нь нэмээд нутгийн оршин суугчид, уугуул иргэд маань аялал жуулчлалын салбар дээр өөрсдийн брэнд бүтээгдэхүүнээ хөгжүүлээд тэрийгээ таниулаад, эхлээд дотооддоо таниулдаг. Дараа нь олон улсдаа таниулаад, гаднын жуулчдыг урьж авчирдаг.

Ялангуяа манай улс 7, 8 сард бусад Зүүн Өмнөд Азийн орнууд, Япон, Солонгостой харьцуулахад харьцангуй сэрүүнхэн байдаг. Энэ давуу талыгаа ашиглаад аялал жуулчлалаа хөгжүүлэх ёстой. 7 сард хэтэрхий их жуулчин ирээд байдаг. 8, 9 сардаа жуулчдаа авах ёстой гэсэн ийм бодлогуудыг авч явах ёстой.

Ажлын хэсгээс асуумаар байна. Барбадос Улсын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө гэж байдаг. LOCAL BRANDING буюу “үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, олон улсад таниулах төлөвлөгөө” гэж байдаг. Энэ тал дээр хамтран ажиллах төлөвлөгөө байгаа юу? Бид ийм тэргүүлж байгаа улсуудын жишгээс суралцаад түүнийгээ бодитоор хэрэгжүүлээд явах ёстой болов уу гэж бодож байна.

Энэ хоёр стратеги төлөвлөлтийн хүрээнд ямар байдлаар хамтран ажиллах гэж байгаа вэ гэдэг асуулт байна.

Б.Пүрэвдорж: Гишүүний асуултад Г.Бямбасүрэн Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал хариулна.

Г.Бямбасүрэн: Гишүүний асуултад хариулъя.

Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн.

Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох асуудлыг бид НьюЙорк дахь байнгын төлөөлөгчийн газраар дамжуулж хэд хэдэн удаагийн хэлэлцээ хийж байсан.

Цаашид дипломат харилцаа тогтоосноос хойш бид хэд хэдэн салбарт хамтарч ажиллая, мэдээлэл солилцъя гэдэг талаар тохирсон. Энэ дундаа аялал жуулчлалын салбар, хөдөө аж ахуйн салбарт бид цаашдаа мэдээлэл солилцох, туршлага солилцох чиглэлээр ажиллая гэдэг ийм үндсэн тохиролцоонд хүрээд ажиллаж байгаа.

Одоогийн байдлаар бид Нью-Йорк дахь байнгын төлөөлөгчийн газраас хавсран хариуцаад ажиллаж байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Одоо Аюушийн Ариунзаяа асуулт асууна.

А.Ариунзаяа: Би Гадаад харилцааны яамыг маш сайн ажиллаж байгаа гэж боддог. Баг хамт олонд нь талархал дэвшүүлж баяр хүргэмээр байна.

Гагцхүү ганцхан эрсдэлийг тооцож чадахгүй байгаа. Тэр нь улс төрийн эрсдэл. Бид маш олон улс орнуудтай дипломат харилцаа, хэлэлцээр, гэрээ, тохироо, маш олон зүйл дээр маш сайн ажиллаж байгаа. Гагцхүү улс төрийн энэ нөхцөл байдал, эдгээр хэлсэн амандаа хүрэх боломжгүй, хүрдэггүй, хэлсэн ярьснаасаа буцдаг ийм нөхцөлийг үүсгээд байна.

Энэ эргээд манай улсад итгэх итгэлийг байхгүй болгож, манай улсын нэр хүндийг маш ихээр унагааж байгаа.

Ийм учраас би Улсын Их Хурлын гишүүддээ уриалмаар байгаа юм. Олон улсын тавцанд өгсөн амлалтуудаа биелүүлдэг байя. Улс орныхоо нэр хүндийг боддог байя. Улс төрийн шалтгаанаар жишээлбэл Казахстаны хэлэлцээрийг унагаасан. Соёрхон батлах үйл явцыг бид удаашруулсан.

Т.Аубакир сайдад би дөнгөж сайд болоод ирэнгүүт нь хэлсэн. Хурдан шуурхай яаралтай оруулж ир. Энэ асуудлыг.

2018 оноос хойш 19 удаагийн хэлэлцээр хийж бид Монгол Улсынхаа Ерөнхийлөгчийг Казахстанд очиход нь хоёр улсын Ерөнхийлөгчид гарын үсэг зурсан тэр хэлэлцээрийг соёрхон батлах асуудлыг бид унагаасан.

Одоо энэ удаагийн чуулганаар орж амжсангүй. Дараагийн гурав дахь өдөр чуулган хаах гэж байна. Ээлжит намрын чуулган эхэлтэл дахиад хоёр, гурван сарын хугацаа өнгөрнө.

Энэ хугацаанд Казахстан Улсад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэд тухайн улсад ажилласныхаа төлөө хуримтлуулсан, нийгмийн даатгалын санд нь төлсөн тэр шимтгэлээ авч чадахгүйд хүрч байна.

Казахстан Улс 2018 оноос хойш. Үгүй ээ, бид хэлэлцээрээ 2018 оноос хойш явуулсан. 1998 оноос хойш хуримтлалын тогтолцоонд шилжсэн буюу манайх шиг “хуваарилалтын тогтолцоо”-нд биш, “хуримтлалын тогтолцоо”-нд шилжсэн байгаа.

Энэ юу юм бэ гэхээр та хэдийг төлнө үү төдий хэмжээнд дансанд нь бодитоор мөнгө нь байршаад, тэтгэвэртээ гарахад нь нэг удаадаа татвараа төлөөд бүтнээр нь авах боломжтой, нас барах юм бол өвлүүлэх боломжтой, өөрөө бодитоор үүнийг захиран зарцуулах боломжтой ийм системтэй улс юм.

Тэгэхээр үүнийг бид өөрийнхөө иргэддээ хувь хүртэх боломжийг нь улс төрийн агуулгаар хойшлуулсан байгаа шүү гэдгийг дахин хэлмээр байна. Үүнийг засах хугацаа бид нарт дахиад л хойшиллоо.

Тэгэхээр энэ дээр улс төрийн эрсдэлүүдийг тооцож явж байгаасай. Үүн дээр Гадаад хэргийн яам хүчтэй дуугарч араас нь явдаг байгаасай гэж хүсэж байна.

Евроазийн хэлэлцээр ч гэсэн мөн адил.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одоо Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

Б.Сайнзориг: Баярлалаа дарга.

Би энэ Улсын Их Хурлын тогтоолыг дэмжиж байгаа. Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орнуудтай ер нь дипломат харилцааг жижиг, бага гэлтгүй, газарзүйн байршлын хувьд хол, ойр гэхгүйгээр бүгдтэй нь найрсаг дипломат харилцааг үүсгэж явах ёстой.

Г.Лувсанжамц гишүүн сая хэллээ. Энэ орны онцлог 300-хан мянган хүн амтай мөртлөө дотоодын нийт бүтээгдэхүүн нь ямар өндөр вэ. Энэ хөгжлийн гарцаа яаж тодорхойлсон бэ. Үүнийхээ төлөө улс орон нь ямар стратеги барьдаг вэ гэдгийг сая товчхон хэллээ.

Жижиг гэлтгүй ийм орнуудаас бид суралцах бололцоо байгаа.

Тэгэхээр би үүний цаана юу хэлэх гээд байна гэхээр гадагшаа Монгол Улсаас бусад улсад сууж байгаа Элчин сайдуудын ажлыг дүгнэх асуудлыг хэдүүлээ нэг өөр шалгууртай болгомоор байгаа юм.

Нэгдүгээрт, Монгол Улсад хөрөнгө оруулалт, эдийн засгийн харилцааг хэрхэн яаж сэргээхэд хувь нэмэр оруулсан юм бэ гэдэг асуудал.

Дээрээс нь Монгол Улсын гадаад паспортыг хүчиргэжүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулсан юм бэ гэдэг асуудал. Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр Нэгдсэн Үндэстний Байгууллага энэ 200-аад улсаас манай улсын паспорт 69-д эрэмбэлэгдэж байгаа. 69-д Кени Улстай хамт зогсож байна лээ. Олон улсын “rank”-аар. Өөрөөр хэлэх юм бол манай улсын гадаад паспортоор визгүй нэвтрэх орны тоо хэмжээ бага л байна гэсэн үг.

Мэдээж энэ өндөр хөгжилтэй, эдийн засаг нь бэхэжсэн орнууд үүгээр тэргүүлдэг. Нэгдүгээрт, Эмират тэргүүлж байх шиг байгаа юм. Араас нь Испани, Америк ч гэдэг юм уу, ингээд явж байх шиг байна.

Тэгэхээр би ер нь гадаад харилцааг эдийн засагжуулах асуудал дээр Гадаад харилцааны яам илүү анхаармаар байна. Яах вэ, хоёр талын айлчлалууд гэдэг маш том хамтын ажиллагааны өндөр түвшинд хүрч байгааг илэрхийлж байгаа боловч яг түрүүн А.Ариунзаяа сайд хэллээ. Энэ уулзалт яриа хэлэлцээрийн хүрээнд яригдсан зүйлүүдийг биелэхгүй учраас хэдхэн жилийн дараагаас Монгол Улсыг үл тоож эхэлдэг. Ярьсан хэлсэндээ байхгүй гэж хэлдэг.

Тэгэхээр энэ асуудлуудыг бид нээрээ нэг цэгцтэй авч явмаар байна. Тэгээд гадаад харилцааг аль болохоор энэ эдийн засаг руу уях, хөрөнгө оруулалтыг татах, Элчин сайд, тэнд ажиллаж байгаа эдийн засгийн зөвлөх байдаг юм уу, атташейнүүдийн үйл ажиллагааг үнэлэхдээ хөрөнгө оруулалтуудыг хэрхэн татаж авчирсан бэ гэдэг байдлаар нь үнэлмээр байна.

Дээрээс нь Монгол Улсын гадаад паспортыг хүчирхэгжүүлэх гэдэг юм уу, монгол иргэдийн зорчих байдлыг нэмэгдүүлэхэд хэрхэн яаж тусалсан юм бэ гэдэг байдлаар үнэлмээр байна.

Тэгээд үүний цаана юу хэлэх гээд байна гэхээр гадаад харилцааны бодлогын хүрээнд Монгол Улсаас гадаад улсад сууж байгаа Элчин сайдын яамдад ажиллаж байгаа Элчин сайдаасаа эхлээд элчин зөвлөх, атташейнүүд дээр жоохон эдийн засаг, бизнесийн хүмүүсийг явуулмаар байна.

Хэдийгээр яах вэ гадаад харилцааны бодлого өргөн хүрээтэй байдаг, мэргэжлийн байгаа боловч зарим тэр эдийн засгийн атташей байдаг юм уу,

зарим хэсэг дээр бизнесийн хүмүүсийг явуулмаар байгаа байхгүй юу. Магадгүй Худалдаа, аж үйлдвэрийн танхим... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалтыг Төсвийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо хоёр хуралдаад. Гишүүд олонх нь тэнд байгаа учраас түр хойшлуулъя.

Одоо дараагийн асуудал.

**Дөрөв. “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/**

“Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг танилцуулна.

Төсвийн байнгын хорооноос дуудаарай.

Энэ хооронд Монголынхоо ард түмний энэ өдрийн мэндийг мэндчилж энэ удахгүй болох сайхан улсын баяртаа бүгдээрээ сайхан баярлах ерөөлийг өргөн дэвшүүлье.

Энэ удаагийн хаврын чуулганаар Батбаярын Жаргалан нарын 40 гаруй гишүүний өргөн барьсан Баяр наадмын тухай хуульд өөрчлөлт орж, ардчилсан хувьсгалын гэж бүх шатанд зарлахаар болж байгаа.

Энэ хуулийн дагуу бүх ойд Ардын хувьсгалын гэдэг үгийг заавал хэлэх болсон шүү гэдгийг хэлье. Энэ 10-ны өдрөөс энэ хууль хэрэгжиж эхэлж байгаа.

Одоо Б.Батцэцэг сайдыг Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох танилцуулгыг хийе.

Б.Батцэцэг: Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай хамтарсан албан мэдээнд 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр гарын үсэг зурсан.

Эсватин Улс нь 1968 онд Британийн хяналтаас бүрэн гарснаар тусгаар тогтнолоо олж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнд элссэн.

Мөн Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнээр 1995 онд элссэн бөгөөд тус байгууллагын Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын бүлгийн гишүүн улс юм.

Африкийн өмнөд хэсэгт орших Эсватин Улс нь мал аж ахуй, аж үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт суурилсан харьцангуй төрөлжсөн эдийн засагтай, дундаж орлоготой улсад тооцогддог бөгөөд далайд гарцгүй гэдгээрээ манай улстай ижил төстэй.

Тус улстай дипломат харилцаа тогтоосноор Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын ашиг сонирхлын хамгаалах зэрэг нийтлэг ашиг сонирхлын төлөө харилцан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах боломж нэмэгдэнэ.

Иймд “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг мөн адилхан. Гадаад харилцааны сайд, Монгол Улсын сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байгаа.

Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Хосбаяр танилцуулна.

Индэрт урьж байна.

Г.Хосбаяр: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоосноор хоёр талын харилцааг хөгжүүлж, хоёр талын болон олон талт тогтолцооны хүрээнд нийтлэг эрх ашгийн төлөө харилцан дэмжлэг үзүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллага түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

“Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Асуулт асуух, үг хэлэх гишүүн хоёр гишүүн байна. Б.Бейсен гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен.

Б.Бейсен: Эсватинийн Хант Улс чинь яг аль тивд байдаг юм? Гол нь дипломат харилцаа тогтооход Монгол Улсын талд ямар ашигтай, яаж хамтарч ажиллах юм? Юуны чиглэлээр? Гол нь. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Гадаад хэргийн сайдаас асуух асуудал байна. Дипломат харилцаа тогтоодог. Тэгээд дараа нь Ерөнхийлөгч нар нь уулзаад л Засгийн газрын хэлэлцээрийг унагаадаг асуудал байна.

Түрүүн А.Ариунзаяа гишүүний саналыг дэмжиж байна, би. Яагаад гэвэл хоёр улсын Ерөнхийлөгч уулзаад Засгийн газрын хамтарсан гэрээний дагуу хийгдэх ёстой зүйлийг Их Хурлаар баталж чадаагүй. Яагаад гэвэл Казахстан Улсад 1990 онд хөдөлмөрийн гэрээгээр гарсан улсууд тэнд арван хэдэн жил ажиллаад хүрээд ирсэн. Одоо тийшээ нүүгээд очсон улсууд байгаа. Тэгээд энэ улсуудын тэтгэврийн асуудал шийдэгдэхгүй байгаа асуудлууд байж байгаа.

Тэгэхээр энэ дээр анхаарахгүй бол ард иргэд чирэгдэх асуудал их гарч байгаа. Нөгөө талаар тэтгэвэр, тэтгэмжээ авч чадахгүй байгаа асуудлууд байгаа.

Хоёрдугаарт, мэдээж хоёр улс хамтарсан хэлэлцээр тогтоосны дагуу тэр улсад манайхаас Монгол Улсын иргэд очоод ажиллах байх. Зарим нь хамтраад

ажиллах нөхцөл гарна. Иргэншлийн асуудал ч гарах байх. Гэхдээ ийм асуудал байж байгаа.

Монгол Улсаас Казакстан явж ирчхээд Монгол Улсаас гараагүй ч улсууд байж байгаа. Гэтэл иргэншлээс хасагдсан, одоог хүртэл иргэншилд орохгүй байгаа асуудлууд байж байгаа.

Одоо яг танд хэчнээн хүний хүсэлт Засгийн газарт уламжлагдаж ирсэн. Иргэншил авч чадахгүй байгаа. 15-аас 20 жил болсон улсууд байж байна. Тэгээд ирчхээд ямар нэгэн ажилд орж чадахгүй, тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж чадахгүй, төрсөн хүүхдүүд нь иргэншил авч чадахгүй байгаа асуудлууд байж байгаа. Энэ талаар та Гадаад хэргийн яамны сайдын хувьд Гадаадын харьяатын албанд хэчнээн хүний хүсэлтийг уламжилсан бэ гэдэг асуулт асууя.

Х.Булгантуяа: Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг сайд хариулъя.

Б.Батцэцэг: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Эсватин Улс нь хаант улс. Энэ Африкт байдаг улс байгаа.

Бид гадаад бодлогын зорилтынхоо хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх улстай дипломат харилцаа тогтооно гэдэг ийм зорилт тавьсан байдаг юм.

Тэгэхээр манай гадаад бодлогын үзэл баримтлал дэлхийн бүх улстай, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улс оронтой найрамдалт харилцаатай байна. Хэнтэй ч муудахгүй, ийм олон тулгуурт гадаад бодлогыг явуулна гэж ингэж заасан байдаг.

Тэгэхээр өнөөдрийн хэлэлцүүлж байгаа 4 улстай дипломат харилцаа тогтоосноор бид дэлхийн бүх улстай дипломат харилцаатай болох юм.

Тэгэхээр ийм улс орон дэлхий дээр их цөөхөн байгаа. Их цөөхөн байгаа. Тэгэхээр энэ манай гадаад бодлогын бас нэг ололт юм гэдгийг онцолж хэлэх гэсэн юм. Дипломат харилцаа бүх л улс оронтой тогтоосноор ямар нэгэн эрсдэлд орохгүй. Хоёрдугаарт нь.

Гуравдугаарт нь, бид энэ улстай харилцаагаа хөгжүүлэх ийм боломж байгаа гэдгийг түрүүн би танилцуулга дээрээ хэлсэн.

Хоёр дахь асуудлын тухайд Казакстанд байгаа Монголоос шилжиж очсон иргэдийн асуудал нэлээд олон асуудлууд байдаг. Таны хамгийн чухалчилж асууж байгаа хэдэн хүн Гадаад харилцааны яаманд хүсэлтээ өгөөд Монголдоо буцаж ирэхийг хүсэж байгаа вэ гэж ойлголоо. Монголын иргэншлээ буцааж авах.

Тэгэхээр Монголын иргэншлийг буцааж авахад хүсэлтээ Гадаадын иргэн, харьяатын газар, Хууль зүй, дотоод хэргийн яамаар дамжуулаад Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргэгддэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудал. Иргэншлээс гаргах болон оруулах асуудал бол.

Би өнөөдөр яг одоо манай яаман дээр ирсэн хүсэлтүүдийн тоог хэлж мэдэхгүй байна. Тэрийг би танд тодруулаад дахиад хэлье.

Мэдээж Казакстанд Монголынхоо иргэншлээс гараагүй очоод Казахстаны иргэншил авсан иргэд байдаг. Манай Монгол Улсынхаа иргэншлээс гараагүй нэлээд олон иргэн байдаг. Тэгээд зарим нь буцаад ирдэг. Өөрөөр хэлбэл Казахстаны баримт бичигтэй ингээд явж байгаа хүмүүс байна. Иргэншлээс гараад Казахстаны иргэн болоод тодорхой хугацааны дараа 5, 10, 20 жилийн дараагаар буцаад нутагтаа ирье гэдэг иргэд байдаг. Энэ иргэдийн асуудал бас эрх зүйн хувьд шууд шийдвэрлэх боломжгүй.

Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчид өгсөн хүсэлтийн дагуу шийдэгдэнэ гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Б.Бейсен гишүүн нэмж тодруулъя.

Б.Бейсен: Эсвадиниин Хаант Улстай аль чиглэлээр, хөдөө аж ахуй ч юм уу, эрүүл мэнд ч юм уу, уул уурхайн тал юм уу, аль нь сайн хөгжсөн улс байна. Ер нь аль талаар хамтарч ажиллахыг цаашдаа төлөвлөж бодож байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэр Казакстанаас ирсэн иргэд маань байж байна. Нөгөө талаар Монголоос гараагүй мөртлөө иргэншлээс хасагдсан улсууд байж байгаа. Энэ Казакстаны квотын асуудалтай холбоотой олон улсад иргэншлээ хасагдсан. Дахиж иргэншил авч чадахгүй байж байгаа байхгүй юу. Нөгөө талаар шинээр төрсөн хүүхдүүд нь бас иргэншил авч чадахгүй ийм асуудал байгаа.

Тэгэхээр үүнийг сая Казахстаны Элчин сайд ирэхэд энэ талын асуудал хөндөгдсөн үү?

Х.Булгантуяа: Б.Батцэцэг сайд нэмж хариулъя.

Б.Батцэцэг: Эсватин Улстай бид олон улсын хамтын нийгэмлэгт хамтарч ажиллах, ялангуяа далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын чиглэлээр хамтарч ажиллах нийтлэг бэрхшээлүүд байдаг. Худалдааны тариф, барьер, тээвэр логистикийн хүндрэл гэх мэт.

Тэгэхээр манайд бид эхний ээлжид далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төв Монгол Улсад байдаг. Энд элсэх саналыг тавина. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид энэ өөрөө чихрийн нишингэ тарьдаг. Хөдөө аж ахуй нэлээн хөгжсөн ийм улс орон. Бид дөнгөж дипломат харилцаа тогтоож байгаа. Үүнээс цаашаа бид харилцан ажил, айлчлалууд, цаашдаа эрх зүйн баримт бичгүүд, худалдаа арилжаа, аялал жуулчлал, бусад чиглэлүүдийг судалж цаашдаа бид ямар харилцах вэ гэдэг эрх зүйн анхан суурь баримт бичгүүдээ байгуулах чиглэлээр эхний ээлжид ажиллана.

Сая Казахстаны Гадаад сайд ирэхэд энэ асуудлыг яриагүй. Токаев Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Монголын иргэдийг... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат.

Д.Ганбат: Ер нь манай гадаад харилцаа хэзээ хэзээнээсээ илүү сайн, өндөр түвшинд байгаа гэж ойлгож байгаа.

800 жилийн өмнө л нэг сайн байсан байх. Яг одоо бол тэр түвшиндээ очиж чадаж байна. Гадаад харилцааг.

Энэ гадаад харилцааг явуулж байгаа тэргүүн дипломат Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт Улсын Их Хурал талархал илэрхийлэх хэрэгтэй гэж би бодож байна.

Юу вэ гэхээр энэ хооронд олон ч төрийн тэргүүн хүмүүс Монгол Улсад уулзах гээд ирээд, ингээд очерлоод, өдөр болгон ингээд явж байна. Ийм байдал л 800 жилийн өмнө л байж байсан байх. Тэрийг мэдэхгүй юм байна.

Нөгөө талаар бүх орнуудтай дипломат харилцаа тогтоочхов уу? Манайх шиг жижиг улсын хувьд. Манайх чинь уг нь үндэсний хувьд жижиг биш л дээ. Энэ гадаад харилцаа маш чухал. Тийм. Хэдэн оронтой шинээр дипломат харилцаа тогтоох гэж байна вэ гэдгийг, Элчин сайдаа суулгах гэж байна вэ гэдгийг асуумаар байгаа юм.

Нөгөө талаар Монголчууд биднийг дэлхий нийтээрээ мэднэ. Тэр байтугай бид чинь хэдэн ч эзэнт гүрэн байгуулж байсан юм дээ. Бараг 2, 3 байх аа. Тийм.

Одоо дэлхийн дэг журам их өөрчлөгдөж байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг роль ч ямар болж байна вэ гэдгийг бид харж үзэх ёстой. Энэ талаар ямар бэлтгэлтэй байна? Аягүй бол сая дэлхийн 3 дугаар дайны ирмэг дээр хүртэл ирлээ гээд зарим нэг судлаачид хүртэл ярьж байна. Цаашдаа ямар байх, юу болохыг хэн ч мэдэхгүй. Цаашдаа энэ дэлхийн газрын зураг яаж өөрчлөгдөхийг бид мэдэхгүй ийм байдалтай байна.

Тэгээд манай гадаад харилцаа, манай аюулгүй байдлын бодлого ямаршуухан байгаа вэ, яаж явж байгаа вэ? Ер нь манайх их олон сайдтай юм. Олон сайдтай ийм Засгийн газар ажиллаж байгаа. Энэ Засгийн газарт ажиллаж байгаа, ажлаа гайгүй сайн хийгээд байгаа хоёр, гурван сайд л байна даа. Нэг нь

манай Б.Батцэцэг сайд, Ч.Учрал сайд байна. Бусад нь нэг иймэрхүү жишигтэй ажлаа хийж байвал зүгээр байна шүү. Тийм. Г.Дамдиннямыг гайгүй болох болов уу гэсэн найдлага байна. Харж л байя. Тийм.

Товчхон ийм байна. Тэгээд хариултыг нь сонсьё.

Х.Булгантуяа: Д.Ганбат гишүүн үг хэллээ.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар санал хураалтыг хоёр Байнгын хороо хуралдаж дууссаны дараагаар Төсвийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд танхимд орж ирсний дараагаар санал хураалтыг явуулъя.

Дараагийн асуудалдаа оръё.

**Тав. “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай
дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/**

“Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг танилцуулна.

Индэрт урьж байна.

Б.Батцэцэг: Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай хамтарсан албан мэдээнд 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр гарын үсэг зурсан.

Карибын тэнгист орших 2 арлаас бүрдэх Тринидад ба Тобаго Улс нь 1962 онд Их Британиас бүрэн тусгаарлаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орон болсон.

Шингэрүүлсэн байгалийн хийн экспортоор бүс нутагтаа тэргүүлдэг тус улс Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн худалдааны байгууллагаас гадна Карибын хамтын нийгэмлэг, Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг, Америкийн улсын байгууллага зэрэг олон улсын байгууллагуудад идэвхтэй гишүүн юм.

Гадаад бодлого нь бүс нутгийн тогтвортой байдал, хөгжил дэвшилд чиглэсэн бөгөөд олон улсын тавцанд төвийг сахисан байр суурь баримталдаг.

Тус улстай дипломат харилцаа тогтоосноор Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд хамтран ажиллаж, нийтлэг ашиг сонирхлын төлөө харилцан дэмжлэг үзүүлэх боломж нээгдэх юм.

Иймд “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Х.Булгантуяа: Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна.

Индэрт урьж байна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоосноор хоёр талын харилцааг өргөжүүлж, хоёр талын болон олон талт тогтолцооны хүрээнд нийтлэг эрх ашгийн төлөө харилцан дэмжлэг үзүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

“Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал,

гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг адилхан байгаа. Түрүүнийхтэй.

Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Нанзадын Наранбаатар асуулт асууж, үг хэлнэ.

Н.Наранбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр Б.Батцэцэг сайдаас асуулт байна. Манай улсаас гадаадын улс оронд сууж байгаа Элчин сайд, төлөөлөгчийн газар, консулууд, Элчин сайдын яамны ажилчдын ажлыг дүгнэхдээ ямар гол үндсэн үзүүлэлтүүдээр дүгнэж байна вэ? Тухайлах юм бол Монгол Улсын эдийн засгийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үндэсний бараа, бүтээгдэхүүн, брэндүүдээ гадаадад экспортод гаргах зэрэг. Мөн боловсрол, соёлын харилцааг өргөжүүлэх зэрэг ажлууд дээр ажил дүгнэх үзүүлэлтүүдийг хэр тооцож үздэг юм гэж би боддог.

Манай эдийн засаг үндсэндээ ганцхан нүүрсэн дээр тогтсон л эдийн засаг байна.

Тийм учраас бид эдийн засгаа тэлэх хэрэгтэй байна, төрөлжүүлэх хэрэгтэй байна, солонгоруулах хэрэгтэй байна. Ганцхан нүүрсний үнэ унахаар л бүгдээрээ бужигнаад л ингээд төрийн албан хаагчдынхаа ч хүртэл хармаа руу ороод, аймаг, нийслэлийнхээ ч хүртэл данс руу шагайгаад, хамаг орлогыг нь татаж аваад ингээд сандралдаад эхлэх юм.

Тийм учраас эдийн засгаа төрөлжүүлэх, эдийн засгаа тэлэх дээр Гадаад харилцааны яам, гадаадад суугаа Элчин сайдууд маш чухал үүрэгтэй байх гэж бодож байгаа.

Би болохдоо тэдгээр улсуудыг зөвхөн нэг айлчлалыг зохион байгуулаад, аль эсвэл гишүүд, сайд очихоор үйлчлээд буцаадаг, бусад үед нь амраад хэвтэж байдаг улсууд гэж бодохгүй байгаа.

Тийм учраас энэ улсууд маань тодорхой үүрэг хариуцлагатай, тухайн улсдаа ажилладаг байх ёстой.

Намайг аймгийн Засаг дарга ажиллаж байхад Беларусь Улсаас Монгол Улсад сууж байгаа Элчин сайд маш олон удаа аймгуудаар, ялангуяа Өмнөговь аймагт очиж Өмнөговь аймгийн удирдлагуудтай ярьж, өөрийн орноо

сурталчилж, өөрийн орныхоо брэнд бүтээгдэхүүн болох “БЕЛАЗ”-ыг борлуулах, мөн шинжлэх ухаан, технологийн чиглэлээр Өмнөговь аймгаас оюутнуудыг Беларусь Улсын холбогдох их дээд сургуульд суралцуулах, мөн тэнд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайнуудтай биечлэн явж уулзаж өөрийн орны бараа, бүтээгдэхүүнээ борлуулах зэрэг ажлуудыг цөхрөлтгүй хийдэг байсан.

Өглөө ажилд очиход л Засаг даргын үүдэнд хүлээгээд сууж байдаг. Тэгээд ярьж байгаа нь дандаа өөрийнхөө улс орны төлөө ярьж байдаг ийм байсан.

Тийм учраас манай Элчин сайдууд маань, гадна суугаа төлөөлөгчид маань яг ажлаа ингэж хийж чадаж байна уу, үгүй юу? Ажлыг нь яаж дүгнэж байна вэ? Ийм үед улс орны төсөв, орлого хүнд байгаа үед Гадаад хэргийн яам, та нөхөд хэрхэн улс орондоо тус болох юм бэ гэдэг асуултыг асууя.

Х.Булгантуяа: Б.Батцэцэг сайд хариулъя.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя.

Гадаад харилцааны яам нэн түрүүнд Монгол Улсын Гадаад харилцааны яам болон бусад Гадаад хэргийн яамдын гол үүрэг улс төр, дипломатын аргаар улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах үндсэн үзэл баримтлалтай байдаг.

Монгол Улсын Гадаад харилцааны яам өнөөдөр гадаад харилцаа сүүлийн жилүүдэд онцгой их тэлж байгаа. Та бүхэн мэдэж байгаа байх. Үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж байна. Манай дипломатуудын тоо өсөөгүй. Маш цөөхөн дипломатаар асар их ажлыг амжуулдаг. Бусад өөртэйгөө адилхан хөгжиж байгаа, манайх шиг хүн амтай, газар зүйн байрлалтай, улс төр болон геополитикийн сорилттой орнуудтай харьцуулахад бид доор хаяж 3-аас 4 дахин бага хүний нөөцтэй ажилладаг. Цалингийн хувьд ч гэсэн дэлхийн дунджаас 40 хувиар бага цалин авдаг. Гэсэн хэдий ч мэргэжилдээ дуртай, маш чадвар утаагаараа бид олон улсад манай дипломатууд гайхагддаг.

Энэ чадвараараа өнөөдөр гадаад харилцааг сайн авч явж байгаа.

Энэ олон айлчлал хийхийг би олон удаа сонслоо. Ингээд шүүмжилдэг. Зөвхөн айлчлал хийгээд л, эсвэл хүн тосож аваад сууж байдаг.

Айлчлал гэдэг нь өөрөө тайлбарлах шаардлагатай. Айлчлал гэдэг чинь аливаа улстай харилцаж байгаа харилцааны хамгийн оргил хэсэг нь байдаг. Энэ айлчлалыг ерөөсөө хүссэн үедээ зугаалах гээд юм уу, эсвэл нэг оронд очиж үзэх гээд хийдэггүй. Асар олон баримт бичиг, асар олон үйл ажиллагааг эцэслэж тохирч, үүнийгээ баталгаажуулах гэж ирдэг, эсвэл очдог.

Тэгэхээр энэ айлчлалуудыг бид өнгөрсөн 30 жилийн хугацаанд хүсээд ч хийж чаддаггүй, хүлээж авдаггүй, манайтай хамтарч ажиллахгүй гэдэг байсан. Уриад ч ирдэггүй. Манайтай хамтарч ажиллах салбар чиглэл байхгүй гээд.

Тэгэхээр энэ идэвхжээд байгаа нь өөрөө гадаад бодлого идэвхтэй явахаас гадна манай улс оронтой бүхий л салбарт харилцаагаа хөгжүүлж гэдэг гаднын улс орнуудын хүсэл эрмэлзлийн илэрхийлэл юм шүү гэдгийг эрхэм гишүүнд хэлж.

Хоёрдугаарт, бид дипломатуудтайгаа маш олон ажлыг нь дүгнэдэг. Хагас жил тутам тайланг нь авч байгаа. Эдийн засагжуулах бодлогын хүрээнд бид эхлээд дотооддоо манай Засгийн газар салбар бүрээрээ яамд аль улстай ямар асуудлаа ярих вэ, ямар худалдаа арилжааг аль улсдаа хийх вэ, ямар төслөө аль улсдаа хийх вэ. Манай уурхай болон хөдөө аж ахуйн бодлого маш тодорхой гарсан байх ёстой.

Хоёрдугаарт, манай аж ахуйн нэгжүүд хангалттай бойжиж, яг гаднын улс орнуудын стандартад таарсан бараа, бүтээгдэхүүнийг өнөөдөр үйлдвэрлэж гаргаж чадахгүй, чанар стандартыг нь тэр болгон хангаж чадахгүй байгаа. Цөөхөн нэр төрлийн бараа гараад, тэр нь олон чиглэлээр борлогдох боломж хомс байна. Тээвэр логистикийн асуудлууд байна.

Тэгэхээр бидний хувьд үндсэн худалдаа арилжаа, эдийн засгаа дэмжих, аж ахуйн нэгжүүдээ дэмжих баримт бичгүүд бүгд зурагдсан. Энэ олон хэлэлцээрүүд бүх эрх зүйн орчныг нь бүрдүүлсэн.

Одоо бид аж ахуйн нэгжүүдээ дэмжих ёстой. Экспортыг дэмжиж байгаа. Эдийн засгийн хөгжлийн бодлогуудаа, том төслүүдээ, салбар аж ахуйн яамд маань яг ямар бараа, бүтээгдэхүүнийг аль улстай яаж экспортлох вэ гэдгээ тодорхой гаргах.

Дипломатуудын хувьд даалгавраа авсан. Бэлэн байгаа. Хэзээд ажиллахад бэлэн. Хэний ч бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад бэлэн байгаа.

Бид мэдээж шилжиж байгаа улсын хувьд дипломатуудын манай хуучин тогтолцооноос шинэ тогтолцоонд, зах зээлийн эдийн засагт аж ахуйн нэгжүүдийг дэмжих ажил дээр соёлын хувьд тодорхой хугацаанд өөрчлөгдөж солигдох ийм хугацаа алдсан.

Өнөөдөр бид даалгавраа сайн зөв өгөх юм бол ажиллахад бэлэн болсон байгаа гэдгийг хэлж. Тодорхой хэмжээнд ажиллаж байгаа. Зөвхөн эдийн засаг, худалдааны чиглэлээр биш бусад зөөлөн хүчний бодлого маш сайн яригдаж байгаа. Соёл, боловсрол, аялал жуулчлал гээд... /минут дуусав/

Х.Булгантуяа: Н.Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Өнөөдөр манай 14 мега төслийг хэрэгжүүлэх төсөв хөрөнгө алга байна. Бүгдийг нь гаднын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх ийм л төслүүд байгаа.

Тийм учраас энэ төслүүдийг цааш нь хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах дээр Гадаад хэргийн яам, Элчин сайдын яам онцгой анхаарч сайн ажиллах ёстой.

Хоёрдугаарт, манай энэ 14 мега төслийн нэлээд хэсэг нь буюу ихэнх нь гадаад харилцаатай, бусад улс орнуудтай харилцах зайлшгүй шаардлагатай асуудал байгаа. Тухайлбал, усны төсөл, Орхон-Онги, Хэрлэн-Тоонот хоёр томоохон эдийн засгийг тэтгэх ийм төсөл байгаа. Энэ төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хоёр талтайгаа ярьж тохирох асуудлууд байгаа.

Тийм учраас Гадаад хэргийн яам цаашдаа эдгээр эдийн засгаа тэлэх, солонгоруулах ажил дээр түлхүү анхаарч ажилла... /минут дуусав/

Х.Булгантуяа: Н.Наранбаатар гишүүн санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Дахиад өдрийн мэнд хүргэе.

Гадаад хэргийн яамны сүүлийн 4, 5 жилийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгаа. Олон улсын том хэмжээний уулзалт, чуулганыг зохион байгуулж байна. Гаднын нэр хүндтэй зочдыг урьж байна. Удахгүй Японы Эзэн хаан айлчлахаар төлөвлөж байгаа. Ерөнхийлөгчийн урилгаар.

Ийм байдлаараа бид гадаад харилцаагаа улам өргөжүүлээд явах нь зөв гэж бодож байна.

- ▶ Тринидад ба Тобаго Улсын хувьд 1.3 сая хүн амтай.
- ▶ Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 28.0 тэрбум доллар буюу Монгол Улсаас нэг хүнд ногдохоор бараг 3 дахин их.

- ▶ Цөөхөн хүн амтай Карибын тэнгисийн арлын жижигхэн улс.

Бид гадаад харилцаагаа хөгжүүлэхдээ ийм жижиг орнуудын амжилттай явж байгаа буюу эдийн засгийн бодлого, ялангуяа уул уурхай, хөдөө аж ахуй гэсэн ийм салбаруудаа хэрхэн хөгжүүлж чадаж байгаа вэ?

Сая Барбадосын жишээн дээр хэлсэн. Аялал жуулчлалаа яаж хөгжүүлж чадаж байгаа вэ? Ийм туршлагаас нь судалбал их зүгээр гэж бодож байна.

Том гүрнүүдтэй хөрөнгө оруулалт татах талаар уулзалт хийнэ. Харин жижиг гүрнүүдтэй буюу Монгол Улстай ойролцоо хэмжээний хүн амтай улсуудтай тухайн улсын стратегийг нь сайн судлаад, манайд хэрэгжүүлэх боломжтой арга барилыг нь нэвтрүүлбэл зүгээр болов уу гэж бодож байна.

Тринидад ба Тобаго бол **CARICOM** /Caribbean Community/ гээд Карибын тэнгисийн улс орнуудын төв нь энэ улсад байдаг. Үүгээрээ бүс нутагтаа манлайлж чадаж байгаа улсуудын нэг болов уу гэж бодож байна.

Ялангуяа уул уурхайн салбар, газрын тос, **LNG** /Liquefied Natural Gas/ дээр маш тогтвортой уул уурхайн, ялангуяа хариуцлагатай уул уурхайн бодлогыг баримталж ирсэн. Тэр хүчиндээ ингэж хөгжиж чадсан улс.

Англи, Америк, Голланд, Франц, Канад гээд бараг бүх улсуудаас л хөрөнгө оруулалтыг татаж чадсан. Ялангуяа BP, Shell, BHP гээд уул уурхайн томоохон компаниуд ийшээ нэвтэрсэн байгаа.

Тэгэхээр манай улс Гадаад харилцааны яам дипломат харилцаагаа ингэж өргөжүүлэхтэйгээ зэрэгцүүлээд Уул уурхайн яам болон Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа хамтарч ажиллаад, яг энэ улсуудын технологи, know-how, арга барилыг нь судлаад, хамтарч ажиллах шаардлага нэлээн байна.

Тэгэхгүй бол Гадаад харилцааны яам ингээд үүдийг нээж өгөөд байдаг. Цаашдаа яг харилцаагаа өргөжүүлээд явах нь тухайн салбарын яаманд чухал байх ёстой.

Тэгэхээр ийм стратегийн төлөвлөгөө тал дээр нь тийм судалгаа хийдэг Гадаад хэргийн яам байна уу, бусад яамдуудтайгаа яаж харилцаж байгаа вэ? Аль болох хамтраад ажлын хэсэг байгуулаад, тухайн улсын салбарын стратегийг нь үзээд, хууль, эрх зүйн орчинд Монгол Улс сайжруулах зүйл юу байна. Тийм юмыг нэвтрүүлбэл их зүгээр гэж бодож байна. Ийм ганц асуулт байна.

Х.Булгантуяа: Б.Батцэцэг сайд хариулъя.

Б.Батцэцэг: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Таны саналтай 100 хувь санал нийлж байна. Бид хөгжиж байгаа орнууд. Сүүлийн үед манай гадаад бодлого тэлж байгаа. Бид сая Төв Азийн орнуудтай адилхан хөгжиж байгаа орнуудтайгаа 30-аад жил харьцаагүй шахуу зогссон байсан. Сүүлийн 2 жил яагаад ийм идэвхтэй байгаа юм бэ гэхээр бас л яг энэ бодлогынхоо хүрээнд бид адилхан хөгжиж байгаа орнуудад харилцан ярилцах,

харилцан бие биеийнхээ туршлагыг судлах, авах маш олон зүйл байдаг юм байна.

Аль алинд нь богино хугацаанд давуу тал гаргах, хөгжлийн хурдтай, хурд руу эрмэлзэж байгаа, амжилттай хэрэгжүүлсэн томоохон төслүүдээ бие биедээ хуваалцах, бие биедээ худалдаа арилжаагаа нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдээ холбох нь маш чухал бөгөөд илүү үр ашигтай юм байна гэдэг дээр санал нэг байгаа.

Сүүлийн энэ 4 улстай ч гэсэн бид онцлогуудыг нь судлаад, саяын энэ уул уурхайн чиглэл, энэ шингэрүүлсэн газрын болон жижигхэн улс мөртлөө маш олон улстай экспорт, импортоо хөгжүүлж байгаа туршлагыг нь судлах, салбар яамдтай холбож өгөх ажлыг хийгдэнэ.

Салбар яамдын тухайд манайх гаднын хөрөнгө оруулалт татах, гадаад улс орнуудтай харилцаагаа хөгжүүлээд баримт бичиг байгуулж байхад нэг зүйл орхигдоод байгаа нь гаднын хөрөнгө оруулалтын тухай хууль, манай банкны тухай хууль, энэ худалдааг дэмжсэн хуулиуд маань бусад улс орнуудынхаас илүү боловсронгуй ч юм уу, ижил хэмжээнд арай хүрээгүй байгаа нь өөрөө бас нэг төрлийн саад тотгор болж байгаа.

Хоёрдугаарт, нь бид бусад салбар яамдтайгаа Засгийн газрын түвшиндээ маш уялдаатай ажилладаг хэдий ч яамдад маань гадаад харилцаа хөгжөөгүй байгаа.

Тэгэхээр яамдынхаа гадаад харилцааг хөгжүүлэх нь их чухал. Яамд дээр жижиг хэлтсүүд байдаг. Тэр улсуудыг дээр үед манай дипломатууд бэлдээд сэлгэж ажиллуулдаг байсан. Энэ асуудал үндсэндээ орхигдсон.

Засгийн газар солигдох тоолонд хүмүүс нь солигддог, тогтворгүй байдаг. Гадаад харилцаатай холбоотой мэдээлэл нь тэр болгон үргэлжилсэн, тасралтгүй явдаг энэ байдал нь алдагддаг учраас цаашдаа яамдын гадаад харилцааг бэхжүүлэх тал дээр анхаарах ёстой. Мөн орон нутагт гадаад харилцааг бэхжүүлэх тал дээр Гадаад харилцааны яам анхаарч ажиллаж байгаа. Үүнийгээ цаашлуулна илүү төгөлдөр болгох чиглэлээр ажиллаж байна.

Х.Булгантуяа: Г.Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Товч тодорхой шийдэл хэллээ. Тантай санал нэг байна.

Энэ дээр нэг зүйлийг тодотгох гэсэн юм. Бид Япон Улстай 2016 онд эдийн засгийн хэлэлцээр байгуулсан. **EPA** /Economic Partnership Agreement/ гэж байгуулсан.

Уг нь манай улсын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, хөнгөн үйлдвэрлэлүүдийн бүтээгдэхүүнийг экспортолъё гэсэн зорилготой байсан боловч сүүлийн 10 жилд бид худалдааны алдагдал Япон Улстай маш ихэссэн. Ялангуяа хуучин машинуудын импорт. Тэр дотроо уул уурхайн хүнд тоног төхөөрөмжүүд мэдээж байгаа боловч төдийлөн манай улсын үйлдвэрлэл, экспортыг дэмжих хэмжээний хэлэлцээр болон үр дүн гараагүй гэж бодож байгаа.

Эдийн засгийн хөгжлийн яамтай ярихаар манай харьяалах асуудал биш ээ. Гадаад яамтай ярихаар бас биш ээ.

Тэгэхээр ингээд дунд нь хаягдаад байгаа асуудал байгаа. Ирэх жил энэ ЕРА хэлэлцээрийн 10 жил буюу хугацаа нь дуусах гэж байгаа. Энэ дээр үр дүнгээ тайлагнаж байгаад цаашдаа сунгах бол ямар засвар өөрчлөлтүүдийг хийх ёстой вэ гэсэн тийм шийдлийг боловсруулах боломжтой юу? Тэр байгаа юу?

Х.Булгантуяа: Б.Батцэцэг сайд хариулъя.

Б.Батцэцэг: Япон Улс манайд их нээлттэй. Бүхий л чиглэлээр хамтарч ажиллая гэдэг манай чухал гуравдагч хөршийн нэг. Тийм ч учраас Эзэн хаан айлчлах гэж байна. Өндөр түвшний харилцан айлчлалууд байнга тогтмол хэрэгжсээр ирсэн.

Би Гадаад харилцааны сайдын хувиар жоохон сөрөг юм ярьчхаж магадгүй. Ер нь бид нарт, асуудал дандаа өөрт байдаг. Манай дотоодод.

Тэгэхээр бид ЕРА-г байгуулаад 10 жил болж байхад бараа, бүтээгдэхүүнээ гаргаж чадахгүй байна гэдэг нь манай л дотоодын асуудал.

- ▶ Бид нарт бараа, бүтээгдэхүүн бэлэн биш байна.
- ▶ Үүнийг бид дотооддоо бодлогоор тууштай дэмжиж чадахгүй байна.
- ▶ Эрх зүйн орчноо сайн бүрдүүлж чадахгүй байна.

▶ Аж ахуйн нэгжүүдээ хөгжүүлж боломж бололцоог нь нээх, танилцуулах, сурталчлах тал дээрээ дутмаг байна.

Тийм учраас хэрвээ манай бараа, бүтээгдэхүүн экспортлох боломж байвал Япончууд үргэлж авъя, өөр ямар хөнгөлөлт, нөхцөл өгвөл гэж л ярина. Түүнээс биш сунгах асуудлыг одоо цаашдаа Эдийн засаг, хөгжлийн яам энэ бодлогыг гаргах ёстой. Бид бүгд... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун.

О.Саранчулуун: Монгол Улсад эрүүл мэндийн дэмжих сангаас зарцуулдаг гадаадад эмчлүүлдэг ийм хэдэн нэр төрлийн эмчилгээнүүд байгаа. Монголд эмчлэх боломжгүй учраас гадагшаа явж эмчлүүлдэг.

Монголд эмчлүүлэх боломжтой ч гэсэндээ заримдаа арга мухардаад ар гэр нь аваад явж байгаа, гадаад руу явж байгаа олон Монголчууд эмчилгээ хайдаг.

Солонгос руу маш олон хүмүүс явдаг. Хятад руу явж байна. Тайланд гээд янз бүрийн орнууд руу гадагшаа явдаг. Нөгөө талд харахаар гадаадад байгаа Монголын Элчин сайдын яамны үүргийг нь консулын туслалцаа үзүүлэх тэр эмчилгээ авч байгаа хүмүүст зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, тэдгээрийн бүртгэл хяналтыг хийх, мэдээлэл өгөх, чиглүүлэх энэ асуудал дээр нь бас нэг жоохон тодорхой статистиктай, тоотой мэдээлэл ер нь байдаг юм болов уу?

Яагаад гэхээр фэйсбүүк ч юм уу, зүгээр олон нийтийн хэрэглэдэг сүлжээ мэдээллийг харахаар тэнд байдаг монголчууд, эсвэл Хятад болон Өвөр Монголчууд ч юм уу эмчилгээ дээр нь туслаад ингээд холбон зуучлаад, заримдаа луйвардаад, заримдаа буруу тийш нь залаад ингээд улам их хохирол учруулж байгаа ийм асуудлууд маш их байдаг.

Хэдийгээр яах вэ, өнөөдөр хоёр улсын дипломат гэрээний асуудлыг ярьж байгаа боловч жишээлбэл Солонгост маш олон хүмүүс хорт хавдраар өвчин эмчилгээ хайж очиж байхад тэнд байгаа ер нь манай Монголын Элчин сайдын яам, консулын албадын үүрэг оролцоо. Японд жишээлбэл. Тийм ээ. Энэ тал дээр ер нь анхаарал дутмаг байдаг юм болов уу гэдэг ийм сэтгэгдэл, хандалтууд маш их байдаг.

Тэгэхээр энэ дээр ер нь ямар статистик гардаг юм бэ? Ямар бодлого байдаг юм бэ? Цаашдаа энэ дээр ер нь монголчууд энэ эмчилгээг хөөж их яваад байгаа. Хямдхан. Тийм ээ. Зардал нь арай төлж чадах хэмжээнд очоод байгаа энэ орнууд дээр шийдэж байгаа, сайжруулж байгаа зүйлс байна уу? Энэ талаар мэдээлэл өгнө үү?

Х.Булгантуяа: Б.Батцэцэг сайд хариулъя.

Б.Батцэцэг: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Тийм. Өнөөдөр манай Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Турк гэхэд голдуу эмчилгээний зорилгоор их аялал жуулчлал аялж байна.

Солонгост Улсад хамгийн ихэнх нь байгаа. Ковидын дараа Хятадад эмчлүүлэх хүмүүсийн тоо буурсан.

Яг танд би өнөөдөр тэдэн хүн тэнд эмчлүүлсэн гэхийг хэлэх боломжгүй. Энэ нэгдүгээрт өөрөө хувь хүмүүсийн өөрсдийнх нь шийдвэр болохоор тэр болгон Элчин сайдын яаманд мэдэгддэггүй. Элчин сайдын яаманд хандахаа зарим иргэд маань мэддэггүй.

Ингээд Солонгост байгаа Элчин сайдын яам иргэдийн асуудал маш их байдаг. Одоо нийтдээ 60 гаруй мянган Монгол хүн байна. Тал нь бараг хууль бусаар оршин сууж байна.

Монгол Улсаас явж байгаа иргэд голдуу хамгийн хүндэрсэн шатдаа хавдрын өвчлөлтэй хүмүүс ихэвчлэн явж эмчлүүлдэг. Эмнэлгээ зөв олсон тохиолдолд азтай байдаг. Зарим нь янз бүрийн эмнэлэгт очоод хохирч байгаа иргэд байдаг. Энэ эрүүл мэндийнх нь, аялал жуулчлалынх нь бодлогын хүрээнд энэ өөрөө эрүүл мэнд нь бизнесийн үйлчилгээ учраас Солонгос Улсад гаднын иргэдэд даатгал үйлчилдэггүй. Даатгалдаа хамруулж өгөөч гэдэг хүсэлтийг бид тавьж байсан. Даатгалыг Монгол Улсын иргэдэд буюу гаднын иргэдэд хамруулдаггүй юм билээ.

Тийм болохоор их өндөр үнэтэй болдог. Гэсэн хэдий ч одоо ингээд эмчилгээ хийлгэдэг. Бас гоо сайхны аялал жуулчлалын чиглэлээр гоо сайхны хагалгаанд манай иргэд маш их ордог. Өөрөөр хэлбэл манай иргэдийн Монголд хөдөлмөр эрхлээд оруулж ирж байгаа мөнгөнөөс бараг илүү мөнгийг манай иргэд Солонгос Улсад аваачиж тушааж байна.

Тийм учраас манай иргэдэд визийн хөнгөлөлт үзүүлээч ээ гэдэг энэ асуудлыг бид байнга тавьсаар ирсэн.

Элчин сайдын яам тэнд байгаа монгол иргэд, мөн зорчиж байгаа иргэддээ анхааруулга, сэрэмжлүүлэг, мэдээлэл зөвлөгөө өгье гэдэг нь нээлттэй болохоос биш яг зохион байгуулалтад ороод эмчлүүлж байгаа хүмүүстээ эмнэлгийг нь олж өгөх барих тийм боломжууд байхгүй.

Бид Эрүүл мэндийн яамтай бас яриад ер нь цаашдаа сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр, дээрээс нь Солонгос хэлтэй эмч мэргэжилтэй хүнийг дипломат төлөөлөгчийн газартай ажиллуулж тэнд байгаа иргэдийн эмчлүүлж байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, зөвлөгөө өгөх, зөв эмнэлэгт нь хүргэх, дээрээс нь даатгал, төлбөр дээр нь зөвлөгөө өгөх гэх мэт ийм асуудлыг ярьсан.

Тэгэхээр ирэх жилээс бид яг Эрүүл мэндийн яамнаас мэргэжлийн хүнийг дипломат албанд томилох ийм бодлого гаргасан байгаа.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Турк дээр эмчлэгдсэн хүмүүсийн тоог би судлаад жич эргээд хэлье.

Х.Булгантуяа: О.Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. Тийм. Одоо жишээлбэл яах вэ хүмүүс аргаа бараад л явж байгаа хүнд хүмүүс байгаа. Тэр гоо сайхны зорилгоор гэдэг хүмүүсийг бизнесийн зорилгоор явж байгаа.

Гэтэл Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй байна гэдэг нэлээн хүнд кэйс.

Тэгэхээр ийм хүнд кэйстэй явж байгаа хүмүүсийн хувьд Эрүүл мэндийн яамнаас дэмжих сангаас дэмжлэгээ авахын тулд маш олон материалыг бүрдүүлж, маш олон замыг туулж байж энэ материалыг бүрдүүлж явдаг. Тэгээд тэрийг нь орчуулахаас өгсүүлээд л өдөр, цаг хормоор хэмжигдэж байгаа. Нөгөө амь насыг нь аврах гээд л ар гэр нь байдаг юмаа дайчлаад явж байгаа.

Яг энэ зохицуулалт, яг энэ хэсэг дээр нь манай гадаадад байгаа консул, Элчин сайдын ажлын алба туслалцаа үзүүлэх, ядаж л итгэмжлэгдсэн эмнэлэг энэ шүү гэдэг. Монголд эмчлэгдэхгүй эмчилгээнүүд нь ядаж энэ гэдэг мэдээллүүдийг өгвөл иргэдэд аягүй хэрэгтэй байх л гэж бодож байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: О.Саранчулуун гишүүн санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалтыг мөн Байнгын хороо дуусахаар хамтад нь явуулъя.

Дараагийн асуудалдаа оръё.

**Зургаа. “Бүгд Найрамдах Ботсвана Улстай
дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/**

Зургадугаар асуудал. “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг танилцуулна.

Индэрт урьж байна.

Б.Батцэцэг: Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай хамтарсан мэдээнд 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр гарын үсэг зурсан.

1966 онд тусгаар тогтнож Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнээр элссэн.

Ботсвана Улс нь колоничлолоос ангижирч, шинээр тусгаар тогтносон Африкийн улс орнуудтай харьцуулахад тогтвортой улс төрийн тогтолцоо бүхий орны тоонд зүй ёсоор ордог.

Далайд гарцгүй. Байгалийн баялгийн нөөц ихтэй. Алмаз болон зэс, никель, нүүрс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний томоохон экспортлогч Ботсвана Улс Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эрх ашгийг хамгаалах чиглэлд идэвхтэй ажилладаг.

Тус улстай дипломат харилцаа тогтоосноор Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд далайд гарцгүй хөгжиж буй орнуудын ашиг сонирхлыг хамгаалах зэрэг нийтлэг ашиг сонирхлын төлөө харилцан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах боломж нэгдэх юм.

Иймд “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ингэснээр манай улсын Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх 192 оронтой дипломат харилцаа харилцаа тогтоох зорилт бүрэн хэрэгжиж байгаа юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллага бүх гишүүн улстай дипломат харилцаа тогтоосон улс орон цөөн байдаг бөгөөд энэ нь манай улсын идэвхтэй дипломат үйл ажиллагаа, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын чухал илэрхийлэл юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хажекберийн Жангабыл танилцуулна.

Индэрт урьж байна.

Х.Жангабыл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоосноор хоёр талын харилцааг хөгжүүлэх, хоёр талын болон олон талт тогтолцооны хүрээнд нийтлэг эрх ашгийн төлөө харилцан дэмжлэг үзүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

“Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Одоо хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдолтой асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Агваанлуvsангийн Ундраа гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг. Б.Батцэцэг сайд аа, өмнөх дипломат харилцаа тогтоох тогтоолууд дээр асуусан. Та Байнгын хорооны хурал давхцаад хариулт авч чадаагүй. Би тодруулаад асууя гэж байгаа юм.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орнуудтай дипломат харилцаа тогтоож, найрсаг харилцаа тогтоох нь чухал байгаа. Ингэснээрээ бид олон улсад НҮБ-ын бүх орнуудтай дипломат харилцаа тогтоосон цөөхөн орны нэг болж байгаа байх.

Гэхдээ ер нь зүгээр энэ айлчлалууд сүүлийн үед нэлээн идэвхжиж байгаа. Бас өндөр түвшинд гарч байна. Харин энэ айлчлалууд дээр хийгдэж байгаа зүйлүүд биелэхгүй байгаа дээр эмзэглүүлж байгаа зүйлүүд байна. Үүний нэг жишээг сая А.Ариунзаяа дарга иш татаад жишээ яриад ярилаа.

Тэгэхээр юу ярих гэж байна гэхээр бид хэд энэ айлчлал гэдэг бол энэ дипломат харилцаа тогтоосны өндөр түвшинд очсоны илэрхийлэл өгөөд байгаа. Тэгэхдээ энд яригдсан зүйлүүд биелдэг байхгүй бол Монгол Улсын нэр хүнд чинь аажимдаа буурах, Монголчууд гэж нэг худалч, хэлсэн амандаа хүрдэггүй гэдэг энэ имиж ер нь бүрдэх тал руугаа маш олон зүйлүүдээр явж байна.

Тэгэхээр бид хэд үүнийг анхаармаар байгаа юм.

Тэгэхээр үүний цаана миний хэлэх гэж байгаа санаа энэ гадаад харилцаагаараа дамжуулаад энэ эдийн засагжуулалт, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх асуудлаа нэлээн анхаарах шаардлага байна. Өөрөөр хэлэх юм бол Монгол Улсаас гадаадад сууж байгаа Элчин сайдаасаа эхлээд Элчин зөвлөхүүд, атташениудыг ерөнхийдөө тийм эдийн засаг, хөрөнгө оруулалтыг, Монгол Улсын эдийн засаг, хөрөнгө оруулалтад ямар хувь нэмэр оруулсан бэ гэдгээр нь ажлуудыг нь тодорхой түвшинд үнэлдэг баймаар байна.

Монгол Улсын гадаад паспортыг хэр хүчирхэг болгосон бэ гэдгээр нь үнэлдэг болмоор байна.

Өнөөдөр Монгол Улс 200-аад улс орнуудын гадаад паспортоор 69-д эрэмбэлэгдэж байна. Энэ нь өөрөө эргээд Монгол Улсын иргэд энэ улаан паспортоороо хэчнээн оронд визгүй нэвтэрдэг вэ гэдэг л энэ асуудал шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлуудыг бид Элчин сайдын баг хамт олон хэрхэн яаж тухайн улсдаа зохион байгуулж байгаа вэ гэдгийг ажлын үзүүлэлт болгомоор байна. Ингэхгүй бол гадаад харилцааны салбар дахь хүмүүсийн томилгоог зарим талаараа олон нийт их шүүмжилдэг. Үүнийг цаашдаа эдийн засгийн харилцаагаар баяжуулж өргөжүүлэх, Монгол Улсын иргэдийн зорчих эрхийг нэмэгдүүлэх чиглэлд бид анхаармаар байна.

Тэгээд миний хэлэх гэж байгаа санаа ерөнхийдөө зарим Элчин сайдууд болоод эдийн засгийн асуудал хариуцсан гэдэг юм уу, худалдааны зөвлөх, атташениудыг энэ Худалдаа, аж үйлдвэрийн санал болгосноор томилдог ч гэдэг юм уу.

Тэгэхээр бид хэд үүнийг шийдэхийн тулд танхимын хуулиа шинэчлэхээс өөр аргагүй байгаад байгаа юм. Ингэж байж бид нэг жоохон бизнесийн BACKGROUND-тай хүмүүсийг явуулж энэ асуудлуудыг анхаарах тийм бололцоо байх уу? Энэ дээр та ямар бодлого байгаа вэ гэдэг зүйлийг нэгдүгээрт хэлээч.

Тэгэхээр би энэ ажлын үзүүлэлтүүдийг ингэж дүгнэмээр байна.

Хоёрдугаарт, бид хэд Дэлхийн оюуны өмчийн байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага дээр Монгол Улсыг төлөөлж суудаг хүмүүсийн орон тоог гаргаж ирмээр байна. Дэлхийн оюуны өмчийн байгууллага гэдэг тэр чигтээ

ноу хау, технологи, инновац, эмийн патентын бүртгэл байгаа. Энэ дээр бид жинтэй хувь нэмэр үзүүлж байх ёстой байхгүй юу.

Сая Ази, Номхон далайн бүсээ тэргүүлэх боломж байсан. Бид үүнийг алгаслаа. Харамсалтай. Энэ өөрөө эргээд үсгийн дарааллаар ирдэг. Одоо ойрын хэдэн жилдээ Ази, Номхон далайн бүсэд Дэлхийн оюуны өмчийн байгууллага дээр бид тэргүүлэх боломжгүй байгаа. Ийм алтан боломж гараад ирж байхад бид ингээд алгасчхаж байгаа байхгүй юу. Тэгээд үнэхээр харамсалтай байна.

Тэгээд улс орнуудын худалдааны бодлого хэрхэн яаж өрнөж байгаа асуудал Дэлхийн худалдааны байгууллага дээр шийдэгдэж байгаа. Энэ дээр бид хүн хүч томилдог байх асуудлыг цаашдаа Гадаад хэргийн яам маань анхаараач ээ. Энэ дээр хүн хүчийг нэмэгдүүлэх асуудал баймаар байна.

Түүнээс биш Женев дэх Элчин сайдын яамны хэдэн хүмүүс нь давхар энэ Дэлхийн худалдааны байгууллагыг хариуцаж явна гэдэг зүгээр нэр төдий оромдож байгаа асуудал байгаа шүү. Тэгээд асар их бид мэдээллийг алдаж байна. Чиг хандлагууд яаж өрнөх гэж байгааг бид хэд алдаад байна.

Тэгэхээр энэ... /минут дуусав/

Х.Булгантуяа: П.Сайнзориг гишүүн үг хэлчих үү? Б.Батцэцэг сайд хариулъя.

Б.Батцэцэг: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт нь, айлчлалуудаар маш олон баримт бичиг зураад олон ажил ярьдаг. Орон болгон тэр тэр чиглэлээр тийм юм хийе гээд ярьдаг. Ер нь дэлхий даяараа гадаад харилцаа их прагматик болж байгаа. Бүр супер прагматик гэж хэлж болно. Маш бодитой харилцаануудыг улс орнууд ярьдаг болсон. Үүнийг бүх Гадаад харилцааны яамд дэлхий даяараа хоорондоо хэрэгжүүлээд эхэлсэн.

Тэгэхээр бид энэ улстай юу ярих вэ, яах вэ гэдгээ бид бодлогын түвшинд Засгийн газар маш тодорхой гаргах ийм цаг үеийн шаардлагууд байгаа.

Тэгэхээр сүүлийн айлчлалууд Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улс оронд Монгол Улсыг төлөөлөх цорын ганц хүн бөгөөд тэргүүн дипломат гэж явдаг. Олон улсад ийм жишгээр.

Тэгэхээр энэ манлайллийг хангалттай сайн үзүүлж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар олон улсууд Ерөнхийлөгчийн түвшинд айлчлал хийхэд өндөр хэмжээнд асуудлуудыг тохирдог.

Тэгэхээр бид сүүлийн жилүүдийн айлчлалуудад яг хэрэгжиж болох, яг үүнийг хийе гэсэн асуудлуудаа ярьж тохирч байгаа нь өөрөө илүү прагматик,

бодитой, хэмжиж болох, тэгээд үр дүн гаргах ажлуудаа тохирч байгаа. Өмнөх шигээ бүх оронтой нэг төслөө яриад юм уу, бүх оронтой чадах, чадахгүй бүх асуудлыг ярьдгаа больсон юм шүү гэдгийг хоёрдугаарт хэлье.

Мэдээж биелүүлэхийн төлөө Засгийн газар чармайж бүх яамд гадаад харилцааны талаар нарийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй, ойлголцдог, хоорондоо уялдаа холбоо сайтай, салбар дундын уялдаа холбоо сайтай байж гадаад харилцаанд оролцоогоо нэмэгдүүлэх юм бол үр дүн нь илүү гарна гэдэг дээр санал нэг байна. Энэ чиглэлээр үргэлжлүүлээд онцгой анхаарч ажиллана.

Элчин сайдын яамдын дипломатууд дотор Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсанаас Эдийн засаг, хөгжлийн яамнаас мэргэжлийн худалдаа, эдийн засаг, санхүүгийн мэдлэгтэй хүмүүс томилох асуудал яригдаад, томилолт аваад явж байгаа. Женевт жишээлбэл Сангийн яамнаас яг энэ орон тоон дээр мэргэжлийн хүн ажилладаг.

Тэгэхээр Сангийн яамнаас нийтдээ 11 газар байна уу, томилолттой байдаг.

Тэгэхээр энэ хүмүүс илүү эдийн засаг, худалдааны чиглэлээрээ мэргэшсэн хүмүүс явдаг жишигтэй. Үүнийгээ мэдээж сайжруулах ёстой.

Өнөөдрийн байдлаар бид Худалдаа, аж үйлдвэрийн танхимын төлөөллийг суулгана гэсэн бодлого байхгүй. Ер нь санааг ойлгож байна. Бид илүү бизнес мэдрэмжтэй ийм хүмүүсийг томилох тал дээрээ Эдийн засаг, хөгжлийн яамны томилгоог нэмэгдүүлэх, ийм мэргэжлийн хүмүүсийг бэлдэж, хэлтэй устай хүмүүсийг явуулах тал дээр анхааръя.

Олон улсын байгууллагуудын төлөөлөл болгоныг гадаадад суулгах боломжгүй. Бүхий л дэлхий даяар дипломат төлөөлөгчийн газрууд, дипломатууд энэ асуудлуудаа хуваарилаад ажилладаг. Энэ чиглэлээр тодорхой хэмжээнд мэргэшдэг.

Бид олон улсын байгууллага, одоо жишээлбэл олон улсын эрүүгийн шүүх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын харьяа олон улсын байгууллагуудад Монгол хүн нэр дэвшихийг маш их дэмжиж байгаа улс. Үүнийг бүр бодлогоор дэмжиж, тодорхой зардал гаргаж, улс хооронд дипломат аргаар лобби хийж байж энэ хүмүүсийг өндөр түвшинд гаргаж ажиллуулах юм бол эргээд Монгол Улсын хөгжил ирээдүйд маш чухал гэж үздэг.

Тийм учраас сүүлийн жилүүдэд бид хэзээ ч гарч байгаагүй өндөр түвшинд Монгол хүмүүс тодорхой хэмжээгээр томилогдож байгаа. Хэрвээ цаашдаа эрхэм гишүүн болон манай бусад гишүүдэд, олон улсын байгууллагуудад худалдааны ямар ч төрлийн байсан Монгол хүн нэрээ дэвшүүлэх боломжтой байгаа бол бид нарт уламжлаад бид бүх л чиглэлээр нь дэмжээд ажиллаад харилцан улс

орнуудтай бие биеийгээ дэмждэг тогтолцоо байдаг. Энэ чиглэлээр нь дэмжээд ажиллана.

Харин дуртайяа олон улсын байгууллагуудад Монгол иргэнээ ажиллуулахыг ажиллана гэдгээ хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал.

Ж.Золжаргал: Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсуудтай бүгдтэй нь дипломат харилцаа тогтоох зорилго их чухал зорилго.

Тийм учраас Ботсвана Улстай харилцаа тогтоохыг дэмжиж байгаа. Их сонирхолтой. Хамтын ажиллагаандаа анхаарвал их сонирхолтой ийм онцлог улс. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улстай хил залгаа байдаг. Манайхтай нэлээн төстэй юмнууд ихтэй.

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс өөрийнхөө шатахууныг, түлшийг нүүрснээс үйлдвэрлэдэг. Одоо 70 жил үйлдвэрлэж байгаа.

XX зууны дунд үеэс хойхно хоригт оронгуутаа бид гадаадаас нефть бүтээгдэхүүн авч чадахгүй юм чинь нүүрснээс бензин үйлдвэрлэнэ, дизелийн түлш үйлдвэрлэнэ гээд үйлдвэрлэсэн. Одий болтол 70 жил ажиллаж байгаа.

Ботсвана Улс яг энэ замаар бас нүүрсний их нөөцтэй улс. Тэгээд үүнийг нэвтрүүлэхийн тулд яг одоо технологи нэвтрүүлээд, эрх зүйн орчин, татвар дээрээ ажиллаж байгаа.

Энэ талаар манай Засгийн газар, харьяалсан сайд нар нь анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Монголын хамтын ажиллагаа нь ч бай, урт хугацааны бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй байна л даа. Тэгээд тэр бодлого энэ 100 жил нүүрс нь байдгаараа байж л байна. Газрын тосны үйлдвэр өөрөө түүхий эд нь эрсдэлтэй байгаа. Нэлээн олон асуудалтай байгаа. Тэгэхээр Африкийн энэ улс чинь бас нүүрсэн дээрээ анхаараад байгаа. Бид нараас хамаагүй урагшаа явсан. Бид бас энэ нүүрснийхээ шингэн түлш, материал үйлдвэрлэх хүнд үйлдвэрийн суурийг одоо тавьж авах, үүнтэй холбоотой бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Энэ тал дээр анхаараарай гэж хэлье. Асуулт байхгүй.

Х.Булгантуяа: Ж.Золжаргал гишүүн санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Агваанлуvsангийн Ундраа.

А.Ундраа: Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох зорилгоо биелүүлж байгаа Гадаад харилцааны яамны хамт олонд баяр хүргэе.

Тэгээд Ботсвана бол бас их чухал улс байгаа. Ялангуяа манайтай их төстэй эдийн засгийн бүтэцтэй. Тэгээд зөв бодлого баримталсан. Хөгжлийн хувьд биднээс урд явж байна гэж би хардаг. Жишээлэхэд уул уурхайн чиглэлээр сая Ботсвана “**De Beers**” компанитай бүтэн 10 жил хэлэлцээр хийгээд уул уурхайн 2052 он хүртэлх амжилттай хэлэлцээрийг байгуулж чадсан. Эндээс суралцах, авууштай тийм саналууд нэлээн байгаа гэж харж байгаа.

Бид Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ, хувь, хувьцаа эзэмшигчдийн гэрээний асуудал бас ингээд Их Хурлын түвшинд түр хороо гээд яригдаж байгаа үед энэ эдийн засгийн төстэй болон давуу, эсвэл сул тал дээр анализ хийж үзэх нь зүйтэй юм уу гэж бодож байна.

Тэгээд асуулт бол Ботсванагийн асуудлыг хаанаас хамаарах вэ? Бид нийт НҮБ-ын гишүүн орнуудтай ингээд хэлэлцээр байгуулаад хамт дипломат харилцаа тогтоосны дараа Африк тивд Элчин сайдын яамтай байх, тэндээсээ хамаарах. Өмнөд Америк тивд Элчин сайдын яамтай байх, тэндээсээ хамаарах зэрэг ийм чиглэл ер нь барьж ажиллах нь зүйтэй юм уу гэсэн байр суурьтай байдаг.

Яах вэ, мэдээж төсөв, санхүү хязгаарлагдмал юм уу, эсвэл төсөв танаж байгаа энэ цаг үед үүнийг ярих нь хэцүү байх. Гэхдээ эдийн засаг сайжрах байлгүй гэсэн тийм өөдрөг бодолтой байна.

Тэгэхээр Элчин сайдын яам нээх тийм чиглэл баримталж байгаа юу? Хэрвээ тэр хугацаандаа нээх бололцоогүй байгаа энэ цаг үед өргөмжит консул томилох асуудлыг судалж үзэх талаар ажиллаж байна уу? Цаашдаа салбарын сайд ямар байр суурьтай байна?

Соёлын элч томилох асуудлыг илүү өргөн хүрээтэй ашиглах юм бол манай гадаад харилцааг болон бусад олон асуудалд дэмтэй юм уу гэж харж явдаг. Энэ дээр таны байр суурийг асууя. Баярлалаа.

Х.Булгантуяа: Б.Батцэцэг сайд хариулъя.

Б.Батцэцэг: А.Ундраа гишүүндээ баярлалаа. Үргэлж гадаад харилцааг дэмжиж, ойлгож байдаг талархаж байна.

Мэдээж Ботсвана их сонирхолтой улс. Манайхтай их төстэй. Бид энэ богино хугацаанд туршлага солилцох. Одоо ер нь харилцан албан айлчлалууд эхэлсэн явж байгаа. Ажлын түвшиндээ салбар яамд.

Тэгэхээр Ботсвана Улстай бид сайн туршлагууд, хууль эрх зүйн орчин, ялангуяа уул уурхайн бодлого, банк, хөрөнгө оруулалтынх нь бодлого маш сонирхолтой. Манайд бараг шууд аваад хэрэгжүүлэхээр юм билээ.

Түрүүн би гишүүдийн асуултад хариулж байхдаа бодож байсан. Бид төстэй гээд Эстонийн загвараар манай өмнөх Л.Оюун-Эрдэнэ сайдын Засгийн газар цахимжилтын бодлогыг бид судалж үзээд, одоо үнэхээр хамгийн бест нь юм байна гээд сонгоод авч байсан. Амжилттай болсон.

Түүн шиг бид саяын дипломат харилцаа тогтоож байгаа улс орнуудтай яг онцлог онцлог салбарынх нь туршлагыг судлах, сайн загварыг нь судлах ажлыг хамгийн түрүүнд эхлүүлнэ.

Бид ер нь гадаад бодлогынхоо тэлэх хүрээндээ Африкийг ер нь нэлээн олон жил орхигдуулсан. Бид Төв Ази руу тэлэх бодлогынхоо хүрээнд Узбекистанд Элчин сайдын яам өнгөрсөн жил нээсэн. Тийм ээ.

Тэгэхээр бид яг одоо Африкийн орнууд, тэр тивд нэг Элчин сайдын яам нээе гэдэг судалгааг хийж байгаа. Нигер, Кени, Өмнөд Африкийг бид нэлээн нарийн судалсан.

Тэгэхээр энэ 3 улсын нэгд нь Элчин сайдын яам нээхээр тэндээс Ботсванаг хамаарна.

Одоохондоо Элчин сайдын яам байгуулах төлөвлөгөө Ботсванад байхгүй. Бид үүнийг Нью-Йоркоос хариуцаж хамаарч ажиллах болно.

Өргөмжит консулын асуудлыг бид судалж байгаа. Өргөмжит консул бид эхний ээлжид томилж ажиллуулна. Тэгж байгаад цаашаагаа бид Элчин сайдын яам Африк тивд аль нэг оронд нь ирэх жил байгуулах өөдрөг төлөвлөгөөтэй байгаа.

Энэ жилийн хувьд бид Испани болон Индонезод Элчин сайдын яам нээж байгаа. Тэгээд Латин Америкт бид Бразилд эргэж нээх асуудлыг ярьж байгаа. Тэгээд харамсалтай нь төсөвтэй холбоотой энэ жил Испаниа нээж чадахааргүй болж байна.

Тэгэхээр дараа жил бид 3 Элчин сайдын яам нээхэд гишүүдийг энэ гадаад харилцааг тэлэхэд манай төсөв дээр анхаарч өгөөрэй гэж хүсэж байна. Бодлогын асуудлууд яригдаж байгаа учраас. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Санал хураалтыг нэгтгэн явуулъя. Дараагийн асуудлыг хэлэлцье.

Долоо.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай асуудал

Долдугаар асуудал. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай асуултыг хэлэлцэж эхэлье.

Нэр дэвшигчийн талаар гаргасан Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал танилцуулна.

Индэрт урьж байна.

Б.Заяабал: Монгол Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Төсвийн байнгын хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд Өвгөнхүүгийн Гэрэл-Одыг Улсын Их Хуралд санал болгосон.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсголыг зохион байгуулахтай холбогдуулан дараах ажиллагааг явуулсан болно.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйл, мөн хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.2 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулахаар товлож, 14 хоногийн хугацаанд сонгол оролцогчдыг бүртгэх болон нэр дэвшигчээс асуух асуулт:

1.Нэр дэвшигчийн талаарх саналыг хүлээн авахаар сонсголын зарыг олон нийтэд хүргэсэн.

2.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал даргалж, сонгол, Төсвийн байнгын хорооны гишүүд нэр дэвшигч Ө.Гэрэл-Од болон зарын дагуу бүртгүүлсэн 1 оролцогч, 4 ажиглагч иргэн оролцсон болно.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигч Ө.Гэрэл-Одыг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэж дэмжсэн болно.

Нэр дэвшигчийн сонголын тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулан, Их Хурлын нийт гишүүд нэр дэвшигчдэд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр Өвгөнхүүгийн Гэрэл-Одыг томилохыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга, нэр дэвшигчийн сонголын тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Өвгөнхүүгийн Гэрэл-Од хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаар тасалъя.

Л.Соронзонболд гишүүн, 3 гишүүн. Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд.

Л.Соронзонболд: Санхүүгийн зохицуулах хорооны нэр дэвшигчийг дэмжиж байна.

Тэгэхээр өөрөө багш хүн байгаа. Энд санхүүгийн салбарт энэ чиглэлээр нэлээн судалгаа хийсэн.

Тэгэхээр Санхүүгийн зохицуулах хорооны одоогийн ажиллаж байгаа ажил дээр ялангуяа энэ хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар шинэлэг зүйлс юу хийх шаардлагатай байна гэж харж байна вэ гэдэг дээр нэг асууя.

Х.Булгантуяа: Нэр дэвшигч 4 номерын микрофоноос хариулъя.

Ө.Гэрэлт-Од: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Өнөөдөр компаниудын хувьцааны арилжааны идэвхжил анхдагч арилжааны хэлбэрээр маш сул байгаа. Харин хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас хэлбэрээр актив дахин борлуулах, арилжаалах хэлбэрийн үнэт цаасны арилжаа сүүлийн үед нэлээн идэвхжиж байна.

Тэгэхээр ер нь анхдагч зах зээлийн арилжааг нэмэгдүүлснээрээ биржийн арилжааг, биржийн үйл ажиллагаа, Хөрөнгийн захын үйл ажиллагааг нэмэгдүүлэх боломж нэмэгдэнэ. Өнөөдөр үүнийг нэмэгдүүлэх гол боломж нь өнөөдөр бүртгэлтэй байгаа компаниудын үнэлгээ нэлээдгүй хэмжээгээр нэгдүгээрт нэмэгдэж байгаа.

Хоёрдугаарт, ер нь хөгжлийн тодорхой үе шатад хүрсэн компаниуд компанийн засаглалаа сайжруулж, өнөөдрийн ажиллаж байгаа засаглалын статусаа хязгаарлагдмал хариуцлагатай компани бус хувьцаат компани хэлбэрээр ажиллах энэ орчин нөхцөлийг бүрдүүлэхэд гол анхаарч ажиллах нь зүйтэй гэж бодож байгаа.

Тэгэхээр ер нь өнөөдөр үнэлгээ өндөртэй компаниуд зөвхөн үнэлгээ өндөртэй бизнесийн бүлэглэл, бизнес компаниуд хувьцааныхаа арилжаанд оролцох үйл ажиллагааг эрх зүйн зохицуулалтын хүрээнд нээлттэй болгох, тэдгээрийг дэмжих чиглэлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь зүйтэй гэж бодож байгаа.

Х.Булгантуяа: Л.Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

Л.Соронзонболд: Ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдыг Монголын хөрөнгийн зах зээл рүү татах талаар нэлээн сайн анхаарах ёстой байгаа. Дээрээс нь зөвхөн Улаанбаатар хотод үйлчилгээ явуулдаг компаниуд их анхдагч арилжаанд хувьцаа гаргаж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг энэ хөрөнгийн зах зээл рүү татах дээр нэлээн сайн анхаарах шаардлагатай байгаа юм болов уу. Ялангуяа тэр хөрөнгийн зах зээл дээр гарахтай холбоотой одоогийн дэд бүтцийн байгууллагууд руу өргөдлөө өгөөд шийдвэрлүүлж байгаа хугацаа, гаргаж байгаа зардал нь аягүй өндөр байна гэдэг ийм асуудал их яригдаад байгаа юм.

Энэ дээр Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо гээд байгууллагуудаас нэлээн шүүмжлэлтэй ханддаг юм билээ.

Тэгэхээр энэ тал дээр хэрвээ сонгогдох юм бол анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна.

Х.Булгантуяа: Л.Соронзонболд гишүүн санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: Би нэг ийм процессын юмыг ярих гэсэн юм.

Ер нь нэр дэвшигчийг дэмжиж байгаа. Одоо энэ дээр Байнгын хороо ажиллаад ирсэн. Зүгээр бид хэд зарим хуулиудыг зөрчиж гэдэг юм уу, үл тоож энэхүү томилгоог хийж байгаа.

Ер нь анх Санхүүгийн зохицуулах хорооны бие даасан хуулийн 11 дүгээр зүйл дээр хорооны орон тооны бус гишүүнд хэн нэр дэвшүүлэх вэ, яагаад нэр дэвшүүлэх вэ гэдэг зүйл заалтууд байдаг.

Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 1 хүнийг дэвшүүлэх ийм заалттай. Тэгээд тухайн үед Сангийн сайд газрын даргаа Лувсандоржийн Сонор гэдэг залууг дэвшүүлсэн.

Улс төрчид энэ залууг маш ихээр гуйвуулж, доромжилж, гүтгэж, тэгээд дэмжээгүй.

Улмаар Улсын Их Хурлаас дэмжээгүй бол 14 хоногийн дотор дараагийн хүнийг оруулж ирнэ гэдэг энэ хуулийн хугацаа заасан заалтуудыг ч гэсэн бид зөрчиж хэзээ хойно энэ асуудлыг оруулж ирж байгаа нь Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүд дээр, ер нь энэ хорооны гишүүд дээр ямар их улс төр, ямар их эрх ашиг явж байна вэ гэдэг нь харагдаж байна гэж дүгнэж болохуйц байна.

Л.Сонор гэдэг залуу Монгол Улсын нэр хүндийг олон улсад маш өндөрт өргөж явж байгаа. Монгол Улсын хамгийн хүнд үед Засгийн газрын өмнөөс маш хүнд хэлэлцээрүүдийг хийж, Монгол Улсад маш хэрэгцээтэй бодлогуудыг явуулж байсан хөшигний ар дахь манай шилдэг боловсон хүчин мөн байсан.

Би яагаад байсан гэж хэлж байгаа вэ гэхээр Л.Сонорыг бид алдсан. Л.Сонор Сангийн яамнаасаа гараад олон улсын банканд уригдаад ажиллаж байгаа.

Тэгэхээр Л.Сонор шиг ийм залуучууд улс төрчдийн золиос болж байгаа нь үнэхээр харамсалтай.

Тэгэхээр үүнийгээ ч гэсэн бид маш сайн ойлгох хэрэгтэй. Хуулиар аливаа хамаатан садан, амраг дүү, албан тушаалд ажиллах хориглосон заалтууд байгаа. Нийтийн ашиг сонирхолд гээд хуулийн заалтууд байгаа. Түүнийгээ бид сайн уншиж ойлгож, хэнд хамаатуулах вэ гэдгийг хуулийн хязгаартаа шүүмжүүдээ хэлдэг байх ёстой. Хэн нэгнийг хэлмэгдүүлж болохгүй.

Ер нь Л.Сонорыг ихээхэн үнэлдэг шүү. Маш мундаг залуу шүү. Хэдийгээр Монголын төр засагт ажилладаггүй ч гэсэн Монгол Улсынхаа төлөө ажилладаг байгаарай гэдгийг хүсэж байна.

Одоо орж ирж байгаа нэр дэвшигчдэд амжилт хүсье.

Х.Булгантуяа: А.Ариунзаяа гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Ө.Гэрэл-Од нэр дэвшигчийг дэмжиж байгаа.

Асуух асуулт Санхүүгийн зохицуулах хорооноос байсан юм. Тэгэхдээ та мэдэж байгаа байх. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний чиг үүрэг, эрхийг ер нь яг ямар баримт бичгээр тодорхойлж өгдөг юм бол?

Тэгээд яах вэ Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм гэж байгаа. Тийм ээ? Тэгээд гуравт нь хорооны дарга, гишүүдийн чиг үүргүүдийг дурдсан байгаа. Хорооны дарга нь ийм байна, гишүүн нь ийм байна гээд. Тэгээд орон тооны бус гишүүдтэй холбоотой хэсэг байхгүй байгаад байх шиг байсан.

Тэгэхээр яг ямар бичиг баримтаар таны үндсэн чиг үүрэг юу байх вэ?

Хоёрдугаар асуулт нь, уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр борлуулдаг болоод бид 2 жил болж байгаа.

Тэгэхээр Санхүүгийн зохицуулах хороо зохицуулагч байгууллагуудынх нь нэг учраас мэдээж танд харьяалагдаад хамаарагдаад явах байх.

Тэгэхээр ер нь энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр борлуулж байгааг та ер нь юу гэж хардаг вэ? Ийм хоёр асуулт байна.

Х.Булгантуяа: Нэр дэвшигч 4 номерын микрофоноос хариулъя.

Ө.Гэрэлт-Од: Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд Санхүүгийн зохицуулах хороо нь орон тооны болон орон тооны бус гишүүнтэй байхаар хуульчилж заасан байдаг. Харин Санхүүгийн зохицуулах хорооны

дүрмээр орон тооны болон орон тооны бус гишүүдийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг зааж өгсөн байдаг. Эхний асуулт нь.

Хоёр дахь асуулт нь, ер нь биржээр бараа, бүтээгдэхүүн борлуулдаг олон улсын чиг хандлага байдаг. Манай Монголд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр борлуулах тогтолцоог бүрдүүлээд ажиллаад явж байна. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр борлуулах тухай үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн актыг нь аваад. Ер нь энэ зөв зүйтэй. Ялангуяа экспортын бүтээгдэхүүний үнийг нээлттэй олон нийтэд зах зээл дээр ханшлагдах боломжийг нэгдүгээрт олгох.

Хоёрдугаарт, үнэ чөлөөтэй тогтох энэ боломжийг олгож байгаа нь нээлттэй давуу талыг бий болгосон ийм үйл ажиллагаа гэж ойлгож байгаа.

Хоёрдугаарт, Уул уурхайн бүтээгдэхүүнийг борлуулах тухай хуулийг нь аваад үзэхээр ер нь хууль дотор тэр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үнэ гэдэгт альныг авч үзэх вэ? Арилжааны ямар ямар хэлбэрүүд байвал зохистой вэ гэдэг төрөл бүрийн зохицуулалтуудыг хэрхэн үзэх ёстой юм байна гэдэг бодол төрж байсан.

Тэгэхээр ер нь уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр борлуулах нь зөв зүйтэй юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний санал хураалтыг нууцаар явуулах ёстой.

Тэгэхээр нэг мөсөн санал хураалтаа нэгтгээд явуулъя. Одоо Байнгын хороод ер нь дуусаж байх шиг байна.

Дараагийн асуудалд оръё.

**Найм. “Засгийн газарт чиглэл өгөх тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Наймдугаар асуудал. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг танилцуулна.

Индэрт урьж байна.

М.Ганхүлэг: Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм гишүүд ээ,

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, монгол үүлдэр омгийн адууны удмын удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг санал, дүгнэлтээ тус Байнгын хороонд танилцуулж, Засгийн газарт тодорхой асуудлаар чиглэл өгөх нь зүйтэй гэж үзсэнийг Байнгын хороо хүлээн авч дараах Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний хэмжээнд шинжлэн тодорхойлох, бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, үржлийн адуу, түүний үр хөврөлийг импортлох тоо, хэмжээг 10 жилийн хугацаанд 0 хувьтай байхаар тогтоох зэрэг асуудлыг тусгасан.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасныг болон ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2025 оны 06 дугаар сарын 24, 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Монгол адууны удмын санг олон улсад бүртгүүлсэн эсэх, Монгол үүлдэр, омгийн адуунд тавигдах ерөнхий шаардлага, стандартын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг хангах, мах экспортлох зорилгоор газар тариалангийн бүсэд махны чиглэлийн цэвэр үүлдрийн адууг оруулж ирээд өсгөн үржүүлж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь тогтоолын үйлчлэлд хамаарах эсэх, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай малын генетик нөөцийн хэрэгжилтийг хангуулах, Монгол адууны удмын санг алдагдуулахгүй байх, хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх, бүсчилсэн хөгжлийн бодлогод туссан цөм сүргийн аж ахуйг дэмжих талаар төсөлд тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан тогтоолын төсөл нь малын таваарлаг байдлыг бий болгох, малын удмын санг хамгаалах, Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Мал сүрэг үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна.” гэсэн бодлогод нийцэж байгааг дурдаад тогтоолын хэрэгжилтийг тайлагнах хугацааг анхаарах талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Монгол адууг хамгаалах, Монгол адууны удам, генетик нөөцийг хамгаалах зорилгоор гаргаж байгаа тогтоолын төслийг дэмжиж, төрийн бус байгууллага, уяачид, малчдыг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан эсэх талаар, Улсын Их Хурлын

гишүүн Ж.Бат-Эрдэнэ улсын хилээр өмнө нь оруулсан үржлийн адууг хэрхэх, зөвхөн үржлийн адууг хориглож байгаа нь давуу эрх олгож байгаа эсэх, холбогдох төрийн бус байгууллагуудын саналыг авсан эсэх, малын генетик нөөцийн асуудлыг төсөлд цогцоор нь тусгасан талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар үржлийн адуу гэдэгт махны чиглэлийн адууг хамруулж байгаа эсэх, ашиг шимийг дахин тодорхойлох гэснийг тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат монгол өв соёл, монгол адууны удмын санг хамгаалахад чиглэсэн шийдвэр болж байгааг дурдаад, цаашид хэрэгжилтэд нь анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат тогтоолын төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Цэвэгмэдийн Мөнхнасан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Батмөнхийн Батбаатар Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Дорждугарын Гантулга Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Түдэвдоржийн Балжинням Мал эмнэлгийн ерөнхий газрын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газрын дарга, Түмэндэлгэрийн Баярмаа Татварын ерөнхий газрын Бүртгэлийн хэлтсийн дарга, Долгорсүрэнгийн Анхтуяа Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Мал эмнэлгийн хяналт хариуцсан Гаалийн улсын байцаагч, Оюунгэрэлийн Баатарцогт Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуйн технологи дамжуулах төвийн захирал, Пүрэвдоржийн Мягмарсүрэн Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Мал аж ахуйн салбарын эрхлэгч, доктор, Мөнхбатын Ариунболд Монголын үндэсний морин уралдаан, уяачдын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Цогнямын Ганбаяр Монголын морин спорт, уяачдын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Адъяагийн Баярмагнай эрдэмтэн, судлаач, Лхаажавын Цагаандалай Морьтны соёл судлаач, сэтгүүлч гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

О.Саранчулуун гишүүнээр, М.Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир.

Ц.Сандаг-Очир: Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны асуудал юм байна.

Эрлийз адууг 2026 оноос 2036 он хүртэл 10 жилийн хугацаанд оруулж ирэхгүй байхаар Засгийн газарт чиглэл олгож байгаа Улсын Их Хурлын тогтоол юм байна.

Тэгэхээр энэ тогтоолын төслийг боловсруулалттай холбогдуулж эдийн засгийн тооцоо судалгаанууд юу байна вэ?

- ▶ Ер нь манай улсын нийт адуун сүрэг хэд байгаа юм?
- ▶ Тэрний хэдэн хувь нь одоо ер нь ийм эрлийзжээд байгаа юм?
- ▶ Цэвэр цусны үүлдрийн адуу ер нь хэдэн хувь нь байна. Нэгд.

Хоёрт, одоо ингээд ирэх жилээс авхуулаад 10 жилийн хугацаанд импортын адууг огт оруулж ирэхгүй болох юм байна. Үүнийг уяачид, уяачдын холбоо маань хэр сайн дэмжиж байгаа юм. Өөрсдөө дэмжиж байгаа юм уу, дэмжихгүй байгаа юм уу?

Та бүхэн чинь одоо дотроо хоёр хуваагдаад “Морин спорт, уяачдын холбоо”, “Үндэсний морин спорт, уяачдын холбоо” гээд ингээд байдаг.

Аль алиных нь төлөөлөл энд байгаа юм уу үгүй юу? Энэ тогтоолын төсөл дээр санал хүсэлтээ өгсөн юм байгаа юм уу, үгүй юу?

Дараа нь тогтоол гардаг. Засгийн газарт чиглэл өгдөг. Засгийн газар өгсөн чиглэлийн хүрээнд арга хэмжээ аваад эхлэхээр бөөн эсэргүүцэл юм болоод байх юм биш биз дээ. Энд.

Нөгөө талаараа энэ чинь одоо морин эрдэнээ хайрлая барья гээд ингээд байдаг. Нөгөө талаараа махны экспортыг дэмжсэн асуудал энэ чиглэл дотор чинь яваа.

Тэгээд нэг талаараа адуу нь сүргээ хайрлаж хамгаалах юм яваад байдаг. Нөгөө талаараа махны экспортыг дэмжээд байх ийм хоёр талын ойлголт яваад байгаа юм. Тэгээд энэ дээр тогтоол санаачлагч нар юу гэж бодож байгаа юм?

Ер нь өнөөдөр малын махны экспорт ер нь хэр байгаа юм? Тэр дотроо адууны махны экспорт хэр байгаа юм? Гарч чадаж байгаа юм уу, чадахгүй байгаа юм уу? Хэчнээн аж ахуйн нэгж энэ зах зээл дээр оролцоотой байна? Энэ талын тооцоо судалгаа байна уу, үгүй юу гэдгийг санаачлагчаас асууя.

Х.Булгантуяа: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хэн хариулах вэ? М.Ганхүлэг гишүүн эхлээд хариулъя. Шаардлагатай нэмэлт ажлын хэсгээс хариулаад явчхаарай.

М.Ганхүлэг: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэг тодорхой хугацаанд ажилласан. Ингэхдээ мэргэжлийн байгууллагууд, мал эмнэлгийн хүрээлэн, мөн мал эмнэлгийн байгууллагууд, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэдтэй нэлээн ажилласан. Мөн таны хэлж байгаа төрийн бус байгууллагуудтай бид бүхэн ажилласан.

Монгол Улсын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 4.7 сая толгой адуун сүрэг байна. Үүний 1.9 сая орчим нь үржлийн адуу байгаа юм.

Сүүлийн 10 жилийн хугацаанд нийтдээ Монгол Улсын хилээр 5209 үржлийн адууг бид бүхэн тодорхой зорилгын хүрээнд оруулж ирсэн байгаа юм.

Хамгийн өндөр дүнгээр 2022 онд бид бүхэн 937 толгойг оруулж ирж байсан. 10 жилийн дунджийг хараад үзэхэд жилдээ бид бүхэн 500 орчим адууг импортоор оруулж ирж байгаа юм.

Манай ажлын хэсгийн үндсэн гол зорилго малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээг хийлгэх, генетик нөөцийг тогтоох, түүнтэй холбогдолтой хуулийн хэрэгжилтийг хамгаалах чиглэлээр гол анхаарлаа хандуулж ажиллаж байгаа юм. Энэ чиглэлийн тооцоо судалгааг бид бүхэн 2019 онд хамгийн сүүлд хийсэн байгаа юм.

Тэгэхээр 2019 онд хийсэн тооцоо судалгаагаар үндсэндээ бид бүхэн адуун сүргийнхээ 30.8 хувийг тодорхой ашиг шимийн нөхцөл байдлыг нь бид бүхэн тодорхойлж чадахгүй байгаа ийм байдалд хүрсэн нөхцөл байдал үүссэн учраас гол үндэслэлээ бид бүхэн энэхүү тооцоо судалгаан дээр үндэслэж оруулж ирсэн.

Ажлын хэсгийн хүрээнд үндсэндээ “Монголын морин спорт, уяачдын холбоо”-ноос албан ёсоор хариултаа ирүүлсэн байгааг Та бүхэндээ дуулгая.

Хоёр холбоод цаг үеийн нөхцөл байдалтай холбогдолтой янз янзын байр сууриудыг илэрхийлж ирсэн. Энэ удаагийн асуудал дээр нэгдсэн байр суурьтай байгаа гэдгийг албан ёсоор гишүүддээ илэрхийлье.

“Монголын морин спорт, уяачдын холбоо” 8 дугаар их хуралд оролцсон төлөөлөгчдийн саналаар энэхүү саналыг бид бүхэнд ирүүлсэн.

Мөн 4 сард Хүнс, хөдөө аж ахуйн сайдад уламжилсан. Энэхүү ажлын хэсгийн дэд ажлын хэсэгт ороод ажилласан байгаа.

“Монголын үндэсний морин уралдаан, уяачдын холбоо” өөрийн саналаа тодорхой агуулгын хүрээнд ердөө ирүүлсэн.

Ерөнхийд нь багцлаад хэлэх юм бол тодорхой хугацаанд импортын энэ хориглох асуудлыг аль аль холбоод дэмжиж байгаа гэдэг байр суурийг илэрхийлсэн байгаа.

Монгол Улсын хувьд махны экспорт сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа. Ялангуяа энэ чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа квотыг цуцлах, бүх төрлийн хориг саадыг арилгах энэ чиглэлээр түүхэн дэх хамгийн өндөр экспортуудыг бид хүн хийж байгаа.

Өнгөрсөн 2024 онд 71.1 мянган тонн махыг бид бүхэн экспортод гаргасан байгаа.

Х.Булгантуяа: Тэгье М.Ганхүлэг гишүүн нэмж 1 минут өгье.

М.Ганхүлэг: 71.1 мянган тонн махыг бид бүхэн экспортод гаргасан. Үүний 23.8 хувь нь буюу ойролцоогоор 24 хувь нь адууны түүхий мах байгаа. Үндсэндээ мал эмнэлгийн хорио цээрийн дэглэмийн хүрээнд бид бүхэн тодорхой өвчлөлийн улмаас олон төрлийн махан дээрээ хорио цээрийн нөхцөл байдлыг тогтоосон байгаа.

Тийм учраас бид бүхэн дулааны аргаар боловсруулж, тодорхой шаардлагын дагуу гаргаж байгаа нөхцөлүүд байгаа. Харин адууны махан дээр харьцангуй өвчлөлийн хувьд бусад малтай харьцуулахад гайгүй учраас үндсэндээ нээлттэй гаргах боломж нь нээлттэй байгаа юм.

Энэ удаагийн тогтоолын гол үндэслэл нь адууны өвчлөлтэй холбогдолтой асуудал, экспорттой холбогдолтой асуудлыг хөндөж байгаа юм.

Дэлхий нийтэд гарч байгаа адууны өвчлөл Монголд цаашдаа дэлгэрэхгүй гэдэг ийм үндэслэл байхгүй байна. Мал эмнэлгийн зүгээс тодорхой анхааруулгууд бид бүхэнд хэлж байна.

Х.Булгантуяа: Ц.Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Салбар холбоод нь дэмжиж байгаа юм байна.

Энэ чинь бас нэг талаараа бизнес болсон. Импортын адуу. Энэ чиглэлийн бизнес хийж байгаа залуучууд санал хүсэлтээ өгсөн үү, үгүй юу? Тэдний санал хүсэлтийг авсан уу, үгүй юу? Энэ чинь бизнесийн эрх ашиг нь хөндөгдөж байгаа шүү дээ.

Гадаадаас, Тувагаас сайхан үржлийн адуунууд оруулж ирээд, азарганууд оруулж ирээд ингээд уяачидтай уулзаж, төл юмыг нь нийлүүлэх, үржилд оруулах. Ингэснээрээ тав, арван цаас өгөлцөж авалцдаг. Энэ чинь тодорхой бизнес болсоныг бүгд мэдэж байгаа шүү дээ.

Энэ бизнес эрхэлдэг залуучуудын бизнесийн эрх ашиг яаж хөндөгдөж байгаа юм бэ? Эд нарын саналыг яаж авсан юм бэ? Манай уяачид яах вэ дээ өөрсдөө аль хэдийн адуунуудаа оруулж ирээд үржил селекцэд оруулсан улсууд нэг их асуудал ярихгүй байх. Одоо яг энэ чиглэлийн бизнес хийж байгаа залуучуудын асуудлыг юу гэж үзсэн юм?

Х.Булгантуяа: М.Ганхүлэг гишүүн нэмж хариулъя.

М.Ганхүлэг: Мэдээжийн хэрэг нийгмийн дунд олон асуудал дагуулсан, сүүлийн жилүүдэд маргаантай байгаа ийм асуудлуудын суурь асуудал.

Тэр утгаараа тодорхой аж ахуйн нэгжүүдийн, хэсэг бүлэг бизнес эрхлэгчдийн эрх ашгийн асуудал энд хөндөгдөнө.

Энэ гол үндсэндээ хэлэлцүүлэг, энэ агуулгууд шийдэгдсэнээрээ өргөн утгаараа малын генетик нөөц, удмыг хамгаалах энэ чиглэлийн асуудлуудыг сууриар нь шийдэх зохицуулалтууд байгаа.

Яг энэ чиглэлийн импортоор оруулж ирж байгаа 70 гаруй аж ахуйн нэгжүүд байгаа. Жил болгон тодорхой квотоо аваад, үйл ажиллагаагаа явуулаад үндсэндээ байж байгаа.

Бид бүхэн бүх төрлийн малыг хориглох тухай асуудал энд яригдаагүй. Бусад чиглэлээрээ үйл ажиллагаагаа явуулах боломж бололцоонууд нь байгаа. Энэ удаад үржлийн адуу, түүний үр хөврөлтэй холбогдолтой асуудлыг түр хугацаанд хязгаарлахтай холбогдолтой асуудлыг үндсэндээ оруулж ирж байгаа юм.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Пүрэвбаатарын Мөнхтулга.

П.Мөнхтулга: Өнөөдрөөс яг долоо хоногийн дараа Үндэсний баяр наадам болох гэж байна.

Яг энэ цаг хугацаанд эрийн гурван наадмын нэг төрөл болох морин уралдаантай холбоотой энэ чухал хууль орж ирж байна.

Тойргоороо яваад ирлээ. Өчигдөр Архангай аймгийн Өгийнуур суманд явж байхад аймгийн бүсийн уралдаан болж байсан. Малчид, уяачид юу гэж байна вэ гэхээр бид ер нь морь уяхаа больё гэж байна. Яяад уралдаад нэмэр байхгүй ээ. Мөнгөтэй хөрөнгөтэй олон эрлийз адуутай хүмүүсийг барахгүй болсон.

Өнгөрсөн жилийн сумын наадмаар манай суманд азарга уралдахад гуравхан азарга бүртгүүлж байсан. Айргийн 5 нүхтэй шүү дээ. Тэгээд гуравхан малчин азарга бүртгүүлж байгаа юм. Бусад нь яасан юм гэхээр азарганы уралдаанд монгол адуу барахгүй. Тэгээд үлдсэн хоёр насанд нь, байнд нь соёолон уралдуулж ингэж наадмаа хийж байсан.

Тэгэхээр хөдөөд бид мэдэж байгаа.

- ▶ Малын арьс борлогдохгүй байгаа.
- ▶ Түүхий эд хэцүү байгаа.
- ▶ Малчдын амьжиргаа хэцүү байгаа.

Хөдөөг залуучуудыг уядаг гол нэг зүйл энэ морин уралдаан байдаг. Тэгээд энэ морин уралдаан маань малчдын морьдууд уралдах боломжгүй болсон. Яг ийм боломжтой хэсгүүдийн наадам болсон энэ үед импортыг 10 жилээр хориглоод харъя гэж байгаа нь зөв зүйтэй асуудал.

Энэ цаашаагаа ингээд даамжрах юм бол ер нь манай яг малчдын, иргэдийн нуруун дээр явж байдаг энэ өв соёл маань боломжтой хэсэг рүү л шилжих болов уу гэж хараад байгаа юм.

Тэгээд энэ цаг хугацаанд оруулж ирж байгааг дэмжиж байгаа. Гэхдээ мэдээжийн хэрэг үүн дээр гомдолтой үлдэж байгаа олон төрлийн талууд байгаа байх.

Гэхдээ цаг үеийн асуудлаар бид олонх нь нийт малчид энэ өв соёлынхоо асуудлыг авч үлдэх нь чухал байгаа.

Үржил гэдэг зөвхөн хурд биш, мэдээж хэрэг махны асуудлууд ярьж байгаа байх. Энэ дээр бид монгол адуу махны чиглэлээр үржүүлнэ гэхэд байгалийн нөхцөл байдал дээрээ. Одоо би яг тоо статистикийг нь мэдэхгүй байна. Тэгэхдээ яг бодит амьдрал дээр хөдөө орон нутгаар явж байхад үхрийн ферм гэж харсан болохоос биш адууны махны ферм л гэж лав хараагүй.

Ер нь байгалийн нөхцөл байдлаараа монгол адуу нэмэх 30, хасах 30-ийн хооронд амьдардаг энэ генетикийнхээ бүтцээр бэлчээрээр явж байгаа онцлогоороо л махандаа үржигдэж явах байх.

Үүнийг мэргэжлийн байгууллагууд нь судалж энэ хуулиа оруулж ирсэн байх аа.

Нэг асуудал байгаа юм. Хуулийн хэрэгжих хугацаа. Хуулийн хэрэгжих хугацаа хэрвээ хойно байвал мэдээлэлтэй хэсэг нь, боломжтой хэсэг нь маш олон хэмжээний адуу оруулж ирээд хориглогдсон хойно үнэ хүргэж зарах ийм

монопольжуулах ч гэдэг юм уу, энэ хуулийн хугацааг ашиглаж бизнесийн давуу байдлууд бий болох магадлалтай.

Тэгэхээр энэ хуулийн хугацаагаа манай ажлын хэсэг яаж оруулж ирж байгаа юм бэ? Яг батлагдсан өдрөөс гэж явах уу? Эсвэл хойш нь хугацаа тавьж өгөх юм бол энэ хэсэгт чинь яг боломжтой хэсгүүд орж ирээд бизнесийнхээ хэлээр дарна гэж ярьдаг. Нөгөө хурдан удмын угшилтай адуунуудаа дарчхаад тэрийгээ дөрөв, тав нугалж зарах иймэрхүү үзэгдлүүд бий болох вий дээ. Энэ дээр ажлын хэсэг ажилласан уу гэдэг ийм асуулт байна.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс 4 номерын микрофон дээрээс хариулъя.

О.Баатарцогт: Нийт Улсын Их Хурлын гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Миний хувьд Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуйн технологи дамжуулах төвийн захирлаар ажилладаг. Биотехнологич мэргэжилтэй О.Баатарцогт гэж хүн байна.

П.Мөнхтулга гишүүний асуултад товч хариулъя гэж бодож байна.

Маш чухал асуудлыг хөндлөө. Өнөөдрийн орж ирж байгаа хуулийн үндэслэл нь зөвхөн уралдааны хурдны адуу гэхээсээ илүү монгол адууны үндсэн өвөрмөц генофондыг бүртгэлжүүлэх, хамгаалах асуудлыг хөндөж орж ирсэн.

2007 онд Малын генетик нөөцийн тухай хууль батлагдсан үндэслэл нь ерөөсөө л Монголд байгаа энэ хатуу ширүүн буюу дөрвөн улиралтай уур амьсгалд дасан зохицсон өвөрмөц тэсвэр чанарыг агуулсан монгол малын генетик нөөцийг хамгаалъя гэдэг ийм үндэслэлтэй.

Дээр нь Үндсэн хуульд монгол мал төрийн хамгаалалтад байх ёстой гээд.

Тэгэхээр бид бүхний хувьд ер нь яах вэ, зөвхөн генетикийн асуудал, импортын адууны асуудал гэхээсээ илүү түрүүн Ц.Сандаг-Очир гишүүн дурдаж байсан. Энэ бизнес талаасаа махны болон сүүний чиглэлийн адуу үржүүлгийн асуудал хөндөгдөнө гээд. Энэ дээр гол асуудал бол өнөөдрийг хүртэл импортоор орж ирсэн сүүлийн 10 жилд 4700 гаран цэвэр цусны үржүүлгийн адуу орж ирсэн байна.

2006 оноос ер нь Монгол орныг нийлүүлгийн өвчин буюу битүү туурайтай амьтны өвчлөлтэй, тайван бус орны тоонд оруулж зарласан байдаг. Энэ нь зөвхөн найр наадам, хурдлах гэхээсээ илүү саяын ярьсан махны экспорт, сүүний гарц, дотоодын асуудлын үндсэн гол гогцоо нь байгаа юм.

Тэгэхээр 10 жилийн хугацаанд хориглоод бид дотооддоо мэргэжлийн байгууллага, төрийн байгууллага, шинжлэх ухааны байгууллагууд хамтраад өнөөдөр Монголд байгаа нийт 4 сая 800 мянган толгой адуугаа

▸ **Эхний ээлжинд**, төрөл, зүйрлэлээр нь бүртгэлжүүлэх;
▸ **Хоёрдугаарт нь**, нийлүүлгийн өвчин, өвчлөлийн асуудлын тандан судалгаа;

▸ **Гуравдугаарт нь**, монгол малын буюу монгол адууны өвөрмөц тэсвэрт чанарын генетикийг олон улсын түвшинд буюу Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад зарлах нь өөрөө үндэсний эрх ашгаа хамгаалах үндсэн суурь үзүүлэлт гэж ингэж том зургаараа харж байгаа юм.

Тэгээд энэ ажлыг хуулийн хүрээнд тодорхой үр дүнтэй гаргах нь бид бүхний хувьд зайлшгүй хэрэгтэй, шаардлагатай цаг болоод байгаа юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хэрэгжүүлсэн манайд тандан судалгаа хийсэн малын талаарх том том судалгааны төслүүдийн үр дүн дээр ч гэсэн зөвлөмжүүд байгаа. Монгол малыг бүртгэлжүүлэх, хамгаалах, дараад нь мэргэжлийн түвшинд үржлийн бодлогыг явуулах нь өөрөө монгол малаас гарах эдийн засгийн үр өгөөж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж хариулъя. 4 номерын микрофон.

О.Баатарцогт: Ашиг шимийг нэмэгдүүлэх гол асуудал нь энэ гээд олон улсын донор байгууллагууд ч бид зөвлөсөн. Мэргэжлийн байгууллага ч гэсэн энэ талаасаа хуулиа мөрдөж ажлаа хийх зайлшгүй цаг үеийн нөхцөл байдал дээр бид ирсэн байна.

Тийм учраас энэ дээр эрхэм Улсын Их Хурлын гишүүд урт хугацаанд, 10 жилийн хугацаанд бид яг мал аж ахуй, тэр дундаа адууны аж ахуй ямар түвшинд хүрэх вэ, эдийн засгийн үр өгөөж нь ямар байх вэ гэдэг талаас нь бодоосой гэж бодож байна.

Х.Булгантуяа: Нэмж тодруулахаар нь хариулъя тэгэх үү? П.Мөнхтулга гишүүн нэмж тодруулахаар хариулъя.

П.Мөнхтулга: Ер нь өнгөрсөн хугацаанд бид адууны чиглэл дээр тодорхой бодлого баримталж ирээгүй, шууд нээлттэй байсан л даа.

Үүний буруу гэж нэг их юм харагдаагүй. Тэгэхдээ яг цаг үеийг нь барьж авч хоригийг нь тавьж байх шиг байна.

Энэ хугацаанд яасан бэ гэхээр нөгөө үржил селекцэд ороогүй зөвхөн нэг аймаг, сумдын адуу ложистик тээвэр хөгжөөгүйгээсээ болоод сум хоорондоо үржил селекцээ л хийдэг байсан. Тийм үед байсан.

Дараа нь одоо ингээд тээвэр хөгжөөд ирсэн. Одоо бид яг үндсэн монгол адуу гэдэг генетикийнхээ тодорхойлолтыг гаргах гээд хориглож байгаа гэж ойлгож байгаа.

Тэгээд хуулийн хэрэгжих хугацааг би асуугаад байгаа юм. Энэ хугацаа хойшоо явбал нөгөө давуу байдлууд чинь бий болно шүү.

Х.Булгантуяа: М.Ганхүлэг гишүүн хариулъя.

М.Ганхүлэг: Хуулийн хэрэгжих хугацаатай холбогдолтой тодорхой хариулт өгье.

П.Мөнхтулга гишүүний хэлж байгаа зөв өө. Үндсэндээ бид бүхэн жил болгон Засгийн газарт тодорхой хувь хэмжээг тогтоож байгаа. Хүнс, хөдөө аж ахуйн сайд энэ жил импортоор авах адууны тоо хэмжээг Засгийн газрын хурлаар оруулаад батлуулж байгаа юм.

Тэгэхээр бид бүхэн олон улсын хэлэлцээр, тодорхой бусад хуулиуд руу оролгүйгээр энэхүү орж байгаа квот, хувь хэмжээг 2026 оны 01 сарын 01-нээс эхлээд “0” хувьтай байлгая. Үүнийгээ 10 жил байлгая гэдэг ийм агуулгаар орж байгаа юм.

Энэ тогтоолын төсөл батлагдсанаар шууд хэрэгжүүлэх нөхцөл боломж нь энэ жилийн квотууд олгогдсон байгаа. Ойролцоогоор 600 орчим үндсэндээ адууг оруулж ирэхээр энэ жил бүх аж ахуйн нэгжүүддээ квот нь олгогдсон байж байна. Энэ бол 300, 400 адуу нь ороод ирсэн. Үлдсэн хугацаанд нэмэгдэх байдаг юм уу, янз янзын эрсдэл байхгүй. Яг энэ 600-гаа бариад энэ ондоо орж ирж дуусна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал.

Х.Баасанжаргал: Би гурван асуулт, нэг санал хэлье. Х.Ганхуяг гишүүн саналд хариулаасай гэж хүсэж байна.

Нэгдүгээрт, мэдээж хүүхдийн эрхийн өнцгөөр асуулт асуух ёстой.

Уралдаанч хүүхдийн хувьд эрлийз адууг унаж уралдах, монгол адууг унаж уралдах хоёр маш их ялгаатай байдаг гэдэг аман яриа бөгөөд уяачдын яриа байдаг. Энэ ер нь яг судлагдсан байдаг уу? Үнэхээр ялгаатай байдаг уу гэдэг нэг асуулт.

Та бүхний тогтоолын үр дагавар өөрөө хүүхдийн эрхийг хамгаалах болов уу л гэж асууж байгаа гэсэн үг. Тийм ээ.

Хоёрдугаарт, хоёр уяачдын холбооноос төлөөлөл байх шиг байна. Хоёулаа хариулах нь зөв байх. Уяач, адуучдынхаа лобби, эсэргүүцлийг та хэд дийлэх үү? Сүүлдээ энэ асуудлыг яриад ирэхээр хужаа л болж дуусдаг юм шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ лоббигоо та хэд дийлэх үү? Маш их мөнгө эргэлддэг салбар гэж ойлгодог. Тэгэхээр энэ мөнгө Монголдоо үлдэж чадах уу гэдэг ийм асуулт байна.

Гуравдугаарт, Үндэсний их баяр наадам удахгүй болох гэж байна. Тэгээд аль болох үндэсний их баяр наадам уламжлалт аргаараа уяж сойсон, уламжлалт зан заншлаа хадгалсан ийм байдлаар уралдаан, тэмцээн маань болоосой гэж маш их хүсдэг.

Гэтэл дандаа жилийн жилд дандаа хэрүүл маргаан тэмцэл болдог. Энэ нь эрлийз, энэ нь Монгол гээд. Үүнийг та нар тасалж чадах уу?

Тэгэхээр үндэсний баяр наадмаар ер нь цаашид яг монгол морьд уламжлалт арга, уяа сойлгоороо уралдах нөхцөл энэ тогтоолыг баталснаараа бүрдэх үү гэсэн үг. Тийм ээ.

Санал. Тогтоолын төсөл дотор хүүхдийн эрхтэй холбоотой ерөөсөө заалт алга. Томчууд дандаа мориныхоо асуудлыг л ярьдаг. Та хэд мэдэж байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ мэдээж чухал. Дараа жилийн наадам болохоос өмнө яг ингэж адуутай холбоотой тогтоолын төсөл оруулж ирж байгаатайгаа адилхан хүүхдийн эрхийг хамгаалсан тогтоолын төсөл оруулж ирээрэй гэдэг санал гаргаж байна. Нэг ийм гурван асуулт, нэг санал.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс 4 номерын микрофон дээрээс хариулъя. Энэ их чухал асуудал шүү. Микрофон нээлттэй.

А.Баярмагнай: Адъяагийн Баярмагнай гэдэг хүн байна, би.

Монголын хурдан морины соёл судлалаар үндсэндээ 50-иад жил ажиллалаа. Яах вэ, нэг их гүнзгийрч чадаагүй ч гэсэн.

Гишүүний асуултад заримыг нь хариулъя. Би эхний асуултаар нөгөө эрлийз морь унах, монгол морь унаж уралдах ялгаатай юу гээд байна. Өөрөө морь унаж чаддаг хүн үүнийг өөрөө хүнээс асуухгүй мэдэх юм. Өөрөө морь унаж чаддаг монгол хүн бол үүнийг хүнээс асуултгүй өөрт нь ойлгомжтой асуудал юм. Ялгаагүй, ялгаагүй. Тийм.

Хоёр дахь нь, хурдан морины орчин тойронд их мөнгө эргэлддэг. Энэ мөнгө тэгээд Монголдоо үлдэж чадах уу гээд. Монголын хурдан морины наймаа гэдэг арилжаа наймаа бол Монголын уламжлалт том бизнес мөн.

Монголчууд ер нь өөрөө юм үйлдвэрлэж чаддаггүй. Одоо байгалийн бүтээгдэхүүн бэлэн юм газар шороогоо жаал зарж байгаа байх. Хуучин хийдэг наймаа нь л ерөөсөө адууны л наймаа, малын наймаа. Энэ уламжлалт бизнесийн ажиллагааг хэн ч хориод нэмэргүй, хэн ч дэмжээд нэмэргүй. Өөрийнхөө зүй тогтлоор явдгаараа явж байгаа. Ийм л юм байгаа юм л даа, энэ чинь. Тийм.

Гурав дахь нь юу байлаа даа. Тэгээд энэ хүн мөнгөө зараад зүгээр гадагшаа алдаж байгаа юм биш. Мөнгөө зараад өөрийнхөө дуртай үнэт ч юмаа авч байгаа юм. Тийм. Мөнгөө зараад хурдан морио авч байгаа юм. Тэр хурдан морийг чинь авч байгаа эзэндээ юугаар ч сольшгүй үнэ цэнтэй зүйл. Үүнийг ойлго.

Х.Булгантуяа: Шууд араас нь хариулаад явчих.

Л.Цагаандалай: Их Хурлын эрхэм гишүүд, эрхэм төрийн түшээддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Ерөнхийлөгч Нэгдсэн Үндэстний Байгууллагад санал гаргаж, түүнийг нь Нэгдсэн Үндэстний Байгууллага дэмжиж, Дэлхийн адууны өдөр энэ наадмаар 07 сарын 11-нд тэмдэглэхийн өмнө Монголчуудын мянга мянган жил гаршуулж, гэршүүлж ирсэн энэ адуу тэргүүтэй монгол малынхаа фондыг хамгаалах энэ түүхэн шийдвэрийг гаргах гэж байгаа Та бүхэндээ их баярлалаа гэж энэ талаар сэтгэл зовж, зовниж явдаг хүмүүсийн төлөөлөн хэлье ээ.

Эрхэм гишүүн асууж байна. Энэ олон уяачдынхаа эсэргүүцлийг дийлэх үү гэж. Энэ манай холбооны бодлого дээр, 8 дугаар их хурал дээр уяачдын. 700 гаруй. Их хурал хуралдсан. Уяачдын холбооны их хурал дээр энэ санал гарсан юм.

Тэгээд уяачдын холбооны шинэ удирдлага.

Х.Булгантуяа: Гүйцээн хариулъя.

Л.Цагаандалай: М.Ганхүлэг гишүүний хэлсэн, тэр харуулсан албан бичгийг уяачдынхаа санал болгож илгээсэн юм. Энэ саналыг дэмжиж өгнө үү.

Энэ бол Монголын мянга мянган уяачдын санал юм гэж ойлгож болно.

Хоёрдугаарт, хүүхдийн эрх ашиг гэдэг монголчуудын ер нь Монголын хурдан морины уралдааны амин гол үзэл баримтлалын нэг нь хүүхдээ

хамгаалах байдаг. Яагаад гэвэл хүүхдээр морио унуулахдаа эцэг, эхээс нь асуудаг. Хүүхэд зөвшөөрөх, хүүхдээс нь өөрөө асуу гэж эцэг, эх нь хэлдэг. Хүүхэд дургүй байх юм бол, жаахан л дургүй байх юм бол тэр хүүхдээр хэзээ ч морио унуулдаггүй. Өөрийнхөө хүүхэд ч байсан морио унуулдаггүй ийм жинхэнэ амин гол үзэл баримтлал нь байгаа юм шүү гэдгийг бас мэдээлэл болгож Та бүхэндээ дуулгая. Баярлалаа.

Х.Булгантуяа: У.Отгонбаяр гишүүн нэмж хариулъя.

У.Отгонбаяр: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд өнөөдөр энэ түүхэн чухал шийдвэр гарах гэж байгаад их баяртай байгаа. Тэгээд үүнийг ойлгож дэмжиж байгаа Улсын Их Хурлын гишүүддээ юуны түрүүн талархал илэрхийлье.

Энэ тогтоол зүгээр маш товчхондоо хэлэхэд монгол адууны генофондыг авч үлдэх хамгийн эхний том алхам гэж манай ажлын хэсэг үзэж байгаа. Сүүлийн 10 жилд 5 мянга гаруй адуу импортоор орж ирсэн. Эндээс 4700, 4800 орчим азарга орж ирсэн. Тэгээд үржилд орж байгаа. Дунджаар бодоод үзэхэд жилдээ 10 мянган гүү хээл авч эрлийзжиж байгаа гэсэн ийм тоо гардаг... /минут дуусав/

Х.Булгантуяа: Х.Баасанжаргал гишүүн нэмж тодруулъя.

Х.Баасанжаргал: Та хэд маань зөвөөр ойлгоод миний асуултад хариулаадхаарай. Би уг нь та хэдийн санаачилгыг дэмжээд л энэ асуултыг асуугаад байгаа шүү дээ. Түүнээс эсэргүүцээд асууж байгаа юм биш ээ.

Бүр тодруулъя. Яг энэ эрлийз морь унаж уралдах, монгол адуу унаад уралдах хоёр дээр хүүхдийн эрүүл мэнд дээр үүсэх, амь насанд үүсэх эрсдэл нь ялгаатай юу л гэж асуугаад байгаа юм. Би өөрөө морь уралдаж байгаагүй.

Тийм учраас ялгааг нь мэдэхгүй. Ялгааг нь мэдэхгүй олон хүн үүнийг үзэж байгаа.

Тэгэхээр үнэхээр ялгаатай байдаг, эсвэл судлагдсан байдаг уу, эсвэл судлагдаагүй энэ нь өөрөө яг шинжлэх ухааны үндэслэлтэй. Судлагдаагүй бол судлагдаагүй ээ л гээд хэлчих. Өөр нэг их тийм юу бол байхгүй.

Хоёрдугаарт, үндэсний баяр наадмын талаар байр сууриа илэрхийлээч. Үндэсний баяр наадмаар үнэхээр яг... /минут дуусав/

Х.Булгантуяа: М.Ганхүлэг ажлын хэсгийн дарга хариулъя.

М.Ганхүлэг: Х.Баасанжаргал гишүүн нэлээн чухал асуудлыг хөндөж байна.

Хүүхдийн асуудал дээр нарийн судлах шаардлагатай зүйлүүд байгаа. Гэхдээ Монгол адууны өөрийн онцлог зүйлүүдийн тухай бид үргэлж ярьдаг. Хүүхдээ гишгэдэггүй. Тийм ээ. Хурдны хувьд ч тэр, бусад талаараа илүү ээлтэй байх ийм нөхцөлийн тухай ярьдаг. Үүнийг илүү сайжруулж бид бүхэн тогтоох шаардлагатай гэдгийг хэлье.

Мөн дээрээс нь хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр тантай санал нэг байна. Энэ чиглэлийн тодорхой төслүүдийг хамтран өргөн барьж ажиллая гэсэн байр суурьтай байна.

Энэ тогтоолын төсөл батлагдсанаараа уяачдын маань дунд байгаа маргаантай олон асуудлуудыг шийдэх суурь эхлэл болно гэж бид бүхэн үзэж байгаа гэдгийг хэлье.

4 номер нэмэх юм байна.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон. Ажлын хэсэг хариулъя.

П.Мягмарсүрэн: Х.Баасанжаргал гишүүнтэй санал нэг байна. Мэргэжлийн түвшинд хариулт өгье гэж бодож байна.

Тэгэхээр ер нь эрлийз адуу, монгол адууны хүүхэд унахад ялгаа нь юу юм бэ гэж байгаа.

Тэгэхээр би ер нь хоёр үндсэн ялгаатай гэж бодож байгаа.

Нэгдүгээрт, харайлтын зай эрлийз адуунд мэдээж их байгаа. Тэгэхэд хүүхдийн тогтох тэр тэнцвэрээ хадгалах байдал их хүндрэлтэй болж ирнэ. Дараа нь монгол адуу чинь өөрөө эзнээ хамгаалах байгалийн инстинкттэй.

Тэгэхээр тэр өргөж босгох, дээрээс нь тэр цочих инстинкт дандаа эзнээ хамгаалж байдаг. Харин эрлийз адуу тэр байгалийн инстинкт бараг байдаггүй гэхэд болно.

Тэгэхээр эрсдэл өндөр байх нь мэдээж. Би мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Мал аж ахуйн салбарын эрхлэгч хүн байна. Малын үржүүлэг генетик, селекцийн цэг дээр 22 жил дагнаж ажиллаж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун.

О.Саранчулуун: Баярлалаа. Тодорхой хэдэн тоотой мэдээлэл авмаар байна гэж бодоод байгаа.

Сүүлийн дунджаар үзье л дээ. Сүүлийн 10 жил гэж ярья. Энэ улсын болон аймаг, орон нутгийн чанартай наадамд үнэхээр үзүүр түрүүнд нь ордог

морьдуудаас эрлийз адуу хэдэн хувь байдаг юм бэ гэдэг тоог сонсмоор байгаа. Үнэхээр уяачид ярьж байгаа шиг тоо баримттай мэдээлэл хэрэгтэй.

Хоёрт нь, эрлийз адуу, монгол адуу хоёрыг маллах, уралдахад ямар эдийн засгийн ялгаа, зардлын ялгаа ер нь ямархуу зардал байдаг юм? Тийм ээ. Энэ нь өөрөө тэр уяачид дээр бизнесийн хувьд ямар ялгаа гаргах вэ гэдэг асуудал байна.

Гуравдугаарт нь, энэ шийдвэр уяачдын хэдэн хүний амьдрал, ажилд шууд нөлөөлж эхлэх вэ? Хэдэн уяачдын бизнес гэж ярья л даа. Тийм ээ. Хэдэн хүний амьдралд нөлөөлөх вэ? Энэ тоо бас их чухал байна.

Дөрөвт нь, ер нь яах вэ, Монгол адууг монголчуудын хувьд морьтой холбоотой уламжлал сэтгэлгээ маш хүчтэй ийм ард түмэн. Үүнийг зөвхөн уралдаанд хүүхдүүдийг унуулж уралдахаас гадна өөр эрүүл мэндийн тал дээр ч юм уу, тийм ээ, маш олон үр ашигтай хэрэглээ байдаг л даа. Олон улсад. Тэр тал дээр та хэд ер нь сонсож байсан уу? Энэ талаар ерөнхийдөө сонсож байсан санаа оноо, мэдээллүүд байна уу гэдэг шинжлэх ухааны үндэслэлтэй, тоотой мэдээллүүдийг сонсьё.

Тэгээд дараа нь хариулт дээр үндэслэж тодруулъя гэж бодож байна.

Сүүлийнх нь зан үйлийн хувьд ер нь эрлийз адуу, монгол адуу хоёрын хувьд шинжилгээ хийсэн юм байгаа юу? Яг хүүхэд унаж харилцахад гэх юм уу.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос хариулъя. Эхний хүн 4 минут хариулж байгаа. Дараагийн хүмүүс 1, 1 минут.

О.Баатарцогт: Гишүүний асуултад хариулъя.

Яах вэ, би түрүүн эхний хариултдаа хэлж байсан юм. Энэ тогтоолын төсөл маань өөрөө яг үндэсний баяр наадам, уралдаан гэдэг утгаараа ерөөсөө биш юм. Ер нь монгол малын генетик тогтоц онцлогийг бид улсын үндэсний хэмжээнд бүртгэлжүүлэх асуудлыг л хөндөөд байгаа юм.

Тэгэхээр уралдаан гэдэг Монголын баяр наадмын тухай хуулиар зохицуулагдах байх гэж миний хувьд бодож байна.

Зүгээр яах вэ, судлаач хувь хүнийхээ хувьд яг эрлийз болон монгол адуунд зарцуулагдах нэг жилийн гэж тооцъё. Тийм ээ. Эдийн засгийн зардал бараг адуу гэж мэддэг бүх хүн мэдэж байгаа байх. Жоохон давуулаад хэлэх юм бол монгол хүн, ялангуяа хөдөөгийн малчид өөрсдөдөө хаврын улиралд ядаргаандаа дусал хийлгэдэггүй тэр мөнгийг тухайн малдаа зарцуулаад байгаа. Энэ нь өөрөө ер нь бид бүхний хувьд язгуураар нь монгол хүний эрүүл байх, монгол хүний эдийн засгийн алдангийг хянах, багасгах.

Гуравдугаарт нь, Монгол малын үнэ цэнийг үндэсний болон олон улсын түвшинд генетик, удам зүйн хувьд баталгаажуулах гэсэн ийм л зорилгын хүрээнд энэ асуудал дээр ач холбогдол өгч хандаж байгаа юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Эдийн засгийн тоонууд. У.Отгонбаяр гишүүн нэмж хариулъя.

У.Отгонбаяр: Тэр дундаа дотоод нөхцөл байдал, дэлхийн санхүү, эдийн засаг хүнд байгаа энэ цаг мөчид энэ бол маш тийм эмгэнэлтэй, маш тийм сэтгэл өвтгөсөн тоонууд бас гарч байгаа.

Жилдээ жишээ нь импортоор орж ирж байгаа адуунд хамгийн багадаа 75-аас 80 тэрбум төгрөг гадагшаа урсаж байна. Үүнийг дагаад эм бэлдмэл, идэш тэжээл гээд. Ингээд нийлүүлээд базаад яривал хамгийн багадаа 100 орчим тэрбум төгрөг зөвхөн импортоор орж ирж байгаа адуунд зориулж монголчууд бид төлж байгаа.

Үүнийхээ хариуд бид бүхэн Монгол Улсад бүртгэгдээгүй, дэлхийд бүртгэлтэй адууны өвчнийг үндсэндээ худалдаж авч байна гэсэн үг.

Нөгөө талаараа Монгол адууны генофондоо устгах ажлыг өөрсдийнхөө сайн дураар мөнгө төлж хийж байгаа ийм ажлууд байгаа гэдгийг би албан ёсоор дуулгая. Баярлалаа.

Х.Булгантуяа: О.Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

О.Саранчулуун: Эрүүл мэндийн талаасаа асуултынхаа хариултыг авсангүй.

Би зүгээр та хэдэд мэдээлэл өгье гэж бодож байна. **Хипотерапи** /HIPROTHERAPY/ гэж ийм эмчилгээ байдаг. Олон улсад. Энэ дээр монгол морины хувьд зан үйлийн хувьд их тохиромжтой гэж олон улсын эрдэмтэд судалгаа хийсэн байдаг юм билээ. Ялангуяа энэ бол хөдөлгөөн заслын зориулалтаар морьдыг унуулж, хүүхдүүдийн нөгөө зан үйлд үр нөлөөтэй эмчилгээ болдог ийм олон улсын маш их эмчилгээний газрууд байдаг.

Монголд энэ зүйлүүдийг хэрвээ хэрэглэж ингэж явбал хүүхдүүдийг морь унуулж уралдуулахаас гадна энэ чинь соёл уламжлал. Тийм ээ. Нөгөө талдаа монгол морины тохиромжтой энэ чиглэлээр ярьдаг ийм уяачдын холбоо, ийм мэргэжилтнүүд байдаг бол энэ үнэхээр нөгөө “Мориндоо хайртай Монгол” гэдэг шиг хэрэглээг нь илүү бүрэн дүүрэн болгох, утга агуулгыг нь илүү төгс болгоход нэмэртэй байх болов уу гэж бодож байна.

Тэгээд асуултдаа хариулаагүй ч гэсэн зүгээр мэдээлэл болгоод дуулгачихъя гэж бодож байна.

Дараа жилийн баяр наадмаар... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс хариулах уу? Санал хэллээ. Тийм ээ. Тийм. О.Саранчулуун гишүүн санал хэллээ.

Манай Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн.

М.Бадамсүрэн: Энэ тогтоолыг санаачилсан гишүүдийн нэг бөгөөд ажлын хэсэгт ажилласан.

Тэгэхээр юуны өмнө энэ тогтоолыг дэмжиж байгаа ард түмний төлөөлөл болсон парламентын гишүүддээ маш их баярлалаа гэдгээ илэрхийлье.

Тэгээд манай энэ Төрийн ордны “Их хуралдай” танхимын хойморт заларч байгаа энэ төрийн сүлдэнд морио залсан ийм улс орон Монголд дэлхийн 195 улсаас ганцхан манай Монгол Улс байх.

Хоёрт, энэ Их эзэн Чингис хааны маань хөрөг байна. Их эзэн Чингис хаан энэ монгол мориор л үндсэндээ дэлхийн талыг эзэлсэн ийм агуу түүхтэй.

Тэгэхээр аливаа улс үндэстэнд өөрийн үндэсний бахархал үнэт зүйл гэж байдаг. Энэ яах арга байхгүй монгол адуу.

Тийм учраас монгол адууны асуудал бүх нийтээрээ, ард иргэдээрээ, мэргэжлийн байгууллагууд нь, мөн парламентын гишүүд нь санал нэгдэж энэ тогтоолыг 10 жилийн хугацаатай гаргах нь зөв юм байна. Харин энэ 10 жилийн хугацаанд монгол адуугаа бүртгэлжүүлэх, монгол адууныхаа генетик нөөцийг хамгаалах, удмын санг хамгаалах ажлаа бүрэн хийж, энэ дээр тодорхой үр дүн гаргая гэдэг ийм зорилтыг дэвшүүлж байгаа гэдгийг энд илэрхийлэхийг хүсэж байна. Яагаад гэвэл монгол адуу Монголын ард түмний хамгийн том өмч байсан.

Тийм учраас жилдээ өмчөө нэг удаа тоолох буюу намартаа унагаа тамгалдаг.

Тийм учраас морины адуун сүргийн бүртгэлийг энэ бүх таван хошуу малын дундаас хамгийн түрүүнд хийхэд хамгийн оновчтой боломж бүрдэнэ гэж үзэж байгаа.

Тийм учраас монгол адууны удмын санг хамгаалах, бүртгэлжүүлэх ажлыг энэ тогтоол батлагдсаны дараа бүх нийтийн үйл хэрэг болгож, төр засаг дэмжиж, мэргэжлийн байгууллагуудтайгаа, адуучидтайгаа, мэргэжлийн холбоодтойгоо хамтарч хэрэгжүүлнэ гэдэг ийм зорилтыг цаашид бид дэвшүүлэх ёстой.

Тэгээд “тахийн удамт монгол адуу, тахилга сүлдэнд мөнхөлсөн адуу” гээд Монголын ард түмэн дуулдаг.

Тэгэхээр саяхны түүх монгол адууны өвөг болсон зэрлэг тахь Монголын нутагт бүрэн устаж байхгүй болоод, тэгээд хаа холын Европын амьтны хүрээлэнгээс энэ тахийг авчирч Монголдоо нутагжуулж байсан түүх саяхных.

Сая М.Ганхүлэг гишүүний хэлдгээр нийт адуун сүргийн 30 хувь нь их тодорхойгүй байдалд байна гэдэг. Энэ бол гуравны нэг учраас маш анхаарах түвшинд очсон байна гэдэг нь энэ судалгаанаас харагдаж байгаа.

Тийм учраас монгол адууныхаа өвгийг хамгаалах хамгийн чухал.

Дээр нь энэ 07 сарын 11, 12-ны өдрийг Монголын ард түмэн Ардын хувьсгал ялан мандуулж, тусгаар тогтнолоо баталгаажуулсан ийм түүхэн өдөр болгож тэмдэглэдэг ард түмний баяр цэнгэл наадам. Гэтэл сүүлийн үед энэ адууны эрлийз, Монгол гэдэгтэй холбоотой маргаан их гарч, энэ яг үндэсний баяр цэнгэл наадам гэдэг агуулгыг алдагдуулахад их нөлөө үзүүлж байна уу гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ бол бидний үндэсний бахархлын хувьд анхаарах ёстой нэг зүйл.

Дээр нь манай Л.Цагаандалай гавьяатын хэлдгээр Монгол Улсын төрийн тэргүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх санаачилж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энэ 07 сарын 11-ний өдөр буюу Монгол Улсын тусгаар тогтнолоо мандуулсан, Ардын хувьсгал ялсан энэ түүхэн өдөр “ДЭЛХИЙН АДУУНЫ ӨДӨР” болсон байгаа.

Тэгэхээр энэ бол утга агуулгаараа бидний хувьд Монголын ард түмний төрийн сүлдэндээ адуугаа дээдэлсэн энэ ард түмний хувьд хамгийн чухал шийдвэр болох учраас энэ дээр бүх нийтээрээ өндөр анхаарлаа хандуулж байгаа гэдэгт найдаж байгаа.

Тэгээд энд “Монголын морин спорт, уяачдын холбоо” болон “Үндэсний морин спорт, уяачдын холбоо”-ны ирүүлсэн ийм 2 албан бичиг байгаа. Хоёулаа дэмжиж байгаа. Тэгээд үүнийг... /минут дуусав/

Х.Булгантуяа: М.Бадамсүрэн гишүүн санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен.

Б.Бейсен: Байнгын хорооны даргын хувьд “Засгийн газарт чиглэл өгөх” тогтоолын төслийг дэмжиж байгаа юм.

Та бүгд нэг сайн ойлгох хэрэгтэй байгаа юм. Яагаад гэвэл улсын баяр наадамд хөдөөгийн малчид маань жилдээ нэг удаа болдог баяр наадамдаа морь уралдуулаад баярлаж цэнгэдэг. Гэтэл энэ эрлийз морьтой холбоотой малчид маань морио уралдуулж чадахгүй байгаа. Яагаад гэвэл техник хөгжсөн. Портер, КАМАЗ-аар ачиж очоод эрлийз морьд орилуулаад явчихдаг. Үүнтэй холбоотой малчид маань ер нь алсдаа малаа эрлийзжүүлж магадгүй. 5, 10 жил юм уу. Энэ хугацаанд.

Жишээлбэл, та бүгд нэг юм хэлээдэхье. Тэмээний тухай хууль гаргасан. Ямааны тухай хууль гаргаагүй мөртлөө ноолууртай холбоотой ямаа өссөн. Түүн шиг эрлийз адууг өсгөх асуудлыг малчид маань урдаа барьж магадгүй.

Тийм учраас энэ асуудал дээр онцгой анхаарах шаардлагатай.

Нөгөө талаар Монгол Улсын Үндсэн хуульд “Мал сүрэг үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна.” гээд заасан байгаа. Монгол адууны генетикийг хамгаалах нь хамгийн чухал байгаа.

Монгол адууны онцлог эрс тэс уур амьсгалтай монгол орны хүйтэн өвлийг давж гардаг. Тэжээл шаарддаггүй ийм чухал сүрэг байгаа юм. Гэтэл эрлийз адуу жилийн 4 улиралд тэжээл шаардана шүү дээ. Өвлийн хүйтэнд тэсвэр чадвар муу, уулын хадаар явж чадахгүй. Заримдаа. Монгол адуу уул хад, бүх цас зудыг тэсвэрлэж чаддаг, явж чаддаг тийм онцлогтой.

Тийм учраас монгол адууны удмыг сайн хамгаалах асуудал хамгийн чухал байгаа юм. Энэ ажлын хэсэг дээр маш их баярлаж байгаа. Цаашдаа ч үүнийг Засгийн газрын хэмжээндээ ярихгүй бол хэдэн жилийн дараа монгол адууны генетик фонд алга болсон, бүх малаа эрлийз юм уу, гадаадын эрлийз малтай эрлийзжүүлсэн тийм сүрэг оруулж ирээд монгол адууны удмын санг устгахад хүргэх юм шиг байна.

Нөгөө талаар нэг эрлийз адуунд ч юм уу, гаднаас орж ирсэнд нийт зарцуулах тэжээлийг бодоод үз. Тооцоог нь. Маш их гарна. Цаашдаа өвлийн үед эрлийзжүүлсэн адуун сүргээ бүхэлд нь тэжээлд оруулах асуудал гарна шүү дээ. Энэ дэлхийд дайгдсан монгол адууны удмын сан хамгаалах асуудал хамгийн чухал гэж бодож байна.

Тийм учраас гишүүд маань үүнийг дэмжиж өгөөрэй. Ажил хийхэд нь. Баярлалаа гэж хэлье.

Х.Булгантуяа: Б.Бейсен гишүүн санал хэллээ. Холбогдох Байнгын хорооны даргын хувьд.

Гишүүд асуулт асууж хариулт авч үг хэлж дууслаа.

Байнгын хорооны санал хураалтыг. Асуулт, санал хамтдаа шүү дээ. Асуулт, үг хамтдаа.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлнэ үү гээд алга тогшоод дэгийн тухай хуулийн дагуу асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрсийг авсан. Зарим гишүүд үг хэллээ. Зарим гишүүд асуулт асууж, хоёр дахь удаагаа үг хэлсэн байж байгаа.

Дэгийн тухай хуулийн дагуу тийм дэгтэй учраас тусад нь дахиж үг авах боломжгүй.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулахаар байгаа. Дэгийн тухай хуулийн дагуу санал хураалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулъя.

Дараагийн асуудалдаа оръё. Ес дэх асуудал.

**Ес.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох,
чөлөөх тухай асуудал**

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал яг хэлэлцэж эхэлье.

Нэр дэвшигчийн талаар гаргасан Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна.

С.Зулпхар гишүүнийг индэрт урьж байна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монгол үйлдвэрчний эвлэлийн холбооноос Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэргэдэх Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, зөвлөх багш Горчинсүрэнгийн Адъяаг Улсын Их Хуралд санал болгосон.

Байнгын хороо Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйлийг баримтлан нэр дэвшигчдийн сонсголыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Д.Далхжавыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь саналаар томилсон.

Хараат бус шинжээч нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичиг ганцаарчилсан ярилцлага хийсний үр дүнд нэр дэвшигч Г.Адъяаг мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс, зүй, туршлагын хувьд тавигдах шалгуурыг бүрэн хангасан талаарх дүгнэлтээ сонсголд танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын хоёр өдрийн дотор хуралдаанд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 84 хувийн саналаар нэр дэвшигч Г.Адъяаг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн болно.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулан Улсын Их Хурлын нийт гишүүд болон нэр дэвшигч, түүнийг санал болгосон этгээдэд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудал хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт аваагүй болно.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэн Г.Адъяаг томилох, Үндэсний зөвлөлийн гишүүнээс Ц.Сүхбаатарыг чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшсэн нэр дэвшигчийн танилцуулга, хараат бус шинжээчийн дүгнэлт, сонсголын тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын

байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Горчинсүрэнгийн Адъяа хүрэлцэн ирсэн байж байгаа.

Та бүгдэд ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Доржийн Далхжав хараат бус шинжээч, Энхбаатарын Тамир Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч, Мангалжавын Нямдаваа Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Ж.Батсуурь гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Нэр дэвшигчийг дэмжиж байгаа. Маш туршлагатай. Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан хүн байгаад их баяртай байгаа.

Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөл дээр очоод тодорхой хэмжээний үйл ажиллагаанууд дээр бодлогын түвшинд ажил хийгээсэй гэж хүсэж байгаа.

Өнөөдөр бид Монгол Улсын Засгийн газраас Нийгмийн даатгалын реформтой холбоотой асуудлууд орж ирнэ гэдэг ийм хүлээлттэй байгаа.

Өчигдөр Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нийгмийн даатгалын реформ Засгийн газрын хуралдаанаар орохтой холбогдуулаад эхлээд нийгмийн даатгалын сангийн хулгайгаа ил болго. Түүний дараагаар энэ реформоо хий гэдэг чиглэлийг өгсөн гэж хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр зарлаж байна.

Бид энэ нийгмийн даатгалтай холбоотой асуудлуудыг нэг тийш нь шийдэхгүй бол аж ахуйн нэгжүүдэд үнэхээр дарамт болж дуусаж байна.

Уян хатан тогтолцоо ерөөсөө алга. Давхардуулж нийгмийн даатгал төлөх, нэг ажил олгогчоос ажилтан авах хэмжээгээр нийгмийн даатгалын дарамтад бид өртөж байгаа.

Төрийн ярьж байгаа зүйл бол төр дандаа Нийгмийн даатгалын сан хоосорчих вий дээ л гэдэг зүйлийг ярьж байгаа юм. Яаж нийгмийн даатгалын

санг тогтвортой байлгах вэ гэдэг дээр хэрхэн уян хатан бодлого явуулах вэ гэдгийг огт хөндөхгүй байна.

Өнөөдөр бид нийгмийн даатгалын шимтгэл авах хэлбэрээр нийгмийн даатгалын санг тогтвортой байлгаснаар тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө, тодорхой хэмжээний халамжийн бодлоготой холбоотой асуудлуудаа л хөндөөд байгаа. Өрөөсгөл байгаад байгаа дээр иргэд бухимдалтай байгаа юм. 100 мянган гарын үсэг хүрсэн. Тодорхой иргэдээс D-Parliament-аар дамжуулаад өргөдлийг бид Нийгмийн бодлого, байнгын хороо авч хэлэлцсэн.

Тэгээд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл гэдэг байгууллага нийгмийн даатгалын бодлого дээр ултай суурьтай ханддаг, бодлогын түвшний үйл ажиллагаан дээр оролцдог, нийгмийн даатгалын сан тогтвортой байгаа юу, үгүй юү, бодлогын ямар хэмжээний алдаа дутагдал гарч байгаа вэ гэдэг дээр өөрсдийнхөө үг, санаа бодлоо илэрхийлдэг байгаасай гэж хүсэж байгаа.

Төрөөс үзүүлж байгаа Нийгмийн даатгалын санг битгий хоосруул, Нийгмийн даатгалын сан дампуурчих вий дээ.

Тийм учраас нийгмийн даатгалын шимтгэлийг өндөр хэмжээгээр авдаг энэ хэлбэрийг хэвээр хадгална гэдэг бодлогын эсрэг мэргэжлийн түвшний бодлогыг Монголын үйлдвэрчний эвлэл, энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл гаргадаг байгаасай гэж хүсэж байгаа.

Үүнийг Улсын Их Хурлын гишүүд дэмжинэ гэдгээ би Та бүхэнд илэрхийлмээр байна.

Аж ахуйн нэгжүүд ийг дэмжихгүйгээр, ажил олгогчийг дэмжихгүйгээр бид өнөөдөр цаашдаа ажилтай, орлоготой байх асуудалыг шийдэж чадахгүй.

Тийм учраас өнөөдөр нийгмийн даатгалын реформ бид хийж байж, ажил олгогчдоо бид дэмжиж байж нийгмийн даатгалын реформ явна гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Дэмжиж үг хэллээ.

Тэгээд нэр дэвшигчээс асуулт асуусан. Тийм ээ. 4 номерын микрофон дээрээс хариулъя. Индрийн 4 номерын микрофон дээрээс нэр дэвшигч Г.Адъяа.

Г.Адъяа: Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Тэгэхээр өнөөдөр миний бие Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэмжсэнээр нээлттэй сонгон шалгаруулалтад орж, Та бүхэнтэй энд уулзах боломж олдсондоо их баяртай байна.

Тэгэхээр нийгмийн даатгалын асуудал маань ер нь аль ч улс орны хувьд маш тулгамдсан Хөдөлмөрчдийн нийгмийн хамгааллын маш эмзэг ийм асуудал.

Тийм учраас би сая Б.Бат-Эрдэнэ гишүүний саналтай санал нэг байна. Нийгмийн даатгалын тогтолцооны реформыг үндэсний эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хөдөлмөрчдийн амьжиргааны түвшингийн өнөөгийн төлөв байдалтай уялдуулан цаашдаа яаж шинэчлэх вэ гэдэг асуудал тулгамдаж байгаа асуудал.

Харин миний хувьд сүүлийн үед Монголын өнөөгийн парламент тэтгэврийг тойрсон маш олон хэлэлцүүлэг хийж, маш олон хуулийн төслүүдийг тодорхой гишүүд, хамт олон санаачилж байгаад би энэ сэдэв цаашдаа ямар нэгэн шинэ гарцыг олох нь гэдэг дээр би санал нэг байгаа.

Тэгэхээр би Монголын үйлдвэрчний эвлэлийг төлөөлж хэлэх хүн бол яг шууд утгаараа биш. Яагаад гэвэл Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны удирдлага саяын Б.Бат-Эрдэнэ гишүүний хэлсэн саналыг анхааралдаа авах нь зүйтэй гэж үзэж байна.

Ер нь миний нэг томоохон байр суурь маань ер нь аль ч компани, байгууллага, улс орон тогтвортой хөгжилд хүрэхийн тулд хөдөлмөр эрхлэлтээ зохистой болгох энэ асуудал үнэхээр тулгамдаж байгаа асуудал. Бид тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх зорилтоо хоёр, гуравхан жилийн дараа дүгнэх гэж байна.

Тэгэхээр энэ хүрээнд бид зохистой хөдөлмөрийн нэг гол тулгуур стратегийн асуудал энэ нийгмийн хамгааллын буюу нийгмийн даатгалын асуудал.

Тэгэхээр энэ дээр бид уян хатан зөв бодлогыг хийж, тэгээд ажил олгогч, ажилтнууд ямар нэгэн байдлаар түншлэлийн хүрээнд энэ шимтгэл, хураамжийг зөв хөгжүүлж, цаашдаа ажил олгогч дарамттай биш, ажилтан хүнд тодорхой хэмжээний эрсдэл учирсан үед өөрийнхөө тэр эрсдэлийг нөхөх орлоготой байх ийм л даатгалын тогтолцоог бид үндэсний хэмжээнд хөгжүүлэх сайжруулах шаардлагатай.

Тэгэхээр энд хамгийн гол асуудал эдийн засгийн өсөлтийн асуудал байгаа.

Тэгэхээр эдийн засгийн өсөлт, баялгийн сангийн асуудал, тэгээд менежментийг сайжруулах замаар бид сая Б.Бат-Эрдэнэ гишүүний хэлсэн тэр санааг хэрэгжүүлэх тал руу явах ёстой гэдэгтэй санал нэг байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Б.Бат-Эрдэнэ гишүүн нэмж тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Ийм бодолтой байгаад нэр дэвшигч Г.Адъяад талархалтай байна.

Шимтгэл их байх нь аж ахуйн нэгжүүд, ажил олгогчдыг татвар төлөхгүй байх эрэл хайгуулд л гаргаад байгаа юм. Ний нуугүй хэлэхэд. Өнөөдөр бид тодорхой хэмжээний шимтгэлийг бууруулснаараа албан ёсны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ гэдгээ их сайн бодох ёстой. Албан бус хөдөлмөр эрхлэлт багасна гэсэн үг. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн ард талд осол, гэмтэл, хүчирхийлэл, ажлын байрны дарамт байгаа шүү.

Бид албан ёсны хөдөлмөр эрхлэлт рүү л явах ёстой. Бид аль болох иргэдээ ажлын байраар л хангах ёстой. Үүний төлөө л төр оршдог. Төр байдаг. Өнөөдөр ажлын байргүйгээс улбаатай орлогогүй. Орлогогүйгээс улбаатай архидалт. Архидалтаас улбаатай хүчирхийлэл, донтолт оршоор байгаа.

Үүнийг та Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөл дээр очоод бусад гишүүддээ сануулж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Г.Адъяа нэр дэвшигч 4 номерын микрофоноос хариулъя.

Г.Адъяа: Ер нь ажил олгогч ажилтнууд хөдөлмөр эрхлэлтийг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр нэг зүг рүү харж ажиллах ийм л хөгжлийн орчин бидэнд шаардлагатай байгаа.

Тийм учраас үүнийг бид зохистой хөдөлмөр эрхлэлтийн тэр үзэл баримтлалтай шууд холбогдох асуудал.

Тийм учраас ажил олгогчоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ гэдэг маань мөн л зохистой түвшинд л бид өнөөгийнхөө ажил олгогчдын хөгжлийн төлөв байдал, олж байгаа ашиг орлогын байдал, компанийн бүтээмжийн асуудалтай холбогдуулж шийдэх уян хатан харж үзэх асуудал гэдэгтэй санал нэг байна.

Тийм учраас би таны хэлснээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр сонгогдох юм бол Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр энэ чиглэлээрх судалгаа, энэ чиглэлээрх гишүүдийн байр суурь, энэ чиглэлээрх Засгийн газрын байр сууриудыг нягт авч хэлэлцэх шаардлагатай. Энэ үндсэн дээр би тодорхой тооцоолол дээр үндэслээд гаргасан саналуудыг авч үзэж, цаашдаа өөрийн түвшинд нийгмийн даатгалын... /минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж 1 минут өгье.

Г.Адъяа: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр сонгогдсон нөхцөлд бид нийгмийн даатгалын шимтгэл уян хатан, ажил олгогчид дарамтгүй, ажилтан хүний тэтгэврийн нөхцөл байдлыг цаашдаа дордуулахгүй авч явах тийм л тогтолцооны төлөө ажиллана гэдгээ Та бүхэнд хэлье.

Тэгэхээр Нийгмийн даатгалын хуулиар нийгмийн даатгалд шимтгэл төлөгчид буюу даатгуулагчдын эрх, үүргийн байдлыг нарийн хуульчилсан байдаг. Ялангуяа даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, тогтоох үндэс нь

- шимтгэл төлсөн хугацаа,
- шимтгэлийн хэмжээ

гэдэг зарчмыг бид хуульчилсан.

Тэгэхээр энэ хоёр үндсэн параметр дээр бид онцгой анхаарал хандуулж ажиллах шаардлагатай гэсэн үүний хувийн байр суурь ийм байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: Нэр дэвшигч Горчинсүрэнгийн Адъяа гуайг орж ирсэнд баярлаж байна. Үйлдвэрчний эвлэлд ийм мундаг төлөөллөө нэр дэвшүүлж байгаад талархалтай байна.

Өмнө нь нэг хүн оруулсан. Түүнийг арай боломгүй байна гээд. Өөрөө ч гэсэн үүнийгээ мэдрээд нэрээ татсан. Тэгээд Г.Адъяа дарга орж ирж байгаад баярлалаа.

Үнэхээрийн ховордсон хүний нэг дээ. Хөдөлмөрийн эдийн засагч. Монгол Улсад ер нь хөдөлмөрийн эдийн засагчаар сурч байгаа бэлтгэгдсэн хүн тун цөөхөн.

Эдийн засгийн ухааны доктор. Докторуудыг өнөөдөр жоохон ад үзэх талтай байхад манай цөөхөн үнэхээрийн мундаг докторуудын нэг. Үйлдвэрчний эвлэлийн Ерөнхийлөгчөөр ч олон жил ажилласан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын орон тооны зөвлөхөөр байсан. Хэний үед вэ гэхээр Т.Ганди сайдын үед.

Тэгэхээр Т.Ганди сайд ямар мундаг сайд байлаа. Түүний ард манай Г.Адъяа гуай л байсан.

Улсын Их Хурлын гишүүнээр ажилласан. Маш олон судалгаанууд хийсэн. Тэгээд өөрийнх нь энэ түүх, мэдлэг туршлагыг харахаар бид ч ёстой өнөө цагийн гишүүд болоод, өнөө цагийн залуучууд ичмээр дамшигдаа гэдэг шиг л байгаа.

Тэгээд хэрэвзээ би томилогдох юм хийж хэрэгжүүлнэ гэсэн ажил дотор тэтгэврийн гурван давхаргат тогтолцоог дэмжинэ. Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих бодлогыг хэрэгжүүлэхэд нь хувь нэмрээ оруулна. Нийгмийн даатгалын тогтолцоог улс төрийн нөлөөлөл

сонгуулийн амлалтуудаас ангид байх чиглэлд ажиллана гэсэн эдгээр заалтууд чинь үнэхээрийн биелүүлж чаддаг бол үнэхээрийн маш сайн байна.

Орлогыг нэмэгдүүлэхийн тулд баялгийн сантай холбох зэрэг энэ асуудлууд маш их чухал юм.

Яагаад ер нь энэ баялгийн сантай холбох ёстой вэ гэхээр өнөөдөр яг энэ хуримтлалын тогтолцоо гэдэг маань юу юм бэ гэхээр хүн хэдий хэмжээний шимтгэл төлнө төдий хэмжээгээр тэтгэврээ тогтоолгох. Өнөөдөр эрсдэлд орлоо гэхэд тэтгэмж нь тогтоолгогдох ийм зарчим явж байгаа.

Би дахиад хэлье. Өнөөдөр орц тал нь буурах юм бол гарц тал нь бас яг адилхан буурна. Ойлгомжтой буурна.

Тэгэхээр ажилтан талыг нь ч гэсэн харж, үүнд нөлөөлдөг юм шүү гэдгийг маш сайн хэлэхгүй бол зөвхөн орц талын л яриад байх нь эргээд гарц тал дээр нь нөлөөлөл үзүүлдэг юм шүү гэдгийг бид ярихаас өөр арга байхгүй.

1979 оноос хойш төрсөн хүмүүс нэрийн дансны аргаар тэтгэврээ тогтоолгоно буюу яг хэдий хэмжээний шимтгэлд хуримтлуулсан байна вэ түүгээрээ шимтгэл авах юм.

Тэгэхээр үүнийг маш сайн ярьж. Хэрэвзээ үнийг бууруулах гэж байгаа бол баялгийн сантайгаа холбохоос өөр арга байхгүй. Гурван давхаргат тогтолцоонд нэвтрэхээс өөр арга байхгүй гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: А.Ариунзаяа гишүүн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байсан хүний хувьд үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа Г.Адъяа гуайг би дэмжиж үг хэлэх гэж байгаа юм. Асуулт байхгүй.

Тэгээд дэмжиж байгаа шалтгааны талаар А.Ариунзаяа гишүүн маш тодорхой хэлсэн учраас үгээ давхардуулахгүй танд хэд хэдэн зүйлийг санаа аваасай гэж ингэж хэлэх гэсэн юм. Таныг тэнд очиж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл чинь хэдэн ч гишүүн байдаг юм. Тэнд очиж нэлээд. 9 гишүүн байдаг гэж байна. Тэнд нэлээд нөлөө бүхий байж чадах болов уу гэж ингэж итгэж байна.

Тэгэхээр нийгмийн даатгал хамгийн эмзэг, эргэлзээтэй сэдэв болчихоод байгаа юм. Өнөөдөр нийгмийн даатгалын үр шимийг ихэнх хүмүүс хүртэхгүй

байгаа учраас нийгмийн даатгалын шимтгэлээс зайлсхийх нэг шалтгаан байгаа юм.

Нөгөөдөх нь нийгмийн даатгал аж ахуйн нэгж, хувь хүн өөрсдөө нийлээд 20 гаруй, энэ 22 ч байна уу, 23 ч байна уу ийм өндөр хувь хэмжээгээр төлж байгаа татварынхаа үр шимийг хүртэхгүй байгаад л хамгийн гол шалтгаан байгаа юм.

Тийм учраас үүнийг ер нь нийт агуулгаар нь бууруулъя гэхээр асар их алдагдалтай явдаг гэж. Энэ алдагдал юунаас үүссэн юм бэ гэхээр ерөөсөө улс төрийн шалтгаанаас, хариуцлагагүй улс төрчдийн шалтгаанаас л үүссэн шүү дээ.

Өнөөдөр улсын төсвөөс гэхэд олон их наяд төгрөгөөр нь дотаци авдаг. Яагаад вэ гэхээр нийгмийн даатгалын олон хүний олон жилийн төлсөн хөлс, хүч хөдөлмөрийг үндсэндээ нохойн замаар оруулсан. Өнөөдөр шүүх, цагдаагийн байгууллага дээрээс нийгмийн даатгалын санг төлөх шийдвэр гарсан ч гэсэн тэр нь одоогоор хэрэгждэггүй. Түүнээс олз омог олоод явсан ийм хүмүүс ч зөндөө байдаг. Би нэг минутаа нэмчихье дарга аа.

Тийм учраас энэ тал дээр анхаарлаа хандуулж ажиллаач ээ гэж хэлэх гэж байгаа юм.

Ер нь нийгмийн даатгалын санг төр өгөөд байгаа юм шиг, улс төрчид өгөөд байгаа юм шиг энэ сэтгэл зүйгээсээ салах ёстой. Ирээдүйд өөрийнхөө эрсдэлийг энэ сангаас авна шүү, ийм ийм хэлбэрээс авна шүү гээд цалин мөнгөнөөсөө бүх насаараа төлж байна.

Дээр нь энэ хүнийг ажиллуулсныхаа төлөө энэ эрсдэлийг хуваана шүү, хуваалцана шүү гэж аж ахуйн нэгж нь төлж байгаа энэ мөнгө төгрөгийг ингэж зувчуулж ийм улс төрийн гараар ашигладаг байдлыг л зогсох хэрэгтэй юм гэж ингэж хэлэх гээд байгаа юм.

Дээр нь үүнийг хамтын тэтгэвэрийн сан гэдэг шиг ийм зүйл рүү оруулах ёстой. Жишээлэхэд аав нь, ээж нь 40 жил, 50 жил нийгмийн даатгалыг нь төлчхөөд тэгээд хорвоогийн мөнх бусыг үзлээ гэхэд тэр юуг ард нь үлдэж байгаа тэр хамтран нэг гэр бүлд байсан, хамтран хөдөлмөрлөж байсан хүмүүст нь тодорхой хэмжээний үр шимийг нь хүртдэг энэ тогтолцоо руу орох ёстой. Тэгэхгүйгээр энэ чинь амьдрал чинь өөрөө баян. Бүгдийг 70 нас хүрнэ, бүгдийг 80 нас хүрнэ гэж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмэлт. Ж.Батсуурь гишүүн нэмэлт 1 минут өгье.

Ж.Батсуурь: Тэгэхээр хувь хүнээсээ гадна аж ахуйн нэгж, байгууллага. 108 мянган аж ахуйн нэгж байна гэж байна.

Тэгэхээр үүний тархалтыг л нэмэгдүүлэх ёстой юм байгаа юм л даа. Бүгдээрээ төлдөг. Тэгээд тэр сангаа арвижуулдаг байх ёстой гэж ингэж үзэж байгаа.

Тийм учраас саяын хэлсэн асуудлуудыг би Г.Адъяа гуайг туршлагынхаа хувьд, туулсан замналынхаа хувьд, мөн би улс төрөөс таныг үндсэндээ хараат болсон гэж үзэж байгаа. Тийм зориг зүрх гаргаж энэ нийгмийн даатгал төлдөг нийт хүмүүсийн эрх ашгийн төлөө таныг ажиллаж чадна гэдэг ийм туршлагатай хүний хувьд чинь хувьд ингээд дэмжиж үг хэлж байгаа юм. Тэгээд танд амжилт хүсье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ж.Батсуурь гишүүн санал хэллээ. Нийгмийн даатгалын сангийн менежментийг сайжруулах талаар.

Санал хураалттай. Санал хураалтыг нэгдсэн журмаар төсөвтэй нэгтгээд үдээс хойш явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Нэр дэвшигчийг дэмжиж байгаа. Олон жил хамтарч ажилласан. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын түүх, боловсон хүчний нэг.

Нэг талаараа даатгуулагчийг төлөөлж байна гэдэг бол энэ маш өндөр хариуцлага. Нөгөө талаараа нийгмийн даатгалын явж ирсэн энэ алдаа оноо дунд үйлдвэрчний эвлэлийн байгууллага 80 жилийн түүхийнх нь 50-ийг нь авч явсан. Сүүлийн 30 жил алдаа оноотой зөндөө зүйл байлаа. Улс төрийнхөнд хаяж өгсөн. Хэт болчимгүй сонгуулийн амлалтад унагаасан. Уг нь хамгийн ашигтай, хамгийн тогтвортой сан байсан.

Хуулийн болон салбарчлан ялгаварлах байдлаар даатгал төлөгч нарыг бага мөнгө хийгээд нэг хэсэг нь өндөр хувиар тэтгэврээ тогтоолгодог энэ хууль эрх зүйн цоорхойнуудыг нээж өгсөн.

Тийм учраас Үндэсний зөвлөл гэдэг бол зүгээр нэг хуралд очоод нэг сайд дагаад гар өргөөд иймэрхүү байдлаар цаашаа явахгүй.

Тийм учраас нэр дэвшигч маань энэ тал дээр нээлттэй, ил тод, мэргэжлийн туршлагаа үндэслэж, долоо хэмжиж нэг огтолж байж энэ нийгмийн даатгалын энэ хуулиуд дээр гар хүрэх ёстой.

Өнгөрсөн 2023 онд бид нэлээн реформ шинж чанартай юмнуудыг хийсэн.

► Тэтгэврийг өвлүүлдэг болгосон.

► Байр, орон сууц, эрүүл мэндийнх нь эрсдэлд нэг удаадаа зарлага гаргаж болдог болсон.

- Системийн банкнууд эх үүсвэр байршуулахад нь хийдэг болсон.
- Олон жил төлсөн хүмүүс нь арай илүү тэтгэвэр тогтоодог, тогтоолгодог ийм боломжуудыг нь нээж өгсөн.

Дутуу юмнууд бий. Сүүлийнхээ 5 жилийг хамгийн өндрөөр төлөөд л хамгийн өндөр тэтгэвэр авч байгаа жилд өнөөдөр 3 мянган хүн байна гэж байгаа.

Энэ бол нэг талаараа шударга бус. Үүнийг засах гэж байна гээд 30, 40 жил явж байсан хүмүүсийн тэтгэврийн насыг дунджаар тооцдог, 5 жилээр тооцдогийг нь 7, 8 жил болгож байдаг нь нэг талаараа буруу.

Тийм учраас шударга юмыг хийхийн тулд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, ялангуяа энэ Их Хурлаар нийгмийн даатгалын хуулиуд ингээд орж ирж байгаадаа маш нухацтай ажиллах ёстой шүү.

Бид сэтгэл хөөрлөө нэг удаадаа өм цөм бууруулж болно. Эргээд хэд дахин алдагдлыг нөхөх зорилгоор нэмэх ийм аюул бий. 2017, 2018 онд нэмэх асуудал. 5 пунктээр нэм гээд эргүүлээд ороод ирсэн.

Тийм учраас бид долоо хэмжиж нэг огтлох дээр Үндэсний зөвлөлийн эрх үүрэг өндөр байх ёстой, хараат бус байх ёстой. Журмыг нь би нээлттэй хийж өгч байсан. Нээлттэй хуралдана гэж.

Одоо манай чуулган нээлттэй явж байгаа. Үүнтэй адилхан хуралддаг байх хэрэгтэй. Чухал асуудлуудаар нь. Шаардлагатай тохиолдолд энэ үйлдвэрчний эвлэлийн байгууллага, даатгал төлөгч нар талбай дээрээ гардаг байх хэрэгтэй байгаа. Энэ үнэт зүйл, зарчим, ирээдүйд ажилчин хүмүүс өндөр тэтгэвэртэй, зээлээс зээлийн хооронд амьдардаг байдал руу нь аваачихгүйн тулд. Өнөөдрийн сэтгэл хөөрөл зарим нэгэн дутуу тооцоо, улс төрийн амлалтаас болж.

Тийм учраас энэ тал дээр илүү сайн ажиллаарай гэдгийг хэлмээр байна. Нэг минутаа авчихъя дарга аа. Үргэлжлүүлээд нэг зүйлийг хэлээдэхье.

Х.Булгантуяа: С.Эрдэнэбат гишүүнд нэмж 1 минут өгье.

С.Эрдэнэбат: Сая энэ тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал хүртэл үндэсний зөвлөлөөр орж ирж шийдэгдэж байх ёстой асуудал байгаа. Олон мянган ахмадууд байж байна. Нэг өдөр авдаг тэтгэврийн 70 хувиар нь бууруулаад, үндсэндээ 80 хувь нь амьжиргаагаа чадан ядан хүргэхгүйдээ бараг ийм орчинд л байгаа.

Тэгэхээр ирээдүйд өнөөдрийн төлж байгаа залуучуудыг ирэх 30 жилийн дараа тэтгэвэрт гарахад нь бид ийм хувь заяатай угтуулахгүйн тулд Үндэсний

зөвлөл маш санаачилгатай, зөвхөн төрийг хараад суудаг биш өөрсдөө идэвх зүтгэлтэй, хараат бусаар ажиллах хэрэгтэй.

Үйлдвэрлэлийн ослын сан гээд байгаа. Г.Адъяа дарга аа, та сайн мэднэ. Энэ санг чинь үндсэндээ хамгийн их ашигтай учраас банканд хадгалуулаад, тэр шимтгэлийг бараг байхгүй болгоё гэдэг ухааны юм ярих гээд байна.

Маш олон хүн үйлдвэрлэлийн осол, аваарт өртөж байгаа. Урьдчилан сэргийлэх зардалд, эмчилгээ сувилгаанд нь, тэтгэвэр, тэтгэмжид нь, ажил олгогчийг эрсдэлээс хамгаалахад нь тусалж ажиллах ийм юман дээр хатуу байр суурьтай байгаарай гэдгийг хэлмээр байна.

Тэгээд амжилт хүсье.

Х.Булгантуяа: С.Эрдэнэбат гишүүн Монголын үйлдвэрчний холбооны ерөнхийлөгчөөр ажиллаж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан хүний хувьд санал хэллээ. Г.Адъяа нэр дэвшигчид.

О.Цогтгэрэл гишүүн нэрээ татсан. Тийм ээ. О.Цогтгэрэл гишүүн нэрээ татлаа.

Би бас хэдэн үгийг хэлье гэж бодлоо. Манай Г.Адъяа нэр дэвшигчийг дэмжиж байна. Энэ бол нийгмийн даатгалын сангийн менежмент нэн чухал асуудал.

Түрүүн хэд хэдэн гишүүд хэлж байна. Гишүүд ер нь нийгмийн даатгалын сангийнхаа менежментийг сайжруулах талаар хүмүүс бага дуугарч байна гээд. Тэгээд манай Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, энэ чиглэлийн мэргэжилтэн, судлаачид оролцоод 2023 онд батлуулж, 2024 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн нийгмийн даатгалын багц хууль дээр ялангуяа нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг байршуулахтай холбоотой нэлээдгүй сайн зүйл заалтууд суусан.

Одоо заавал Монголбанкнаас зөвшөөрөл авдаг. Тэгээд энэ дээрээ ялангуяа эрсдэл багатай томоохон банкуудад байршуулна. Ингээд менежментийг нь хэрхэн хийх вэ гэдэг талаарх зохицуулалтуудыг бид хийж өгсөн.

Хөрөнгийн удирдлагыг нь тэр битгий хэл зөвлөлтэй байна. Тэр хөрөнгийн удирдлагын зөвлөлд нь санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтаар мэргэшсэн хүмүүс ажиллана гэж бид оруулж өгсөн. Яагаад гэвэл одоо ажил олгогчдын төлөөлөл, Засгийн газрын төлөөлөл, ажилчдын төлөөлөл буюу үйлдвэрчний эвлэлийн төлөөллүүд гэж орж байгаа ч гэсэн хэдэн их наяд, хэдэн тэрбумын төсвийг хаана яаж байршуулах вэ гэдэг талаарх нарийн тооцооллын хийнэ гэдэг бол ахиад өөр арга зүйн мэргэжил ур чадвар байдаг учраас бид хамтдаа энэ

сангийн менежментийг хийхийн тулд нийгмийн даатгалын багц хууль дээр оруулж өгсөн.

Тэгэхээр үүний хэрэгжилтийг хангах нь нэн чухал юм.

Г.Адъяа нэр дэвшигч нэг бодлын бас манай нийгмийн даатгалын шимтгэлээ ажил хөдөлмөр эрхэлж байхдаа төлчхөөд, одоо тэтгэвэр авч байгаа хүмүүсийг төлөөлж манай Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд сууж байгаа, одоо нэр дэвшиж байгаа гэж би ойлгож байгаа. Нийгмийн даатгалын шимтгэлээ өнөөдөр төлж байгаа 1.2 сая орчим иргэн байгаа. Эндээс үр шимээ хүртээд явж байгаа 500 орчим мянган тэтгэвэр авагчид байгаа.

Тэгэхээр бид нар бас нөгөө талдаа шимтгэл төлөгчдийн болон ажил олгогчдын төлөөлөл байхаас гадна шимтгэлээ төлчхөөд өнөөдөр тэтгэвэр авч байгаа манай ахмадуудын төлөөлөл заавал энд байж байж энэ сангийн нөгөө талдаа авч байгаа хүмүүс маань энэ сангийн удирдлага дээр бас дуу хоолойгоо өргөж оролцох ёстой юм.

Нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа 1.2 сая хүн байгаа бол түрүүний хэлсэнчлэн 500 орчим мянган тэтгэвэр авагчид байгаа. Монгол Улсад өнөөдөр 10 хүн тутмын нэг нь ахмад настан байгаа бол тун удахгүй 25 жилийн дараа 5 хүн тутмын нэг нь ахмад настан болох гэж байгаа.

Тэгэхээр энэ сан дээр өөрийн эрхгүй ачаалал ирнэ. Тэгэхдээ ачаалал ирнэ гээд бид сангаа мөнгөгүй болгочхоод ирээдүйд хүний амьдрал болсон хойно ахмад настан болохоор тэтгэвэр байхгүй, улсаасаа халамж нэхээд, эсвэл үр хүүхдүүдээсээ мөнгө нэхээд явдаг биш, энэ сангийн менежментийг улам сайн сайжруулахын төлөө Г.Адъяа дарга хуулиа хэрэгжүүлээд, шаардлагатай бол хуульд нь өөрчлөлт оруулах санал санаачилгыг гаргаад явна гэдэгт итгэлтэй байна.

Тэгээд Г.Адъяа нэр дэвшигчдээ амжилт хүсье.

Нэр дэвшилттэй холбоотой санал хураалтыг мөн үдээс хойш хамтатган санал хураалтыг явуулъя.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх. Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцүүлгийг.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн өргөн барьсан байгаа.

Төсөл санаачлагч төр байхгүй байгаа тул дараагийн асуудалдаа орж байгаад дараагийн асуудлынхаа араас хамтатган хэлэлцээд явъя.

Дараагийн асуудалдаа оръё. Арван нэгдүгээр асуудал.

**Арав.Монгол Улсын нэгдсэн төсвийн
2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Улсын Их Хурлын гишүүд чуулганы танхимдаа цуглаарай.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Төсвийн байнгын хороо саяхан дуусаад санал, дүгнэлтээ нэгтгээд орж ирэх гэж байх шиг байна.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 онд төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 07 сарын 04-ний өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед дэмжигдсэн зарчмын саналуудыг төсөлд тусган төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах нь зүйтэй гэж үзсэн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 онд Төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 онд төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээг 2025 онд 5.5 хувь, 2026 онд 6 хувь, 2027 онд 6.5 хувь байх, хэрэглээний үнийн өсөлтийг 2025 онд 9.5, 2026 онд 7 хувь, 2027 онд 6.4 байхаар тооцсон.

Мөн макро эдийн засгийн үндсэн үйлдлүүдтэй уялдуулан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 2025 онд 30 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 33.6 хувь, нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээг 31.5 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35.1 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 1 их наяд 365 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний хасах 1.5 хувьтай тэнцэхээр байна.

Хуулийн төслийн эцсийн хувилбарын төслийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн гишүүдийг нэрлэе.

Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын төлөвлөлтийн газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батчулууны Мөнгөнсүх ирээгүй байна. Очиржанцангийн Мөнхтөр, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга.

Энэ ирээгүй байгаа хүмүүсээ оруулаарай.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Миний нэрийг хойшлуулчих.

Даваагийн Цогтбаатар асуулт асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Түрүүн Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргаад Өвөрхангай аймагт хийгдэж байгаа гэр хорооллын шугам сүлжээний ажлын гүйцэтгэлтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргаж Улсын Их Хурлын гишүүд Төсвийн байнгын хороон дээр дэмжээгүй саналыг дэмжээгүйгээр босгож ирж өгсөн гишүүддээ баярлалаа.

Тэгээд улс орны эдийн засгийн нөхцөл байдал жоохон хүндэрч байгаатай холбоотойгоор Засгийн газрын нөөц хөрөнгөөс авч энэ ажлыг гүйцээлгэх байсан зарчмын зөрүүтэй саналаа эргүүлэн татаж байгаа гэдгээ хэлэх гэсэн юм.

Б.Пүрэвдорж: Зөв байна. Ер нь бол ийм санал гаргана гэдэг чинь тийм амар биш.

Дараагийнх нь Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Улс орны эдийн засаг дотоод гадаад аль аль хүчин зүйлээс шалтгаалаад хүндрэлтэй байдалд орсон гэдгийг бүгд ойлгож байгаа.

Гэхдээ бид нарт ямар ч үед хөндөж болдоггүй нэг хүчин зүйл баймаар байна. Тэр нь ус. Ерөөсөө Монгол Улсын хэмжээнд төдийгөөс өдий хүртэл усыг дандаа тийм нэг хорон санаатай хойд эцгийн юм шиг зангаар хандаж ирсэн байна л даа.

Одоо өнөөдөр жишээ нь төсвийн тодотголоор мөнгөнүүдийг хасаж байхад усан дээр ерөөсөө 5-хан тэрбум байгаа байхгүй юу. Тэрийг нь хасчхаж байгаа юм. Гэтэл ойн газар, ус цаг уур дээр болохоор мөнгийг нь бараг хасаагүй хэвээрээ байгаа. Тэр хоёр дээр тэр мөнгө нь 60 хэдэн тэрбум нь явах нь зөв. Гэхдээ бид өнөөдөр дэлхий нийтээр байгаль экологио анхаарсан, цөлжилтийн эсрэг явж байгаа, олон улсын гэрээ конвенцод даган орсон, 2026 онд НҮБ-ын цөлжилтийн эсрэг COP-17-г Монгол Улсдаа зохион байгуулах гэж байгаа ийм үед дэлхий даяар ногоон зээл, ногоон хөгжлийн төлөө явж байгаа энэ үед бид ингэж усан дээр хоёрын хооронд мөнгө харамладаг баймааргүй байгаа юм.

Тэгэхээр нийт гишүүддээ, Засгийн газрын гишүүдэд ямар ч хүндрэлтэй үе тохиолдож болно. Намар цалингаа ч тавьж чадахгүй байж болно. Гэхдээ бид усны мөнгийг л хасдаггүй баймаар байна. Энэ дээр л санал хэлж байгаа юм. Ямар ч хэцүү үед бид байгаль орчноо хайрлах ёстой, усаа хайрлах ёстой, Монгол Улс усны дутагдалд ороход хэдхэн жил дутуу байгаа. Энэ үед Та бүхэн үүнийг анхаарч ажиллаач ээ гэж хүсэх хүсэлт байна.

Б.Пүрэвдорж: Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууна.

Б.Заяабал: Баярлалаа.

Тэгэхээр өнөөдөр 2025 оны төсвийн хүрээ, 2026-2027 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт хийх энэ хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг болж байна.

Энэ дээр эдийн засгийн гол гол үзүүлэлтүүд ингээд доошоо буулгасан ийм л асуудлууд орж ирж байгаа л даа. Жишээлбэл,

➤ Эдийн засгийн өсөлтийг 8 хувь байтал 5 хувь болгож бууруулсан. Өмнө нь бидэнд 8 хувиар баталсан. Одоо 5 хувь болгож бууруулж баталж байна.

➤ Инфляцын зорилтот хэмжээ 7 хувь байсан. Одоо 9 хувь болгож нэмэгдүүлж орж ирж байна.

➤ Төсвийн орлого, төсвийн орлого, зарлагыгаа бид буулгаж орж ирж байна.

Гэх мэтчилэнгээр эдийн засгийн том том үзүүлэлтүүдийг бид томоохон өөрчлөлт хийж орж ирж байгаа юм.

Гэхдээ миний асуух гээд байгаа зүйл нь буулгасан ч гэсэн эдийн засгийнхаа өсөлтийн хэмжээгээ энэ жилдээ бид хадгалж чадах уу гэдэг дээр надад эргэлзээтэй байгаад байгаа юм.

Яагаад гэвэл өнөөдөр нүүрсний үнийн асуудал чинь маш доогуур болсон байгаа. Зэсийн тооцоолол байна. Цаанаа эдийн засгийн өсөлтийг авчрах гол өөрчлөлт нь зэсийн тооцоолол гэж тооцож байгаа боловч энэ Оюу Толгойн асуудлууд чинь ер нь юу болж байгаа юм бэ?

Оюу Толгойн татварын маргаантай холбоотой асуудлууд явж байна. 2, 3 жил явлаа. Энэ дээр ер нь ямар ахиц байгаа юм бэ?

Дубайн гэрээг хүчингүй болгосон. Дубайн гэрээг хүчингүй болгосонтой холбоотой тооцоолол, нэгтгэл нь Засгийн газар дээр дуусгаагүй байгаа. Энэ асуудал ямар шатандаа явж байгаа юм бэ?

ENTRÉE-той холбоотой, шинэ ордтой холбоотой асуудлууд яригдсан. Улсын Их Хурлын 89 гишүүн энэ дээр гарын үсэг зураад хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахтай холбоотой асуудлуудыг нэлээдгүй их ярьж байгаа.

Тэгээд Оюу Толгой бол яг ийм асуудал дээр эргээд дахиад л нэг юм гаргаж ирдэг л дээ.

Тэгээд иймэрхүү томоохон хөрөнгө оруулагчтай холбоотой маргаантай асуудлууд чинь эргээд энэ эдийн засгийн чинь 5 хувьд өсөлтийг хадгална гэсэн 2025 оны чинь тооцоолыг бүрэн хийх боломжийг бүрдүүлж өгөх юм уу?

Алтны аян гээд яриад байна. Алт өнөөдөр яг энэ нүүрсний алдаж байгаа орлогыг нөхөж чадахгүй шүү дээ. Ямар ч боломжгүй. Намар гэхэд хэдэн тонн алт авна гэж байгаа. Тэр алтыг алт худалдаж авдаг гаднын арилжааны банкнуудаас урьдчилаад зээл аваад л тэрийгээ интервенц хийхэд ашиглах л, богино хугацааны төлбөрийн баланс дээрээ ашиглах ийм л зүйлийг Засгийн газар бодож явж байгаа гэж ойлгож байгаа.

Өнөөдөр ингээд аваад үзэх юм бол эдийн засгийнхаа буулгаад 5 хувь болгосон хувь хэмжээндээ бид барьж чадах уу гэдэг дээр надад итгэл дундуур байгаа. Энэ дээрээ тодорхой нэгдүгээрт хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь, бид ингээд өнөөдрөөрөө л амьдраад л яваад байна л даа. Өнөөдрөөрөө амьдраад л, өнөөдөр олсон мөнгөө Улаанбаатар хотын 500 бонд гэсэн, EBRD-ийн 300 сая доллар л гэсэн, арилжааны банкнуудын гадаадад байршуулсан мөнгө гэсэн. Одоо Хөгжлийн банкны 350 сая доллар гээд л дандаа асуудлыг хойшоо шийдээд өнөөдрөөрөө бид амьдраад яваад байгаа юм. Гаднаас орж ирж байгаа хөрөнгө оруулалт ерөөсөө байхгүй.

Тэгэхээр эдийн засгийн өсөлтөө яаж авч явах гэж байгаа юм бэ? Ямар дүр зураг байгаа юм бэ? Гаднын хөрөнгө оруулалт, гаднаас орж ирэх мөнгө, орлогыг нэмэгдүүлэхтэй холбоотой ямар арга хэмжээ авах юм бэ гэж.

Өмнөх Засгийн газар нүүрсний асуудалтай холбоотой тэмцэж, даргын ширээн дээр нүүрсний үнэ, хэмжээгээ тогтож зардаг байсан бол үүнийг биржээр нээлттэй зардаг өрсөлдөөнт хэлбэр лүү оруулж ирсэнтэй холбоотойгоор 2023, 2024 оны эдийн засгийн өсөлт бид бүхний бялуурлын эхлэлийг тэндээс тавьж байсан. Тэндээс тавьж байсан. Яг үүнтэй дүйхүйц ямар бодлогын арга хэмжээг оруулж ирэх гэж байгаа юм бэ?

Гадаад нөхцөл байдал энэ Украин, Оросын асуудал, Хятад, Тайванийн асуудал, Иран, Израил, Ойрх Дорнод, дээрээс нь Трампын 04 сарын 9-нд гаргаж ирсэн худалдааны тарифын асуудлыг 3 сараар хойшлуулаад 07 сарын 09-нээр дахиад нэг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн 4 номер. Хэн бэ? Нэрээ хэлээд гишүүний асуултад хариулъя.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яамнаас Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан. Гишүүний асуултад хариулъя.

Эдийн засгийн өсөлтийг өнгөрсөн жил 8 хувь гэж баталж байсан бол энэ удаа 5.5 болгож бууруулж орж ирж байгаа. Гол бууруулсан шалтгаан нь манай улсын экспортын орлого буурсан. Тэр нь гадаад зах зээлээс үүдэлтэй нүүрсний үнэ буурсантай холбоотой. Ингээд төсвийн орлого буурсан. Мөн төсвийн

зарлага буурч байгаа нь өөрөө эдийн засгийн эрэлтийн нэг хэсэг байдаг. Ингээд өсөлтийг бууруулж байгаа.

Гишүүний хэлж байгаагаар эдийн засгийн өсөлт 5.5-ыг хангахгүй байх эрсдэл байгаа юу гэвэл байгаа. Үүний эсрэг Засгийн газар дээр өсөлтөө 5-аас дээш хувьд хадгалахад тодорхой арга хэмжээнүүд төлөвлөж байгаа.

Гол хүчин зүйл бол энэ жил манай хэрэгжиж байгаа зэсийн ордууд дээр агууламжийн өндөр үечлэлийн хэсэг рүү олборлолт эхэлж байгаа. Үүнтэй холбоотойгоор манай өсөлтийн гол эх үүсвэр зэс байх болно. Ялангуяа Оюу Толгойн олборлолт. Эрдэнэтийн үйл ажиллагаа тогтвортой явж байгаа.

Дээр нь үйлчилгээний салбарыг дэмжсэн бодлогууд үргэлжлэн хэрэгжиж байгаа. Аялал жуулчлал байна.

Эхний улирлын байдлаар хөдөө аж ахуйн салбар маш сайн гарсан. 35 хувийн өсөлттэй гарсан. Өнгөрсөн 2 жил унасан нь нөгөө суурийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн өсөлтийн гол нэг хүчин зүйл байх болно.

Тэгээд дээшээ доошоо эрсдэлүүд байгаа. Бид хэд хамгийн боломжит дундын хувилбар буюу 5.5 дээр тооцоо оруулж ирсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Баатаржавын Мөнхсоёл гишүүн алга байна.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Төсвийн хүрээний мэдэгдэл дээр эдийн засгийн өсөлтийг өөдрөгөөр төсөөлж харж байгаа юм байна.

Нөгөө талд инфляцыг буурна. 7, 6 руу байна гэж харж байгаа юм байна. Яг ийм бодит боломж бололцоог хэрхэн яаж харж байгаа вэ? Одоо инфляц чинь 9, 10 хувь руу өссөн байгаа үед энэ хэт өөдрөгөөр төсөөлөх. Үүнийг дагаад бусад нэмэгдэл юмнууд дагадаг учраас би үүнийг хэлээд байна.

Сая 6 хувиар инфляц өснө гээд цалин нэмсэн боловч инфляц 9 хувь, 10 хувь руу ороод ирсэн. Цаанаа эдийн засгийн үр дагавруудтай учраас үүнийг би тодруулж асуумаар байна.

Хоёрдугаарт, эдийн засгийн хүндрэлийн байдал маш олон цомхотгол, төсвийн таналтууд гээд эдийн засаг нэлээн агшина.

Эсрэгээрээ төсвөөс хамаарсан агшилтыг аль салбараас нөхөх гэдэг байдлаар та бүгд оруулж ирж байгаа вэ? Сая статистикийн тоо харахад хөдөө аж ахуй 30 хувиар өссөн байна лээ. Бусад салбарууд ихэнх нь жоохон бууралттай байгаад байдаг. Мэдээлэл, технологийн салбар өссөн байна лээ.

Тэгэхээр энэ мэдээлэл технологи болон хөдөө аж ахуй, энэ салбаруудаас нөхнө гэж бодож байна уу? Эсвэл уул уурхай буюу алт хөтөлбөр гэдэг юм уу. Эндээс нөхнө гэж бодож байгаа юм уу?

Тийм учраас бидний төсвийн 3 орчим их наяд төгрөг танана гэдэг чинь нэг талаараа маш их эдийн засгийг агшаах, хумих ийм бодлогын асуудал байгаа.

Тийм учраас энэ тал дээр нэг тодруулж Та бүгдэд хэлж өгнө үү гэдгийг хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Асуултад индрийн 4 номероос хариулъя. Нэрээ хэлээрэй.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам. Л.Энх-Амгалан. Гишүүний асуултад хариулъя.

Инфляц дээр 9.5 хувь гэж оруулж ирсэн. Монголбанкны зорилтот түвшин 8 хувь байдаг.

Мэдээж Засгийн газрын хувьд Монголбанктай бодлогоо нийлүүлэх, Монголбанкны зорилтот түвшин буюу 8 хувийг хангаж ажиллахыг хичээж бодлогоо тийшээ тохируулж ажиллаж байгаа.

Энэ төсвийн зарлагыг хасаж байгаа нь ч гэсэн Монголбанкны зорилтот түвшинтэй инфляцаа нийцүүлэх нэг гол арга хэмжээ байгаа. Гэхдээ инфляцын хувьд дээшээ өсөх эрсдэл өндөр байгаа. Тэр агуулгаар нь төсвийн хүрээний мэдэгдэл дээр бодит тооцоо хийхдээ инфляцыг бага зэрэг өндрөөр оруулж ирсэн байгаа.

Эдийн засгийн өсөлтийг хаанаас нөхөх вэ гэж асууж байна. Гол эх үүсвэр бол таны хэлж байгаатай адилхан хөдөө аж ахуйн салбар. Эхний улирлын байдлаар гол үндсэн салбарууд уул уурхай, тээврийн салбар байгаа. Гэхдээ цаашдаа тээврийн салбарын уналтыг бусад үйлчилгээний салбарынх нь өсөлт нөхнө гэж харж байгаа юм.

Уул уурхайн салбар дээр удааширсан асуудал бол хөдөө аж ахуйн салбар дээр нэлээд нөхөгдөнө. Алт хөтөлбөрийн тухайд төсвийн орлого эдийн засгийн өсөлтөд учиргүй том нөлөө байхгүй. Валютын нөөцөд л гол нь нөлөөтэй тийм арга хэмжээ байгаа.

Б.Пүрэвдорж: Банзрагчийн Түвшин асуулт асууя.

Б.Түвшин: Тэгэхээр Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, төсвийг ингээд олон янзаар хэдүүлээ тодотгоод л явж байна. Одоо хэн нэгнийг буруутгахаасаа илүүтэй энэ бүх хуулиуд чинь өөрөө нөхцөл байдалд хувьсаад байдаг. Үүний цаана яг агуулга нь юу болоод байна вэ

гэхээр бид эдийн засгийн нөхцөл байдлаа ерөөсөө 3, 4 жилээр харж чадахгүй, цаг тухай болгонд нь ерөөсөө төлөвлөж чадахгүй байна гэсэн үг.

Тэгэхээр ерөөсөө энэ төсвийн хүрээг одоо тодотголоос үл хамааралтай болгох боломж нэгдүгээрт юу байна вэ? Тодотгол хийх болохоор төсвийн хүрээгээ өөрчилдөг. Төсвийн хүрээ нь ирээдүйн 3 жилд бид эдийн засгаа барьж явна гэсэн ийм агуулга явж байдаг.

Хоёрдугаарт, төсвийн хүрээний агуулгын цаана ерөөсөө бид энэ төсвийнхөө агуулгыг ингээд их явцууруулж харагдаад байна л даа. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн удирдах энэ бодлогын бичиг баримтыг бид гаргаж байтал яг л улсын төсвийн орлогыг хурааж, зарлагыг гаргаж байгаа байдал шиг гаргаж ирдэг. Тэгээд энэ нь тодорхой нүүрс, зэсээс болонгуут л бид өсгөдөг, бууруулдаг. Үүнийгээ дагаад төсвийн тогтвортой байдлынхаа тухай хуулиа өөрчилдөг.

Тэгэхээр ямар арга зам хэрэглэж байж бид энэ тогтворгүй орчныг тодорхойлж байж ирээдүйн энэ 3 жилээ тогтвортой байдлаар томъёолж ийшийгээ зорьж ажиллах вэ гэдэг нэгдүгээр асуулт байж байгаа юм.

Хоёрдугаар асуудал нь ерөөсөө энэ төсвийн хүрээний мэдэгдлийг ямар мэргэжлийн түвшинд хийж хэдүүлээ сайжруулах вэ? Ингээд байн байн өөрчлөөд байх юм уу? Ер нь энэ байн байн өөрчлөөд байгаагийн цаана зарлага нь гараад явчихдаг. Орлогоо бид тодотгодог. Тэгээд дараа дараагийн алдагдлууд нь асар их ихэсдэг.

Тэгэхээр энэ төсвийн хүрээний мэдэгдлийг мэргэжлийн түвшинд хийж, илүү тогтвортой, жилдээ хөдөлдөггүй, 3 жилдээ ч бараг цөөнх хөдөлдөг ийм болох арга зүйн талаасаа та хэд нэг тодорхой хариулт өгөөдхөөч.

Б.Пүрэвдорж: Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд хариулна.

Н.Учрал: Энэ төсвийн хүрээний мэдэгдлийг Эдийн засаг, хөгжлийн яам нь хуулиараа оруулж ирдэг. Түүнд нь Сангийн яам төсөв хийдэг ийм хууль, эрх зүйн орчныг өнгөрсөн парламентын үед бид бүрдүүлсэн.

Тэгэхээр энэ өөрөө дэвшил.

Тэгэхээр энэ төсвийн хүрээг өргөж хөндөхгүй байх. Үүнийг тогтвортой авч явахын тулд бид нэг ийм хоёр арга зам байгаа юм. Жишээ нь, эдийн засаг өсөж байхад энэ 3 сар гээд байгаа энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийн тэр 3 сар их тийм сайн ажиллана. Мэдээж эдийн засаг өсөж байгаа үед. Орлого, зарлага хоёулаа багасаж байгаа үед зайлшгүй төсвийн хүрээг өөрчлөөд түүндээ төсвөө барьдаг тодотгол хийхээс өөр арга зам байхгүй.

Тэгээд та мэдэж байгаа. Мэдээж экспортын 50 хувь нь нүүрснээс хамааралтай.

Тэгэхээр энэ өөрөө нүүрсний үнэ өөрөө гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаалаад хэлбэлзэлтэй, тааж таамаглаж болохгүй өдөр өдрөөр өөрчлөгдөж байгаа энэ цаг үед ийм 3 сар гэдэг хатуу тоо бариад яг тэр төсвийн хүрээгээ хөндөхгүй яваад байна гэдэг маш бэрхшээлтэй гэж ойлгож болно.

Тэгээд Эдийн засгийн яам энэ макро үзүүлэлтүүдийг олон улсын байгууллагуудын нөхцөл байдалтай уялдуулж шинэчилж байгаа. Гэхдээ **“тодорхойгүй байдлын индекс” /VOLATILITY INDEX/** гэдэг индекс түүхэн дээд түвшиндээ хүрсэн.

Тэгэхээр ийм “тодорхойгүй байдлын индекс” ийм түүхэн дээд түвшиндээ хүрчхээд байгаа энэ үед бид 3 сарын өмнө экспортын 50 хувь нүүрснээс хамааралтай төсвийн орлогынх нь 23 хувийг нүүрс бүрдүүлдэг ийм улс 3 сараар урьдчилан тооцно гэдэг бол маш их тийм бэрхшээл дагуулж байгаа юм.

Гэхдээ бид энэ төсвийн бодлого дээрээ нэг зүйлийг хатуу ойлгох ёстой. Эдийн засаг агшиж байгаа үед бид тэлэх бодлого барина. Халж байгаа үед хумих бодлого л барьдаг.

Тэгэхээр энэ өөрөө юу юм бэ гэхээр нөгөө мөчлөг сөрсөн бодлого зайлшгүй хэрэгжүүлэх ёстой.

Магадгүй эдийн засаг агшиж байгаа үед хэмнээд байгаа мөртлөө тодорхой төсвийн алдагдалд тооцоод түүн дээрээ эдийн засгаа тэлэх бодлого барихгүй бол. Дээрээс нь:

- чөлөөт зах зээлээ дэмжих;
- хувийн хэвшил, баялаг бүтээгч нар дээр үүсээд байгаа хүнд суртлуудыг арилгах;
- зөвшөөрлүүдийг илүү богино хугацаанд шийдвэрлэдэг болох;
- баялаг бүтээгчдийг татварын бодлогоор дэмжих чиглэл рүү явах;
- гадаад зээл, тусламжийг нэмэгдүүлэх.

Яагаад гэхээр инфляцад шууд нөлөөлөл нь багатай.

Тийм учраас ингэж явахгүй бол болохгүй нь. Магадгүй халж байгаа үед хумиад хуримтлал үүсгэх гэдэг ийм хоёр төсвийн бодлого дээр л явна.

Тийм учраас зөвхөн хэмнэх биш, бид энэ үед тэлэх бодлогын хүрээнд баялаг бүтээгчдийг дэмжих эрх зүйн орчныг намар оруулж ирье ээ л гэж байна.

Б.Пүрэвдорж: Банзрагчийн Түвшин гишүүн нэмж тодруулъя.

Б.Түвшин: Яах вэ, ер нь Н.Учрал сайдтай яг энэ арга зүйн талаа ингээд бэхжүүлээд явбал төсвийн хүрээний тогтвортой байдал энэ тэр ч гэсэн сайжраад явах байх.

Тэгэхдээ нэг зүйлийг тодруулж хэлье гэж бодож байна.

Өнгөрсөн намар төсвийн асуудлыг хэлэлцэж байхад 5 их наядаар буулгаач ээ. 30 их наяд болох гээд байна гэдэг асуудлуудыг ярьсан. Тэгээд хоржоонтой юм шиг бид хэдүүлээ яг л 30 руу л орж байна.

Тэгэхээр Н.Учрал сайд аа, яг энэ асуудлыг тогтвортой байлгахын тулд мэргэжлийн байдлуудаа хангахаас гадна энэ улсын төсвийн зарлага дээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас нэг томоохон бодлого бариач ээ.

Ерөөсөө манай Монгол Улсын төсөв сүүлийн 10 жил огцом өслөө. Яаж ч өссөн бидний нийгэм, эдийн засагт нөлөө гардаггүй.

Тэгэхээр ийм нөлөөтэй биш зардлуудыг хасдаг аргачлалууд бас олон улсад байж байгаа. Жишээлбэл, барууны орнууд COST-BENEFIT ANALYSIS_[зардал-үр ашгийн шинжилгээ]... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж гүйцээе.

Б.Түвшин: Ерөөсөө л 5 мянган доллараас дээших бүх зардлууд дээр COST-BENEFIT ANALYSIS хийгээд энэ зардал гарснаараа нийгэм, эдийн засагт ямар импакт үзүүлж байна. Үүнийг нь оруулдаг байя. Үүнээс бусад зардал гардаг үед.

Миний харж байгаагаар манай улсын төсвийн зардлуудыг сая бид ингээд л хасах гээд л нэлээн махаа зулгаалаа. Гэтэл энэ зардлуудыг бүгдийг нь хассан ч бараг магадгүй хэдхэн хүний цалингаас бусад нь ямар ч эдийн засагт нөлөөгүй ийм их зардлууд байгаа юм. Энэ дээр та нэг бодлого явуулаад, ерөөсөө энэ зардлын үр ашиг талаас нь цаашдаа аргачлалуудыг нь боловсруулаад явуулаач ээ гэж танаас хүсэх байна.

Хоёрдугаарт, орон нутгийг эдийн засгийн хувьд бэхжүүлсэн байдлаар явуулахгүй бол орон нутгийн бүх төсвийг энэ хотдоо төвлөрүүлээд төвлөрсөн төлөвлөгөө рүүгээ татчихсан. Энэ дээрээс нь бид янз янзын урсгал зардлууд гаргаад явдаг. Эдийн засгийн хөгжлийн суурь нэмдэггүй зардал. Тэр зардлаа бид хасаж чадахаа байсан.

Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яаман дээр зардлын үр ашиг талаас нь дүгнэлт гаргадаг тийм аргачлалыг нэвтрүүлээч ээ гэж хүсэх байна.

Б.Пүрэвдорж: Ням-Осорын Учрал сайд тодруулъя.

Н.Учрал: Тийм. Б.Түвшин гишүүний хэлж байгаа маш зөв өө.

Ер нь энэ төсвийн зарлага дээр реформ хийхгүй бол цаашаа бид ер нь урагшлахгүй юм байна. Тийм ч учраас ер нь **“төсвийн зарлагын реформ”** /PUBLIC EXPENDITURE REFORM/ дээр ядаж л бид худалдан авагчдыг оновчтой болгоод нөгөө хиймэл оюун ухаан ашиглая гээд байгаагаа. Бодитойгоор ашиглаж эхлэх. Нөгөө хураангуй листийг хиймэл оюун ухаан, технологи дээр хийх, худалдан авалт дээрээ реформ хийх чиглэл рүү явахаас өөр замгүй.

Дээрээс нь төсвийн сахилга батыг зайлшгүй бид сайжруулна. Тэгээд ер нь Эдийн засаг, хөгжлийн яам нэгэнт төлөвлөлт хийж байгаа бол дунд хугацаандаа дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн орлого, зарлагын хувь хэмжээг бууруулах, эдийн засагт эзлэх төрийн хэмжээ, зохицуулалтыг багасгах, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, тэр төр, хувийн хэвшлийн түншлээрээ төслүүдээ явуулдаг байх чиглэл рүү анхаарахгүй бол орлогоо нэмэгдүүлээд л зарлагаа өсгөөд л байдаг ийм төлөвлөлттэйгөөр цаашаа явахгүй ээ.

Тэгэхээр үүн дээр анхаарч ажиллана.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлэх. Үг хэлэх байхгүй юм байна шүү дээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

**Арван нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
гурав дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэх асуудал.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Засгийн газар 2025 оны 06 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Гурав дахь хэлэлцүүлэг.

Дээрх хуулиудын гурав дахь хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Төслүүдийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн танилцуулна.

Индэрт урьж байна.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж гуравдугаар хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 07 сарын 04-ний өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын дагуу холбогдох өөрчлөлтийг төсвийн төсөл болон холбогдох хавсралтад тусгаж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээ.

Дээрх саналуудад үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд төсвийн холбогдох тооцооллуудыг хийж, төслүүдийн эцсийн хувилбарыг бэлтгэсэн.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудад нийцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний

баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулж, төслүүдийг батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого 30 их наяд 209.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 573.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл хасах 1 их наяд 809.4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон тэнцэл хасах 1 их наяд 364 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний хасах 11 хувьтай тэнцэхээр байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хувилбар болон холбогдох хавсралт тооцоог Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гуравдугаар хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Солонгийн Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Ононгийн Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны

Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга.

Нэр гараагүй хүмүүс байна уу?

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан тайлбар хийх, асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү?

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна. Тайлбар хийнэ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Яах вэ, төсвийн тодотгол хэлэлцэж байгаа энэ цаг хугацаанд нэг зүйлийг л асуух гэсэн юм.

Өчигдөр Ерөнхий аудитор байгаа билүү, үгүй билүү? Монгол Улсын ерөнхий аудитор С.Магнайсүрэн гэмт хэргийн шинжтэй мөнгө угаасан байж болзошгүй 7.3 их наяд төгрөг байгаа нь татварын нийт орлогын 26.7 хувьтай тэнцэж байна гээд. Энэ гуйвуулчав уу, эсвэл үнэхээр ийм мөнгө угаасан хэлбэр дээр 7.3 их наяд төгрөг явчав уу?

Энэ чинь нийт төсвийн 26 орчим хувь гэдэг бол, татварын нийт орлогын 26.7 хувь гэдэг бол маш өндөр хувь. Татварын дарга байх шиг байна.

Тэгээд Сангийн яам, Үндэсний аудитын газар татвар. Энэ дээр нэг хариулт өгөөдхөөч. Яг ийм процесс болсон юм уу, болоод байгаа юм уу, нотлогдсон юм уу гэдэг дээр. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Аан..? Аудитын газрын дарга уг нь байх ёстой доо. С.Магнайсүрэн дарга хаана байна? С.Магнайсүрэн даргыг. Рэн хариулах юм?

Татварын Ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн. Индрийн 3 дугаар микрофон.

Ч.Чимидсүрэн: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Татварын ерөнхий газар Ч.Чимэдсүрэн.

Тэгэхээр Татварын ерөнхий хууль болон мөнгө угаах терроризмтой тэмцэх хууль гэх мэтчилэн холбогдох хуулиудад төрийн байгууллагуудаас мэдээлэл солилцох, мэдээллээр бие биеэ хангах тийм чиг үүрэгтэй байдаг.

Тэгэхээр энэ татварын албаны татвар хураах болон татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны явцад бас ийм сэжигтэй байж болох гүйлгээнүүдийг бид хууль хяналтын байгууллагад шилжүүлж мэдээлэх ийм чиг үүрэгтэй байдаг.

Тэгэхээр энэ хүрээндээ нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг хуурамчаар үйлдсэн байж болох гүйлгээний давхардалтай дүн. Мөн хонжворт тоглоомтой холбоотой гэмт хэргийн шинжтэй байж болох гүйлгээнүүдийн мэдээллийг бид хууль хяналтын байгууллагуудад шилжүүлсэн энэ мэдээллийг төсөвт орсон татварын орлоготой холбосон хэлбэрээр ийм дүгнэлт гарсан байна лээ. Түүнээс энэ бол бодитой гарсан тийм зөрчил гэж үзэх зүйл биш байх. Энэ дээр аудитын байгууллагаас нэмэлт тайлбар өгөх байх аа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Нэмж Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Өчигдөр С.Магнайсүрэн дарга ажлынхаа дүгнэлтийг хэлсэн.

Тэр дүгнэлт дотор дурдагдсан тэр дүн ийм учиртай юм шүү. Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засгийн газрын гишүүдийг харин ажлаа сайн хийсэн байна гэсэн ийм дүн юм.

Тэр нь ямар учиртай вэ гэхээр татварын байгууллагын татварын байцаагч нар татварын тайлан дээр шалгалт хийгээд илрүүлсэн зөрчлүүд нь мөнгө угаасан байж болзошгүй байна гэсэн ийм дүгнэлттэйгээр хуулийн байгууллагууд руу шилжиж очсон дүнг яриад байгаа юм.

Тийм дүгнэлт хийсэн байхгүй юу. Түүнээс биш аудитын дүгнэлт дотор зөрчил нь тусдаа байгаа. Тусдаа дүн байгаа. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, бусад өөр бүртгэлийн шинжтэй холбоотой зөрчил гээд тусдаа дүн байгаа.

Тэгээд гэмт хэргийн шинжтэй гээд байгаа нь би сая хэллээ. Төсвийн ерөнхийлөн захирагч нар, төсвийн... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Б.Жавхлан: Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн мөнгийг мөнгө угаасан байж болзошгүй гэдэг тэр зөрчил ерөөсөө огт биш байгаа юм шүү.

Татварын байцаагч нар зөрчил илрүүлээд тэрийгээ ийм мөнгө угаасан байж болзошгүй байна гэсэн үндэслэлээр хуулийн байгууллага руу тэр татвар төлөгчдийн тайлан, судалгаа, шинжилгээнүүдийг хүргүүлсэн дүнг аудитын байгууллага дүгнэлтдээ оруулсан байгаа юм. Эш татаж. Тийм л зүйл байгаа юм шүү.

Б.Пүрэвдорж: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан асуултаас нэрээ татаад дагалдах хуулиуд дээр нэрээ өгсөн байгаа.

Банзрагчийн Түвшин асуулт асууя.

Б.Түвшин: Түрүүний төсвийн хүрээний мэдэгдэл дээр ерөнхий санааг нь хэлсэн. Цаашдаа Эдийн засаг, хөгжлийн яам маань санаачлаад явах байх.

Бид ер нь сүүлийн 5 жил гэхэд дандаа өсөлтийн эдийн засагтай үед явсан. Жил болгон маш их мөнгө зардаг. Жил болгон төсөв маань өсдөг. Гэтэл нөгөө талдаа ард иргэд маань улам бүсээ чангалж, аж ахуйн нэгжүүд маань улам их татвар даатгалын өрөнд орж явдаг.

Тэгээд үүний цаана нөгөө эдийн засаг маань бүхэлдээ нэг ийм төрийн гэдэг нэрийн доор мөнгө цуглуулаад, тэрийг нь тараадаг л ийм л хэлбэр лүү шилжиж харагдаад. Тэгээд бид төсвөө хараад баярлаад явдаг.

Төсвийн зарцуулалт маань нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийг бид үнэлдэггүй. Нэг ёсондоо өнгөрсөн жил, 3 жилийн өмнөөс зарцуулж байсан мөнгө ч байдаг байсан. Өнөөдөр ч байсан. Инфляц, ханшийн өөрчлөлтөд нөлөөлж л байдаг.

Сүүлийн 5 жил тасралтгүй уурхайн бүтээгдэхүүний баялгуудын үнэ өсөж ирсэн. Үүнийг дагаад бид эдийн засаг хөгжиж байгаа гэж нэрлээд бүгдийг нь орлогоо нэмэгдүүлээд, зарлагаа нэмэгдүүлээд явсан.

Тэгээд сая төсвийн тодотголоор орж ирж байгаа энэ зардлууд дээр ч гэсэн бид сүүлдээ хасах ч юмгүй болсон. Ерөөсөө арай гэж хийж байж л, бөөн юм болж байж л 2 их наяд гаруй төгрөг хасаж байх шиг л байна л даа.

Тэгэхээр одоо ерөөсөө энэ төсвийн нэг бүрчлэн зарлагыг эдийн засгийн үр өгөөжтэй байлгах тал дээр Сангийн яам анхаарч, төсөв баталж байгаа гишүүд ч гэсэн ерөөсөө ширхэг мөнгө болгоныг эдийн засаг, нийгэмд хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу гэдгийг нь бид үр дүнг нь гаргахгүй бол яаж төсөв нэмэгдсэн ч гарын салаагаар урсаж байгаа юм шиг үр ашиггүй болоод л дуусаад байна.

Энэ бол өнгөрсөн 5 жилийн үйл ажиллагаагаар харагдаж байна. Тэгээд нэг жижигхэн нүүрсний үнэ хагас жилийн дотор унахад л бид бүх юмаа хасдаг, танадаг, хямралын байдал руу ордог.

Тэгэхээр ерөөсөө энэ тэнцвэржүүлсэн үнийн асуудлуудыг ч гэсэн хийж энэ нөөцөө ч гэсэн бид үр ашигтай байршуулж, ийм хэлбэлзлээс үл хамаарах хэмжээний урсгал зардлыг тогтоох зайлшгүй шаардлагатай байгаа. Миний харж байгаа байдлаар ерөөсөө бид энэ урсгал зардлыг 15 их наядаас гаргахгүй байж байж л бид цаашаа хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэнэ.

Энэ дээр би Сангийн сайдаас асуухад ер нь энэ урсгал зардлыг хэд хавьцаа байлгаж тогтворжуулах вэ?

Энэ уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн хэлбэлзлээс шууд хамаараад байхгүйгээр бид тогтвортой үйл ажиллагаа явуулаад, магадгүй уурхайгаас орж ирж байгаа тэр илүүдэл, нэмэгдэл ашгаа хөрөнгө оруулалт руу, эсвэл тэр баялгийн сан руугаа, эсвэл дараа дараагийн тогтворжуулалтын сан руугаа явуулах нэг ийм зохистой харьцаа гэж байгаа.

Энэ зохистой харьцааны талаар Та тодорхой тоо хэлж тайлбарлаж өгнө үү?

Б.Пүрэвдорж: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Б.Түвшин гишүүний асуултад хариулъя.

Б.Түвшин гишүүн өөрөө бүртгэлийн талын мэргэшсэн хүн. Бүртгэлийн талаас юм уу, эсвэл эдийн засгийн агуулгаар тийм харилцаа, тийм харьцааг ярих ямар ч боломжгүй болсон.

Өмнө нь би зөндөө тайлбарлаж байсан. Одоо 208 хууль байна. Бид судлаж, судлаж гаргаж ирсэн. 1200 гаруй заалтаар аль хэдийн төсвийг хуваарилчихсан. Салбар салбарт нь. Ингээд төсөвт аль хэдийн хуваарилчихсан энэ хуулиудын дагуу багтахгүй цаана нь дахиад 8 их наяд ингээд хүлээгээд байж байдаг. Хүлээгээд байж байдаг.

Энэ дотор Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, түүнийг дэмжих ийм заалтууд ч байна.

Дээрээс нь мөн салбар салбарын маш олон ийм төсвийн хуваарилалтууд, дэмжлэг, санхүүжилтүүдийг ингээд хуулиар нь аль хэдийн хуваарилчихсан.

Одоо хүүхдийн мөнгө ч гэсэн хуультай шүү дээ. Цалин, тэтгэвэр, тэтгэмж бүгд хуультай. Халамж бүгд хуультай.

Одоо бид ингээд тодотголоор 2.1 их наядыг хасаж байгаа нь та ямар тооноос хасаж байна гэж бодож байна. Одоо ингээд жилийн дундуур гүйцэтгэл нь 05 сарын 31-нээр үндсэндээ бид сая 75 хувийн гүйцэтгэлтэй татаж явж байгаа гэсэн үг. 25 хувийн хэмнэлттэй явж байгаа гэсэн үг.

Ийм үед одоо энэ чинь бараг 8 их наяд төгрөгийн урсгал зардал гарчхаж байгаа юм. Үлдэж байгаа 25-аас чинь 8 нь гарахаар цаана нь ингээд 17. Үүний 11 их наяд нь хүүхдийн мөнгө, цалин, тэтгэвэр, тэтгэмж, хуулиар олгодог заалтуудтай.

Нэн тэргүүнд хүрч болохгүй зардал нь 11 их наяд. 11 их наяд. Тэгээд цаана нь үлдэж байгаа урсгал зардал 5 их наядас бас л хууль, төлөвлөгөөний заалтуудтай.

Тэндээс яг тэвчиж болохоор, хойшлуулж болохоор, зарим үйл ажиллагаагаа хязгаарлаад, зогсоогоод, зарим Засгийн газрын хүрэх зорилтот түвшнүүдээ хойш нь татаж байгаад ингээд 5 их наядаас 2.1 их наядыг л танаж хасах ийм боломж гарч ирж байгаа байхгүй юу. Энэ бас нэг тийм амархан баярлаад хийх зүйл биш. Маш хүнд нөхцөлд хийж байгааг Та бүхэн бүгдээрээ харж байгаа байх.

Нөгөө тодотгол хийх ёстой. Танана танана гээд л байсан. Танана гээд л оруулаад ирэхээр танаж болохгүй, танаж болохгүй гээд л уралдаан зарлаж байгаа биз дээ.

Тийм учраас миний хэлээд байгаа нь тэр шүү.

9 сард бид төсөв өргөн барихдаа ер нь 40-өөд хууль тусад нь өргөн барина. Аль хэдийн төсөв хуваарилчхаад байгаа. Түүн дээр л битгий хойшоо суугаарай. Салбар салбарын хамгаалагч нар болоод бариад тал тал тийшээ гүйгээд лоббидоод явчхав.

Тэрний дараа л бид нэг эдийн засгийн агуулга ярих ийм боломж гарч ирэх байх шүү.

Б.Пүрэвдорж: Банзрагчийн Түвшин гишүүн нэмж тодруулъя.

Б.Түвшин: Тэгээд сүүлийн 6 жил эдийн засгийг барьж байсан хүний хариулт гэхэд одоо бас жоохон сонин л байна шүү.

Ер нь энэ Монгол Улсын эдийн засгийг тогтвортой байлгах тухай, урсгал зардлыг дээд хэмжээг нь тэддээ барья. Түүнээс дээшээс гарсан дүнгээс нь Баялгийн сан руугаа, эсвэл нөөц сан руугаа, эсвэл хөрөнгө оруулалтаа хийе гэдэг нэг ийм ерөнхий загварчлал гаргах боломж байсан. Нэг талаасаа.

Нөгөө талаасаа ерөөсөө мөнгө хураахын төлөө явсаар байгаад одоо нөгөө талд нь иргэд, аж ахуйн нэгжүүд одоо үндсэндээ бүсээ чангалаад туйлдаа хүрч байдаг.

Энэ зарсан мөнгө нь өөрөө нийгэм, эдийн засагт эргээд өсөлт авчирдаггүй. Ерөөсөө зарлагын шинж чанартай болсон. Юу үнэн бэ гэхээр энэ бүх зардлуудын ихэнх нь хуулиар баталгааждаг явсан. Одоо энэ хуулиудыг задлах нь үнэн.

Гэхдээ энэ хуулиудыг задлахын өмнө бид уул уурхайн хамаарлаас ингэж багасгаж байж, ийм хэмжээнд, ийм түвшинд очиж байж бид урсгал зардлаа, тогтмол зардлаа барих ёстой юм гэдэг бодлогуудыг бид гаргаж ярих ёстой. /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя. Б.Түвшин гишүүн.

Б.Түвшин: Ийм бодлогууд гараагүй учраас хуулиар бусад зардлууд нэмсэн. Тэгээд өнгөрсөн жил 5 их наядыг л хасъя гэхэд ямар ч боломжгүй гэсээр байгаад хоёр, гурван хоногийн тодотголоор эцсийн дүндээ 5 их наядыг л хасаж байна шүү дээ.

Тэгэхээр энэ хуулиуд дээр урьдчилаад Улсын Их Хурлын гишүүддээ хэлэх ёстой байгаа юм. Ерөөсөө урсгал зардлыг тэдээс хэтрүүлэхгүй байя гэдэг ийм загварчлал байгаа.

Бид нарын орж байгаа орлого хязгаартай. Энэ хууль болгонаар зардал нэмээд байх юм бол өнөөдөр бид одоо яг өнөөдрийнх шигээ Оюу Толгой, Тавантолгой, алт, нүүрсээсээ олсон бүх мөнгөө урсгал зардал руу зараад, эргээд эдийн засаг маань өөрөө босох тэнхэлгүй ийм болж байгаа.

Энэ загварчлалын тухай яриад байгаа юм. Ер нь цаашдаа бүгдээрээ эдийн засгийг цаашаа авч явъя гэх юм бол энэ урсгал зардлыг тогтвортой түвшинд бариад үүнээс дээших хөрөнгө оруулалтын дүнгээ заагаад гаргадаггүй бол олсон бүх мөнгөө урсгал зардалдаа гаргачхаад тэгээд дээрээс нь гадаад, дотоодын зээлээр хөрөнгө оруулалт хийдэг энэ байдал чинь өөрөө эдийн засгийн модель биш байгаад байна гэдгийг л хэлээд байгаа юм.

Б.Пүрэвдорж: Цэрэнпилийн Даваасүрэн. Байнгын хорооны дарга нэмж хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм. Б.Түвшин гишүүний хэлээд байгаа дээр бас анхаарах юм бий бий.

Сүүлийн жилүүдэд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй зардлынхаа дээд хязгаарыг уячихаар дотоодын нийт бүтээгдэхүүн өслөө. Төслийн зардал өсөөд яваад байгаа байхгүй юу.

Тийм учраас бид энэ төсвийн тогтвортой байдлын шаардлагаа хүртэл эргэж харах тийм шаардлага байж магадгүй. Би өөрийн чинь хэлсэнтэй санал нэг байна. Ер нь ингээд 3 дахин өсөхөөр чинь бид маш хүнд байдалд орж байна шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр ингэж дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ тодорхой хувиар зардлын хязгаар тавиад байгаа чинь оновчтой байна уу, үгүй юу гэдгийг хүртэл эргэж харах тийм шаардлага байж магадгүй.

Тийм учраас бид бас энэ зүйл дээр цаашдаа анхаарах ёстой гэсэнтэй санал нэг байна.

Б.Пүрэвдорж: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Баярлалаа. Б.Пүрэгдорж дарга аа. Манай Б.Пүрэгдорж дарга даргалахаар их сайн хугацаа өгдөг шүү. Баярлалаа.

Б.Түвшин гишүүн ээ. Ер нь та яг тийм тоо сонсох гээд байгаа бол ингэж байгаа шүү дээ. Одоо Төсвийн тогтвортой байдлын хууль дээр урсгал зардал дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтэрч болохгүй ээ гэсэн хязгаар байгаа. 2026 оны сарын өмнө батлуулсан төлөвлөгөө дотор 26 хувиас хэтэрч болохгүй гэсэн заалт байгаа.

Ер нь бидний зорилт 4 жилийн эцэст 20 хувь руу багтаах ийм зорилтууд байгаа.

Гэхдээ энэ хуулиудыг цэгцлэхгүй бол бид бүр 26 хувь руу ч оруулж чадахгүй. Дээрээс нь таны санаачлаад давхиж байгаа нөгөө хууль чинь 1 их наядын зардал нэмэх гэж байгаа ийм хууль байгаа шүү.

Тэгэхээр хоёулаа зардлаа таная гэж ярингуутаа нөгөө орлогоос нь танах, зардал нэмэгдүүлэх тийм хууль бас санаачлаад яваад байгаа чинь үүнтэйгээ нийцэж байна уу, үгүй юу. Бас ярилцах л ёстой байгаа юм.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Төсвийн ажлын хэсэгт орж ажилласан.

Тодорхой зарчим барьж, хуулиар хүлээсэн үүрэг болон чухал гэж үзсэн асуудлуудыг эргүүлэн тавьсан. Жишээлбэл, төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг оруулж ирсэн байсныг эргүүлэн татах шийдвэр гарсантай холбогдуулан тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой, нэмэгдэлтэй холбоотой 1.1 тэрбум төгрөгийг эргүүлэн тавьсан.

Гэр бүл, хүүхдийн хэрэг маргааныг шийдвэрлэх шүүх маш чухал байгаа учраас энэ шүүх үйл ажиллагаагаа эхлүүлэх, явуулахад нь 12 тэрбум төгрөгийг Шүүхийн ерөнхий зөвлөлд эргүүлэн тавьсан.

Мөнгө угаах терроризмтой тэмцэх ажил өөрөө Монгол Улсыг **FATF**-ын /Financial Action Task Force/ саарал жагсаалтад оруулахгүй байх тал дээр анхаарч байгаа учраас Улсын ерөнхий прокурорын төсвийн багцад бас 1.3 тэрбум төгрөгийг тавьсан.

Гэх мэтчилэн асуудлуудыг анхаарч явсан боловчиг хассан зардлууд маань яах вэ нөгөө дэд сайдын томилгоо, Улсын Их Хурал, Засгийн газрын нөөц сангийн шинээр тавьсан асуудлуудыг урьд онуудаасаа давахгүй байх, боломжит хэмжээнд нь байлгах зэргээр 50 тэрбумыг нэмэлтээр тавьсан байсныг яах вэ бид 16 тэрбумыг нь эдгээр асуудалдаа авчихъя гээд саналуудаа оруулаад явсан.

Төсвийн байнгын хороон дээр унасан буюу дэмжигдээгүй Улсын Их Хурлын гишүүдийн саналууд дэмжигдээд ороод ирлээ.

Засгийн газрын нөөц сан 50-ийг тавьсан байсан. 50-ийг нь тэр чигээр нь хасах гэхлээр ажлын хэсгийн оруулсан 16-тайгаа нийлээд одоо байгаагаасаа бууруулах боллоо. Чухам одоо яаж шуурхай гэнэтийн ажлууд дээр Засгийн газар үйл ажиллагаа явуулах байгаа юм.

Дахиад Улсын дээд шүүх дээр 2 тэрбум, 1.5 тэрбум нэмэлтээр ороод ирлээ. Шаардлагагүйг нь л уг нь ажлын хэсгийн хүрээнд тавьсан байсан. Дахиад энд ингээд завшсан маягийн л юм боллоо.

Боловсролын сайдын төсвийн багцаас 2.6 тэрбумыг аваад Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайдын урсгал руу орууллаа. Нөгөө тэтгэмжээ бодуулах гэж байсан тэтгэвэртээ гарсан төрийн албан хаагчдынхаа тэтгэмжийн зардлыг нь хаслаа. Одоо нөгөө хүмүүс маань уйлаад суух нь. 117 багш байна. Яах юм. Бүү мэд. Засах арга байхгүй. Энэ хэвээрээ явах нь. Ийм дэгтэй.

Ерөнхийлөгч хориг тавья гэхэд хөрөнгө оруулалт дээр л хэсэгчилсэн хориг тавьж болно. Урсгал дээр бүтнээр нь л тавих нь байна. Мэдэхгүй. Яах юм. Юу болоод өнгөрчхөв?

Б.Пүрэвдорж: Санал хэллээ.

Тэгэхээр ер нь А.Ариунзаяа гишүүн ээ, танай намын зарим сайдууд чинь хоорондоо л нэгнийхээ төсвөөс авцгаасан л юмнуудыг хийсэн шүү дээ. Энэ дээрээ.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Одоо тэгээд төсвийн тодотголын маань гурав дахь хэлэлцүүлэг явж байна.

Тэгээд үүнтэй залгаад ирэх оны төсөв удахгүй боловсруулагдаж боогдож, 09 сарын 01 гэхэд өргөн барина.

Гэхдээ хэд хэдэн зүйлийг л анзаармаар юм шиг санагдаж байна. Ер нь энэ төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн асуудлыг иж бүрнээр нь нэг хуульчлаад эрэмбэ тогтоовол яадаг юм бэ гэдэг нэг ийм бодол байна.

Энэ хөрөнгө оруулалтын төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээнүүдийн эрэмбийг төлөвлөөд, дээрээс нь үүнийгээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр алийг нь хэрэгжүүлэх, алийг нь яг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх гээд яг энэ дээрээ зааг ялгааг нь гаргадаг.

Үүнийг Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам хоёр хамтраад нэг чиг баримжаатай байхгүй бол ер нь тойрог тойргийн жижиг эрх ашгууд намраас үнэртэх юм байна. Үнэртэх юм байна.

Том зургаараа бодлогын юмнуудыг дэмжээд явъя гэхээр өнөөдөр гишүүд маань санал гаргаад унасан саналаа босгодог ч гэдэг юм уу. Яг энэ гишүүд чинь, зүгээр сууж байсан хүмүүс чинь тойрогтоо юу ч тавьж чадахгүй асуудалд жоохон тийм зарчимгүй юм шиг харагдаад байна.

Тэгэхээр үүнийг ер нь цаашдаа Сангийн яам том бодлогын хүрээнд анхаараач гэж байгаа юм. Эдийн засаг, хөгжлийн яам хоёрыг.

Тэгээд ер нь хурал, зөвлөгөөн хийснээр эдийн засаг сайжрахгүй юм шиг байна. Одоо тэгээд гоё гоё хурлууд ч хийж л байна л даа. Эдийн засгийн форум энэ тэрээс.

Тэгэхээр яг бодит action буюу үйлдэл хийх гэж байгаа юм уу гэдэг зүйлийг хөрөнгө оруулагч нь хараад байна. Уул уурхайн салбар дээрээ яг яах гээд байгаа юм. Яриад л байдаг, яриад л байдаг, юу ч хийдэггүй. Бэлэн байсан хэдэн төслүүдээ хөдөлгөсөн.

Тэгэхээр ер нь цаашдаа энэ Ашигт малтмалын хууль ч гэдэг юм уу, ер нь зүгээр уул уурхайн салбар дээрээ тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг татах асуудлаа бодлогын түвшинд нь хууль эрх зүйн орчиндоо тодорхой болгож зарлахгүй бол “манайд хөрөнгө оруулаач ээ” гээд мянган форум хийсэн ч ирэхгүй.

Тийм учраас цаашдаа ирэх оны төсөв, бас орлого бүрдүүлэх тал дээрээсээ анхаарах үүднээс яг энэ төсвийг хүлээлгүй энэ салбарын яамд тодорхой эдийн засгийн секторуудыг хариуцаж байгаа сайдууд ажилламаар байна. Тэгээд галаас зугтаагаад хэзээ гэдэг нь ерөөсөө хариулж чадахгүй, ажиллаж байгаа гээд нэг ийм жижүүрийн үг хэлээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээрээ анхаараач ээ гэдэг зүйлийг бас хэлмээр байна.

Тэгээд сая Сангийн сайд 200 хуулиар, 1200 заалтаар төсвийг аль хэдийн хуваарилж байна гэж байгаа юм. Үүний эрэмбийг Үндсэн хуулийн эрх зүйгээс нь эхлээд зөв тодорхойлоорой. Үндсэн хуулиараа яг уг асуудлыг хэрэгжүүлэх юмнуудыг сая хасагдаж байгаа зүйл байхад, бусад шаардлагагүй явж байгаа зүйлүүд байна.

Тэгэхээр би зарим зүйлүүд, энэ эрэмбийг тогтоож нэгтгэхдээ бас энэ шүүх эрх мэдлийн байгууллага гэдэг юм уу, ер нь засаглалын энэ салаа мөчрүүдийнхээ юмыг баланстай тэнцвэртэй оруулж ирэхэд анхаараач ээ гэж байгаа юм.

А.Ариунзаяа сайд бид хоёр зарчмын хувьд хөндөж ярьдаг юм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уясан юмнуудаа цэгцлээч гэж хүсэж байгаа юм. /минут дуусав/

Б.Пүрэвдорж: П.Сайнзориг гишүүн нэмж тодруулъя.

П.Сайнзориг: Тэгээд нэг ийм юм байна. Бас манай эдийн засгийн төлөвлөлт талаасаа анхаараач.

Төрийн байгууллагуудын “**чиг үүргийн тооллого**” гэдэг зүйлийг хийж байгаа.

Чиг үүргийн тооллогыг:

- ▶ Засгийн газар талдаа нэг тоолмоор байна.
- ▶ Шүүх эрх мэдлийн талдаа нэг тоолмоор байна.
- ▶ Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын хэмжээнд нэг тоолмоор байна.
- ▶ Нутгийн удирдлагын хэмжээнд нэг тоолмоор байна.

Ингээд үүнийгээ хэдүүлээ бас нэг баланстай ийм ийм чиг үүргүүдтэй, ийм ийм орон тоо хэрэгтэй гэдгийг нэг арга зүйгээр тогтохгүй бол тэгшитгэж хасаад байхаар сүүлдээ Улсын Их Хурал дээр хэрүүл болоод байна.

Тэгэхээр хэн хэнийхээ засаглалын эрх мэдлийг хүндэтгээд энэ чиг үүргийн тооллогыг хийгээд орон тоог тогтоодог арга зүйтэй болгох асуудлыг бүр Төрийн албаны хууль дээрээ хуульчилдаг ч юм уу, ингээд хийх асуудал байхгүй бол ерөөсөө л энэ маргаанууд Улсын Их Хурал дээр эцэс төгсгөлгүй л явах юм байна.

Тэгэхээр үүнийг хамтарч Эдийн засаг, хөгжлийн яам байх юм уу, Хэрэг эрхлэх газар байх юм уу нэг анхаараад Улсын Их Хуралтайгаа хамтраад хиймээр байна.

Тэгээд аль аль засаглалтайгаа барьцахгүйгээр орон тоо тогтоодог энэ арга зүйтэй болъё л гэсэн... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал хариулна.

Н.Учрал: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг парламентаас баталсан. Энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөн дотор “**төсвийн зардлын реформ**” хийнэ гэдэг том зорилт байгаа.

Энэ зорилт урсгал зардлаа бууруулна. Ингээд нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүнтэй нь холбоод 24 хувиас хэтрэхгүй байна гээд.

Үүнд хүргэх л ёстой. Тэгээд Б.Түвшин гишүүний түрүүний яриад байгаа ч гэсэн энэ урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарах бодлого маш чухал.

Гэхдээ энэ “төсвийн зарлагын реформ” хийхэд түрүүн бас Сангийн сайд хэлсэн. Энэ 208 хуульд заасан 1200 заалтыг цэгцлэхгүй бол улсын жилийн төлөвлөгөө ч байсан, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад ч гэсэн хуулиар хүлээсэн үүргийг Засгийн газар биелүүлэх шаардлага зайлшгүй үүсдэг.

Тийм учраас ирэх намрын чуулганаар бид энэ төсвийн зарлагын реформыг зайлшгүй хийх ёстой.

Мөн улсын жилийн төлөвлөгөөг хүслийн жагсаалт болгож болохгүй байна. ТЭЗҮ байхгүй, зураг төсөвгүй баахан юм орсон. Тэгээд наад чинь гүйцэтгэл хангагдахгүй. Гүйцэтгэл хангагдахгүй. Гишүүд санал гаргасан байдаг.

Тэгээд мөн сая Их Хурлын дэд даргын ярьж байгаагаар ч гэсэн зарим сайд нар дундуур нь янз бүрийн санал оруулдаг. Тэгээд төлөвлөж болдоггүй.

Эдийн засаг, хөгжлийн яам үнэхээр жилийн төлөвлөгөөг оруулж ирэх гэж байгаа бол бид энэ дээрээ хатуу байна.

Дээрээс нь Төсвийн тогтвортой байдлын хууль дээр “тусгай шаардлага” дээр нь хүртэл урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх шаардлага байгаа шүү дээ. Эдийн засаг, хөгжлийн яам бол Төсвийн тогтвортой байдлын хуулиа барьж л төсвийн хүрээгээ оруулж ирээд л хатуу ингэж явахгүй бол болохгүй.

П.Сайнзориг гишүүний хэлж байгаагаар ч гэсэн зүгээр наад захын эдийн засгийн онолын энгийн ойлголт бол эдийн засаг агшаад байвал тодорхой төсвийн тэнцэл дээр нь алдагдалтайгаар батлаад тэлэх бодлого явуулах ёстой шүү дээ. Тэгэхгүй бол агшлаа гээд л дагаж хэмнээд л, ямар ч үг, үйлдэлгүй байгаад байвал эдийн засаг сэргэхгүй шүү дээ.

Нийгэмд байгаа хэдэн ажлын байрыг яаж хадгалж авч үлдэх вэ гэдэг сорилтын өмнө бид байгаа байхгүй юу. Тэгээд энэ тохиолдолд юу вэ гэхээр төсөв шаардлагагүй зардлуудаа хэмнэнэ, урсгалаа бууруулах бодлого барина.

Гэхдээ дагаад Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг одоо улс төргүйгээр батлах л ёстой. Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиа оруулаад, батлаад, хөрөнгө оруулагч нараа хамгаалдаг болох ёстой. Чөлөөт зах зээлийг дэмжих ёстой. Эдийн засгийн эрх чөлөөнд саад тотгор учруулж байгаа дүрэм, журам, саад, тээгүүдийг бүгдийг нь авч хаях ёстой.

Нэгэнт төсвөөс төсөл, хөтөлбөрөө санхүүжүүлж чадахаа больсон бол Төр, хувийн хэвшлийн түншлэлийнхээ хуулийг оруулж ирээд тэр үе шатуудыг нь бууруулаад, тодорхой босго тавиад аймаг, нийслэл нь өөрөө концессын зарчмаар зарим төслүүдээ явуулдаг. Эдийн засгийн яам нь үүн дээр урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ дээр нь туслалцаа үзүүлдэг ийм хэлбэрүүдийг сонгох ёстой.

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг ч гэсэн инфляцтай уялдуулж нэмэх гэж байгаа бол гүйцэтгэлд суурилахаас өөр замгүй болж байгаа. Энэ дээр бид зорих л ёстой заавал.

Дээрээс нь бид халамжийг ч гэсэн зорилтот бүлгүүдэд хүргэхийн төлөө улс төргүйгээр үүнийг хийх л ёстой. Ингэж байж энэ эдийн засгийн эрх, эрх чөлөө гэдэг зүйл чинь баталгаажихгүй бол “улс төрийн эрх чөлөө” гэдэг юм чинь “эдийн засгийн эрх чөлөө”-нөөсөө давчихлаа шүү дээ.

Тэгээд “**чөлөөт зах зээл**” гэж олон жил ярилаа. Тэгээд одоо энэ чөлөөт зах зээлийг дэмжье гэвэл:

- Либералчлах бодлого явуулна.
- Чөлөөт зах зээлээ дэмжинэ.
- Баялаг бүтээгч нартаа түшиглэнэ.
- Дүрэм, журам, саад, тээгүүдийг арилгана.
- Төр зарим эрх, үүргээсээ сална.

Тийм учраас төрийн албаны бүтэц дээрээ ч гэсэн шинэчлэл хийж байгаа.

Тэгээд бид намар баялаг бүтээгчдээ дэмжих багц хуулиараа энгийн 100 зөвшөөрлийг мэргэжлийн холбоонд шилжүүлнэ гээд. Би ийм л бодолтой байгаа. Тэгээд ингээд оруулж ирнэ. Үүнийг гишүүд маань дэмжээсэй гэж хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Одоо Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Протоколд тэмдэглүүлж үг хэлэх гэсэн юм.

Засгийн газраас “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар гэдэг яаралтайгаар оруулж ирсэн.

Энэ дээр Төсвийн байнгын хороон дээр унагасан саналыг босгосон. Энэ нь юу болсон бэ гэхээр “Зарим газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 46 дугаар тогтоол, 47 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулж алтыг эргэлтэд оруулах саналыг дэмжүүлж авсан байгаа.

Өнөөдөр Төсвийн байнгын хороон дээр энэ саналыг эсэргүүцээд бараагүй байна гишүүд.

Тэгэхээр энэ юу болж байна гэхээр энэ бол Ноён ууланд байгаа алтыг, тэр солбилцлийг нь өөрчлөөд зөвшөөрөл аваад ухах ийм л арга хэмжээг лоббидож оруулж ирж байгаа юм.

Үүний ард томоохон компаниуд байгаа.

Улсын Их Хурлын зарим гишүүдийг мэдээлэлгүй байгаагаар нь далимдуулж зарим сайдууд зөвхөн үүний төлөө шинэ Засгийн газарт орж ирсэн гэсэн мэдээллийг авсан.

Ноён уулын төрийн дахилгатай болох гэж, хамгаалалтад авах гэж 60 удаагийн шүүх хурал болсон юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2021 оны 06 сард төрийн тахилгатай болсон юм.

Би хөдөөгөөс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн. Манай говийн бүсэд Говь гурван сайхан уул гэж уул бий. Бас төрийн тахилгатай. Газар болгонд, бүс болгонд ийм уул байдаг. Монголын ард түмэн соёл, ёс заншлаа хамгаалах гэж Монгол Улсын төрийн тэргүүн төрийн тусгай хамгаалалттай болгодог. Засгийн газраар шийдвэр гаргадаг.

Тэгэхээр төсвийн тодотголыг дагасан хуулиуд одоо орж ирнэ. Энэ дээр гишүүдээс санал авахгүй.

Тийм учраас гишүүд улс орныхоо эрх ашгийг бодож, хэдхэн компанийн мөнгөнд автахгүйгээр төслийг унагааж өгөөч ээ. Хэрвээ энэ төсөл батлагдах юм бол Ноён уулыг хамгаалалтад авч байх үед Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан, одоо Монгол Улсын Ерөнхийлөгч байгаа Ухнаагийн Хүрэлсүх Та энэ хуульд хориг тавьж өгнө үү.

Хэрвээ үүнийг дэмжих юм бол хөдөө орон нутгаас бүх ард түмэнд санаачилж, уриалж, бослого тэмцлийг зохион байгуулна гэдгээ мэдэгдэж байна.

Протоколд тэмдэглүүлье.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхбат: Бид төсвийн тодотголын тухай гуравдугаар хэлэлцүүлгийнхээ хүрээнд ингээд ярьж байна.

Яах вэ, улс орныхоо эдийн засаг хүндрэлтэй байгаа нөхцөл байдлыг харгалзаад Сангийн яам, Засгийн газраас боловсруулаад оруулаад ирж байгаа

энэ зүйлүүдийг одоо бид тэгээд л ерөнхийд нь дэмжээд л яваад байгаа. Ялангуяа манай Сангийн яамныхан оруулаад ирсэн төслөө тэгээд нэг гүлдийж байгаад л тэр чигт нь тэгээд нэг гүрийсээр байгаад л аваад л гардаг нэг ийм л юутай болчхоод байгаа юм.

Тэгээд яах вэ өнөөдрийн гуравдугаар хэлэлцүүлэг дээр юу хэлэх гэсэн юм гэхээр бид ер нь дараа нь удахгүй ирэх оны төсвийг ярьж эхэлнэ. Энэ дээр зарим нэг зүйл дээрээ жоохон прагматик хандахгүй бол бид болохгүй нь ээ. Болохгүй байна. Бүх юм манай Сангийн яамны хийж байгаа тооцооллоор зөв болоод байгаа юм байхгүй байна.

Үүнээс болоод бид энэ төсвийн тодотголын тухай дахин дахин яриад байна. Тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн оруулж ирж байгаа тэр санал, дүгнэлт, тэр зөвлөмжүүдийг бид авдаг баймаар байна. Хэрвээ авдаггүй юм бол одоо тэрийг бид байлгаад яадаг юм гэдэг нэг ийм асуудал.

Манай Монгол Ардын намын зарим гишүүдээс одоо бүр хувийн хэвшлийг дэмжихгүй тухай. Социал, демократ үзэл бол өөрөө хувийн хэвшлийг дэмждэггүй тухай ийм асуудлуудыг ярьж байна. Ингэж болохгүй ээ. Бид хувийн хэвшлээ дэмжээгүйгээс болоод өнөөдөр эдийн засгийн байдал чинь ийм болоод байгаа шүү дээ. Бүх юмаа төр лүүгээ төвлөрүүлээд. Нүүрсээ ч, зэсээ ч бүх үйлдвэрүүдээ төвлөрүүлээд, бүгдийг нь төр хийнэ гэж үзсээр байгаад бид л ийм байдалд ороод байгаа шүү дээ. Ер нь.

Тэр хувийн сургууль нь ч байна уу, цэцэрлэг нь ч байна уу, бусад хувийн хэвшлүүдийг бид дэмждэг байх хэрэгтэй.

Харин сая манай Н.Учрал сайд энэ дээр харин их бодитой, зөв асуудал хөндөж, ер нь бид энэ төсвийг төсвийнхөө, төрийнхөө аль болохоор ажлыг хийгээд, хувийн хэвшлээ илүү дэмждэг энэ зүйл рүүгээ илүү орно гэдэг ийм зүйлийг ярилаа.

Тэгэхээр зэрэг. 1 минутаа нэмээд авчихъя. Б.Пүрэвдорж дарга аа.

Би өчигдөр тэр юу хэлэх гээд байсан юм. Гол нь энэ боловсролын салбарын тэр нэг хувийн хэвшлүүдэд өгдөг, хувийн хэвшлийн сургуулиудад өгдөг 0.92 хувь юм билээ л дээ. Хувьсах зардал нь. 30 орчим тэрбум төгрөг юм билээ. Үүнийг өгөхгүй гээд л. Түүнээсээ болоод бөөн л юм болцгоосон.

Уг нь энэ чинь төр дээр байх юм бол энэ төрийн сургуулиудын чинь ачааллуудыг харьцангуй хуваалцаж байгаа. Яг яс юман дээрээ улсын төсвөөс төрийн сургуулиудад өгөх юм бол 152 тэрбум төгрөг очихыг л 30 болгоод л хэмнэж байгаа ийм л зүйл юм билээ шүү дээ. Яах вэ, юм хоёр талтай. Зарим нэг нь түүгээрээ үйл ажиллагаагаа аваад явдаг сургуулиуд байна. Чанартай, чанаргүй үйлчилгээ үзүүлдэг юм байгаа л байх. Гэхдээ нөгөө талд нь бас хэрэг болдог, хүүхдийн эрх ашгаа хамгаалахад нь зориулагддаг ийм юмнууд бий.

Өчигдөр тэр Удирдлагын академийн зардлыг 2.6 тэрбумаар шууд танаад хаячихна лээ. Хэрэгтэй үедээ болохоор баахан намынхаа гишүүдийг бэлдээд л үнэгүй сургаад л байдаг юм билээ. Одоо хэрэггүй боллоо гэхээр зэрэг тэр чигээр нь, хуйгаар нь 50 хувийг нь тэр чигээр нь, үндсэндээ 60 хэдэн хувийг нь авчхаж байгаа юм байна лээ шүү дээ.

Энэ байдлаа дараа дараагийн төсвүүд дээрээ зөв зохистой, бодитой оруулж ирэх шаардлагатай байна. Үүнийг ирэх оны төсөв ярилцахад бид дахин давтаж ярина шүү гэдэг зүйлийг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд үг хэлэх гэж байсан чинь өмнөх Ц.Мөнхбат гишүүн маань нэг юм хэлчих юм. Монгол Ардын намын гишүүд гээд.

Тэгээд хувийн хэвшлийг одоо энэ орж ирж байгаа хуультай холиод ингэж гүтгэж дайрч болохгүй ээ. Эхлээд асуудлаа хар. Хувийн хэвшлийг дэмжинэ. Төр харин хувийн хэвшил рүү орохгүй юмаа багасгаад, тэр оролцоод байгаагаа болиод хувийн хэвшилдээ зай гаргах ёстой.

Энэ боловсролын салбар бас өөр. Дан ялангуяа төсвийн мөнгөөр хувийн байшин барьж өгнө гэдэг болохгүй юм.

Зөндөө байшин барилга, сургууль, цэцэрлэг дутуу байгаа. Энэ төсвийн мөнгө болох ёстой татварын мөнгөө, тэр зүйл рүүгээ нөөцөө зарцуулаач ээ гэж байгаа юм.

Төсвийн мөнгө хувийн өмчийг барихад зарцуулагдаж болохгүй. Энэ зарчмаа Ц.Мөнхбат гишүүн бас ойлгох хэрэгтэй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ дээр би нэг зарчмын юм ярих гээд байгаа юм. Өчигдөр чуулган дээр санал хураалтууд яваад, Байнгын хороо, ажлын хэсэг дэмжээгүй саналууд санаатай, санаандгүй нэлээн олон босож ирсэн.

Одоо бид төсвийн гуравдугаар хэлэлцүүлэг болж байна. Энэ боссон саналуудыг ерөөсөө засах, залруулах боломж дэгээрээ хаалттай байна.

Өчигдөр Гомбын Ганбаатар гишүүний гаргасан Нийслэлийн боловсролын газрын 2.6 тэрбум төгрөгийг хасаад Цахим хөгжлийн яам руу урсгал зардалд нь шилжүүлэх санал боссон юм.

Тэгээд энэ Нийслэлийн боловсролын газар чинь 47 мянган ажилтан, албан хаагчтай, сая гаруй аав, ээж нарын, иргэдийн боловсролын үйлчилгээ

хийдэг байгууллага. Бүгдээрээ энэ урсгал зардалд нь явдаг. Тэгээд жил болгон 30, 40 жил ачаалалтай ажиллаж байсан багш нар Төрийн албан хаагчийнхаа хуулийн дагуу 36 сарын тэтгэмжээ авдаг юм.

Тэгээд энэ саналыг гаргаснаас болж энэ 117 багш нэр ус, регистртэйгээ багш нар маань 36 сарын тэтгэмжээ авах боломжгүй болоод байгаа байхгүй юу. Тэгээд яах вэ, Г.Ганбаатар гишүүнтэй ярилцсан л даа. Тэгээд Г.Ганбаатар гишүүн учир явдлыг нь ойлгосон. Ойлголцсон. Ажлын алба буюу тэр Ардчилсан намын ахлах зөвлөгч гэнэ үү, тэр хүмүүс нь буруу тооцоолол хийсэн байна лээ.

Яам Нийслэлийн боловсролын газраас нь тодруулалгүй болчимгүй санал гаргасан байна лээ. Тэгээд татвал татчихъя гэсэн байр суурьтай байгаа юм шиг байна лээ. Би тэгж ойлгосон. Бас юмаа ухаараад.

Тэгтэл энэ дэгийн хуулиар төсөвтэй холбоотой ийм буруу, зөрүү саналаа татах ямар ч боломж байхгүй зохицуулагдчихсан байгаа юм байна.

Тэгээд гишүүд мэдээж санал гаргах бүрэн эрхтэй. Гэхдээ тэр нь буруу санал байж магад. Түүнийхээ дараа ойлгож бай магад. Тийм ээ. Эсвэл бүр ингээд зарчимгүй хууль зөрчсөн саналууд гарч ирж магад.

Шүнийгээ нэг засах процесстой болохгүй бол хоёрдугаар хэлэлцүүлэг дээр уначихсан баахан саналууд босоод, төсвөө дахиад хачин болгочихдог. Тийм ээ. Засах боломжгүй болчихдог маань өөрсдөө дахиад бүтэн жил. Одоо энэ ч яах вэ 5 сарын асуудал байх шиг байна. Хэрэглэх төсөв маань, бодлого маань алдагдах ийм юм руу л ороод байна. /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Санал хэллээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Төсвийн тодотгол маань бас нэлээн их зардал бүхий л салбар хамрагдаж байна. Төрийн албан хаагчийн цомхотгол ерөнхийдөө 9 хувь гээд жигд шийдсэн юм шиг байна.

Тэгэхээр зарим салбарт 9 байтугай 15 ч гэдэг юм уу, тийм юм руу болгох. Зарим салбарт нь 1 хувь ч гэсэн цомхотгож болохгүй юунууд байна. Тэр хүүхэдтэй холбоотой, эрүүл мэндийн салбартай холбоотой. Эмч, багш хоёроос гадна тэр салбарт ажилладаг өөр олон хүмүүс байдаг.

Тэгээд энэ тал дээр Сангийн яам маань яг тэр хатуу 9 гэдэг юмыг бүгдэд нь жигд тараахгүйгээр яг тэр чухал эрэмбэлэх эрэмбээр нь шийдэх тал дээр ямар гарц гаргалгаа байгаа вэ? Энэ тал дээр бас би тодруулмаар байна.

Төсвийн тодотголд бүтээн байгуулалт дээр өөрчлөлт оруулахгүй гээд хуультай. Би тэрийг ойлгож байгаа. Гэхдээ энэ бүтээн байгуулалтыг харахаар

зарим нь анхныхаа өртгөөсөө 70 хувь, хоёр дахин, гурав дахин өсчихсөн. Зарим нь болохоор яг хэвээрээ яваад байдаг.

Энэ асуудал дээр үүнийг цэгцэлсэн нь дээр байх аа. Тэгэхгүй нэг мөнгө тавиулж байгаад дараа нь гурав дахин өсгүүлчихнэ гээд хөөцөлдөж явдаг. Үүний цаана нь авлига, хээл хахууллын асуудал, янз бүрийн буруу, зөрүү тохироо наймааны асуудал яваад байдаг юм биш байгаа. Энэ талын тодорхой асуудал дээр Сангийн яам маань юу гэж бодож байгаа вэ?

Аудитаар орсон, ороогүй. Заримыг нь оруулдаггүй, заримыг нь оруулсан гээд л. Энэ нь үзэмжийн асуудлаас болоод байдаг асуудал байна.

Тэгэхээр энэ төсвийн магадлалын асуудал дээр одоо бас нэлээн анхаарах шаардлага байна гэдгийг хэлмээр байна.

Бүтээн байгуулалттай холбоотой бүр нам зогсчихсон, мөнгө нь байгаа мөртөө хийж болохооргүй ийм бүтээн байгуулалтууд ер нь байна уу? Төсөв дээрээ бас нэмэр болоод. Тэр зардлаа энэ жилдээ юм уу, ирэх жилдээ орхиж байгаад өөр сая О.Номинчимэг гишүүний хэлдэг шиг тэр боловсрол. Хүний 30 жил ажилласан тэтгэмжтэй асуудал руу хамаагүй мөнгөн дүнгээр орж болохгүй байх. Ийм байдлаар жоохон маневр хийх боломж бололцоо байна уу гэдгийг би асуумаар байна.

Тийм учраас ер нь цаашдаа төсвийн тодотгол, хэмнэлтийн асуудлуудыг ярихдаа магадгүй 1 сараас 5 сар хүртэл маш хурдан хийсэн ажлууд нь урагшаа явсан. Ухнатсаар байгаад шийдэж чадаагүй тэр эрүүл мэндийн тоног төхөөрөмжүүд байж байна. Би сая нэг зарчмын санал оруулсан. Тэр нь боссон. Их дээд сургуулиудын хүүхдүүдийн төлбөрийг нэмэхгүй шүү, хамаагүй нэмэхгүй шүү гэж хязгаарлаж байгаад төрийн өмч өөрийнхөө ашиглалтын зардлыг төсөвт олон жил ярьж байгаад суулгаад шийдсэн.

Тэгэхээр хүүхдийн төлбөр гэдэг чинь цаанаа ард түмний нуруун дээр л ачаалал авчирна гэсэн үг.

Тийм учраас энэ нэг дулааныг нь хэрэглээд, цахилгааныг нь хэрэглээд өнгөрсөн, хагас жил өнгөрч байхад нь үгүй ээ, одоо бид үүнийг төсвийн тодотголоор хассан гээд хийгдээд өнгөрсөн юмнуудыг нь хасаж байгаа нь өөрөө зарчмын хувьд цаашдаа би буруу гэж хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн. Хэн хариулах юм. Та хариулах дэг байхгүй.

Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Асуулт, санал холилдоод л явчих шиг боллоо. Гишүүний асуултад хариулъя.

Ер нь 2021 оноос хойш ковидын тэр хүнд үеүдэд маш олон хөрөнгө оруулалтууд бас хойшилсон. Маш их хойшилсон, сунжирсан. Тэр үед төсөвт өртөг бас нэлээдгүй нэмэгдсэн. Тэрийг ойлгоод хүлээн зөвшөөрч болох юм. Гэтэл 2023, 2024 онд зургаар хийгдсэн төслүүд мөн төсөвт өртөг нэмэгдээд байгаа зүйлүүд байгаа. Нөгөө 3 дэд бүтцийн яамны маань дэргэдэх хөгжлийн төвүүд дээр нэмэгдээд хүрээд ирдэг. Тэрийг хэлж байх шиг байна.

Тэгэхдээ С.Эрдэнэбат гишүүн ээ, тэндээс үзэмжээрээ цааш нь оруулаад явуулаад байдаг тийм юм байхгүй шүү. Та үүнийг баримттай нотолгоотой ярина шүү. Ингэж худлаа ярьж болохгүй шүү. Бид бүгдийг нь аудитлуулаад, ингээд одоо хүлээж байгаа. Тэндээс сураг дуулдах нь ээ ер нь бүгдээрээ л бараг зөв байна гэж ирэх юм шиг байгаа юм.

Тэр төсөвт өртгийн нэмэгдлээр бараг 300 гаруй тэрбум төгрөг байна лээ. Тэрийг ирэх оны төсөвт бид багтааж шингээж тийм орон зай бараг байхгүй ээ. Ер нь бараг орж ирэхгүй байх. Үүнийг л нэлээн цэгцэлмээр байгаа юм. Ёстой нөгөө нэг цэцийн дээшээгээ хөх тэнгэр гэдэг шиг одоо тэр 3 хөгжлийн төвөөр гарч ирсэн магадлал дээр одоо хэн ч өөр ямар ч эксперт хийх өөрчлөх ямар ч эрх тийм зохицуулалт байхгүй. Байдаггүй. Ийм л нэг зовлонтой байна.

Нөгөө тал дээр тэр хувийн хэвшлийн сургуулиудыг бас хувьсах зардлаар нь дэмжих, дэмжихгүй гээд л гишүүд хоёр янзаар яриад байгаа юм. Та болохоор өг гээд л загнаад байгаа. Зарим гишүүд нь өгч болохгүй гээд л загнаад байгаа. Одоо ямар ч байсан ийм зохицуулалттай, хуультай. Хэрвээ оролдоё гэвэл хуультай нь ярих ёстой байгаа юм. Нөгөө намар орж ирэх хууль дотор чинь бас энэ орж ирнэ. Тийм.

Б.Пүрэвдорж: С.Эрдэнэбат гишүүн нэмж тодруулъя. Тэрний дараа Ц.Даваасүрэн сайд дарга хариулчих.

С.Эрдэнэбат: Үгүй ээ, би энэ зүгээр худлаа ярьсан гэж. Зарим юм анхныхаа өртгөөсөө 3 дахин өссөн байж байдаг. Яг ижилхэн баригдаж байгаа зарим юм огт өсгөдөггүй. Тухайлбал би одоо Хөвсгөл аймгийн Цагааннуур сумд очиход 9 удаа тендер зарлаад замынх нь нөхцөл нь маш хүнд. Тэрийг оруулахгүй. Үндсэндээ хуучин юутайгаа байгаад байдаг. Зарим газар нь гурав, дөрөв дахин өсөөд байгаа. Энэ бол хэн ч харсан бас би хардах эрхтэй.

Тийм учраас энэ бүх төсвийн магадлалгаатай холбоотой нэмэгдсэн төсөвт өртөг нь сүүлийн жилүүдэд огцом нэмэгдсэн энэ асуудлуудыг би тусгайлан татаж үзээд ажлын хэсэг гаргаад үзье. Түүн дээр аудитаар орсон бол бандан пад гэдэг байдлаар асуудалд хандаад яваад байх юм бол би энэ асуудлыг тусгайлан харж үзье. Хэн ч харахад зарим нь гурав дахин, хоёр дахин, 70 хувь өсчихсөн. Зарим хэсэгт нь огт өсгөдөггүй байгаад байдаг л асуудал байгаа шүү дээ. Жагсаалтаар харахад. Тэрийг л хэлсэн шүү.

Б.Пүрэвдорж: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн хариулъя.

Ц.Даваасүрэн: Тэр үнэ өсөөд байгаа асуудал дээр одоо бас их төвөгтэй юм нь хувийн магадлан экспертээр ордог. Тэгээд манай барилгын салбарынхан чинь одоо тэгээд л нэг анги төгссөн, найз нөхөд, янз бүрийн шалтгаанаар тэгээд л янз бүр үнийн өсөлтийг авдаг юм байдаг байж магадгүй гэж би бодож байна.

Тэгэхээр энэ асуудлыг ер нь цаашдаа нэг цэгцлэх ийм шаардлага байна. Энэ чинь аудит дээр очоод бараг өөрчлөлтгүй гараад явчхаад байгаа байхгүй юу.

Өөр нэг шалтгаан бол 3 жилээр төсвийн хөрөнгийг хуваарилалт тавиад байгаа нь миний бодлоор инфляцтай уялдаж үнэ өсөх нэг шалтгаан болж байгаа байх.

Тэгэхээр үүнийг бид цаашдаа төсөв батлахдаа энэ хөрөнгө оруулалтын юун дээр анхаарах шаардлага байна уу гэж.

Тэр С.Эрдэнэбат гишүүний яриад байгаа ялангуяа тэр үнийн өсөлттэй холбогдолтойгоор янз бүр тавигдаад байна гэдэг шалтгааныг бид төсөв хэлэлцэх хүртэл... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм.

Тэгэхээр цаашдаа одоо ингээд 2026 оны төсөв гэнгүүт энэ нэлээн яригдана. Одоо тэр Б.Жавхлан сайдын сая хэлээд байгаа 500-аад тэрбум болж байгаа байх. Тэр үнийн өсөлтийн юу чинь. Энэ орж ирнэ.

Тэгэхээр тэр үед бид үүнийг багтаах шингээх боломж төсвийн орлого буурч байгаа үед хэцүү байх гэж би бодож байна. Тэгээд ямар нэг байдлаар зохицуулахгүй бол. Зарим нэг компани магадгүй зүгээр одоо ингээд ерөөсөө ажлаа хийхгүй үнэ өсгөчхөөд. Тэгсэн мөртлөө хэдэн 100 саяар нэхээд аваад байгаа ийм зүйл ч бас байж байж магадгүй. Тэгээд энэ аль аль талаасаа бас анхаарах ийм шаардлагатай.

Тийм учраас Сангийн яам уг нь аудит хийлгээд байх шиг байгаа юм л даа. Тэгэхдээ үүнийг нь тогтоож өгч байгаа юм нэг их харагдахгүй л байна гэж би хараад байгаа. Зүгээр тэр 05 сарын 31-нээр яагаад байгаа бол цэц дээр очсон юм билээ. Одоо ингээд хөрөнгө оруулалт амжихгүй бол хураана гэдэг цэцээр шийдэгдэх байх.

Б.Пүрэвдорж: Болдын Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Үгүй ээ. С.Эрдэнэбат гишүүн ээ. Болдог бол Та тэгээд өгөөч. Бүгдийг нь татаж аваад нэг цэгцлээд өгөөч. Бид нарын дийлэхгүй, оролдож чадахгүй хэсэг ерөөсөө тэр байгаа юм.

Төсөвт өртгийг бид ерөөсөө оролдож чаддаггүй юм. Хянаж ч чаддаггүй. Тийм эрх байхгүй.

Тийм учраас тэрийг татаж аваад нэг цэгцлээд өгөөрэй. Өнгөрсөн онд бид төсөв батлуулахдаа дагасан тогтоол дээр бас тийм заалтууд оруулж авсан. Түүнийхээ дагуу эргэж тайлагнах үүрэг аваад 3 сард Их Хурал дээр дахиад хүргүүлсэн шүү дээ. Тэрийг та олж үзээгүй юм шиг байна.

Ийм ийм компаниудын хийж байгаа ийм ийм төслүүд дээр ийм магадлангаар ийм яамны дэргэдэх хөгжлийн төвүүдээр ийм экспертүүд ингэж ингэж үнэ нь нэмэгдсэн байна. Үүнийг нь бид дахиад аудиталсан боловч бас яг аудитын дүн нь хэвээрээ гарч ирж байна. Одоо үүнийг яах вэ. Төсөвт энэ багтахгүй шүү гээд. Тэрийг нь та сайхан татаж аваад үзээд шалга.

Б.Пүрэвдорж: Яг энэ асуудал ярьж байгаатай холбогдуулан. Ер нь энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тавьж байгаа тендер, арга хэмжээнд компаниуд оролцохдоо хэтэрхий үнээ доошоо тавьдаг. Тэгээд түүнийгээ буцаагаад яаж нөхдөг вэ гэх дээр магадлангаар нэмэгдүүлдэг. Түүндээ Их Хурлын гишүүд таны тавьсан хөрөнгө оруулалт энэ тэр гэж тэрийгээ ийш тийш яриулах гэж оролддог. Энэ нь ашиг сонирхлын зөрчил болдог ийм асуудлууд байгаа.

Тийм учраас ер нь энэ цааш цаашдаа хөрөнгө оруулалтыг тавихдаа ирэх намар 2026 оны төсвийн хуулийг оруулж ирэхдээ ер нь магадлал хийхгүй гэдэг ийм нэг заалт оруулж бас нэг хязгаар тавихгүй бол энэ арай. Сүүлийн үед үүнийг дагасан нэг тийм луйвар бизнес. Тийм ээ. Тэгээд ихэнхдээ төрийнхөн хулгай хийдэг ийм л зүйл болоод байгаа шүү.

Тийм учраас энэ дээрээ Сангийн сайд ирэх жилийн төсөв дээр анхаарч энэ заалтыг оруулж ирэх талаараа анхаарч ажиллаарай гэж хүсмээр байна.

Тэгэхдээ нэг талдаа бас яг тэр хөрөнгө оруулалтаар барилга барьж байгаа, үйлчилгээ үзүүлж байгаа тэр компаниуд тодорхой хэмжээнд компанидаа ашигтай байх ийм юмнуудыг хийхгүй тэгээд тулгаад тулгаад хийхээр буцаад л энэ магадлалаар оруулах ажил чинь орж ирээд байх юм гэдгийг хэлье.

Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Баярлалаа.

Ер нь хэлэгдэж байгаа асуудлууд давхцаж байна.

Үнэхээр төсвийн тухай хууль дээр бас асуудал байгааг бид бүгдээрээ хараад байгаа юм. Өнөөдөр энэ төсөвт ийм үр ашиггүй төсвүүд төсөвт орж суучхаад жилээс жилд инфляцаар өртөг нь нэмэгдээд, ингээд цаашлаад энэ бүр ингээд төсөв дээр ачаалал болоод ингээд дарамт болоод яваад байгаа юм.

Тэгэхээр бид энэ Төсвийн тухай хууль дээрээ бас нэлээн нэмэлт, өөрчлөлт, реформын шинжтэй өөрчлөлтүүд хийгээд энэ үр ашиггүй төслүүд байвал доор доор нь зогсоогоод, дуудлага худалдаанд оруулдаг ч юм уу, ингээд Засгийн газраас дахиж нэмж хөрөнгө оруулдаггүй. Энэ төсөл дээр дахиж нэмж хөрөнгө гаргадаггүй. Тэгээд үүсэж байгаа хэмнэлтийг нь илүү ирээдүйд чиглэсэн хөгжлийн хөтөлбөрүүдтэй оруулдаг ийм тогтолцоо руугаа бид орох ёстой байгаа юм.

Тэгэхээр надад нэг асуулт байна л даа.

2025 оны төсөл дээр 2011 оноос хойш үргэлжилж явж байгаа хэдэн төсөл байна аа? Мөн 2025 оны төсөв дээр ороогүй царцаж үлдсэн хэдий хэмжээний төсөв байна? Хэдий хэмжээний төсөв царцчихсан байгаад байна вэ?

Гуравдугаарт нь, төсөвт өртөг ер нь жилээс жилд өсөөд байна гээд гишүүд яриад байна. Жишээлбэл, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын инженерийн шугам сүлжээний төсөл 2022 онд 2.3 тэрбум төгрөгөөр орж ирж байсан байна. Одоо 16.9 тэрбум болоод 634 хувь өссөн байгаа. Баянхонгор аймгийн орон сууцжуулах төсөл байна. 2.3 тэрбум төгрөгөөр 2022 онд орж ирээд одоо 9.6 тэрбум болоод 3 дахин нэмэгдсэн байгаа юм.

Гэх мэтчилэн төсөвт өртгүүд маш огцом өсдөг байна. Үүнийг бид ер нь хэрхэн яаж гэнэт өсгөдөг, ямар тогтолцоогоор өсөөд байдаг юм бэ?

Хоёрдугаар асуулт нь, энэ жилийн шинэ орж ирсэн 110 шинэ төслүүдээс 39 нь барилга, байшингийн төсөл байсан. Тэр 39 төсөл нийтдээ 440 тэрбум төгрөг болсон. Гэтэл 380 орчим тэрбум төгрөгт тоног төхөөрөмж гэж орж ирж байгаа байхгүй юу. 2025 онд.

Ер нь яах вэ тоног төхөөрөмжийн хувьд үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүд өндөр өртөгтэй байдаг юм байна. Барилга, байшингаасаа өндөр өртөгтэй байдаг юм байна. Оффис удирдлагын барилга байшингуудын тоног төхөөрөмж нийт барилга, байшингийнхээ хөрөнгийн 20, 30 хувьд нь тэнцэж болохоор байдаг юм байна.

Тэгэхээр энэ тоног төхөөрөмжийн өртгийг хаанаас хяналт, баталгаажуулалтыг нь хийж энэ төсөвт оруулж ирдэг юм бэ? Цаашдаа бид 2026 оны төсөв батална. Тэр үед дахиад ийм их тоног төхөөрөмжийн төсөв орж ирэх үү гэж асууя.

Тэгээд надад нэг санал байна. Энэ төсөвт өртөг нь хүрэлцээгүй гэх мэт олон төслүүд жилээс жилд улсад ч тийм ээ, гүйцэтгэж байгаа компаниуддаа ч асуудал үүсгээд сунжраад яваад байна. Тиймд бид 2026 оны... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн нэмж тодруулъя.

Б.Пунсалмаа: Тэгэхээр бид 2026 оны төсвөөсөө өгсүүлээд Улсын Их Хурлаас Засгийн газарт тодорхой чиглэл өгөх хэрэгтэй байна.

Нэгдүгээрт, Засгийн газар төслүүдээ ач холбогдлоор нь эрэмбэлээд 2026 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмж тусгаж гүйцээж энэ ажлуудаа оруулаад, эсвэл хоёрдугаарт нь дуудлага худалдаагаар дуусаагүй бүтээн байгуулалтуудыг худалдах, борлуулах гэх мэтчилэн ажиллахыг Засгийн газарт Улсын Их Хурлын тогтоолоор чиглэл өгөхийг санал болгож байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн хариулъя.

Ц.Даваасүрэн: Манай тойрогтой холбогдолтой нэг зүйл яриад байх шиг байна.

Тэр шугам сүлжээний ажил чинь нэг нэртэй байхгүй юу. Нэг онд 2.3 тэрбумаар, дараа онд нь 16 тэрбумаар гэсэн. Нэр нь ижилхэн болохоос биш тухайн жил бүрдээ өөр өөр төсөвт өртөгтэй ажлууд байхгүй юу.

Ер нь бид нэг зүйл дээр анхаарах хэрэгтэй. Одоо ингээд хямд үнийн бага санал гэдгээр маш хямдаар авчхаад тэгээд энэ чинь төсөв чинь багтахгүй байна шүү дээ гээд л хэвтчихэж байгаа шүү дээ. Тийм ээ. 10 жил, 5 жил хэвтэж байна.

Тэгэхээр энэ асуудлыг нэг цэгцлэх ёстой юм бол ер нь байна шүү дээ барилгын салбарын хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй байгаа юм. Би энэ барилгын салбарын хуулийг нэг өөрчлөлт өргөн барья. Тэгээд гишүүд бас үүнийг дэмжиж өгөөч ээ гэж хүсээд байгаа юм.

Ерөөсөө бусад оронд яадаг вэ гэвэл даатгалаа төлж чаддаг, хариуцлага хүлээж чаддаг компаниар байшин бариулдаг байхгүй юу. Энэ тендерийг авч байгаа компани заавал тэрийг даатгуулдаг. Энэ байшинг барина гэдэг даатгал хүлээдэг. Хэрвээ барьж чадахгүй бол даатгалаас төлдөг.

Тийм учраас даатгалын компани, зөвлөх компаниар дамжуулаад хяналт тавьдаг. Энэ системийг бид оруулж ирэхгүй бол одоо энэ төсөвт өртгийг хянаж баталгаажуулаад хувийн барилгын зөвлөх, магадлан хийж байгаа экспертүүд үүнийг чинь хийж байгаа шүү дээ. Тэгээд тамга дараад төсвийг нь батлаад өгч байгаа.

Тэгэхээр Сангийн яам тэрийг хүлээж авахаас өөр ямар ч арга байхгүй. Хувийнхан шийдэж байгаа байхгүй юу. Тэр үнийн өсөлтийг. Тэгээд нөгөө хувийнхан шийдсэнийг Сангийн яам яаж ч чадахгүй учраас аудит хийлгэмээр болж байгаа юм. Аудитынх нь болохоор ер нь бараг өөрчлөлтгүй явуулчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ нэг талдаа тийм бизнесийн шинж чанартай болчихсон байж магадгүй. Үүнийг цэгцлэхэд их төвөгтэй байгаа нь тэр хувийнхан байгаа байхгүй юу. Төрийнхнөөр хийлгээ гэхээр бас тийм боломж байхгүй. Хэрвээ төрийнхнөөр хийлгэх юм бол маш том, энэ бүх төслүүд дээр магадлан хийх экспертүүдийг багтаасан агентлаг шиг хэмжээний 100 гаруй хүнтэй ч юм уу ийм нэгж байгуулах шаардлага гарна.

Хувийнхнаар хийлгээд байхаар бид хянаж чадахгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэр хүний оруулж ирснээр Монгол Улсын төсөвт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж батлаад байна шүү дээ бид нар.

Тэгэхээр ийм зүйл байгаа. Үүнийг ер нь цэгцлэх шаардлага бий. Ер нь барилгын хуульд нэлээн томоохон өөрчлөлтүүдийг хийх зайлшгүй шаардлагатай. Тэгж байж бид үүнийг засна.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Одоо төсвийн тодотголоор шинээр бүрдсэн Засгийн газраас өргөн барьж байгаагаар бид 1 их наяд 363 тэрбум төгрөгийн алдагдалтай төсөв баталж байгаа.

Тийм учраас би Төсвийн байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гаргаж 1 тэрбум 700 сая төгрөгөөр Өвөрхангай аймагт хийгдэж байсан ажлын нэмэлт санхүүжилтийг оруулах ийм зарчмын зөрүүтэй санал гаргаад Байнгын хороо, чуулганаар дэмжигдсэн. Үүнийгээ боломж байдаг буцаах ийм санал гаргаж байна.

Хоёрт, одоо энэ батлагдаж байгаа төсвөөр хувийн хэвслээ дэмжиж, хөрөнгө оруулалтаа сайжруулах ажлууд хийж чадах уу? Н.Учрал сайд аа.

Хоёр дахь асуулт нь, одоо энэ батлагдаж байгаа төсвөөр Засгийн газар хийнэ гэж төлөвлөсөн ажлуудаа хийж чадах уу? Одоо жишээлэхэд энэ Хөгжлийн банкн дээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд чинь үр дүнгээ өгч чадах уу?

Ер нь Засгийн газар төлөвлөсөн ажлуудаа алдагдалтай төсвөөр хийж дотоод, гадаадын бонд босгож оруулж ирж хийж чадах уу л гэдгийг тодруулж хэлж өгөөч.

Б.Пүрэвдорж: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Хамтарсан Засгийн газрын үед Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад Ардчилсан нам, ХҮН нам, Монгол Ардын намын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг тусгасан.

Та бид хамтдаа намуудын мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг тусгасан Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг Их Хурлаар баталсан. Энэ үед Ардчилсан намын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр дотроос Эдийн засгийн эрх, эрх чөлөө гэдэг бүлгийг нь энэ хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан.

Тэгэхээр энэ бол намын биш, одоо бол Засгийн газрын хөтөлбөр.

Тийм учраас энэ хувийн хэвшлийг дэмжих, баялаг бүтээгчдийг дэмжих, чөлөөт зах зээлийг дэмжих, энэ либералчлах бодлогыг манай Засгийн газар хэрэгжүүлэх л ёстой. Тэгэхдээ энэ өөрөө яг одоо өөрийн чинь ярьж байгаагаар зөвхөн нэг ийм төсвийн хөрөнгө оруулалтаар ажлуудыг хийгээд байх биш энэ төр, хувийн хэвшлийн түншлэлээр, гадаадын хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, гадаад зээл, тусламжийг нөгөө импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зарцуулах зорилго руугаа л чиглэх ёстой.

Нэгэнт эдийн засаг агшаад байна. Нөгөө гол экспортын бүтээгдэхүүний маань үнэ унаад байна. Тэгээд ийм үед бид яах ёстой юм бэ гэхээр тэлэх бодлого явуулна. Би үүнийг байнга хэлж байгаа юм. Тэлэх бодлого явуулахын тулд энэ чөдөр тушаа болоод байгаа дүрэм журам, саад тээг, хувийн хэвшил, баялаг бүтээгчдийг дэмжих ямар боломж бололцоо байна бүгдийг нээх ёстой шүү дээ. Тэгж байж эдийн засаг цаашдаа эрүүлжинэ.

Тэгэхээр энэ бодлого Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан. Ардчилсан намын эдийн засгийн эрх чөлөө гэсэн мөрийн хөтөлбөрийнх нь зорилтууд. Би үүнийг хэрэгжүүлэх ёстой гэж бодож байгаа. Эдийн засаг, хөгжлийн сайдаар ажиллаж байгаагийн хувьд.

Тэр Хөгжлийн банк гээд бас дурдсан. Хөгжлийн банк ашиггүй зээл нь тоогоо алдсан. Бараг 1.6, 1.7 их наяд болсон уу, юу болсон.

Тэгээд энэ Хөгжлийн банк засаглалаа эрүүлжүүлэх ёстой. Манай 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Хөгжлийн банкныг Экспорт, импортын банк болгоно гээд ийм зорилттой юм шүү дээ.

Тэгээд сая 350 сая долларын бонд босгосон байна. Сайн мэдээ. Гэхдээ эхнээсээ зам барья гээд эхэлж байна. Манай сайд нар. Би хэлж байгаа юм. Зам барихгүй ээ. Өмнө нь яалаа. Ирээдүйд өрийг юу гэж бичээд билээ. Нэг юм болсон шүү дээ. Түүн шиг бонд гэдэг чинь өр шүү дээ. Тэгээд 1 доллар оруулж ирсэн юм бол түүнийг 3 доллар болгох зүйлд л зарцуулах ёстой биз дээ.

Тийм учраас харин Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нөгөө гангийн үйлдвэр. Магадгүй арматурыг Монголдоо үйлдвэрлэх. Тэгээд гадагшаа гарах валют дээр нь хязгаарлалт хийх боломжтой энэ төслүүдийг дэмжих ёстой шүү дээ.

Бид бас үнэнийг ярьж сурах ёстой. Хөгжлийн банкны өнгөрсөн хугацааны зээлүүдээс ер нь явж явж хараад үзэхээр МАК, Монполимет хоёрын цементийн зээл л хамгийн сайн юм билээ шүү дээ. Тэр чинь гадагшаа гарч байгаа урсгалыг зогсоогоод, дотооддоо цемент үйлдвэрлэдэг болох л төслийг санхүүжүүлсэн байхгүй юу. Гэтэл уулзвар бариад, зам бариад юу болсон юм.

Тэгэхээр яг импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа төслүүдийг дэмжиж чадсан цагт цаашаа бондын санхүүжилт ч бодитой болно.

Тийм учраас ер нь гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг 3 удаа оруулж ирсэн байна. Энэ жил эдийн засгийн форумыг 3 дахь жилдээ хийж байна. 3 жил гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг батална гэж ярьсан юм билээ. Тэгээд одоо болих л хэрэгтэй л дээ.

Тийм учраас одоо намар гадаадын хөрөнгө оруулалтын хуулиа ч тэр, наад төр, хувийн хэвшлийн түншлэлээ ч тэр бүгдийг нь явуулах л хэрэгтэй гэж үзэж байгаа.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Н.Учрал гишүүний зарим хариулт буруу байна шүү.

МАК, Монполимет хоёр цементийн үйлдвэр барилаа ч гэсэн Хятадын цементийнхээ татварыг хөнгөлчхөөр тэр үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тэр асуудал чинь бас буцаад байхгүй болчхож байгаа шүү дээ.

Хоёрдугаарт нь, Да.Цогтбаатар гишүүн ээ, би таны эхний гаргаж байгаа тэр саналаа татах асуудал дээр чинь хариулт өгье.

Дэгийн тухай хуулийн 39.32 дээр гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа Байнгын хорооны хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад л татаж авч болно.

Мөн 41.7-гоор гишүүн, нам, эвслийн бүлэг гаргасан зарчмын зөрүүтэй саналаа нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад татаж болно.

Тэгэхээр гуравдугаар хэлэлцүүлэг эцсийн хэлэлцүүлэгт тооцогдоно.

Тийм учраас төсөв хэлэлцэх тусгай дэг байгаа. Түүгээр ч гэсэн бас татаж болохгүй юм байна.

Тийм учраас таны санал бандан тас болсон гэсэн үг.

Одоо Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Өнөөдөр 2025 оны төсөв хэлэлцэж байна.

Төсөв хэлэлцэж байх үед Хөдөө аж ахуйн сайд Ж.Энхбаяр нь чуулгандаа суудаггүй юм байна. Өчигдөр малчдад өгөх дэмжлэгээ баяртайгаар хасуулж авчхаад хэдэн троллуудаараа намайг балбуулж яваад байх шиг байгаа юм.

Би энэ дээр хариуцлагатайгаар хэлье. Би өчүүхэн ч хувийн эрх ашиг энд яриагүй. Би Монголын 220 мянган малчдын ажилтай, орлоготой, амьжиргааг нь сайжруулахын төлөө л ярьсан.

Өнөөдөр Зээлийн батлан даалтын сангийн 45 тэрбум төгрөгийн активыг 40-ийг нь хасаж хаяад хэдхэн аж ахуйн нэгжид өгөх урамшууллын төлөө тэмцэж байна. Энэ хүн. Малчдад ээлгүй Хөдөө аж ахуйн сайдтай бид болжээ гэдгийг хэлье.

Биднийг өнөөдөр хоолтой ундтай, Монгол ахуй соёлтой, Монголыг эзэнтэй байлгаж байгаа хүмүүс малчид шүү. Сонгууль болохоор малчдадаа хайр зарлаж явчхаад, сонгууль дуусахаар малчдын эсрэг ажилладаг ийм Хөдөө аж ахуйн сайдтай сууж байгаадаа үнэхээр гутаж байна.

Одоо тэгээд тойрог дээрээ очоод малчид дээрээ очихоор малчдад өгөх “Шинэ хоршоо” хөдөлгөөнийх нь дэмжлэгийг хасуулж хаячхаад тэгээд өөрсдөө үгээ олоод хэлнэ байлгүй дээ. Энэ эсрэг санал өгсөн хүмүүс нь.

Би зүгээр нэг статистик тоо хэлээдэхье. Сая Хөгжлийн банкны асуудлыг ярьж байх шиг байна. Хөгжлийн банканд 66 аж ахуйн нэгжид зээл олгосон. 3.2 их наяд төгрөгийн зээл. Тэгээд өнөөдөр чанаргүй зээл нь 80 гаруй хувьтай. Тэгтэл “Шинэ хоршоо” хамгийн амжилттай эргэж байгаа төсөл гэдгийг нь би хэлээдэхье. Одоо эргэн төлөлт нь 2-хон сарын хугацаанд эргэн төлөлт явж байгаа. Зээлийн төлөлт хэвийн, ганц ч хоцрогдсон зээл арилжааны банкууд дээр байхгүй байна. Өнөөдрийн байдлаар. Одоогоор 20 гаруй тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн. Татварын санд 500 гаруй сая төгрөгийг төвлөрүүлж байгаа.

Малчны хэрэглээний зээл 24 хувийн хүүтэй. 98 хувийн эргэн төлөлт ямар ч асуудалгүй төлж байгаа шүү. Хамгийн их эргэн төлөлт, чанаргүй зээл үүсгэж байгаа асуудал бол аж ахуйн нэгж дээр үүрдэг.

Үндсэндээ Хөдөө аж ахуйн яам төвийн бүсийн яам болсон юм байна. Монгол Улс даяар хэрэгжиж байгаа хөдөлгөөнийг дэмждэггүй, зөвхөн хэдхэн аж ахуйн нэгж, газар тариаланг дэмжиж байгаа ийм л Хөдөө аж ахуйн яам болсон юм байна. Маш их харамсаж байна.

Дахиад энэ улс даяар хэрэгжиж байгаа хөдөлгөөнүүдийг ялгамжтай ханддаг, Засгийн газар үе үе хэрэгжүүлээд нэг санаачилга гаргаад хэрэгжүүлдэггүй унагаадаг. Үүнийг хэн төлдөг вэ гэхээр өнөөдөр татвар төлөгч... /минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир.

Ө.Шижир: Өдрийн мэнд.

Ер нь Засгийн газрын танилцуулга дунд “Алт-3” гэдэг хөтөлбөр нэлээн хэд давтагдлаа.

Монгол Улс нүүрс, зэс, алт гэх мэт байгалийн баялгаа зарж түүнийхээ орлогоор амьдардаг буюу байгалийн баялгийн үнийн өсөлт, уналтаас хэт хамааралтай ийм эдийн засаг, төсөвтэй улс.

Дэлхийн зах зээл дээр аль нэг бүтээгдэхүүний үнэ уналаа гэхэд манай төсөв яг тэр чигээрээ дагаж төсөв хасагддаг ийм зүйл байгаа. Одоо л гэхэд ганцхан нүүрсний үнээс улбаалаад 3.3 их наядын төсөв татрах асуудал үүсчхээд байна.

Тийм учраас Засгийн газрын Сангийн сайд, Н.Учрал сайд дан ганц алт гэхгүйгээр бусад эрдэс баялгаа бас эдийн засгийн эргэлтэд оруулах тийм боломж ямар байгаа юм бэ гэдэг дээр илүү анхаарах ёстой байх. Тэгж байж бид эдийн засгаа тэлэх тал дээр илүү анхаарах байх.

Одоо уран. Өөр юу гэдэг юм. Нөгөө газрын овор элемент гэдэг ч юм уу. Ер нь тэгээд нэгэнт цаашдаа бид хөтөлбөр зарлаад явж байгаа бол Засгийн газар нэгэнт олгосон зөвшөөрлөө өөрөө хамгаалдаг байх хэрэгтэй. Тэгэхгүй Засгийн газар, төр нь зөвшөөрөл олгодог. Авсан компани нь очоод хайгуулаа хийх гэдэг. Орон нутгийн иргэд нь, орон нутгийн иргэдийн төлөөлөгчид нь, орон нутгийн тэнд нөлөө бүхий хүмүүс нь жадлан эсэргүүцээд тэнд зогсдог. Үйл ажиллагааг нь явуулдаггүй. Сүүлд гэхэд 06 сарын 11-ний өдөр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд хайгуул хийхээр очсон компани руу буугаар буудсан хүртэл хэрэг гарсан байна шүү дээ.

Тэгэхээр энэ мэт юмнуудаа Засгийн газар хамгаалдаг, үйл ажиллагааг нь хэвийн явуулдаг болохгүй бол манайд гадаадын хөрөнгө оруулалт шинэ шинэ хөтөлбөрүүд амжилттай хэрэгжихгүй. Одоо хамгийн энгийн жишээ гэхэд бид

уран сая хэдэн жилийн үр дүн тэмцлийн ард нэг юм хоёр улсын Засгийн газрын хооронд эхлэв.

Нөгөө “Хармагтай” гээд л яригдаад байдаг, “Эрдэнэ Монгол” гээд л яригдаад байдаг, “Халзан бүргэдэй” гээд л яригдаад байдаг. Зөвшөөрлийг нь өгсөн. Нөгөө компаниуд нь үйл ажиллагаа явуулах гээд явуулж чаддаггүй. Очоод тэгнээд хэвтчихдэг. Түүн дээр нь аймгийн Засаг дарга нар нь хүртэл оролцдог, сумын иргэдийн Хурал нь оролцдог ийм байх юм бол бид хэзээ ч гадаадын хөрөнгө оруулалт гэдэг зүйлийг ахиад ярьж чадахгүй.

Ер нь дахиад хэлэхэд төр нэгэнт олгосон өөрийн зөвшөөрлөө тухайн авсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөл байдлаар нь хангах тал дээр анхаарахгүй бол бид хэчнээн гоё хөтөлбөр, хэчнээн гоё мөрийн хөтөлбөр зарлаад хэрэгжилтийн шатанд унаад байна.

Тэгэхээр Монгол Улсын Засгийн газар өөрөө зөвшөөрөл өгсөн бол олгосон зөвшөөрлөө хамгаалдаг, үйл ажиллагаагаа хэвийн явуулдаг, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг саадгүйгээр үйл ажиллагаа явуулахад тусламж, дэмжлэг үзүүлдэг байхгүй бол бид нарт хэзээ ч дараа дараагийн хөрөнгө оруулалт гэж байхгүй. Одоо ганцхан гадаад хөрөнгө оруулалтын компани гэхгүйгээр дотоодын компаниудыг хүртэл одоо яг энэ проблем маш их тулж байна.

Тэгэхээр бид энэ дээр анхаарах хэрэгтэй.

Ер нь цаашдаа эдийн засгийн алт, зэс, нүүрс гээд хэдхэн байгалийн баялгаас олж байгаа орлогын үнийн өсөлтөөс бүх юм хамаараад байгаа учраас бид эдийн засгаа төрөлжүүлэх солонгосруулах үүднээс илүү олон ашигт малтмалын ордууд, нөөцүүдийг ашиглах тал дээр Засгийн газрыг анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Ө.Шижир гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Энэ төсвийг дагаад хамгийн том асуудал бол төрийн өмчийн компаниуд дээр байгаа.

Тэгэхээр Эрдэнэ-Очирын Тамир гэдэг залуу “Тавантолгой төмөр” замын хяналтын менежерээр очсон. Маш их олон зүйлүүдийг гаргаж ирсэн. 5 их наядаар бид “Тавантолгой төмөр” замыг барьсан. Гэвч өнөөдөр Тавантолгойгоос хил хүртэл нүүрс зөөхөд 15 доллар 74 центээр авто тээврээр зөөж байна.

Гэтэл нөгөө “Тавантолгой төмөр” замаар болохлоор 18 доллароор зөөж байгаа байхгүй юу даа. Үгүй ээ, энэ төмөр замаар хямдхан тээвэрлэнэ гээд. Угаасаа ч дэлхий даяар хямдхан байдаг.

Гэтэл авто тээврээсээ үнэтэй төмөр замын тээвэр байх юм бол яах гэж бид 5 их наяд төгрөгөөр төмөр зам барьж байгаа юм бэ? Тэгээд яагаад энэ Тавантолгойн төмөр зам ийм үнэтэй болов гэхээр:

▷ **Нэгдүгээрт**, хэт олон ажилчидтай.

▷ **Хоёрдугаарт**, улс төрчдийн нөлөө орсон. Хулгай хийдэг.

▷ **Гуравдугаарт**, иддэг уудаг юм тэнд бүр дээд зэрэг.

Тэгээд би үүний жишээ нь харьцуулалтуудыг хэлээд өгье л дөө. Жишээ нь, “Тавантолгой төмөр зам”, “Ханги-Мандалын төмөр зам” гээд хувийн хэвшлийн компанийн зам байна. Хоёулаа адилхан 240 километр замтай.

Гэтэл “Тавантолгой төмөр зам”-д **1000 хүн ажиллаж байна**.

Нөгөө хувийн хэвшлийн “Ханги-Мандалын төмөр зам” компани дээр **290 хүн ажиллаж байна**.

Тэгээд “Тавантолгой төмөр” замын төв **оффист 180 хүн ажиллаж байгаа**. Түүний 120 нь нөгөө төмөр зам дээр очиж үзээгүй байгаа нөхдүүд байгаа шүү дээ.

Гэтэл нөгөө “Ханги-Мандал”-ын хувийн хэвшлийн Улаанбаатар дахь **оффист 9-хөн хүн ажиллаж байгаа**. Үйлчлэгч, нарийн бичиг хоёрыгоо оруулаад.

“Тавантолгой төмөр” замын 1000 ажилчин 810 вагон хариуцаж байгаа.

Гэтэл “Ханги-Мандалын төмөр зам”-ын 290 хүн 1000 вагон хариуцаж байгаа байхгүй юу даа.

Ийм замбараагүй юм байгаа юм. Тэр худалдан авалт нь бүр замбараагүй. Муурын цээживч худалдаж авах жишээтэй. Архи, пиво аваагүй юм байхгүй.

Тэгээд шүүмжлэл гараад. Э.Тамир бид хоёр хэвлэлийн бага хурал хийсэн. Үүний үр дүнд тэр юуг татан буулгасан байгаа. 2 компанийг. “Тавантолгой төмөр зам”, “Монголын төмөрзам” хоёрыг нийлүүлсэн. Тэгээд 500 гаруй хүн халсан байгаа.

Гэтэл өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой”-н нэг авлигач түшмэл энэ 2 компанийг нэгтгэнэ гээд албан бичиг өгөөд тэрийг нэгтгэж байна шүү дээ. Ийм юм байхгүй.

1 минутаа нэгмөсөн авчихъя.

Х.Булгантуяа: Б.Пүрэвдорж гишүүн нэмж 1 минут.

Б.Пүрэвдорж: Тэгээд яаж байна гэхээр энэ төмөр замтай холбоотой “Эрдэнэс Тавантолгой”-гоос 14 километр газар яваад ТНАЛТ /Тээврийн Нэгдсэн Автомат Логистикийн Төв/ гэнэ үү, юу гэнэ үү, нэг газар аваачиж, нэг машин нүүрс буулгахад 1 сая 100 мянган төгрөгөөр тээвэр хийж байгаа юм. 14-хөн километр газар.

Тэгээд хил дээр аваачиж буулгачхаад хилээсээ Хятадын хил давуулахад 4-хөн километр газар. 1 сая 800 мянган төгрөгөөр тээвэр хийж байсан.

Энэ бүхнийг бүгдийг нь буулгаад явсан чинь нөгөөдхөө идэж уухын тулд “Эрдэнэс Тавантолгой”-н нэг авлигач түшмэл энэ хоёр компанийг нэгтгэнэ гээд албан бичиг бичээд Засгийн газар тэрийг нь нэгтгэж байгаа юм байна.

Энэ тийм юм байхгүй шүү. Би энэ түр хороо байгуулах эрх энэ цөөнхөд бүрэн ирж байгаа. Би намар түр хороо байгуулна. Энэ “Тавантолгой төмөр зам”, “Монголын төмөр зам”-ыг шалгах түр хороо байгуулна.

Идсэн уусан бүх юмыг чинь яаж түр хороог ажиллуулж болдгийг би та нарт харуулна.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Төрийн өмчийн компаниуд 122 шүү. Бүртгэлтэй байсан. Орон нутгийн улсын төсөвт үйлдвэрийн газрууд, орон нутгийн өмчит компаниуд бараг 700 гаруй. Бүтэн ч тоолж чадахааргүй байгаа шүү дээ.

Тэгэхээр төрийн өмчийн компаниудыг цэгцлэх чиглэлээр төрийн өмчийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль Их Хурал дээр хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн.

Энэ хууль батлагдлаа бол “Засгийн газраас төрийн өмчийн компани дээр баримтлах чиглэл” гэж орж ирсний дараа зөвхөн ашигтай ажилладаг төрийн өмчит компаниуд Компанийн хуулиар зохицуулагдаад үлдэнэ. Бусад төрийн нэрийн өмнөөс зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа зарим газрууд сайдын багц дээр PUBLIC INSTITUTION гээд “нийтийн үйлчилгээний байгууллага” гэж үлдэх ёстой.

Тэгэхээр “Монголын төмөр зам”, “Тавантолгой төмөр зам” хоёр компанийг нэгтгэх шийдвэрийг хамтарсан Засгийн газрын үед гаргасан. Тийм.

Тэгээд “Тавантолгой төмөр зам” бол төслийн компани болсон.

Энэ дээр Б.Пүрэвдорж гишүүн бас энэ асуудлуудыг нь гаргаж тавьсан. Үүний дараа энэ хоёр компани нэгдсэн. Ингээд цомхотгол хийгдээд ажил нь явж байгаа.

Түүнээс биш Г.Занданшатарын Засгийн газар байгуулагдсанаас хойш тэр “Эрдэнэс Тавантолгой” компанитай энэ хоёр том төмөр замыг нэгтгэх асуудал огт яригдаагүй байгаа. Энэ бол өөрөө бас тийм судлагдаагүй буюу тийм боломжгүй зүйл ээ л гэж би ойлгож байна. Энэ асуудал шийдэгдээгүй.

Яагаад вэ гэхээр компани нэгтгэх, нийлүүлэх асуудал дээр заавал аудит орж байж, ингээд аудитын дүгнэлтийг харж байж, тэгээд нэг чиг үүргийн шинжилгээ хийж байж нэгтгэх асуудал яригдаж байгаа болохоос биш зүгээр Их Хурал дээр орж ирсэн тогтоолоор нэгтгэх, нийлүүлэх гээд шууд хүчээр шийдээд үр дүнд хүрээгүй.

Өнгөрсөн хугацаанд ч гэсэн Их Хурлын тогтоол гараад зарим компанийг нээлттэй компани болгох шийдвэр гарсан ч гэсэн аудит ч ороогүй, UNDERWRITER-ын зардал, чирэгдэл нь ч бүтэхгүй, үнэлгээ нь ч үнэд хүрэхгүй ийм компаниудыг нээлттэй компани болгоод хөрөнгө мөнгө босгоно гэж байхгүй шүү дээ.

Тийм учраас зарим компанийг татан буулгах, нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, хувьчлах, IPO гаргана гэдэг цэвэр хөрөнгө төвлөрүүлэх. Хөрөнгө босгож, илүү үр ашигтай ажиллуулах чиглэл рүү хандана.

Тийм учраас Засгийн газар дээр ийм шийдвэр гараагүй байгаа гэдгийг Б.Пүрэвдорж гишүүнд хэлье.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд асуултад хариуллаа.

Гишүүд тайлбар хийж, асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орьё.

**Арван хоёр.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн
2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Түрүүн хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа өөр нэг хорооны хуралтай байж байгаад хуулиа уншиж танилцуулж арай амжаагүй. Өмнөх асуудалдаа оръё.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025 оны 06 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа.

Хэлэлцэх эсэх асуудалд оръё.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна.

Индэрт урьж байна.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн, хүмүүжүүлсэн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хуулийг анх Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1957 оны 43 дугаар тогтоолоор хэлэлцэн баталсан байдаг.

Монгол Улсад парламентын тогтолцоо үүссэнээс хойш буюу 2010 онд Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль болгон баталж, 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдөж эхэлсэн юм.

Хууль 2010 онд батлагдсанаас хойш хоёр удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд өнөөг хүртэл олон хүүхэдтэй эхчүүдийн хөдөлмөр, нийгмийн хариуцлагыг үнэлж, төрийн хүндэтгэлээр алдаршуулж ирсэн чухал эрх зүйн зохицуулалт.

Эхийн алдар одон нь олон хүүхэд төрүүлсэн эхчүүдэд хүндлэл, нийгмийн үнэлэмж, хөшүүргийн бодит хэрэгсэл болсоор ирсэн юм.

Гэтэл одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.2 дахь хэсэгт бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх, нас барсан

хүүхэд нь нэг ба түүнээс дээш настай байх гэсэн шалгуур тавьж байгаа нь хүний эрх зөрчсөн, ялгаварлан гадуурхсан нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж байгаа юм.

Энэхүү зохицуулалтаас үүдэн хүүхдээ 1 нас хүргэлгүй алдсан эхчүүд зөвхөн ээжүүд энэ үүрэг хариуцлагыг хүлээх болж, ээжүүд төрийн хүндэтгэлийг хүртэх эрхгүй, сэтгэл зүйн хувьд дарамтад орох, нийгмийн үнэлэмжээс доогуур орхигдох зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...”. Мөн хуулийн 2-т “...хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж, Арван зургадугаар зүйлийн 5-д “...хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1-д “...төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 нас хүртэл эрхийг нь хангах тухай тус тус заасан байдаг.

Тиймээс энэхүү хуулийн төслөөр одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.2 дахь хэсэгт заасан бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх, нас барсан хүүхэд нь 1 ба түүнээс дээш настай байх гэсэн шалгууруудыг хасаж төрүүлсэн, өсгөсөн, асарсан бүх хүүхдийг ялгаварлалгүй тооцон эхийн алдар одон, төрөөс үзүүлэх урамшуулалд хамруулах нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Хууль санаачлагчид цаашид эхчүүдийн үүрэг, үнэ цэнийг төрийн хүндэтгэл урамшууллын хэлбэрээр эрх зүйн орчинд нь тогтвортой хадгалан үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэж байгааг онцлон тэмдэглэе.

Хуулийн төсөл 2 зүйлтэй бөгөөд дараах агуулгыг тусгасан.

Нэгдүгээрт, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсгээс “бага хүүхэд нь 1 нас хүрсэн” гэснийг, 3.2 дахь хэсгээс “бага хүүхэд нь 1 нас хүрэхэд байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас 1 ба түүнээс дээш настай” гэсэн болзлуудыг тус тус хасаж, хүүхэд тээн төрүүлсэн болон асарсан хөдөлмөрийг бодитоор үнэлэх зохицуулалтуудыг тусгасан болно.

Хоёрдугаарт, энэхүү хууль нь 2026 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн хэрэгжихээр заасан.

Хуулийн төсөл батлагдсанаар эхийн алдар 1 дүгээр зэргийн одон авах эхчүүдийн тоо 10 мянга 154-өөр, 2 дугаар зэргийн одон авах эхчүүдийн тоо 27 мянга 140-өөр нэмэгдэх бөгөөд үүнд нийтдээ 7.5 тэрбум төгрөгийн нэмэлт зардал улсын төсөвт шаардлагатай болно.

Энэхүү зардал нь нийгмийн халамжийн нийт төсвийн 0.2 хувийг эзлэх бөгөөд хүүхдийн эрхийг сэргээх, хүний эрхийн тэгш зарчмыг хангах, төрийн бодлого ялгаварлалгүй үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх, хүн ам зүйн бодлогын хэрэгжилтэд үр өгөөжтэй бодит хөрөнгө оруулалт болно гэж хууль санаачлагчдын зүгээс үзэж байгаагаа илэрхийлье.

Иймд энэхүү хуулийн төсөл нь төрөөс олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийн хөдөлмөр, амьдралын бодит нөхцөл байдалд тулгуурлан эхчүүдийг алдаршуулахдаа тэгш, ялгаварлалгүй байх зарчмыг хэрэгжүүлж, хүний эрхийг хамгаалах, хүн ам зүйн бодлогыг тууштай хэрэгжүүлэх төрийн хүндэтгэлийн мэдэгдлийг хадгалах, үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон хүн амын өсөлтөд үнэтэй хувь нэмэр оруулах эрх зүйн зохицуулалт гэж үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж өгөхийг Та бүхнээсээ хүсэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Төслийн талаарх Нийгэм бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ танилцуулна.

Индэрт урьж байна.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нараас 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 07 сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчид одоогийн хуулийн зохицуулалтаар урамшуулал авах болзолд бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх, нас барсан хүүхэд нь 1 ба түүнээс дээш настай байх зэрэг нөхцөл тавигдаж байгаа нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг зөрчиж, хүүхдийг насаар нь

ялгаварлан гадуурхах нөхцөл бүрдүүлснийг засах, хүний эрх, эрхэм чанарыг хүндэтгэх, төрийн үүргийг хангах шаардлагатай байгааг харгалзан хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргах зардлын тооцоо хийх аргачлалын хүрээнд Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталснаар улсын төсөвт 7.5 тэрбум төгрөгийн зардал шинээр үүснэ гэж хууль санаачлагчид үзжээ.

Хуулийн төслийг D-Parliament.mn цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Засгийн газраас тус хуулийн төслийг дэмжээгүй үндэслэл, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хуулийн төслийн хүрээ хязгаарт зөвхөн Монгол Улсад төрсөн хүүхдэд хамаарах талаар тусгасан үндэслэлийн талаар тус тус асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хуулийн төслийг хэлэлцэх хүрээнд хүүхдийн насны талаар үүсэж буй ой ойлголтын зөрүүг арилгах талаар санал хэлсэн.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68.8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн хүүхдийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд

Х.Булгантуяа: Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчдын илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. 2 гишүүн ирүүлсэн байна.

С.Эрдэнэболд гишүүн. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн байхгүй байна. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн байхгүй байна.

Одоо хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан дэмжсэн болон эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдахуй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

Урьдчилсан ирүүлсэн нэрсээр Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн. 1 номерын индрээс хэлэх нь байна шүү. Х.Баасанжаргал гишүүн. Индрийн 2 номерын микрофон өгье.

Х.Баасанжаргал: Өдрийн мэнд хүргэе. Эрхэм Улсын Их Хурлын гишүүддээ.

Хууль санаачлагчдын санаачилсан энэхүү хуулийн төслийг Та бүхнийг дэмжиж өгөхийг хүсэж өнөөдрийнхөө үгийг бэлдлээ.

Юуны өмнө Монгол Улс Хүүхдийн эрхийн конвенцод нэгдэн ороод Хүүхдийн эрхийн конвенцод заасан төрийн хүлээх үүргийг бүгдийг хүлээхээр олон улсын өмнө амлалт авсан. Гэвч харамсалтай нь бид 1 нас хүртэл хүүхдийг хуульд заасны дагуу хүүхдийн тоонд оруулахгүй байх, 1 нас хүрээгүй байхдаа нас барах юм бол олон хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэг тоонд оруулахгүй байхаар олон жил мөрдөж ирсэн.

Энэ нь хүүхдийн эрхийн асар ноцтой зөрчил. Олон улсад 1 нас хүрсэн байтугай эхийн хэвлийд байгаа хүүхдийг хүүхдэд тооцох эсэх асуудлаар маш их маргаан өрнөж байна. Аль хэдийн эхийн хэвлийдээ бүрэлдээд, төрөөд өсөж бойжиж байсан энэ хүүхдийг бид хүүхэд биш гэж үзэж ирсэн энэ төрийн бодлогыг, энэ хүүхдийн эрхийн зөрчил бүхий хуулийн заалтыг бид нэн даруй өөрчлөх ёстой.

Манай Улсын Их Хурал, парламент “хүн төвтэй” бодлого, стратегийг бид баталсан. Үүн дотроо тэр дундаа хүүхдийн эрхийн асуудал нэгдүгээрт байх ёстой.

Тийм учраас Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхнийг энэ хуулийн төслийг дэмжиж өгөхийг хүсье.

Энд ганцхан заалтын асуудал байгаа хэдий ч гэсэн үүний цаана байгаа мянга мянган ээжүүд, мянга мянган охид бүсгүйчүүд, мянга мянган аавуудын зүрх сэтгэл эмтэрч явдаг ийм сэдэв асуудал байгаа шүү гээд өнөөдрийнхөө үгийг өндөрлөө.

Ингээд Та бүхнийг дэмжинэ гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал дэмжиж үг хэллээ.

Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар хэлэлцэх эсэхийг дэмжих санал хураалтыг нэгдсэн байдлаар бусад санал хураалттай нэгтгэж явуулъя.

Дараагийн асуудалдаа оръё.

Арван гурав.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна.

О.Номинчимэг гишүүнийг индэрт урья.

Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд болон холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Нэг.Бусад Байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлт.

1.Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу Хууль зүйн байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан 2 зарчмын зөрүүтэй санал гаргаснаар санал хураалт явуулахад олонх дэмжиж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг санал, дүгнэлтийн хамт байнгын хороонд ирүүлсэн.

2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт холбогдуулан 1 зарчмын зөрүүтэй санал гаргаснаар санал хураалт явуулахад олонх дэмжиж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын санал, дүгнэлтийн хамт Байнгын хороонд ирүүлсэн байна.

3.Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн.

4.Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу Төсвийн байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн.

Хоёр.Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хороодоос ирүүлсэн 3, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Д.Батбаяр нарын гаргасан 4, нийт 7 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явууллаа.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хишгээгийн Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга Маамын Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх Ичинноровын Баттөгс гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Зөвхөн асуулт. Эхнийх нь.

Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл.

Д.Рэгдэл: Баярлалаа. Улаанбаатар хотын зүгээс ямар ч байсан түгжрэлийг бууруулах талаар алхам алхмаар нэлээн ажил хийгээд байгаа нь мэдэгддэг.

Энэ ажил нэлээн сайн явчихна. Зохион байгуулж чадвал. Яагаад вэ гэвэл энэ түгжрэлтэй холбоотой маш том өгөгдлийн сантай болсон байна лээ. Тэр өгөгдлийн сан дээрээ ажиллаад жинхэнэ шинжлэх ухааны үндэслэлтэй асуудлаа шийдээд явахад нэлээн амжилтад хүрэх боломжтой.

Гэр хорооллыг орон сууцжуулах ажил ерөнхийдөө эхлэлийн шаттай болов уу гэж боддог. Эхлэлийг бас харж байна.

Энэ ажлыг цааш нь эрч хүчтэй, зохион байгуулалттай явуулахад эрх зүйн боломжоо сайжруулах зорилгоор энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирж байгаа юм байна гэж харж байгаа юм. Холбогдуулаад хоёр, гурван асуулт байгаа юм.

Нэгдүгээрт, энэ хууль сайн байвал их сайн. Бас гоё байж болдог. Тэгэхдээ хамгийн гол нь ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байвал их зүгээр л дээ. Үүнтэй холбогдуулаад энэ хуулийн 7.1.1 дүгээр зүйлийн оноосон нэр байгаа юм. Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сан. Энэ их ойлгомжгүй илэрхийлэл байна. Яагаад гэвэл монголчууд чинь нэг санааг хоёр үгээр илэрхийлэхдээ үгийнхээ аймгийг нэг үгийн аймгаар илэрхийлдэг. Монгол хэл бол.

Тэгэхээр эхнийх нь үйл үгээр төлөвлөх гэххээд, хоёр дахь хэсэг нь хөгжлийн гэсэн байгаа.

Тэгэхээр энэ хоёр чинь угаасаа нийлэхгүй. Нийлж ойлгогдохгүй шүү дээ. Яг монгол хэлнийхээ найруулгаар. Тэгэхээр үүнийг бодох ёстой. Яагаад ийм нэр өгснөө та нар нэг тайлбарлачихвал их сайн.

Хоёр дахь асуулт. Энэ сангаа юу юунд зарцуулах вэ гээд. Энэ зарцуулалт их боломжийг нь зааж өгсөн мөртлөө нэг юмыг орхигдуулсан байгаа юм. Энэ яагаад орхигдуулсан юм гэж би асуумаар байгаа юм.

Айл өрхийн гэрийн дулаалга, дулаан алдагдлыг бууруулах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ гээд. Гэтэл энэ чинь гэр хорооллын амины орон сууцыг орхисон байгаа. Амины орон сууцыг дулаалах, дулаан алдагдлыг бууруулбал гэрүүдийг дулаалснаасаа илүү урт хугацаатай ажил болно гэдэг нь ойлгомжтой шүү дээ. Үүнийг сайн бодмоор.

Гурав дахь асуудал. Энэ сан одоо чухам хэний сан юм бэ гэдгийг энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс харагдахгүй байгаа. Яах вэ, хяналт тавих, захиран зарцуулах, бүрдүүлэх асуудал иргэдийн Хурал дээрээ, дүрмийн Засаг дарга баталдаг. Захирлын хэн томилох юм гэдгээсээ хамаарна. Одоо манайд байдаг сангуудаас бодоход Нийслэлийн Засаг даргын дэргэдэх тусгай сан гэсэн хэлбэртэй сан гэж ойлгогдоод байгаа. Тэр зөв үү? Энд нэг хариулж өгөөч.

Сүүлчийн асуулт. Одоо энэ түгжрэлийг бууруулах асуудлыг танилцуулахдаа Засаг дарга хэд хэдэн чухал арга хэмжээг нэрлэсэн. 5, 6 арга хэмжээ байсан. Тэрний нэг нь энэ дүүжин тээвэр байгаа юм.

Тэгэхээр энэ дүүжин тээврийг яагаад нийслэлийн доторх түгжрэлийг бууруулах арга хэмжээ гэж үзээд байгаа юм бол. Би бүр гайхаад байгаа юм. Анх энэ Түгжрэлийг бууруулах үндэсний хороо байгуулахад би бас гишүүн нь байсан юм. Тэгээд хороон даргадаа хэлж байсан юм. Энэ дүүжин тээвэр чинь түгжрэлийг бууруулах арга хэмжээ биш байна шүү. Энэ хэдэн хувь бууруулах юм гээд тоо бодоод оруулж ирж байгаа болов уу?

Тэгэхээр энэ хэчнээн хүнийг газар дээрээс хөндийрүүлээд тэр тэнгэрийн тээврээр зөөгөөд, тэр нь түгжрэлийг хэдэн хувь бууруулаад явах юм бэ? Энэ дээр нэг тооцоо хэлж өгвөл сайн байгаа юм.

Дараа нь бас нэг мөнгө төгрөгтэй холбоотой нэг асуудал байгаа юм... /минут дуусав/

Х.Булгантуяа: Д.Рэгдэл гишүүн ээ, эхлээд хариулт авчхаад тодруулах уу? Дараа нь тодруулчихъя.

Ажлын хэсгээс хариулах уу? 4 номерын ажлын хэсгийн микрофон дээрээс хариулъя.

Х.Нямбаатар: Би Д.Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын сан байгуулах асуудал энэ хуулийн гол амин сүнс нь байгаа юм.

Улаанбаатар хотын хүн ам 2000 оны статистикаар 700 мянга байсан. Өнөөдөр Улаанбаатар хотын албан ёсны хүн амын тоо 1 сая 800 мянга болсон. Мөн түр оршин сууж байгаа хүмүүстэйгээ нийлээд бараг ойролцоогоор 2 сая хүнтэй ийм том хот болчихоод байгаа юм.

1976 онд Улаанбаатар хотын 3 дугаар ерөнхий төлөвлөгөө буюу яг өнөөгийн хотын үндсэн дэд бүтэц төлөвлөлтийг хийхэд 500-аас 600 орчим мянган хүн амтай, авто зам дээр 84 мянга орчим зорчиж байхаар тухай тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсын зураг төслийн хүрээлэн хийсэн. Гэтэл өнөөдөр манай авто зам дээр 804 мянган машин одоо бүртгэлтэй байна. Хөдөө орон нутгаас өдөрт дунджаар 80-аас 100 мянган машин бас авто зам дээр зорчиж байгаа.

Тэгэхээр бид нийслэл Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах нэртэй анхдагч хуулийн төслийг 2023 оны 12 дугаар сард батлуулсан.

Ингээд хууль хэрэгжих нэг жил гаруйн хугацаанд бид дараах өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй юм байна гэж үзсэн нь одоогийн гэр хорооллуудыг бид яаж орон сууцжуулах вэ гэхийн тулд одоогийн баригдаж байгаа урт хугацаатай зээл, тусламжаар баригдаж байгаа орон сууцуудыг зарж борлуулсан мөнгөөр газар чөлөөлөлтийн сан үүсгэе. Тэр чөлөөлсөн сангаараа гэр хорооллуудыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрыг нь үнэ тохиролцох байдлаар худалдаж авах ийм сан бүрдүүлж байгаа.

Зүгээр таны саяын сануулж хэлж байгаа заалтыг бид яагаад оруулсан бэ гэхээр энэ сангийн хөрөнгөөр инженерийн шугам сүлжээ татах, газар чөлөөлөх энэ тэрийг та сайшаан дэмжиж байна.

Нэг зүйл дээр эргэлзэж байгаа гэж сая та хэлж байна. Энэ юу вэ гэхээр амины орон сууцуудыг дулаалах, тэдгээрт хатуу түлш хэрэглүүлэхгүй байх урьдач нөхцөлийг хангахад энэ сангаас мөнгө зарцуулах гээд байна гэдэг зүйлийг ярьж байгаа.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хүрээнд 2040 он гэхэд Улаанбаатар хотын нийт иргэдийн 80 хувийг инженерийн шугам сүлжээнд хангагдсан амины болон нийтийн орон сууцаар хангахаар байгаа.

Энэ хүртэл хугацаанд бид агаарын бохирдлыг бууруулахын тулд зарим бүсүүдийг, тухайлах юм бол Гандан орчим, Радио, телевизийн орчим, Эх нялхсын орчим гээд хотын төвтэй залгаа байгаа инженерийн шугам сүлжээнд

холбогдоогүй байршлуудад бид Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд, Г.Лувсанжамц гишүүний санаачилсан “Дулаанбаатар” төслийн хүрээнд бид тэдгээр айл өрхүүдийг дулаалж хийн болон цахилгаан түлшинд шилжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх цаг хугацаатай шаардлагатай зүйлүүд байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон дээр 1 минут нэмж өгье.

Х.Нямбаатар: Дүүжин тээврийн төсөл 2019 онд Монгол Улсын Засгийн газраар ороод Улсын Их Хурлаар батлагдсан. Францын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулагдсан ийм гэрээ. Өөрөөр хэлбэл намайг хотын дарга болохоос өмнө, Засгийн газрын гишүүн болохоос өмнө энэ төсөл хэрэгжээд эхэлсэн төсөл байсан.

Миний бие ажил авснаас хойш энэ төслийн зарим байршил тэр юунууд дээр нөгөө station-ийн газар чөлөөлөлтийн ажлуудыг хийгээд, одоо ажил үндсэндээ эрчимжээд, суурь багана цутгах ажлууд хийгдээд явж байгаа.

2026 оны 3 дугаар сар гэхэд үндсэндээ хөдөлгөөнд орж эхэлнэ. 6 сар туршилт хийнэ. Цагт дунджаар 4800 орчим хүнийг Яармагаас Хархорин, Хархориноос Яармагийн чиглэлд нэвтрүүлнэ.

Одоогийн байдлаар бид нарын хиймэл оюун ухаан бүхий камерын нэгдсэн системээр Яармагийн замын оргил ачааллын үед 90 мянган машин цагт Улаанбаатар хотын төв рүү орох хөдөлгөөн... /минут дуусав/

Х.Булгантуяа: Д.Рэгдэл гишүүн нэмж тодруулъя.

Д.Рэгдэл: Энэ төсөл хэзээ яаж эхэлсэн энэ тэр гээд би ерөнхийдөө ойлголттой байгаа.

Хамгийн гол нь энэ 7 дугаар зүйлийн нэр монгол хэлээр биш байна гэдгийг л асуугаад байгаа шүү. Төлөвлөх, дэмжих гэсэн үгтэй байж болно. Энэ чинь хоёр өөр үгээр яасан. Үүнийг л бодохгүй бол энэ монгол найруулга биш байгаа юм. Энэ зүгээр хэл зүй талаасаа.

Дүүжин тээврийн хувьд харин тодорхой тоо анх удаа сонслоо. Бас ч овоо хэдэн хүн зөөх ийм боломжтой юм шиг байна.

Нөгөө нэг асуудалд хариулсангүй. Энэ агаарын тухай хуульд оруулаад тэр бүсийн гэр хорооллын өрхийг хийн түлшээр хангаад, тэгээд урамшуулал олгоно гэж байгаа юм. Энд ер нь баримжаагаар бодоход жил жилээр хэдэн хэр зардал орохоор байгаа юм гэж асууж байгаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс нэмж хариулъя. 4 номерын ажлын хэсгийн микрофон.

Х.Нямбаатар: Дахин төлөвлөх гэдэг нэр томьёо манай Улаанбаатар хотод хэрэглэгдээд сүүлийн 20-иод жил энэ газрыг дахин төлөвлөх гэдэг агуулгаар явж байгаа.

Хот суурин газрыг дахин төлөвлөх хууль байгаа. Энэ хуулийн хүрээнд бид дахин төлөвлөх гэдэг энэ нэр томьёог одоо нэлээд сүүлийн үед түгээмэл ашиглаж байгаа.

Өөрөөр хэлбэл инженерийн шугам сүлжээгүй газар баригдсан айл өрхүүдийн газрыг нөхөн олговортойгоор чөлөөлж аваад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөж орон сууцжуулах, дэд бүтэцжүүлэх энэ агуулгаар орж ирсэн. Магадгүй энэ дээр нэр томьёоны нөгөө тайлбар гаргадаг байгууллагуудаас бид үүнийг эргэж тодруулах боломжтой гэж Д.Рэгдэл гишүүн ээ, хэлье.

Хоёрдугаарт, хийн түлш дээр би танд энэ 13 секундэд товчхон хариулчихъя. Бид 51 мянган айлийг хийн түлш, цахилгаан түлшээр хангахад бид жилд дунджаар 90 тэрбум төгрөгийн татаас олгохоор байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе.

Нийслэл Улаанбаатар хотын түгжрэл, утааг шийдэхээр ийм цогц хуулийн төслийг өргөн бариад, ялангуяа үр дүнд суурилсан бодлого боловсруулалт, цогц арга хэмжээ авах, нотолгоонд суурилсан бодлого хэрэгжүүлэлт, EVIDENCE-BASED POLICY MAKING гэж хэлдэг. Ийм зүйлүүдийг хийх гээд явж байгаад их баярлаж байна. Гурав, дөрвөн асуулт байна.

Эхнийх нь, Замын хөдөлгөөний удирдлагын төв дээр ухаалаг технологи нэвтрүүлээд, одоо иргэдэд, жолооч нарт зөрчил гаргасан тохиолдолд мэдээлэл хүргэж байгаа гэж ойлгосон.

Хэдий хэмжээний, ямар хэмжээний хүчин чадалтай камер суулгаад, ямар төрлийн зөрчлүүдийг илрүүлж байгаа вэ? Үр дүн ер нь хэр байгаа вэ? Ер нь ирэх жилээс бүгд ийм ухаалаг системдээ шилжээд явахад боломж байгаа юу? Зам дээр жишээ нь дүн өвлийн хүйтнээр замын цагдаа нар уулзвар дээр зогсдог. Их хүнд нөхцөлд ажиллаж байгаа. Нэгэнт ийм ухаалаг Улаанбаатар хотыг бодитоор хэрэгжүүлэх гэж байгаа бол ямар хэмжээний техник болон технологийн шийдлийг оруулж өгсөн юм бэ гэдэг эхний асуулт.

Хоёрдугаарх нь, Даатгалын тухай хууль дээр орж ирж байна. Энэ цахимаар хохирлыг үнэлдэг больё. Учирсан хохирлыг барагдуулдаг үйл ажиллагааг хөнгөвчилъе гэж байна. Тийм ээ. Ер нь дунджаар манайх чинь зам

дээр мөргөлдөөд шүргэлцэхээр 40 минут зогсоод байгаа. Цахимаар шийдэх юм бол ер нь хэдэн минутад асуудал шийдэгдэх боломжтой болж байна: Түгжрэл хэдэн хувиар буурах боломжтой вэ гэсэн хоёрдугаар асуулт байна.

Гуравдугаарх нь, “Дулаанбаатар” аяныг дэмжихийн хүрээнд, ялангуяа энэ дулаалгыг дэмжье гэсэн юугаараа дахин төлөвлөлтийн сан гэж байгуулж байгаа юм байна. Их зөв шийдэл. Дэлхийн олон улс энэ л аргаар агаарын бохирдол, орон сууц, дэд бүтцийн асуудлаа шийдэж ирсэн. Ялангуяа Токио дээр их тод жишээ байдаг.

Гол нь энэ сангийн хөрөнгийг ашиглахдаа хүн амын нягтрал ихтэй байгаа газрууд буюу Баянзүрх дүүргийн 18, 25, 26 дугаар хороо, Хан-Уулын 2, 15, 17, 18, 19 дүгээр хороо, Баянгол дүүргийн 26 дугаар хороо. Энэ хороод нягтаршил өндөртэй буюу 1 га-д 2000 хүн байгаа. Энэ газруудад жишээ нь, Баянзүрхийн 26 дугаар хороо одоо л сургуультай болох гэж байна. Энэ намраас. Тийм ээ. Цэцэрлэг байхгүй, өрхийн эмнэлэг байхгүй. Энэ асуудлуудыг ер нь шийдэхэд нийслэл ер нь ямар байдлаар Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалттай уялдуулж ажиллах гэж байгаа вэ гэсэн асуулт байна.

Дөрөвдүгээр асуулт. Замын засварын ажил. Ялангуяа явган дугуйн замуудын ажлын явц төлөвлөгөө хэр байгаа юм бэ?

Ер нь өнгөрсөн энэ жил гаруйн хугацаанд маш олон ажлууд хийгдэж байна гэж харж байна. Толгойтын замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох зам бараг 10 гаруй жил гацсан. Одоо хэзээ холбогдох гэж байгаа бол?

Дээрээс нь, Нарны хотхоноос хойшоогоо гардаг явган гүүрийг хийсэн гэж байна. Дахиад өөр газар ийм байдлаар явган зорчигчдыг дэмжиж байгаа гүүрэн гарц, дугуйн замуудын ажил байгаа юу?

Их тойруу дотор ялангуяа дугуйгаар зорчих боломжийг нээх ёстой. Дугуйн зам бүтэн болох ёстой. Энэ ажлуудыг төлөвлөж байгаа явц болон хэрэгжилт ямар байгаа вэ?

Хамгийн сүүлийнх нь тээврийн хэрэгслийн техник хяналт нийслэл дээр шилжиж байна гэж ойлголоо.

Улаанбаатар хотод нэг хэцүү асуудал байна. Одоо нэг чоппер гэж нэрлэдэг том том мотортой, өргөн яндантай, маш том дуу чимээ гаргаад давхидаг хүмүүс их олон болж байна. Шөнө оройн цагаар нялх нойтон хүүхэдтэй хүмүүс, өндөр настай хүмүүс энэ чимээнээс болоод сэрж байна. Ер нь хотын стандарт дууны зөвшөөрөгдөх хэмжээ өдөр 55 децибел, шөнө 45 байдаг. Гэтэл энэ мотоциклууд 80-аас 115 децибелийн дуу чимээ гаргаад яваад байгаа. Энэ асуудлыг техникийн хяналтаараа зохицуулах боломжтой юу? Ер нь хэдэн мотоцикл ингэж дураараа дургиад хотын энэ амар амгалан байдлыг эвдээд

яваад байдаг юм бэ? Тийм асуудлуудыг яаж шийдэх гэж байгаа вэ гэсэн шийдэл асууя.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс хариулъя. 4 номерын микрофон.

Х.Нямбаатар: Би сүүлийнх нь асуултаас товчхон хариулъя. Г.Лувсанжамц гишүүний.

Одоо бид авто тээврийн техник хяналтын үзлэгийг Зам, тээврийн сайд хүсвэл Улаанбаатар хотод хяналт тавих эрхийг нь шилжүүлж болно л гэдэг зохицуулалт оруулж байгаа.

Өнөөдөр Улаанбаатар хотод авто техникийн үзлэг явуулж байгаа байгууллагуудын 50 хувь нь Авто тээврийн үндэсний төвийн буюу төрийн өмчит компани хариуцаж явж байгаа. 50 хувь нь хувийн сектор явж байгаа.

Гарч байгаа нийтлэг зөрчил юу вэ гэвэл хайбрид машинуудын нүүрсэн янданг импортолсон. Хууль бусаар. Ихэнх нь. Тэгээд үзлэгт орохын өмнө үүдэн талд нь 100 мянган төгрөгөөр нүүрсэн янданг суурилуулж өгөөд үзлэгт оруулчихаад буцааж тайлж авдаг ийм хууль бус бизнес явж байгаа.

Сая би Зам, тээврийн сайд руу бичиг явуулсан. Одоогоос эхлээд улсын үзлэгийн газрууд дээр нүүрсэн яндан дээр нь авто тээврийн хэрэгслийнх нь арлын дугаарыг одоо цифр л цохиж байгаа. Өөрөөр хэлбэл солихгүй байх боломжийг олгож байгаа.

Тэгэхээр цаашид энэ хяналтыг сайжруулах шаардлагатай байгаа учраас Зам, тээврийн сайд хүсвэл ийм байдлаар явъя гэж байгаа.

Хоёрт нь, та сая асуулаа. Энэ техникийн үзлэгээр дуу чимээ ихтэй мотоциклын асуудлыг яаж шийдэх гэж байна гээд. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээр нэр бүхий иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нар яг энэ асуудлаар Нийслэлийн иргэдийн Хурлын тогтоол гаргая. Өөрөөр хэлбэл нөгөө дуу чимээний бохирдлыг бууруулах чиглэлээр иргэдийн хүлцэх хэмжээний децибелийг мотоцикл, байкууд дээр тавья гэдэг ийм санаачилгууд өрнөөд явж байгаа гэдгийг хэлье.

Та камерын нэгдсэн систем хэдийг суурилуулсан юм бэ гээд. Би Хууль зүй, дотоодын хэргийн сайдаар ажиллаж байхдаа энэ камерын нэгдсэн системийн техник, эдийн засгийн үндэслэлийг анх боловсруулсан.

Тэгээд би ажлаа өгөөд хотын даргаар очихдоо нөгөө ТЭЗҮ-гээ барьж очсон. Үргэлжлүүлсэн. Одоо манай систем бүрэн ашиглалтад орсон. 9 дэд төв байгуулагдсан. Одоогийн байдлаар 2606 камерын систем, камер бүрэн ажиллаж байна.

Би танд нэг статистик тоо хэлье. Өнөөдөр 07 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд 531 мянга 569 тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож байна. Үүнээс 86.8 мянга нь хөдөө орон нутгийн машинууд явж байна.

- 30 мянга 210 машин татвараа төлөөгүй явж байна.
- 13.7 мянган машин техникийн хяналтын үзлэгт ороогүй байна.
- 8440 машин 100 мянгаас дээш төгрөгийн торгуулиа төлөөгүй хугацаа хэтрэлттэй явж байна.

- 29.7 мянган машин жолоочийн хариуцлагын даатгалд даатгагдаагүй байна.

- 340 мянган зөрчил одоогийн байдлаар үйлдээд байж байна.
- 139.6 мянган машин зөрчил гаргасны дараа мессежээр тухайн машинуудад дуудлагыг бид мессежээр та ийм зөрчил гаргалаа шүү гэдгийг хэлж байна.

Долоо хоногт дунджаар 3 төрлийн зөрчил дээр 5 сая... /минут дуусав/

Х.Булгантуяа: Нэмж 1 минут.

Х.Нямбаатар: Би Г.Лувсанжамц гишүүний үлдсэн асуултуудад маш товчхон хариулъя.

Тэгэхээр бид хянаж чаддаг систем рүүгээ орсон. Тэгээд бид Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар орон нутагт орж байгаа торгуулийн орлогын 50-иас доошгүй хувийг камерын нэгдсэн системийг өргөтгөн тавихад зориулахаар хууль баталсан. Энэ хууль одоо энэ нийслэлийн төсвийн тодотголоос хэрэгжиж эхэлнэ.

Сөүл хот гэхэд өдөрт дунджаар нэг хүн 400 удаа камерт өртөж байж гэрээсээ гараад ажил дээрээ очоод буцаад гэртээ харихад өртдөг байдлаар бид камерын нэгдсэн системийг.

Одоо сая камерын систем манайд ашиглалтад орсон чинь халаасны хулгайн гэмт хэрэг 58 хувиар буурсан. Өөрөөр хэлбэл энэ камерын системийнх нь өөрийнх нь ач холбогдол ийм байгаа.

Жолоочийн хариуцлагын даатгалын хуульд өөрчлөлт оруулж байгаа нь хэрвээ хоорондоо маргахгүй камераараа шийдүүлье гэх юм бол шууд хоёр тийшээгээ салаад явна. Энэ тохиолдолд өдөрт гарч байгаа саяын тэр 100... /минут дуусав/

Х.Булгантуяа: Г.Лувсанжамц гишүүн нэмж тодруулъя.

Г.Лувсанжамц: Дэлгэрэнгүй хариулсанд баярлалаа.

Замын засварын ажлууд дээр хариулт авч чадаагүй. Замын ажлууд ер нь ямар явж байгаа. Дугуйн зорчигчдыг. Нийтийн тээврийг бид тэргүүн ээлжид тавих ёстой. Тэр талаар асууя гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, 40 минутаас 10 минут болж буурч байгаа гэдгээ ойлголоо.

Ер нь түгжрэлд нэлээн нөлөөтэй юм гэж ойлгож байна.

Тэгээд ер нь хэмжиж чаддаг болъё гээд ийм ухаалаг технологиудыг нэвтрүүлж байгаа нь их зөв. Яг үр дүнд суурилсан байдлаар л бид яг шалгуур үзүүлэлтээ зөв хэмжиж чадаж байгаа болов уу гэж бодож байна. Бодитоор өдөр болгон ийм тээврийн хэрэгслийн авто ослын тоонуудыг ингэж нарийн авч чаддаг байгаагүй болов уу гэж бодож байна. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээрээ үндэслээд цаашдаа зам тээврийн хөдөлгөөний төлөвлөгөө, нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр гарц шийдлүүд гарах болов уу. Замын засварын ажлууд бас тэнд шийдлүүд гарах болов уу гэж бодож байна. Тэнд анхаарахыг хүсэж байна.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос хариулъя.

Х.Нямбаатар: Энэ жил Улаанбаатар хотод шинэчлэлийн болон шинээр тавих нийтдээ 101 километр автозам шинэчлэн хучих болон шинээр барихаар байгаа.

Яг өнөөдрийн байдлаар буюу 07 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт 101 километрээс 62 километр замын шинэчлэл болон шинээр тавих ажил дууссан.

Бидний төлөвлөж байгаагаар бороо хур багатай байвал 08 дугаар сарын 20 гэхэд үндсэндээ энэ жилийн авто замын засвар шинэчлэлийн ажлыг бүхэлд нь дуусахаар төлөвлөж байгаа.

Явган замын тухайд энэ жил 14 байршилд явган замын ажил хийхээс одоогийн байдлаар шинэчлэлийн ажил 50 хүрэхгүй хувьтай явж байна. Учир шалтгаан нь дандаа нэг бүрчилж гараар хийдэг ажлууд байгаа.

Ирэх жил бид Улаанбаатар хотын нэгдүгээр бүс, хоёрдугаар бүсээс гадна талын замуудыг бүхэлд нь асфальтан явган хүний замын технологиор хийвэл илүү хурдацтай явна.

Х.Булгантуяа: Г.Лувсанжамц гишүүн нэмж тодруулъя.

Г.Лувсанжамц: Нэмж нэг үг хэлэх гэсэн юм.

Энэ метроны төсөл, дэд төвүүдийг эрчимжүүлэх, дахин төлөвлөлтийг хийх, зам засварын ажлууд, явган дугуйн замуудыг засах гээд ийм олон ажлууд ер нь олон жилийн, 20 жилийн өмнөөс яригдаж байгаа, төлөвлөгдөж байгаа хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр туссан ажил байсан.

Ардчилсан нам нийслэлийг, засгийг барьж байх үедээ энэ ажлуудыг хийнэ гээд метроны урьдчилсан ТЭЗҮ-г хийж байсан. “Гудамж төсөл” гээд маш олон зам уулзваруудыг засаж байсан. Явган дугуйн замуудыг хийж байсан. Э.Бат-Үүл хотын даргыг их сайн ажилласан, мундаг байна гээд ярьдаг юм билээ.

Тэгээд Х.Нямбаатар хотын дарга ажил хийхээр болохгүй байна, бүтэхгүй байна, энэ Сэлбэ дэд өвөө зогсоо ч гэх шиг, метро яг хэрэгтэй юм уу, зам засаад ирэхээр үүнийгээ болиоч ээ гээд харлуулаад явж байгаа зарим нэг намын гишүүд байгаа.

Ажил хийх гэж байгаа хүмүүсийг ажлыг нь хийлгээсэй л гэж хэлмээр байна. Өнөөдөр дэлгэрэнгүй хариултуудыг нь хэлж байна. Тухайн намаас нэмээд асуугаад нарийн мэдээллүүдээ энд аваад ойлголцоод явах хэрэгтэй гэж бусад намын гишүүддээ уриалж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа.

А.Ариунзаяа: Х.Нямбаатар дарга бид хоёр ер нь их түүхтэй гэх юм уу, сайдаар хамт ажиллаж байсан. Дараа нь хотын даргаар томилогдоход нь Удирдах зөвлөлийн хурлынхаа дараагаар хэвлэлийн хурал хийхдээ би дөнгөж Германаас ирээд толгой маань одоо юу гэдэг юм германаараа сэтгээд гэдэг шиг фронтод гаргаж байгаа буюу уг нь тэргүүн эгнээнд гаргаж байгаа шилдэг боловсон хүчний гэж хэлж байсан.

Эртээр Д.Ганбат гишүүн бас фронт гэж хэн хэллээ гээд байсан. Ганбаа ах аа, би хэлсэн шүү дээ гэсэн. Чи тэгвэл фронт Ариунаа юм байна шүү дээ гэлээ. Танк Ганбаа ах гэдэггүй шүү дээ гээд. Үгийн алдаа ч яах вэ.

Үгийн алдаанаасаа гадна ер нь манай Х.Нямбаатар дарга их тийм зоригтой, зүрхтэй, их галтай, асуудлуудыг бас их сайн авч явдаг.

Би нэг асуудал бид шийдэх гэж байгаа шүү гэдгийг анхаарлын төвд авчиръя гэж бодсон юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг бид дагуулж шийдэж байгаа. Гишүүд маань дараад нь би мэдээгүй гэх вий дээ. Иргэд маань дараад нь би сонсоогүй, хэзээ шийдчих вэ гэх вий дээ.

2030 оноос хойш, 2030 оны 06 сарын 01-ний өдрөөс эхлэн баруун гар талдаа жорлооны хүрдтэй механикжсан тээврийн хэрэгслийг Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцуулах зорилгоор импортлохыг хориглоно гэдэг заалт. Бид одоо яг батлах гэж байна шүү. Энэ зөв өө.

Яагаад үүнийг хэлж байна вэ гэхээр зөв. Үүнийг Э.Бат-Үүл хотын дарга 2012 онд хийх оролдлого хийсэн юм. Тухайн үедээ шийдсэн байсан бол, тухайн үед Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж чи хүрдээр оролдохоос өөр юм байхгүй байна уу гэж хэлээгүй байсансан бол хэчнээн хүн өнөөдөр гүйцэж түрүүлэх үйлдэл дээрээ алдаа гаргаснаас болж амь насаа алдсан тохиолдол байхгүй байх байсан бэ гэдгийг бид бас ярих ёстой.

Энэ яалт ч үгүй нэн ялангуяа хөдөө орон нутгийн замд гүйцэж түрүүлэх үйлдэл дээрээ буруу рультэй машин бүрэн гүйцэд гарч ирж өөдөөс машин ирж байна уу, үгүй юу гэдгийг харах боломжтой байдаг учраас ослын шалтгаан болдог юм аа, болдог юм. Энэ бол судалгаан дээр, нотолгоо дээр, тоон дээр нотлогдсон асуудал.

Ийм учраас бид эсвэл дүрмээ өөрчлөх ёстой, эсвэл машиныхаа хүрдийг өөрчлөх ёстой. Өөр арга байхгүй. Дэлхийн 190 улс орны 60 нь баруун талдаа, 130 нь зүүн талдаа рультэй, дүрэмтэй. Манай дүрэм зүүн талынх боловчиг машины дийлэнх нь баруун талын хүрдтэй. Энэ бол хоорондоо зөрчилтэй байдаг. Энэ бол ослын учир шалтгаануудын нэг байдаг юм гэдгийг бас онцлон хэлмээр байна.

Тэгэхээр энэ дээр бас зориг гаргаж энэ асуудлыг оруулж ирж байгаад нь бас би талархлаа дэвшүүлмээр байна. Нэг талдаа.

Хоёр дахь нь, үүнийг бид баталж байгаа шүү гэдгийгээ бас чанга дуугарч, гаргасан шийдвэр дээрээ баттай зогсдог байхыг бас хэлмээр байна.

Аливаа шүүмжлэлээс айж, эмээж зөв шийдвэрээсээ буцдаг явдлыг яг одоо зогсооё. Иргэддээ учир шалтгааныг маш сайн зөв тайлбарлаж, гаргасан шийдвэрээ гаргахаасаа өмнө долоо хэмжиж нэг огтолж гаргасан шийдвэрийнхээ талд зогсдог байх нь улс төрчид, төрийн хүмүүс, төрийн захиргааны хүмүүс бүгдэд нь байх ёстой зан чанар юм шүү гэдгийг хэлье.

Х.Нямбаатар даргад амжилт хүсье.

Х.Булгантуяа: А.Ариунзаяа гишүүн үг хэллээ. Тийм ээ. Дэмжиж. 4 номерын микрофон.

Х.Нямбаатар: Тийм. 1968 онд Венийн конвенц батлагдсан. 1997 онд Монгол Улс нэгдэж орсон.

Венийн конвенцоор тухайн улс орон жолооны хүрдээ өөрийн замын хөдөлгөөнийхөө дүрэмд заахаар тусгасан байдаг. Манайх зүүн хүрдтэй дүрэмтэй.

А.Ариунзаяа гишүүний саяын хэлж байгаа тэр Э.Бат-Үүл даргын анх санаачилж байх үеийн 2013 онд Монгол Улсад нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 325 мянга байсан. Өнөөдөр 1 сая 325 мянга болсон.

Өөрөөр хэлбэл энэ 12 жилийн хугацаанд 1 сая машинаар манай импортын машин энэ 12 жилийн хугацаанд нэмэгдсэн. Энэ чинь хэдэн жилийн статистик билээ. Гарсан. 30 мянган осол гарсан байна. Хөдөө орон нутгийн зам дээр.

Энэ 30 мянган ослын 74.4 хувь нь баруун хүрдтэй машиныг гүйцэж түрүүлэх хөдөлгөөн хийх үедээ осолдсон ийм аймшигтай осол гарсан байгаа. Өөрөөр хэлбэл нийт ослын 74.4 хувь нь баруун хүрдтэй машинууд гүйцэж түрүүлэх хөдөлгөөн хийх үедээ гаргасан байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Мөнхбат байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Хосбаяр.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

2013 онд тухайн үеийн Засгийн газар Ардчилсан нам эрх барьж байх үед бас гаднаас 1.5 тэрбум долларын Чингис бонд босгож оруулж ирээд, бас бонд босгож болдгийг, бас бонд босгоод мөнгөтэй ажил хийж болдгийг харуулж, Улаанбаатар хотод олон ажил хийж байсан.

Тэр үед хэл ам болж л байсан 33 уулзварыг шинэчиллээ гэж байсан. Өнөөдөр тэр 33 уулзварыг тухайн үед өргөтгөснөөрөө өнөөдрийн Улаанбаатар бүр тэг зогсчихгүй ингээд явж байх шиг байна.

Тэгээд одоо бас Х.Нямбаатар дарга, нийслэлийнхэн маань бас энэ гаднын зах зээлээс хөрөнгө мөнгө босгоод ажил хийж болдгийг харуулж байгааг дэмжиж байгаа. Бүх талаар дэмжиж байгаа. Мэдээж одоо хэрэгжилт анхан, дунд шатдаа бас алдаа асуудал байхыг үгүйсгэхгүй. Тэгээд үүн дээрээ сайн анхаарч ажиллаарай.

Ер нь Монгол Улсад хотод ч тэр, хөдөөд ч тэр хийх ажил маш их байгаа. Тэгээд бид дэлхийгээр дүүрэн мөнгө байна гэж ярьдаг. Бид мөнгө оруулж ирж энэ улсынхаа дэд бүтэц, энэ бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх шаардлага байгаа юм.

Бид ойрын 10, 15 жилдээ энэ дэд бүтцийн асуудал, дэд бүтцийн хөгжлийн тухай, бүтээн байгуулалтын ажлын тухай л ярих байх. Манай нийгмийн хүмүүсийн ер нь хамгийн чухал сэдэв, чухал асуудал. Үүн дээр л төвлөрөх байх.

Тийм учраас бид асуудлыг шийдээд, гарц гаргалгааг хайгаад, мөнгө хөрөнгө босгоод, оруулж ирээд, түүгээрээ ажил хийгээд ингээд явмаар байна л даа. Тэгэхгүй бол ингээд ямар ч боломжгүй, ямар ч гарц гаргалгаагүй юм яриад суугаад байвал байрнаасаа хөдлөхгүй ээ гэж харж байгаа.

Тийм учраас нийслэлийнхний мөнгө босгож хийж байгаа ажлыг би маш сайн дэмжиж байгаа.

Тэгээд ер нь ажил хийж том бүтээн байгуулалт хийх гэхээр газрын асуудал хөндөгдөж байгаа. Үе үеийн нийслэлийн удирдлагууд газраа төлөвлөлтгүй хамаа замбараагүй олгосноос болоод одоо гишгэх ч газаргүй шахуу л болох гээд байна л даа.

Тэгэхээр энэ газрын ашиглалт дээр зарим, одоо энэ Байгаль орчны яамнаас ч юм уу олгосон Яармагийн замын урд талын газар гэхэд 10, 20 жил ашиглахгүй зүгээр том хашаа барьчихаад л байгаад байдаг. Жилд га га-гаар нь 500 сая, тэрбумаар өсгөөд л, үнэ нь явж байдаг. Зүгээр газрын бизнес хийж амьдраад байна. Нэг хэсэг хүмүүс.

Тэгэхээр зориулалтын дагуу ашиглахгүй байгаа, яг одоо хийнэ, хэрэгжүүлнэ гэсэн төсөл, хөтөлбөрөө хийхгүй байгаа аж ахуйн нэгж, хүмүүсийн газрыг яаж шийдэх вэ? Үүн дээр энэ Газрын хуульд өөрчлөлт оруулах асуудал байна уу?

Дараа нь энэ сангийн асуудал байгаа. Мэдээж сан үүсгэх нь зөв. Энэ сангаасаа хөрөнгө хуримтлагдсан, орж ирсэн мөнгөөрөө газрын төлөвлөлт, инженерийн дэд бүтэц, нийгмийн асуудлаа шийдээд явах юм байна.

Тэгэхээр энэ хөрөнгө мөнгийг зөв зарцуулах дээр бас онцгой анхаарч ажиллаарай.

Дараа нь энэ ТОСК, Төрийн орон сууцын корпорац гээд нэг газар байгаа. Одоо аймаг болгонд орон сууц бариад улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа юм харагдахгүй байгаа. Гэтэл дахиад хажууд нь өөр газар НОСК, Нийслэлийн орон сууцын корпорац гээд байгаа.

Тэгэхээр энэ ТОСК, НОСК хоёр ер нь нэгтгэж ч юм уу, энэ хоёрын чиг үүрэг давхардаад байгаа ийм зүйл байгаа юу? Эсвэл заавал энэ хоёулаа байх шаардлагатай юм уу?

Дараа нь энэ ипотекийн зээлийн эх үүсвэр хүрэлцэхгүй байгаа. Тэгэхээр нийслэл дээр үүсэж байгаа энэ үл хөдлөх хөрөнгө, одоо энэ олон ашиглалтад орж гоо орон сууцууд, ирээдүйд бий болох зүйлээс ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд тийм сан үүсгээд, эсвэл тэр бизнесийн зарчмаараа эх

үүсвэрийг нь бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломж байгаа юу гэсэн ийм асуулт байна.

Х.Булгантуяа: 4 номерын микрофоноос ажлын хэсэг хариулъя.

Х.Нямбаатар: Авто замын түгжрэлийг бууруулах, гэр хорооллын орон сууцжуулах хуулийг дагаж бид Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа бид инженерийн шугам сүлжээ, зам харгүй барих, шаардлагатай тохиолдолд тухайн траст өртсөн айлуудын 70-аас доошгүй хувь нь дэмжсэн тохиолдолд тухайн газрыг бүхэлд нь чөлөөлж байхаар ийм хууль эрх зүйн орчныг оруулсан.

Гэсэн хэдий сая Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц сая асуудалдаа хөндөж байх шиг байна. Ард Аюушийн гудамжны замыг бид тавихад нэгхэн айлтай ойлголцохгүй, ажил үндсэндээ 4 жилээр гацсан. Гэсэн хэдий ч бид хуулийн өөрчлөлт оруулаад айлуудтай ойлголцол, зөвшилцөлд хүрсний үр дүнд одоо энэ 9 дүгээр сард тухайн замыг ингээд бүхэлд нь явган замтай нээх гэж байна.

Тэгэхээр газар чөлөөлөлт гэдэг бол Улаанбаатарын хамгийн том тулгамдсан асуудал болоод байгаа.

Нийслэлийн газрын алба албан ёсоор 1999 онд байгуулагдсанаас хойш 420 мянган га газрыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон. Бид нарын 2023 оны өөрчлөлтөөр газар олголтыг үндсэндээ нөгөө 007, 004 га газар инженерийн шугам сүлжээгүй газар олгодгийг бүр мөсөн зогсоосон.

Одоогийн Газрын тухай хуульд газрыг зориулалтын дагуу ашиглахгүй 2 жилээс дээш хугацаагаар ашиглаагүй тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ашиглаагүй тохиолдолд цуцлах эрх зүйн орчин байгаа. Харамсалтай нь бид хэд хэдэн ийм цуцлалтуудыг хийсэн боловч эргээд шүүх дээр ямар нэгэн тийм хүндэтгэн үзэх шалтгаанууд гарч ирж байгаа гэдгийг би бас танд хэлье.

ТОСК, НОСК хоёрыг нийлүүлэх гэж үзсэн юм. Нэг нь өртэй нэг нь өргүй.

Тэгэхээр энэ хоёрыг нийлүүлэхээр агуулга нь болж өгөхгүй байгаа учраас НОСК бол нийслэлийн орон сууцын корпорацынхаа чиг үүргийг хэрэгжүүлээд нийслэлд орон сууцын бодлогыг хэрэгжүүлэхэд гол үүргээ гүйцэтгэж явъя гэж байгаа. ТОСК нь өөрөө хөдөө орон нутаг, аймгийн төв, сумдад энэ чиг үүргээрээ явъя гэдэг ийм хоёр зааг ялгааг гаргаж явж байгаа гэдгийг хэлье.

Яах вэ бонд дээр сая та асуулаа. Ипотекийн эх үүсвэр бид ер нь татвал яасан юм бэ гээд.

Би Их Хурлын гишүүдэд бас нэг мэдээлэл сонссон байх гэж бодож байна. Сая өнгөрсөн долоо хоногт бас нэг сайн мэдээ гарсан. Манай улсад Олон Улсын Валютын Сангийн төлөөлөгч нар ирж ажиллаад дүгнэлтүүд гаргасан. OECD-гийн экспортын зээлийн эрсдэлийн үнэлгээгээр манайх хамгийн сүүлийн байранд байсан. Сая нэг байр урагшлаад 6 дугаар байранд орсон.

Энэ нь урт хугацаатай 20 жил хүртэлх хугацаатай зээл дээр манай зээлийн хураамж дээр бараг 20 орчим хувийн хэмнэлтүүд үүсгэгдэхээр ийм сайн нөхцөл үүссэн.

Гэхдээ бид гаднаас хувийн секторт ч тэр, төрийн байгууллага, Барилга, хот байгуулалтын яам мөнгө босгож орж ирэхэд нэг хүндрэлтэй зүйл байгаа нь манай Монголбанкны свопын төлбөр өөрөө өндөр байгаа. 7 хувьтай байгаа. Бид 8 хувьтай мөнгө оруулж ирээ гэхэд 7 дээр своп төлөөд, банкны марж... /минут дуусав/

Х.Булгантуяа: Г.Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Би Э.Бат-Амгалан сайдаас тодруулчихъя.

Энэ ТОСК гээд байгууллага байгаа. Сая яах вэ хотын дарга хэлж байна. Нэг нь өртэй, нэг нь өргүй байгаа учраас гээд.

ТОСК бол нэг их үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулаад л аймгуудад орон сууц бариад л юм уу, хангамж нэгдүүлээд л, эсвэл үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулаад байгаа юм байхгүй л дээ.

Тэгэхээр ер нь цаашдаа ТОСК дээр ямар барь бодлого баримтлах юм бэ?

Хотын даргаас. Ипотек чинь Монголбанкныхнаас тодруулахаар эх үүсвэргүй болчхоод байна гээд байгаа юм л даа. Тэгэхээр энэ жил гэхэд 1.2 их наядын эх үүсвэр бий болгоно гэсэн чинь бүрдэхгүй байна. Одоо “Эрдэнэс Монгол”-оос 300 тэрбум гээд яриад байдаг. Ард иргэдэд ипотекийн зээл олгогдохгүй байна гээд байдаг.

Тэгэхээр орон сууцжуулалт, энэ бэлэн бус орон сууцаа зараад орсон мөнгөнөөсөө эх үүсвэр бүрдүүлж болох уу л гэж асуугаад байгаа юм.

Х.Булгантуяа: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан хариулъя.

Э.Бат-Амгалан: Г.Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө би тантай санал нэг байгаа. Хотын дарга Х.Нямбаатар сая хэллээ. Тэр өртэй, өргүй гээд. Төрийн орон сууцын корпорац Хөгжлийн банканд

нэлээдгүй өртэй явж байгаа юм билээ. Тэгээд ерөнхийдөө ажлаа аваад 10 гаруй хонож байна.

Ер нь сайдын зөвлөл дээрээ ч ярьж байгаа, нөхдүүдтэйгээ ярилцаж байгаа. Сая Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулиар ч гэсэн энэ шинэ Засгийн газар цомхотгол хийх, мэдээж дарга нарын түвшинд орон тоог цөөлөх, өөрсдөөсөө эхлээд энэ тансаглалыг болиулах гээд энэ асуудлууд яригдаж байгаа.

Тэгээд энэ асуудлын хүрээнд ч гэсэн би бас. Тэгэхдээ ганцхан сайд яриад хийчихдэг асуудал биш. Зүгээр Барилга, хөгжлийн төв, Төрийн орон сууцын корпорац хоёрыг бас нэгтгээд цааш нь явах ийм боломж бололцоо байна уу, үгүй юу. Судлаад явж байгаа. Тэгээд танд бас албан ёсоор хариу өгнө.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан. Ажлын хэсгийн 4 номерын микрофон. Х.Нямбаатар дарга нэмж хариулъя.

Х.Нямбаатар: Тийм. Яг одоо Улаанбаатар хотод жишээлбэл Засгийн газрын тогтоолоор яг өнөөдрийн байдлаар энэ наадмын дараа гэхэд 2 мянган айлын орон сууц зарахад бэлэн болчихоод, улсын комисс ажиллахад бэлэн болчихоод байгаа. Шар хад дэд төв, Баянхошуу дэд төв, 1008 айлын орон сууц.

Тэгэхээр эх үүсвэрийн хувьд бид өмнө нь Э.Бат-Амгалан сайдыг төрийн орон сууцжуулалтын бодлого хариуцаж байх үед бид эх үүсвэрүүдийг яг саяын таны хэлснээр татъя гээд ажил хөөцөлдөж байсан. Энэ ажил ч гэсэн одоо үргэлжилнэ. Э.Бат-Амгалан сайд бид хоёр дээр үлдээд байгаа юм.

Ер нь бид гаднаас эх үүсвэр татахад би хүндрээд байгаа хүндрэлийг л танд хэллээ. МИК гэхэд “Монголын ипотекийн корпорац” 500 сая долларыг Америкийн хөрөнгө оруулалтын сангаас 15 жилийн хугацаатай 8 хэдтэй билээ дээ. Татахаар байгаа. Тэгээд татахаар 8.5-тай татъя гэж бодоход свопын төлбөр чинь 7 болохоор 15 болчихож байгаа юм. 15 дээр банкны марж 3 хувь нэмэгдэхээр... /минут дуусав/

Х.Булгантуяа: Болно. Хангалттай хангалтгүй гэж үзвэл нэмж 1 минут болно. Г.Хосбаяр гишүүн нэмж.

Г.Хосбаяр: Тийм. Сая хотын даргын хэлдгээр 2 мянган айлын орон сууц бэлэн болоод зарагдах гээд байна шүү дээ.

Тэгэхээр чинь мөнгө орж ирнэ ээ дээ. Тэр мөнгөнөөсөө л ипотекийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломж байгаа юу гэж асуугаад байхгүй юу. Би. Тэгэхгүй бол одоо Монголбанк чинь энэ жил 2025 онд 1.2 их наядын эх үүсвэр хуучин байгаа ипотекийн эх үүсвэр дээрээ нэмнэ гэсэн хэрнээсээ нэмж чадахгүй байна. Энэ хэмжээндээ хүрэхгүй байна. Мөнгө байхгүй байна гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо тэр нийслэл 2 мянган айлын орон сууцаа зараад, түүнээсээ 300 тэрбум байна уу, 500 тэрбумыг тэр МИК-ээр дамжуулаад ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж болох уу? Тийм боломж бололцоо байдаг юм болов уу л гэж.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 4 номерын микрофон. Ипотекийн хүртээмжийг яаж нэмэгдүүлэх вэ? Эх үүсвэрийг.

Х.Нямбаатар: Чиг үүрэг нь Монголбанк дээр байгаа шүү дээ. Ипотекийн зээл Монголбанк, МИК хариуцаад явж байгаа.

Бид өндөр эх үүсвэртэй мөнгө босгохоор зөрүүг нь хэн төлөх вэ л гэдэг асуудал ярьж байгаа юм.

Бид энэ 2 мянган айлын орон сууцаа зараад юу хийхээ энэ хууль дээр бичсэн. Газар чөлөөлье, инженерийн шугам сүлжээ тавья л гэдэг ийм ер нь хоёр зүйл дээр зориулъя гэж байгаа юм.

Хэрвээ чиг үүрэг хот руу юм уу, Барилга, хот байгуулалтын яам руу шилжиж ирвэл бид хямд эх үүсвэрийг эрэлхийлнэ. Бид МИК-тэй уулзалтууд хийгдээд явж байгаа. МИК дээр бэлэн 500 сая доллар Америкаас босож ирэх бэлэн болоод байгаа. Гол нь свопын төлбөр гэдэг л асуудал яригдаад байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан байхгүй байна. Р.Батболд гишүүн асуултаа асууя.

Р.Батболд: Оройн мэнд хүргэе гишүүдэд.

Энэ хуультай холбоотой ганц хоёр асуудлууд байна. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан гээд энэ хууль дээрээ байсан энэ сангийн нэрийг л өөрчлөөд газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сан болгох юм байна гэж ойлголоо.

Тэгээд энэ сангийнхаа хөрөнгийн эх үүсвэрийг нь харахаар энэ 7.2.2 нь их сонин заалт орж ирээд байгаа. Энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд бий болсон орон сууцыг худалдан борлуулснаас олсон орлого гээд ороод ирж байгаа.

Энэ нь нийслэлийн явуулаад байгаа Сэлбэ төсөл ч гэдэг юм уу, үүнтэй адилхан ийм төслүүдээ явуулахын тулд л хууль руу ерөөсөө чихээд оруулаад ирлээ гэж харагдаад байгаа юм.

Тэгээд Сэлбэ төслийнхөө явж байгаа царайг нь харахаар баахан гаднын компанид өгсөн. Бөөн хэрүүл уруул. Дотоодын бизнесүүдээ ер нь яаж дэмжих гээд байгаа юм бэ? Энэ бүтээн байгуулагчдаа ер нь яах гээд байгаа юм бэ гэдэг нэг асуудал байна.

Одоо бид хуулиараа нэг сантай. Сангийнхаа зарцуулалтыг нийслэл мэднэ гээд энэ чинь бүр хамаагүй л явах гээд байгаа юм шиг л юм болоод л явчихлаа л даа. Ер нь би тэгж хараад байна.

Тэгээд энэ хувийн бизнесээ яах гээд байна аа? Зарласан тендерийнх нь 3, 4 дүгээр багц нь юу болж байна аа? Энэ дотоодын аж ахуйн нэгжүүдтэйгээ ер нь тохиролцож чадаж байна уу, үгүй юу гэдэг нэг асуудал. Эхний асуулт.

Хоёр дахь нь гэвэл одоо энэ Сэлбэтэй нь холбоотой би дахиад асуумаар байна.

2500 айлын газар чөлөөлсөн юм. Тэгээд одоо энэ дээрээ 10 мянган айлын байшин бариад байгаа юм. Тэгээд бид нар энэ төвлөрлийг багасгачихлаа, түгжрэлийг бууруулна гэж яриад байгаа юм.

Энэ 2500 айлын газар чөлөөллөө гэхэд хашаандаа хоёулаа байшин бол 5 мянган өрх ч юм уу байхгүй болсон байх байх л даа. Тэндээс чөлөөлөгдсөн байх. Түүн дээрээ 10 мянган айлын орон сууц бариад байгаа юм. Тэгээд бид чинь төвлөрөл сааруулаад байна гэж ярьдаг.

Энэ яг тэр төсөл дээр нь байгаа хажуугаар нь баригдах тэр хувийн орон сууцын хотхоны тэр айлуудын тоо ороогүй явж байгаа шүү дээ. Энд. Зөвхөн баригдах орон сууцад нь орох өрхийн тоо яваад байдаг.

Тэгээд тэр чинь бид аятайхан шиг 60-аас дээш квадраттай байшин болгочхож болохгүй юм уу гэхээр дарга нь уурлаад байдаг. Квадрат заалаа гээд байдаг. 30-аас 40 хэдэн квадратын хоорондох 10 мянган айлын байр барих гээд суугаад байдаг. Энэ дээр нэг хариулт авчихмаар байх юм. Тэгээд тодруулъя би.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 4 номерын микрофоноос Х.Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Р.Батболд гишүүн төслөө гүйцэд сайн хараагүй байна. Та маш буруу ойлголттой явж байна.

Нийтийн тээврийг хөгжүүлэх санг энд ерөөсөө хөндсөн зүйл нэг ч байхгүй. Таны ярьж байгаа наад төслийн 7 дугаар зүйл дээр бид шинээр Гэр хорооллын газар төлөвлөлтийг дахин хөгжүүлэх сан гэж шинэ тусдаа сан байгуулах гэж байгаа.

Өөрөөр хэлбэл саяын ярьж байгаа 2 мянган айлынхаа орон сууцыг зарж борлуулсан орлогоос бид энэ сангаа бүрдүүлье, газрыг дуудлага худалдаагаар зараад энэ сангаа бүрдүүлье, Сэлбэ дэд төвийн барилгыг зараад тэр зарсан барилгаасаа энэ газар чөлөөлөлтийнхөө санг бүрдүүлье гэдэг.

Сэлбэ дэд төвийн өөрийнх нь үндсэн зориулалт юу вэ гэвэл эхлэлтийн цэг байгаа юм. Өөрөөр хэлбэл газар чөлөөлөлтийг бид ингэж хийгээд Улаанбаатар хотод байхгүй хамгийн нягтаршил багатай орон сууцын хорооллыг бид энд байгуулах гэж байгаа юм.

Энэ чөлөөлсөн сангаараа Таван буудал, Хайлааст, Зургаан буудал гээд энэ хавийг буцаж чөлөөлөөд, чөлөөлсөн газар дээрээ бид дэд бүтэц тавиад, замыг нь тавьж өгөөд, сургууль цэцэрлэгийг нь шийдэж өгөөд барилгын компаниудад цаашид үргэлжлүүлж та нар энэ дээр дараагийн барилгуудаа барь гэдэг энэ эхлэлтийн цэгийг бий болгож байгаа зүйл гэдгийг хэлье.

Дээр нь та Сэлбэ дэд төвийн 3, 4 дүгээр багцтай холбоотой мэдээллийг бас хэвлэл мэдээллээс аваагүй байх шиг байна. Бид 5 багц болгож зарласан.

200, 200 тэрбумаар нь 5 багц болгож зарласан. Тендер 08 сарын 03-ны өдөр нээгдэнэ. Дотоодын аж ахуйн нэгж, байгууллагууд барилгын бүх мэргэжлийн холбоодтой тохиролцсоны дагуу шалгуур үзүүлэлтүүдийг нь тэдгээрт нийцүүлж зарласан гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Тодруулах уу? Р.Батболд гишүүн. Р.Батболд гишүүн нэмж тодруулъя.

Р.Батболд: Яах вэ, ингээд ярихаар болоод байгаа юм шиг юм яригдаад байгаа юм.

Тэгээд наадах чинь одоо энэ бондын чинь эргэн төлөлт нь 3 жилийн хугацаатай биш юм уу? Би уг нь 3 жилийн хугацаатай бонд л гэж ойлгоод л та нарыг чинь 2 жилийн дотор барилгаа барьж дуусаад явчих гээд байгаа юм байна гэж ойлгоод байсан шүү дээ. Тэгсэн чинь одоо энэ чинь цаашаа үргэлжлээд явна гээд яригдаад уналаа.

Ер нь яах вэ, би нэг л юм хэлэх гээд байгаа юм. Бид чинь энэ хот тосгоныхны эрх зүйн байдлын тухай хууль ч билүү. Үүнийгээ ирэх жилийн 06 сарын 01-нээр болгоод тавьчихсан. Тэр хүртэл нөгөө хот нь 14 хот болох гэж байна уу, юу болох гэж байна. Үүнийгээ мэдэхгүй сууж байдаг.

Тэгсэн чинь Улаанбаатар хотын хот төлөвлөлт, гэр хорооллыг орон сууцжуулах гээд яаралтайгаар ийм хууль орж ирээд байх юм.

Бид хэрвээ 06 сарын 01-нээс ирэх жилээс тэр хууль чинь хэрэгжээд эхэлбэл 11 сарын хугацаатай хуулийг яаралтайгаар оруулж ирж хийлгээд байгаа юм уу гэж бас асуумаар байгаа юм. Энэ чинь аягүй сонин юм болох гээд байна шүү дээ.

Ирэх жил Улаанбаатар хот нийслэл хот гэж юм чинь байхгүй 14 салчихвал газар нь хаана очоод энэ хууль чинь ер нь юу болох гээд байгаа юм.

Х.Булгантуяа: 4 номерын микрофон Х.Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Р.Батболд гишүүн бол хэлэлцэж байгаа асуудалтай холбоогүй юм асуулаа. Гэхдээ би нэмж хариулъя.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг нэг жилээр хойшлуулсан.

Шалтгаан нь юу вэ гэвэл 14 хотынхоо хилийн цэсийг Их Хурлаар батлуулаагүй байгаа. Энэ ажил Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Барилга, хот байгуулалтын яам, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар Их Хурлаар оруулж энэ 14 хотын хилийн цэсийг батлуулж байж энэ хуулийн цаашаа хэрэгжилт хангагдаж явна.

Энэ хилийн цэс хангагдсан тохиолдолд бид хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөө Засгийн газрын хуралдаанаар батлуулна. Их Хурал дээр 2040 ерөнхий төлөвлөгөөгөө батлуулна гэсэн ийм дараалалтай явж байгаа.

Тэгэхээр хотын зүгээс шалтгаалах бүх ажлуудаа хийгээд, холбогдох суурь судалгааны хамт Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар хилийн цэс, эргэлтийн цэгүүдээ гаргаад өгсөн байгаа. Хууль хэрэгжлээ гэхэд тийм хүндрэлтэй зүйл байхгүй. Бид шилжилтийн үеийн зохицуулалтаа бас хууль батлуулахдаа батлуулсан.

Х.Булгантуяа: Хэмээд хариулъя. 4 номерын микрофон. Бондын хугацаа гэсэн.

Х.Нямбаатар: Тийм. Бондын хугацаа 3 жилээр 2027 оны сүүлээр төлөгдөнө.

Тэгэхээр бид 08 сарын 01-нээс эхлээд одоо эхний барилгын ажил эхэлж байгаа 2 багцынхаа борлуулалтын ажлыг энэ 8 дугаар сараас эхэлж байгаа. Бид дахин санхүүжилт хийлгүйгээр 2027 ондоо зээлсэн 500 сая ам.долларынхоо бондын эргэн төлөлтийг төлөх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. 100 сая ам.доллар нь бид 7.7 хувийн хүү хүүтэй босгосон. 100 сая долларыг нь бид 9 хувийн хүүтэй арилжааны банканд хадгалсан. Үлдсэн 400 сая төгрөгийг Эдийн засаг, хөгжлийн яамны тавьсан шаардлагын дагуу Монголбанканд арилжаад 13-аас 16 хувийн хүүтэй гүйцэтгэлээрээ санхүүжүүлэх нөхцөлтэйгөөр арилжааны системийн 4 банканд хадгалуулсан байгаа. Эрсдэлгүй явж байгаа.

Энэ жил хүүгийн орлогоос 108 тэрбум төгрөг болно. Үүнээс 50 орчим тэрбум төгрөгийг бондын хүүд төлнө. Илүү нь ханшийн эрсдэлийг хаах зориулалттай хадгалуулсан.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд.

Р.Батболд: Ингээд харин ийм юм яриад байгаа байхгүй юу. 2027-нд төлөх бондынхоо мөнгийг эргүүлээд, эргүүлээд бид юманд ашиглана шүү дээ гээд. Ингээд сандаа оруулаад явна гээд тийм юм яриад байх юм. Одоо тэр нь дүүрч байа гэж бодъё доо.

Энэ чинь тэгээд бизнесийн байгууллагууд. Уг нь газар чөлөөлөөд, тэр дуудлага худалдааныхаа орлогоор сан нь эх үүсвэрээ бүрдүүлээд явж байвал болмоор юм шиг байгаад байгаа юм.

Тэгээд тэр дуудлага худалдаагаараа бизнесийн байгууллагууддаа газраа зарчхаад, хотынхоо төлөвлөлтийн дагуу барилгыг нь бариулаад л явж байвал хотын хийх ажил нь тэгээд болох юм шиг байгаа юм. Тэгэхгүй энэ бизнес рүү л хамаагүй их ороод байна л гэж хараад. Үүнийг нь жоохон шүүмжлээд байгаа юм л даа. Тэгээд ерөөсөө зөвшөөрөхгүй юм.

Х.Булгантуяа: Санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ ордны баруун хаалган дээр байгаа нийслэлийн иргэд хоёр, гурван асуулт асуугаадхаач ээ гээд өдөр хоолонд гарч байхад асуултыг дайсныг би дамжуулж асуух гэж байгаа юм. Хотын дарга аа.

Нэгдүгээрт, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байсан ТҮЦ эрхлэгчдийн холбоо гээд нэг холбоо байна. Өмнө хотоос хоёр ч удаа энэ хүмүүст ТҮЦ-ээ зарж байсан юм байна. Иргэд өөрөө ТҮЦ-ээ мөнгөөр худалдаж аваад үйл ажиллагаагаа явуулаад хоёр ч удаагийн ийм үйл ажиллагаа болсон.

Сүүлд бүр хурааж байна, зам чөлөөлж байна гэдэг байдлаар хүний хөрөнгөд халдсан, эвдэж сүйтгэсэн гэдэг асуудлууд хүртэл яригдаж байна. Үүнийгээ нэг тийш нь шийдэж өгөөч ээ. Зам харгуй чөлөөлж байна, түгжрэлгүй болгох гэж байна гэдэг юм ярьсан. Тэгтэл одоо тэр дээр чинь хэдэн скүүтэр, сурронуудыг ямар ч замбараагүй байрлуулаад бас л түгжрэл, стресс нэмэгдсэн ийм байдалтай байна.

Бид үндсэндээ 3 сарын хугацаанд ямар ч орлогогүй явж байна. Энэ дээр бид нар яаж орлоготой, ажилтай болох вэ гэж байна.

Хоёрдугаарт нь, эдгээр хүмүүсийг ТҮЦ-ийг нь нураачхаад, эсвэл ТҮЦ-ийг нь булаачхаад, эсвэл буулгачхаад ажлын байранд зуучилж өгнө, ажилд оруулж өгнө гэж хэлсэн гээд. Энэ нь дандаа бичгээр ирсэн байгаа. Би эд нарыг танд одоо ингээд өгье.

Тэгээд эд нар дээр нэг хариулт авахгүй бол одоо ажил ч үгүй, ТҮЦ-ийн орлого ч үгүй 3 сар болж байгаа иргэд яаж амьдрах вэ гээд энэ ордны баруун талд байгаа юм байна.

Тэгээд энэ хүмүүс чинь дахиад ерөөсөө иргэдтэйгээ уулздаггүй. Нийслэлийн дүүрэг болон хорооноос сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийнхэн ерөөсөө уулзахгүй байна. Энэ дээр Нийслэлийн Засаг дарга иргэдтэй уулздаг цаг гаргаж өгөөд иргэдтэйгээ уулзаж санал, сэтгэгдлийг нь сонсдог болбол их сайн байна гээд надад 20, 30 минут сэтгэлээ онгойтол юмаа ярилаа. Энэ дээр та нэг уулздаг цаг гаргаад өгвөл их сайн байна гэж.

Гурав дахь асуулт нь, та энэ өмнөх хурал дээр орж ирээд хотод нэг ч барилга барих зөвшөөрөл өгөөгүй гэж хэлсэн. Одоо UB Palace-т зөвшөөрөлгүйгээр юм уу, эсвэл зөвшөөрлийг нь авчхаад барилга эхлэх гэж байгаа юм уу? Зөвшөөрөлтэй юу, зөвшөөрөлгүй юу? Тэнд өндөр байшин одоо энэ Улсын Их Хуралд сууж байгаа нэг хүний хамаарал бүхий компани барилга барих гээд байна. Энэ дээр та зөвшөөрөл өгсөн юм уу? Энэ барилга нь баригдах юм уу гэдэг ийм 3 асуултыг асуулгасан. Энэ дээр би цаасаар байгаа бүх баримтуудыг нь танд бас давхар өгчихье. Эдгээр дээр хариулт өгөөч?

Х.Булгантуяа: 4 номерын микрофон. Х.Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: UB Palace-ийн хуучин суурь дээр баригдаж байгаа барилгын зөвшөөрлийг хотоос олгоогүй.

Хоёрт, ТҮЦ эрхлэгчдийн холбооныхонтой бид уулзаад амьжиргаа дэмжих нөхөн олговор олгоё гэдэг уулзалтууд хийгдсэн. Улаанбаатар хотын иргэдийн дунд бид хэд хэдэн удаагийн социологийн судалгаа явуулсан. Судалгаанд оролцогчдын бараг 90-ээс дээш хувь нь одоо ТҮЦ үүргээ гүйцэтгэсэн. Инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй ээ. Дотор нь ямар ч гар угаах болон ариун цэврийн байгууламжгүй хэрнээ хагас боловсруулсан болон бүтэн боловсруулсан бүтээгдэхүүнүүдийг иргэд, хүүхэд багачуудад зарж байна. Насанд хүрээгүй хүүхдэд тамхи ширхэглэж зарж байна, оройн цагаар архи худалдаалж байна, нийтийн эзэмшлийн зам талбай дээр саад учруулж байна. Ийм учраас ТҮЦ-ийг нүүлгэх нь зүйтэй гэдэг социологийн судалгаа гарсан.

Мэдээж хэрэг бид иргэдэд ажлын байр зуучлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТҮЦ эрхэлж байсан иргэдийг эхнээс нь бид ажлын байрууд бий болгох ажлуудыг хийгээд явж байгаа.

Одоо бид ТҮЦ эрхлэгчдийн холбоотой ямар уулзалтууд хийхээр төлөвлөж байгаа вэ гэвэл хоёр хувааж үзье. Аль хэсэг нь яг ажлын байранд зуучлуулах юм. Бид яг бэлэн ажлын байр. Нийслэлийн орон сууцын конторт орж болж байна. Тохижилт, үйлчилгээний компаниуд болж байна. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд орж болж байна. Эдгээр сул ажлын байрууд зөндөө байна.

Дээр нь бид тодорхой үйлчилгээний төвүүд дээр лангуу түрээсэлж амьжиргааг нь дэмжих байдлаар явж болж байна.

Дараагийн дугаарт нь бид тодорхой хөнгөлөлттэй зээлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгох боломжтой гэдэг ийм төрөл хэлбэрүүдийг бид санал болгож байгаа. Энэ уулзалтуудыг хийхэд бид бэлэн байгаа. Эхнээсээ уулзалтууд хийгдээд явж байгаа.

Ер нь яг хариуцлагатай мэдэгдэхэд Улаанбаатар хотод дахиж шинээр ТҮЦ олгохгүй. Тэр ТҮЦ худалдаалсан гэдэг ойлголт их буруу, зөрүүтэй ойлголт шүү. “UB смарт карт” гэдэг картыг 2014 онд хотоос Солонгосын хөрөнгө оруулалттай байгуулаад, карт зарах зориулалтаар ТҮЦ-үүдийн байршил зааж өгсөн юм билээ. Тэр нь сүүлдээ дамлагдаж зарагдаад явсан асуудлууд байгаа. Түүнээс хотоос ТҮЦ зарсан ойлголт ерөөсөө огт байхгүй.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд чуулганыхаа танхимд цуглаарай. Одоо үүний дараа сүүлийн асуудал.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцээд, тэгээд өглөөнөөс хойш хэлэлцсэн бүх асуудлуудын санал хураалтууд явах ёстой байгаа. Өнөөдөр. Тийм. Тэгж байж эдгээр хуулиуд чинь дараагийнхаа хуулиуд руу орно шүү дээ. Тийм. Тэгэхдээ санал хураалтууд харьцангуй гайгүй.

Болсон уу? Тийм ээ.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал байгаа. Энэ хууль дээр.

Дараагийн асуудалдаа оръё.

**Арван дөрөв. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн
хууль, тогтоолын төслүүд**
/Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Эцсийн хэлэлцүүлгийг явуулах гэж байна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна.

Индэрт урьж байна.

Гишүүд танхимдаа цуглаарай. Үүний дараа шууд санал хураалттай.

Да.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хийлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг холбогдох хууль, тогтоолын төсөлд нэмж тусган төслүүдийн эцсийн хувилбарыг бэлтгэн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хувилбарыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцүүлэн шийдвэрлэж өгнө үү.

Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асуух нэрээ татлаа. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал нэрээ татлаа. Түрүүн Байнгын хороон дээр асуух шиг болсон. Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан байхгүй байна.

Ингээд асуулт асууж, хариулт авах гишүүд байхгүй байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн санал хураалт

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Өнөөдөр Улсын Их Хурал өглөөний 10.00 цагаас хуралдаж 15 асуудал нийтдээ хэлэлцсэн байна.

Санал хураалтуудыг өглөөнөөс хоёр Байнгын хороо ар араасаа зэрэг хуралдаад, дундуур нь бас Засгийн газрын хуралдаан ээлжит бус хуралдсан учраас санал хураалтыг явуулж чадахгүй хойшлуулсан байгаа.

Тийм учраас өнөөдөр эдгээр асуудлууд нь зарим нь хуулийн хугацаатай. Зарим нь дараагийн хэлэлцүүлэгт бэлтгэх шаардлагатай байгаа учраас санал хураалтуудыг эхэлье.

Бүлгийн дарга нар ирцээ бүрдүүлээрэй. Гишүүд бүгдээрээ санал хураалтад бэлтгээд хуруугаа уншуулъя. Бүлгийн дарга нар ирцээ.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлт. Өнөөдөр чуулганы хамгийн эхний асуудал болж хэлэлцсэн байгаа.

Гишүүд бүгдээрээ санал хураалтад хуруугаа уншуулж бэлтгэе.

Өнөөдрийн хамгийн анхны санал хураалт явагдах гэж байгаа учраас хамгийн эхнийх нь ирцийн санал хураалт явуулъя. Сая орж ирсэн гишүүд хуруугаа уншуулаад санал хураалтад бэлдээрэй.

Ирцийн санал хураалт. /алх цохив/

51.8 хувьтай байна.

Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. /алх цохив/

1.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-д заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн хүнээс бууруулж бүртгэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

Санал 55.5 хувиар дэмжигдлээ.

2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-д заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн хүнээс бууруулж бүртгэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

Санал 57.3 хувиар дэмжигдлээ.

3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-д заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн хүнээс бууруулж бүртгэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх эрхтэй” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

59.1 хувиар санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

Байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүдэд баярлалаа.

Хоёр дахь асуудал.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг явуулъя.

Гишүүд түрүүн асуулт асууж, үг хэлж дууссан байгаа.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

59.1 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа.

Гурав дахь асуудал.

“Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Шууд ар араасаа явчихъя. Тэгэх үү. Хэдүүлээ ар араасаа санал хураалт ойрхон явчихвал асуудал байхгүй. Тийм ээ. Заавал бэлтгүүлэх ёстой юу. Улсын Их Хурлын гишүүнд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

62.7 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа.

Дөрөв дэх асуудал.

“Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбоотой Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Одоо санал хураалтыг явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

1.Байнгын хорооны саналаар “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

53.6 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа.

Дараагийн асуудал. Тавдугаар асуудал.

“Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хорооны саналаар “Бүгд Найрамдах Тринадад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хурааа. /алх цохив/

58.2 хувиар дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа.

Зургадугаар асуудал.

“Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг явуулъя.

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хорооны саналаар “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хурааа. /алх цохив/

61.8 хувиар дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа.

Дараагийн асуудал. Долдугаар асуудал.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Санал хураалтыг явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Энэ санал хураалт нууц явах ёстой. Тамгын газар, нууц санал хураалтад бэлтгээрэй.

Байнгын хорооны саналаар Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох нууц санал хураалт одоо явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Тамгын газар нууц санал хураалтад бэлтгээрэй. Арай болоогүй юу?

О.Алтангэрэл гишүүн, Ж.Батсуурь гишүүн гээд ороогүй байна шүү. Хуруугаа уншуулж санал хураалтад бэлдүүлмээр байна. Одоо зүгээр байна.

Байнгын хорооны саналаар Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох нууц санал хураалтыг явуулъя.

Өвгөнхүүгийн Гэрэлт-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Хэлэлцэх асуудал найм. Асуулт асууж, үг хэлж Улсын Их Хурлын гишүүд дууссан.

Одоо санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

58.2 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа.

Есдүгээр асуудал. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Одоо санал хураалтыг явуулъя. Улсын Их Хурлын гишүүд санал хураалтад бэлтгэе. Энэ бас нууц санал хураалт явуулах байгаа. Тамгын газар нууц санал хураалтад бэлтгэе. Гишүүд дэлгэц нь шар болсон байгааг санал хураалтад хуруугаа уншуулаад бэлтгээд. Энэ бол дахин явуулах горим байхгүй учраас. О.Алтангэрэл гишүүн санал хураалтад бэлдээгүй байна.

Түрүүний санал хураалт дээр М.Бадамсүрэн гишүүний төхөөрөмж нь ажиллаагүй. Санал дэмжсэнээр тооцоорой гэж байна. Тамгын газрынхан. Санал хураалтыг явуулъя.

Цэндийн Сүхбаатарыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлөх саналыг. Эхлээд чөлөөлөхийг нь дэмжих ёстой юм байна. Дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүдийн 61.8 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Одоо Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилох санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Ж.Алдаржавхлан гишүүн, Ж.Батсуурь гишүүн, Н.Батсүмбэрэл гишүүн санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

Горчинсүрэнгийн Адьяаг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

64.5 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох саналуудыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Дараагийн асуудалд оръё.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг явуулъя.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

64.5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Арван нэгдүгээр асуудалд орьё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны. Үүнийг тийм Байнгын хороонд шилжүүлчихсэн. Тийм ээ.

Түүний дараагийн асуудал. Арван хоёрдугаар асуудлыг хэлэлцээд Байнгын хороонд нь шилжүүлсэн байгаа. Төсөвтэй холбоотой асуудлууд бол шууд Байнгын хороо руу нь шилжүүлчхэж байгаа.

Дараа дараагийн асуудал.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг явуулъя.

Шууд Байнгын хороонд нь шилжүүлсэн. Ц.Даваасүрэн дарга.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.7¹ дүгээр зүйлийн 7¹.2.1 дэх заалтыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг. Санал хураалт. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүдийн 64.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн “3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн 3 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг. Санал хураалт.
/алх цохив/

Улсын Их Хурлын гишүүдийн 66.4 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Нэг.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүсэд” гэсний дараа “нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, барилга байгууламжаас бусад” гэснийг “бүсэд” гэсний дараа “инженерийн дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламжаас бусад” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, М.Ганхүлэг, Ж.Батжаргал.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал.
Санал гаргасан Б.Уянга гишүүн үг хэлнэ.

Б.Уянга: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д нийтийн зориулалттай дэд бүтцийн тодорхойлолт орсонтой холбоотой.

Тэгээд бас хэрэгжилт дээр нь тайлбар оруулъя гэж Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдтэй тохиролцсон тул гүйцээн боловсруулах чиглэл авъя. Дарга аа.

Х.Булгантуяа: Тэгвэл энэ санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Хоёр.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “албан тушаалтан” гэсний дараа “зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа

/оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн” гэж,” гэснийг “7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “харьяалах шүүхэд хүсэлт гаргана.” гэснийг “харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана.” гэж,” гэж өөрчилж 4 дүгээр зүйлд шилжүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 68.2 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 6.8 дахь заалтын “7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг,” гэснийг “7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 7.6 дугаар зүйл, 7.7 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.15, 7.17 дугаар зүйл,” гэж,” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

Хууль зүйн байнгын хорооноос дэмжсэн санал. Санал хураалт. /алх цохив/

Гурав.Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.7.Энэ хуулийн 16.6-д заасан тохиолдолд даатгагч энэ хуулийн 15.2-т заасан үүргээс чөлөөлөгдөх ба хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа үнэлгээний тайлан шаардахгүйгээр эд хөрөнгийг засуулахаар тохиролцож болно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянхишиг. Санал хураалт. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүдийн 64.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 16.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.6.Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй, холбогдогч талуудын тээврийн хэрэгслээс бусад эд хөрөнгийн хохиролгүй, холбогдогч талууд өөр хоорондоо маргаангүй тохиолдолд даатгагч, жолоочийн даатгалын сан нь даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл, баримтыг цахимаар даатгуулагч болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.6-д заасан автоматжуулсан системээс хүлээн авч, нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр. Санал хураалт. /алх цохив/

Г.Лувсанжамц гишүүн нэрээ өгсөн байсан. Г.Лувсанжамц гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Эрхэм гишүүдэд оройн мэндийг хүргэе.

Энэ хуулийн төсөл бол ухаалаг Улаанбаатарыг бодитоор бий болгох гэж байгаа зөв хууль байгаа. Яг ямар шийдлүүд орж байгаа вэ гэхээр нийслэлд байрлуулсан ухаалаг камерын системүүдийг ашиглаад зөрчил, осол гарсан тохиолдолд заавал даатгалын компани замын цагдааг хүлээхгүйгээр шууд тухайн газарт нь камерынхаа баталгаажуулалтаар асуудлыг шийдэх боломжтой болж байгаа.

Өнөөдөр одоо яг ямар байдалтай байгаа гэхээр замын цагдаа даатгалын компанийг хүлээгээд дунджаар нэг осол 40 минут замыг нэг эгнээг тэр чигээр нь хаагаад зогсчхож байгаа.

Тэгэхээр цахимаар шийдэхээр энэ маань 10 минут болж богиносно гэсэн үр дүн гарна.

Тэгэхээр нийслэлийн авто замын түгжрэл бол 13 хүртэлх хувиар буурах боломж нь бүрдэж байгаа.

Гэхдээ энэ дээр хэрэгжүүлэх тал дээр нь анхаарах хэрэгтэй зүйл байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Зам, тээврийн яам Тээврийн цагдаагийн албанд зориулж зөвлөмжүүдийг хэлмээр байна. Үүнийг бодитоор хэрэгжүүлэхийн тулд төрийн болон мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа аягүй чухал.

Ялангуяа даатгалын холбоотойгоо ойлголцохгүй болбол энэ бодитоор хэрэгжих боломжгүй. Хуулийн хийдэлтэй, зөрчилтэй байна гээд хэрэгжихгүй болоод хайран тэр их мөнгөөр авсан техник, тоног төхөөрөмжүүд үргүй зарцуулагдах болох гээд байгаа юм.

Тэгэхээр Тээврийн цагдаагийн алба, Даатгалын холбоо, Замын хөдөлгөөний удирдлагын төвүүдийг оролцуулсан ажлын хэсгийг нийслэл эсвэл Зам, тээврийн яамнаас байгуулаад, тэгээд үүнийгээ бодитоор хэрэгжүүлэх арга хэмжээг нь авах хэрэгтэй гэж ийм зөвлөгөө байна.

Хоёрдугаарт нь, техникийн хяналт гэж байгаа.

Одоо Зам, тээврийн яаман дээр хэрэгжүүлдэг. Төсөв, хөгжлийн төлөвлөгөөний 1 дүгээр хавсралт дээр зорилтоо тавьсан байдаг. Уг нь энэ Улаанбаатар хотод төдийгүй, улсад явж байгаа бүх тээврийн хэрэгсэл техникийн үзлэгтээ орсон байх ёстой.

Гэтэл зорилт нь 75 хувь гээд. Анхнаасаа ерөөсөө ажил хийе гэсэн сонирхолгүй шалгуур үзүүлэлт тавьсан байгаа юм. Үүнийгээ заавал хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнийгээ хэрэгжүүлэхдээ юун дээр анхаарах хэрэгтэй байна гэхээр одоо яг ингээд урин дулаан цаг болонгуут баахан чопперчууд гээд нэртэй мотоциклоо чарлуулаад, ялангуяа шөнө оройн цагаар давхилдаад байдаг аягүй олон хүмүүс байгаа. Эд нарыгаа техникийн үзлэг дээр нь шалгаад тэр янданг нь солих хэрэгтэй. Солиулах ёстой. Тэгэхгүй бол мотоцикл гэдэг юм чинь шөнө давхиж байхдаа хамгийн чанга нь 120 децибелээр чимээ гаргаад давхиад байгаа.

Тэгэхэд хотын стандарт бол, ер нь олон улсын жишгээр өдрийн цагаар 55 децибел хүртэл зөвшөөрөгддөг. Шөнийн цагаар 45 децибел хүртэл зөвшөөрөгддөг.

Гэтэл нэг хэдэн эго нь дэндсэн, мотоцикл унасан залуучууд 120 децибелтэй тийм чимээ гаргаад хотын дундуур сүлжилдээд давхиад байгаа. Эд нарыг яаралтай зогсоохыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан гуайгаас хүсэж байна.

Үүнийг сайн анхаарч ажиллаад аль болох наадмын дараа ч юм уу, намараас өмнө энэ асуудлыг шийдэхгүй болбол нялх нойтон хүүхэдтэй хүмүүс, өндөр настай хүмүүс шөнийн цагаар энэ дуу чимээнээс болоод сээрээд тав тухгүй хэцүү байгаа байдалтай байгаа.

Тэгэхээр энэ зүйл дээр анхаарахыг хүсэж байна.

Хамгийн сүүлийнх нь энэ хуулийн 2 дугаар зүйлийн 7.1.1 дээр “нийслэлийн нийтийн тээвэрт ашиглах автобусны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх” гэсэн дээр “автобус” гэдэг үгийн ард “таксины” гэж нэмсэн байгаа.

Нийслэлээс хэрвээ таксины үйлчилгээг хийх гэж байгаа бол энэ болохгүй шүү. Чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ гэдэг дээрээ анхаарч ажиллаарай. Тэгэхгүй бол хувийн таксинд явж байгаа байгууллагуудтай төр нь өөрсдөө очоод бизнес хийж булаацалдаад байдаг явдал байж болохгүй шүү.

Тэгэхээр энэ сангийн зарцуулалтыг зөвхөн чанар, хүртээмжийг дээшлүүлэх дээр төвлөрүүлээсэй гэдэг тийм хүсэлт байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Саяын Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 64.5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Санал хураалтууд дууслаа.

Одоо эцсийн найруулгуудыг уншиж танилцуулъя.

Арван тав.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлох, зөвшөөрөх гэж заасны дагуу хууль тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

“Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байгаа эсэхийг асууя.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгатай саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Бүгд Найрамдах Тринадад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Сонссонд тооцлоо. /алх цохив/

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хууль татаж авч байгаа тухай Та бүгдэд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатад санаачилсан хуулийн төслөө татан авч болно гэж, 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль

санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж тус тус заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр хуулийн төсөл татан авах тухай 25/680129 дугаартай албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл татан авах тухай.

Улсын Их Хурлын гишүүн миний 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлангаас 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг татан авсанд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 7 цаг 00 минут үргэлжилж, 17 цаг 10 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД